# Арлингтон Улсын Сургууль
# АХЛАХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР 2023-24

## ЦОГЦОЛБОР АХЛАХ СУРГУУЛИУД БОЛОН АХЛАХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮД

**WAKEFIELD АХЛАХ ДУНД СУРГУУЛЬ**
1325 S. Dinwiddie Street
Arlington, VA 22206
(703)228-6700

**YORKTOWN АХЛАХ СУРГУУЛЬ**
5201 N. 28th Street 22207
Arlington, VA 22207
(703)228-5400

**ШИНЭ ХАЯГ**
2121 N. Culpeper Street
Arlington, VA 22203
(703)228-2117

**WASHINGTON-LIBERTY АХЛАХ СУРГУУЛЬ**
1301 N. Stafford Street
Arlington, VA 22201
(703)228-6200

**КАРЬЕРЫН ТӨВ/ АРЛИНГТОН ТЕХНОЛОГИ ХӨТӨЛБӨР**
816 Walter Reed Drive
Arlington, VA 22204
(703)228-5800

**ARLINGTON COMMUNITY АХЛАХ СУРГУУЛЬ**
800 S. Walter Reed Dr.
Arlington, VA 22204
(703)228-5350

---

## АХЛАХ СУРГУУЛИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

**LANGSTON**
2121 N. Culpeper Street
Arlington, VA 22203
(703)228-5295

*El Programa de las Escuelas Secundarias está disponible en ispanol en todas las oficinas de consejería de las Escuelas Públicas de Arlington эсвэл el sitio web: www.apsva.us*

# АРЛИНГТОНЫ АХЛАХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР
## АГУУЛГА


Эрдмийн ерөнхий захирал, доктор Жералд Манны хэлсэн үг..................... ............................................. ............ii
Хөтөлбөрийн төлөвлөлт.............................................................................................................................1
Тусгай хөтөлбөрийн зохицуулалт................................... ................................ ...........................................3
Төгсөлтийн шаардлага...................................... ........................................ ............................................ ...5
Коллежийн Оюутны Тамирчдын NCAA (Үндэсний Коллежийн Тамирчдын Холбоо)-д элсэх эрх... ........................9
Оюутны үйлчилгээ ба тусгай боловсрол................................................................................................11
Номын сангийн үйлчилгээ................................................................................. ..........................................13
Сонгох хөтөлбөрүүд.......................................... ....................................................................................14
Нэмэлт Сургалтын Сонголт......................................................................................................................16
Авьяасын үйлчилгээ авдаг оюутнуудад зориулсан боломжууд.......................................... ...........................15
Арлингтон нийгэмлэг, Вэйкфилд, Вашингтон-Либерти, Йорктаун зэрэгт санал болгож буй курсууд……..............16
Урлагийн боловсрол.......................................... ........................................... ........................................ .19
Ажил, Мэргэжлийн Сургалт.......................................... ............................................................................23
Бизнес ба Мэдээлэл технологи (МТ) .......................................... .............................................. .........................25
Компьютерын шинжлэх ухаан............... ................................................................................................32
Гэр бүл ба Хэрэглээний шинжлэх ухаан...................................................................................................29
Маркетинг............................................. ..................................................................................................34
Технологийн боловсрол......................................... ....................................................................................35
Жолоочийн боловсрол ба аюулгүй байдал............................................................................................ ...33
Англи хэл............................................ ............................................. ............................................ ..................33
Эрүүл мэнд ба Бие бялдрын боловсрол ..................................................................................................... 43
Англи хэл суралцагсдын үйлчилгээ ........................................................................................................... 45
Математик................................................................................................................................................... 46
Байгалийн шинжлэл...................................................................................................................................... 53
Нийгэм судлал ........................................................................................................................................... 60
Тусгай боловсрол ....................................................................................................................................... 69
Амьдралын сургалт..................................................................................................................................... 72
Сайн дурын ажил ....................................................................................................................................... 73
Дэлхийн хэл ................................................................................................................................................ 74
Нэмэлт хөтөлбөр, хичээлүүд
Арлингтоны Карьер төв – Бүх сурагчдад зохиулсан тусгай хөтөлбөр, Тусгайлсан хөтөлбөрүүд
Сургалтын хөтөлбөр Хавсралт ............................................................................................................... 77
Арлингтон нийгэмлэг дунд сургууль – Бүх сурагчдад зориулсан тусгай хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хавсралт ................................................................................................................................................. 105
Уэйкфилд дунд сургууль – Бүх сурагчдад зориулсан тусгай хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хавсралт ..... 107
Вашингтон-Либерти ахлах сургууль – Олон улсын бакалаврын хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хавсралт 116
Йорктаун ахлах сургууль – Сургалтын хөтөлбөрийн хавсралт................................................................. 138
Хос төгсөлтийн (NOVA) тусгайлсан хөтөлбөр ........................................................................................ 142
Санал болгож буй хос төгсөлтийн хичээлүүд............................................................................................ 162
NOVA-ийн Ерөнхий сургалтын гэрчилгээ.................................................................................................. 165
Сургалтын хөтөлбөрт санал болгож буй хичээлүүдийн индекс................................................................. 146
Хавсралт A – Санал болгож буй урлагийн хичээлүүд................................................................................ 146
Хавсралт B – Ажил болон мэргэжлийн боловсролын тойм....................................................................... 147
Хавсралт C – Санал болгож буй цахим хичээлүүд ................................................................................... 149

2023 оны 1-р сар

Хүндэт Арлингтоны гэр бүлүүд ээ,

Арлингтоны улсын сургуулиудын дунд сургуулийн сургалтын хөтөлбөрийг хүлээж авна уу! Та ахлах сургуулийн хичээлийн хуваариа төлөвлөх явцдаа энэхүү баримт бичгийг лавлах, хөтөч болгож ашиглана гэдэгт найдаж байна. Энэхүү Сургалтын хөтөлбөр нь нийт ахлах сургууль, Карьерын төв болон манай онцгой хөтөлбөрүүдийн хүрээнд сургуулиас үзүүлж буй үйлчилгээний талаар сурагчид болон эцэг эхэд ерөнхий төдийгүй нарийвчилсан мэдээллийг өгөх болно. Бид товч бөгөөд тодорхой байхын тулд ахлах сургуулийн олон онцлогийн талаар тойм бэлтгэн тухай бүрийн зорилтуудыг тайлбарласан. Та дараах хаягаар ахлах сургуулийн зөвлөх үйлчилгээтэй холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой:

| | |
|---|---|
| Arlington Community ахлах сургууль | 703/ 228-5350 |
| Arlington career center | 703/ 228-5800 |
| Langston | 703/ 228-5295 |
| Шинэ чиглэлүүд | 703/ 228-2117 |
| Wakefield ахлах сургууль | 703/ 228-6702 |
| Washington-Liberty ахлах сургууль | 703/ 228-6250 |
| Yorktown ахлах сургууль | 703/ 228-5350 |

Сурагчид өөрсдийн сонирхлыг даган, мэдлэг туршлагаа тэлэхийн хэрээр маш олон боломж сонголтуудтай байх болно. Сурагчид, эцэг эх болон зөвлөх багш нар хамтран ахлах сургуулийн хичээлийн жилүүдийг төлөвлөж, явцын дунд зохих өөрчлөлтийг оруулах нь зүйтэй. Сурагчдын урт хугацааны зорилтууд болон тэдний сонирхол, мөн төгсөхөд тавигдах шаардлага зэрэг нь шийдвэр гаргах хүчин зүйлс юм. 2022-2023 оны Сургалтын хөтөлбөр үүнд дэмжлэг болох болно. Үүний дээр, сургуулийнхаа Зөвлөх үйлчилгээний оффистой хамтран ажиллах нь танай хүүхэд авах боломжтой олон дэмжлэгийн тухай олж мэдэхэд боломжийг олгоно. Жишээ нь сурагчид нэмэлт дэмжлэг хэрэгтэй олон сэдвүүдээр сургуулиас жижиг бүлгээр давтлага өгдөг.

Энэ гарын авлагын төгсгөлд ахлах сургууль тус бүрд санал болгож буй хичээлүүдийн жагсаалтыг та олж үзэж болно. Эдгээр хичээлүүд нь сурагчдад тулгарч буй хэрэгцээ шаардлагыг харгалзаж, сургуулийн ажилтнуудын чадвар, сонирхлыг илүү сайн ашиглаж гаргасан ахлах сургуулийн өөрийн онцгой чиг баримтлалын илрэл юм.

Таныг чиглүүлэх өдөрлөг, Хичээлийн шинэ жилийн үдэшлэг болон бусад хуваарьт арга хэмжээгээр дамжуулан сургуультайгаа харилцаа холбоотой байхыг уриалж байна. Түүнчлэн та өөрийн хүүхдийн зөвлөх эсхүл багштай биечлэн уулзах цаг утсаар залгаж авч болно.

Та бүхнийг ахлах сургуулийн хичээлийн жилүүдэд олгож буй  олон боломжуудыг бүрэн ашиглана гэдэгт бид найдаж байна.

Хүндэтгэн ёсолсон,

Жералд Манн
Эрдмийн ерөнхий захирал

# ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Сургалтыг хөтөлбөрийг сайтар судалснаар эцэг эх, сурагчид санал болгож буй хичээлүүд, сургуулийн үйлчилгээний талаар мэдэж авч, сургууль төгсөх болон хувийн хөгжлөө хангах цогц хөтөлбөрөө төлөвлөхөд тустай. Зөвлөх үйлчилгээний газраас таны төлөвлөлттэй холбоотой асуултуудад хариулж туслах болно. Зөвлөхүүд сурагчидтай хөтөлбөр боловсруулах зорилгоор 2-р болон 3-р сард уулзах ба холбогдох хүсэлтийн дагуу эцэг эхийн хурлын цаг товлоно (дунд сургуулийн зөвлөхүүд төгсөх 9-р ангийнхантай уулзана; 10, 11, 12-р анги төгсөх сурагчидтай анхлах ангийн зөвлөхүүд уулзана). Хөтөлбөр төлөвлөхөд туслах зарим нэг удирдамж.

**Хичээлийн сонголтууд**

Хичээл сонгохдоо эцэг эх, багш, зөвлөхүүд болон сурагчид хариуцлагатай хандаж, хамтран ажиллах нь зүйтэй юм. Хичээл сонгохдоо сургууль төгсөхөд тавих шаардлага, ирээдүйн сонирхлоо харгалзаж үзэх нь чухал байдаг. Сурагчид аль болох олон сонголт, боломжийг сургууль төгссөний дараа олгохыг бид эрмэлздэг. Үүнд анхлах сургууль төгсмөгц даруй байнгын ажилтай болох, бизнесийн эсхүл техник мэргэжлийн сургууль ба/эсхүл хоёр буюу дөрвөн жилийн коллежид элсэж цааш суралцах багтана. Иймээс таны сонголтод олон төрлийн хичээл, боломжууд байх болно.

**Өөр хичээл сонгох**

Сургалтын хөтөлбөрт орсон бүх хичээлүүдэд сурагч хамрагдах хүсэлт гаргах боломжтой. Хичээлийн хуваарийг эцсийн байдлаар гаргахдаа 15-с бага сурагчидтай сургалтыг явуулахгүй байж болно. Иймд хуваариа зөв зохистой гаргахын тулд хичээлийн хувилбарт сонголт хийсэн байх нь зүйтэй. Хуваарийн дагуу давхцаж байгаа хичээл байвал мөн өөр хичээл сонгох шаардлагатай болж болзошгүй. Харьяалах сургуульд нь хүссэн хичээл нь цуцлагдсан тохиолдолд сурагчид өөрийн дүүрэг дэх өөр сургуульд орон тоо байгаа бол тэнд хамрагдах боломжтой. Эцэг эх нь хүргэж өгч, авах шаардлага гарч болзошгүй. Хичээл цуцлагдсан эсвэл аливаа давхцал үүссэн тохиолдолд сурагчдын сонирхол, хэрэгцээг хангах бүхий л оролдлогыг хийх болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй болно. Түүнчлэн хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас эсхүл онлайн сургалтаар зааж болно.

**Эрчимжүүлсэн курст бэлтгэх**

Арлингтоны улсын сургуулиуд бүх сурагчдыг ахисан түвшний хичээлүүдэд элсэн, амжилттай суралцахыг уриалдаг. Ахисан түвшний хичээлд амжилттай суралцсанаар сурагчид бахархах сэтгэл төрж, өөртөө итгэх итгэл нэмэгдэж, суралцах ур чадвар нь сайжирч, дараа дараагийн ахисан түвшний хичээлүүдэд болон сургуулиас цааш амьдралдаа илүү амжилт гаргах суурь тавигдана. Гэхдээ сурагчид ахисан түвшний хичээлд элсэн орох зүгээр л нэг хүсэлтэй байх нь хангалтгүй юм. Мэдлэг, чадварын бат бөх суурьтай байх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь ахисан түвшний ангид амжилттай суралцах эсэхийг нь тогтоох гол хүчин зүйл юм.

Иймд сурагчид бүхий л хичээлдээ хамгийн сайнаараа хичээж, хичээлдээ амжилт гаргах бат бөх суурийг бий болгох нь чухал. Энэ нь үр дүнтэй суралцах арга барилаа сайжруулах, даалгаврыг заасан хугацаанд биелүүлэх, тусламж хүсэх эсвэл шаардлагатай үед нэмэлт цаг зарцуулах, ахисан түвшний сургалтын үндэс болох суурь сургалтуудад амжилттай суралцахыг хэлнэ. Сурагчид болон эцэг эх, багш нар, зөвлөхүүдтэй ойр нягт ажиллан, ахисан түвшний ангиудад элсэн амжилттай суралцах боломжийг нь дээд түвшинд хүргэхийн тулд эдгээр ур чадварыг хөгжүүлэн, дэмжихийг уриалж байна. Бүх 9-р ангийн сурагчид зөвлөхүүд болон эцэг эхтэй хамтран зөвлөлдөж дөрвөн жилийн хичээлийн төлөвлөгөөгөө гаргаж, жил бүр түүнийгээ шинэчлэн сайжруулж байх шаардлагатай.

Ахлах сургуулийн ахисан түвшний хичээлүүд нь баяжуулсан, түргэвчилсэн хичээлүүд юм. Эдгээрийг "түргэвчилсэн" эсхүл өөр нэг байдлаар тусгайлан тэмдэглэсэн байх буюу мэргэжлийн гэрчилгээтэй байж болно. Дараах хүснэгтэд 9, 10-р ангид эрчимжүүлсэн хичээл авсан нь 11, 12-р ангид хичээлийн сонголт, боломжид хэрхэн нөлөөлөх талаарх гурван жишээг харуулав:

| Хичээл: | Үр дагавар: |
|---|---|
| Геометр | 11 эсхүл 12-р ангидаа шинжлэх ухааны хичээлийн Ахисан түвшинд орох сонирхолтой сурагчид 10-р ангидаа гүнзгийрүүлсэн химийн хичээл авна. (Ахисан түвшний хичээлүүд нь сурагчид ахлах сургуульд байх хугацаандаа коллежийн кредит цуглуулах боломж бүрдүүлнэ.) Алгебр II бол Гүнзгийрүүлсэн химийн хичээлд тавих хавсарсан шаардлага юм. Иймээс 9-р ангидаа геометрийн хичээл аваагүй сурагч кредит авах Шинэ ажлын зуны сургуульд сууж байж 10-р ангидаа Эрчимжүүлсэн химийн хичээл болон 11, 12-р ангидаа Ахисан түвшний шинжлэх ухааны хичээлд бүртгүүлэх боломжтой. |
| Испани хэл II | Испани хэл II хичээлийг 9-р ангид авснаар сурагч 10, 11, 12-р ангидаа Испани хэл III, IV бүүр V хичээлийг хүртэл авах боломжтой бөгөөд эсхүл ахлах сургуульдаа хоёр жилийн хугацаанд өөр хэл суралцах боломжтой болно. Коллежид тэнцэхэд илүүд үздэг Ахисан сургалтын дипломыг авахын тулд нэг хэлийг гурван жил эсхүл хоёр өөр хэлийг тус бүр хоёр жил үзсэн байх шаардлагатай болохыг анхаарна уу. |
| Мэргэжлийн гэрчилгээ | Авто техник I, II, III хичээлийг B болон түүнээс дээш дүнтэй дүүргэсэн сурагчид холбогдох төгсөлтийн кредит авах боломжтой ба Үндэсний авто үйлчилгээний чадварын [Automotive Service Excellence (ASE)] гэрчилгээ авах шалгалт өгч, мэргэжлийн гэрчилгээ авч болно. |

Сурагчид, эцэг эх, зөвлөхүүдтэй харилцаатай байж дөрвөн жилийн төлөвлөгөөндөө урьдчилсан болон дагалдах ахисан шатны хичээлүүдийг багтаасан байх хэрэгтэй. Ийм оролцоо нь сурагчдад ахлах сургуулийн дараах сонголтуудын талаар мэдээлэл авах боломжийг нь дээшлүүлнэ.

**Хичээлийн өөрчлөлт** Өөрийн хэрэгцээ, шаардлагад үндэслэж төлөвлөгөөгөө сайтар гаргаснаар явцын дунд өөрчлөлт оруулж, суралцах явцдаа ямар нэг саад учруулахгүй байх болно. Хичээл сонголтоос шалтгаалж багш ажилтан, ном, хэрэглэгдэхүүнийг авах тул төлөвлөгөөг аль болох өөрчлөхгүй байх хэрэгтэй. Зарим харгалзаж үзэх тохиолдлуудад дараах хүчин зүйлд үндэслэж төлөвлөгөө өөрчлөх хүсэлтийг авч үзэх болно:

- сурагч зуны сургуулиар хичээлийг амжилттай дүүргэсэн.
- жишээ нь Испани хэл III-ийг сонгох хүсэлт гаргасан ч Франц хэл III тавигдсан зэрэг төлөвлөгөөний алдаа гарсан.
- зөвлөхөөс баталсны дагуу сурагч карьерын зорилгоо өөрчилсөн.
- сурагч өнгөрсөн жилийн багш дээрээ дахин хичээлд суух болсон бөгөөд өөрчлөх хүсэлт гаргасан.
- Оюутан хурал хийх, дэмжлэг үзүүлэх зэрэг олон талт арга хэмжээний дараа ч Геометрээс Геометрийн зарчмууд эсвэл vice versa гэх мэтээр суралцах чадварт тохирохгүй хичээлийг төлөвлөдөг.

Хичээлийг амжилттай дүүргэхийн тулд сурагч эзэмшсэн байх шаардлагатай чадвар, туршлагыг зааж өгөхийн тулд урьдчилсан нөхцөлүүдийг жагсаасан. Эцэг эхчүүд хүүхдээ эдгээр хичээлүүдэд бүртгүүлж болно. Эцэг эхчүүд өөрийн хүсэлтийг сургуулийн ажилтан, ялангуяа өөрийн хүүхдийн зөвлөхтэй хэлэлцэх нь зүйтэй. Ийнхүү санал авах зорилго нь тухайн сурагч амжилт гаргахад тусалж, тэдгээр хичээлээс тавигдах хүчин зүтгэл, шаардлагыг эцэг эхчүүдэд ойлгуулахад оршино. Сууж болно гэж анх зөвлөөгүй хичээлд хүүхдээ бүртгүүлэх бол энэ талаар эцэг эхчүүд хичээлийн жил дуусахаас өмнө сургуулийн багш ажилчдад мэдэгдэх хэрэгтэй.

# ТУСГАЙ ХӨТӨЛБӨР

| | |
|---|---|
| **Эрчимжүүлсэн сургалт** | Төгсөх үйл явцаа хурдасгахын тулд илүү хурдан сурах боломжийг сурагчид олгож болно. Зуны сургалтууд, анги дамнасан сургалтын бүлгүүд, сонгох хичээлүүд болон эдгээрийн хослолуудаар эрчимжүүлж болно. |
| **Эрчимжүүлсэн агуулга** | Тухайн сурагчид тусгайлан зориулсан хөтөлбөр, анги дамнасан бүлгүүд, чадавхын шалгалт ба бүртгэл, сонгох хичээл, уртасгасан хичээл гэх мэтээр сурагчид ахисан түвшинд хүрч, илүү эрчимтэй сурахыг сурагчдад уриалж байна. |
| **Давхар элсэлт** | Ахлах сургууль, ахлах сургуулийн дараах сургалтад давхар бүртгүүлж болно. Үүнд ахлах сургуулийн хөтөлбөрийг эрчимжүүлэх ба/эсвэл баяжуулах зорилгыг болон холбогдох орон тоонд холбогдож зөвшөөрөл өгсөн байх ёстой. |
| **Бие даан сурах** | Бие даасан сургалтыг өндөр чадвартай, өндөр эрмэлзэлтэй сурагчид өөрийн сонирхсон зүйлийг эрчимтэй сурахад зориулж ахлах сургуулийн сургалтын хүрээнд санал болгоно. Судалгаа, өөрийн сонирхлын дагуух хичээл, дадлага, сайн дурын ажил буюу цалинтай ажилд өмнө тавьсан тусгайлсан нөхцөлийн дагуу ахлах сургуулийн захирал ахлах сургуулийн кредит цаг өгч болно. Зармын хувьд бие дааж сурахыг онлайн хичээлтэй ойролцоо гэж үзнэ. Сурагчид бие даасан хичээлийг эхлүүлэх жилийн өмнөх хавар Зөвлөхүүдийн үйлчилгээний газраар дамжуулж өргөдөл хүсэлт бөглөж, бие даасан сургалтын өргөдөл хүсэлт гаргана. |

## ТӨГСӨЛТӨД ТАВИХ ШААРДЛАГУУД

Ахлах сургуулиа төгсөхийн тулд оюутнууд дор дурдсан Стандарт Диплом эсвэл Ахисан түвшний Сургалтын Дипломын аль алинд нь тавигддаг хамгийн бага шаардлагыг хангасан байх ёстой. Оюутан нэг хичээлд тэнцсэнээр стандарт кредит авдаг. Оюутан курс болон холбогдох сургалтын төгсгөлийн SOL шалгалт эсвэл түүх, нийгмийн шинжлэх ухааны гүйцэтгэлийн үнэлгээнд тэнцсэн тохиолдолд баталгаажсан кредитийг авдаг.

***2018-2019 онд болон түүнээс хойш 9-р ангид элсэн орох сурагчдад дараах зүйл хамаарна.***

<table>
<tr><th colspan="2">Виржиниагийн дипломын төрөл/Төгсөлтийн шаардлага</th></tr>
<tr>
<td>Ахисан түвшний сургалтын диплом (8 VAC 20-131-51)<br>Хичээлийн нийт 26 кредит<br>Англи хэл 4<br>Математик 4<br>Байгалийн шинжлэл 4<br>Түүх, нийгэм судлал 4<br>Эрүүл мэнд/Биеийн тамир 2<br>Эдийн засаг, хувийн санхүү 1<br>Дэлхийн хэл 3 (эсвэл 2 хэлний 2)<br>Дүрслэх урлаг 1 (FA) эсвэл Карьер, мэргэжлийн боловсрол (CTE)<br>Сонголтоор 3 (хоёр дараалсан хичээл орно)</td>
<td>Стандарт диплом (8 VAC 20-131-51)<br>Хичээлийн нийт 22 кредит<br>Англи хэл 4<br>Математик 3<br>Байгалийн шинжлэл 2<br>Түүх, нийгэм судлал 3<br>Эрүүл мэнд/Биеийн тамир 2<br>Эдийн засаг, хувийн санхүү 1<br>Дэлхийн хэл 2 (WL), Дүрслэх урлаг (FA), эсвэл Карьер ба технологийн боловсрол (CTE)<br>(1 нь FA эсвэл CTE, 1 нь WL, FA эсвэл CTE байх ёстой)<br>Сонголтоор (хоёр дараалсан хичээл орно)</td>
</tr>
<tr><td colspan="2">Баталгаажсан кредитүүд (SOLs): Нийт 5<br>Англи хэл 2 (1 унших, 1 бичих)<br>Математик 1<br>Байгалийн шинжлэх ухаан 1<br>Түүх, нийгэм судлал 1</td></tr>
<tr><td colspan="2">Нэмэлт шаардлага<br>• Анхны тусламж, Зүрхний уушгины сэхээн амьдруулах (CPR) болон автоматжуулсан гадны дефибриллятор (AED) сургалт (APS-ийн оюутнууд үүнийг PE/Эрүүл мэнд 9 сургалтын хөтөлбөрөөр дүүргэдэг)<br>• Виртуал курс 1 (APS-ийн оюутнууд үүнийг Эдийн засаг ба Хувийн Санхүү эсвэл AT/IB Экономикс-ээр дүүргэдэг)<br>• Түргэвчилсэн (HN)/AT/IB/DE 1 курс ЭСВЭЛ 1 CTE магадлан ЭСВЭЛ HQWBL туршлага</td></tr>
</table>

**Шатлалтай сонгох хичээлийн заавар**

Ахлах сургуулийн стандарт диплом, Гүнзгийрүүлсэн стандарт диплом авахын тулд сурагчид гүнзгийрүүлсэн хичээлээс хамгийн багадаа хоёрыг авах шаардлагатай. Гүнзгийрүүлсэн сонгох хичээл гэдэг нь сурагч хичээлийн янз бүрийн түвшинд хүрэх явцдаа агуулгыг гүнзгийрүүлж, түвшнээ ахиулах хичээлүүд юм. Эдгээр хичээлүүд нь аль ч чиглэлээр байж болно Дүрслэх урлагийн нэг нэгж кредитийг хангахад ашигладаг хичээлүүд эсвэл CTE нь энэхүү шаардлагыг хэсэгчлэн хангахад ашиглагдаж болно. Танилцах хичээлийн дараа удиртгал хичээл авбал шаардлагыг хангасан гэж үзэхгүй; гэхдээ удиртгал хичээлийн дараа тухайн хичээлийн дараагийн шатыг үзвэл болно. Сурагчид сонгох хичээлүүдийг шатлалтайгаар дараалсан жилээр эсхүл ахлах сургуулийн хоёр жилийн аль нэгт нь авч болно. Энэ шаардлагыг хангахад холбогдож зөвлөхүүд сурагчдад туслах болно.

**Диплом**

**Хэрэглээний сургалтын диплом**

ЭЕШ-ын шаардлага хангасан, бусад дипломын шаардлага хангаагүй хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад Хавсралт сургалтын диплом олгоно. Хавсралт сургалтын дипломын талаарх нэмэлт мэдээллийг https://www.doe.virginia.gov/parents-students/for-students/graduation/diploma-options/applied-studies-diploma хуудаснаас авна уу.

**Бусад диплом, гэрчилгээ**
**Хөтөлбөр дүүргэсэн гэсэн гэрчилгээ**
Заасан сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн боловч дипломын шаардлага хангаагүй оюутнууд. Нэмэлт мэдээллийг Виржиниа мужийн Боловсролын газрын вэбсайтаас авах боломжтой: https://www.doe.virginia.gov/parents-students/for-students/graduation/diploma-options/other-diplomas-certificates\

**Ерөнхий боловсролын хөгжлийн гэрчилгээ** (8 VAC 20-360-10, гэх мэт)
Ерөнхий боловсролын хөгжлийн гэрчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг https://www.doe.virginia.gov/teaching-learning-assessment/specialized-instruction/adult-education/high-school-equivalency-hse-credential хуудаснаас үзэх боломжтой.

**Ерөнхий боловсролын гэрчилгээ, Тодорхойлох зэрэг**

Карьерын төвд Арлингтоны Технологийн сургуульд суралцаж буй оюутнууд Хойд Виржиниагийн олон нийтийн коллежид (NVCC) давхар элсэж коллежийн кредит авах боломжтой бөгөөд ерөнхий боловсролын гэрчилгээ болон/эсвэл өөр чиглэлээр бакалаврын зэрэг авах боломжтой.

## Шилжих оюутнуудад зориулсан мэдээлэл

8VAC20-131-60.G-д заасны дагуу Виржиниагийн ахлах сургуульд аравдугаар анги буюу түүнээс дээш элсэж буй оюутнууд баталгаажуулсан кредитийн тоог цөөлөх замаар ашиг хүртэх боломжтой бөгөөд энд хураангуйлав:

**https://www.doe.virginia.gov/parents-students/for-parents/information-for-transfer-students**

## Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан кредитийн зохицуулалт

**Ахисан түвшний сургалтын дипломын кредитийн зохицуулалт**

Оюутнууд гадаад хэлний шаардлагад нийцэх өөр хувилбар нь ганцаарчилсан боловсролын хөтөлбөр (IEP)-т боломжтой бөгөөд компьютерын шинжлэх ухааны хоёр стандарт нэгж кредитийг гадаад хэлний хоёр стандарт нэгж кредитээр орлуулдаг кредитийн зохицуулалт байдаг.

**Стандарт дипломын кредитийн зохицуулалт**
Кредитийн зохицуулалт нь стандарт дипломтой төгсөхөд шаардагдах стандарт болон баталгаажсан кредитийг авах өөр хувилбаруудыг санал болгодог бөгөөд үүнд:

- Стандарт кредитийн шаардлагыг хангах өөр хичээлүүд

- Дотоодод баталгаажсан кредитэд тавигдах шаардлагуудад оруулсан өөрчлөлт
- Баталгаажсан кредит авахын тулд Боловсролын Зөвлөлөөс баталсан нэмэлт шалгалтууд; Зөвшөөрөгдсөн тестийн жагсаалтыг “Баталгаажсан кредитийг орлуулах тест” хэсгээс үзнэ үү.
- Баталгаажсан кредит авах тестийн оноог бууруулсан
- Ажил болон мэргэжлийн боловсрол (CTE) дамжаагаар дамжуулан ажил дээр суурилсан суралцах туршлагыг олгох

Кредитийн зохицуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг VDOE дээрээс үзэх боломжтой.

**Дотоодод авсан, баталгаажсан Кредитийн бодлого** 8VAC20-131-110(B)
Дотоодод авсан, баталгаажсан кредитийг кредитийн зохицуулалттай оюутнуудад олгож болно. Англи хэл, математик, байгалийн шинжлэх ухаан, түүх/нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр дотоодод баталгаажсан кредит авах эрхтэй болохын тулд оюутан дараах зүйлийг хийх ёстой.

1. Ахлах сургуулийн курст тэнцэх,
2. Шалгалтыг хамгийн багадаа хоёр удаа өгсний дараа SOL тестийн аль ч удирдлагад 375-399 онооны хүрээнд оноо авах, болон
3. Дотоодын түвшинд хүсэлт гаргах журмаар сурлагын амжилтыг харуулах.

Стандарт диплом авсан кредитийн зохицуулалттай оюутнуудад дотоодоос олгосон баталгаажсан кредитийн тооны хязгаарт хамаарахгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг “Төгсөлтийн кредит” хэсгээс авна уу

**Тусгай зөвшөөрөлтэй кредитийн зохицуулалт**
Тусгай зөвшөөрлийн кредитийн зохицуулалт нь өмнө нь Виржиниа орлуулах үнэлгээний хөтөлбөрийг (VSEP) ашиглаж байсан хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад стандарт диплом авахын тулд шаардлагатай баталгаажсан кредитийг авах боломжийг олгодог. Нэмэлт мэдээллийг https://www.doe.virginia.gov/parents-students/for-students/graduation/graduation-requirement-resources/credit-accommodations хаягаас авах боломжтой.

## Амжилтыг батлах төгсөлтийн тамга

Төгсөлтийн тусгайлсан шаардлагыг хангасан, онцгой сайн амжилт гаргасан сурагчид хүндэтгэлийн дипломын тамга дардас авна. Виржиниагийн Боловсролын газраас Арлингтоны улсын сургуулиуд болон нутгийн бусад сургуулиудад дараах тамга дардаснуудыг өгнө:

- Ахисан шатны сургалтын дипломыг “B” эсхүл түүнээс дээш голч дүнтэйгээр авсан бөгөөд Ахисан түвшинд оруулах [Advanced Placement (AT)], Олон улсын бакалавр [International Baccalaureate (IB)] эсхүл давхар кредиттэй төгсөлтийн хичээлд шилжүүлэх боломжтой ес болон түүнээс дээш коллежийн кредит авах коллежийн түвшний ангийн ажил амжилттай хийсэн бол **Засаг даргын тамгыг** дарж шагнана.

- Стандарт дипломын шаардлагыг хангасан, “A” гол дүнтэй Ахисан шатны сургалтын дипломтой сурагчид **Боловсролын зөвлөлийн тамгатай диплом** өгч шагнана.

- **Карьер, техник мэргэжлийн боловсролын зөвлөлийн тамгатай** шагналыг дараах сурагчдад олгоно:
  - ❖ Стандарт эсхүл ахисан түвшний диплом авах болзол хангасан, карьер, техник мэргэжлийн чиглэлд төвлөрсөн эсхүл мэргэшсэн шаталсан хичээлүүдийг сонгосон бөгөөд эдгээр хичээлүүдэд “B” эсхүл түүнээс дээш дүн авч ирсэн.
  - ❖ ЭСХҮЛ хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэр, худалдаа, мэргэжлийн холбооны гэрчилгээ буюу мэргэжлийн боловсролын чадамжийн нотолгоо олгох карьер, техникийн боловсролд төвлөрсөн буюу мэргэшсэн чиглэлээр шалгалт эсвэл мэргэжлийн боловсролын чадамжийн үнэлгээнд тэнцсэн.
  - ❖ ЭСХҮЛ Виржиниагийн Коммонвэлтээс холбогдох карьер, техникийн боловсролын чиглэлд мэргэжлийн тусгай зөвшөөрөл авах.

Боловсролын зөвлөл эдгээр шаардлагуудыг хангахын тулд холбогдох мэргэжлийн боловсролын бүх зөвшөөрөл, шалгалтыг хүлээн зөвшөөрсөн байх ёстой.

- Дараах дөрвөн шалгуурыг бүгдийг нь биелүүлсэн сурагчид **Боловсролын зөвлөлөөс Иргэний боловсролын Төгс сайн тамга дардас** олгоно:

- ❖ Тохируулсан стандарт диплом, стандарт диплом эсхүл ахисан түвшний дипломыг авах шаардлагыг хангасан
  - ❖ Виржиниа, АНУ-ын түүх болон Виржиниа, АНУ-ын Засаг төрийн тухай хичээлүүдийг “B” эсхүл түүнээс дээш дүнтэйгээр дүүргэсэн.
  - ❖ Ядуу, өвчтэй, азгүй хувь тохиолтой хүмүүст туслах сайн дурын эсхүл шашны байгууллага гэх мэт олон нийтийн эсхүл сургуулиас гадуурх ажилд сайн дураар оролцсон; хөвгүүд, охидын скаут эсхүл төсөөтэй залуусын байгууллагад оролцох, “Залуу нөөцийн офицерын сургалтад [Junior Reserve Officer Training Corps (JROTC)]” оролцох; улс төрийн компанит ажил, засгийн газарт дадлага хийх; Хөвгүүдийн улс, Охидын улс, Загвар Ерөнхий Ассамблейд оролцох; иргэнд анхаарсан сургуулиас санхүүжүүлсэн сургуулиас гадуурх ажилд оролцох. АНУ-ын армид төгсөхөөсөө өмнө элссэн аливаа сурагчийг нийтийн тусын төлөөх үйлчилгээний шаардлагыг хангасан гэж үзнэ.
  - ❖ Нутгийн сургуулийн зөвлөлийн дүрэм журмыг мөрдөж хичээлд тогтмол сайн суусан ба аливаа сахилгын арга хэмжээ авхуулаагүй.

- Боловсролын зөвлөлөөс баталсан дипломын авахын зэрэгцээ дараахыг хангасан сурагчийг **Боловсролын зөвлөлийн хос хэлний дардас тамгаар** шагнана:
  - ❖ Англи хэлний унших, бичих хичээлийн төгсгөлийн бүх үнэлгээгээр сайн буюу түүнээс дээш түвшинд хүрсэн гэж үнэлгээ авсан.
  - ❖ Нийтэд зориулсан Захирлын журмын дагуу баталсан жагсаалтын үнэлгээгээр англи хэлнээс өөр аль нэг бөгөөд түүнээс дээш тооны хэлэнд дунд түвшний дундах болон түүнээс дээш түвшинд хүрсэн гэдгээ баталж харуулсан. Англи хэлнээс бусад хэл гэдэгт Америкийн дохионы хэл багтана.

- 9-р ангид 2018-19 он болон үүнээс хойш анхлан элссэн бөгөөд дараах шаардлагыг хангасан сурагчийг **“Шинжлэх ухаан, байгаль орчин” хичээлд онцгой амжилт гаргасан гэсэн Боловсролын зөвлөлийн тамга дардсаар** шагнана:
  - ❖ Стандарт эсхүл Ахисан түвшний сургалтын диплом авах
  - ❖ Зөвлөлөөс баталсан анхан шатны гурав болон түүнээс дээш төрлийн лабораторийн шинжилгээний хичээлийг дүүргэх ба эрчимжүүлсэн ахисан төвшний дор хаяж нэг эсхүл дунд ангийн дараах түвшний лабораторийн шинжилгээний хичээлийг тус бүрийг нь “B” эсхүл үүнээс дээш дүнтэй дүүргэх
  - ❖ Лабораторийн эсхүл шинжлэх ухааны дадлага бүхий судалгааг хийх ба судалгааг албан ёсны шүүгчидтэй байдлаар хийсэн гэдгийг нотлох
  - ❖ Олон нийтийн ажил эсхүл сургуулиас гадуурх үйл ажиллагаанд хамгийн багадаа 50 цаг сайн дураар оролцсон байх ба энэ нь орчны ажиглалт, хамгаалалт, удирдлага, нөхөн сэргээлт гэх зэрэг шинжлэх ухааны хэрэглээнд холбогдох

- **Байгалийн шинжлэл, технологи, инженерчлэл, математикийн (STEM)** тамга нь стандарт диплом эсвэл ахисан түвшний сургалтын дипломын аль нэгийг авсан, ахисан түвшний боловсролын дипломд тавигдах математик, байгалийн шинжлэлийн бүх шаардлагыг “B” дундаж дүнтэй хангасан оюутнуудад STEM тамга олгоно. мөн бүх хичээлд илүү сайн, болон
  - ❖ STEM чиглэлээр 50 цаг ба түүнээс дээш хугацаанд ажил дээр суралцах боломжийг амжилттай дүүргэх, мөн
  - ❖ Ажил, мэргэжил хосолсон сургалтад тавигдах бүх шаардлагыг хангах (хосолсон гэдэг нь <u>CTE хөтөлбөрийн гарын авлагад</u> заасан хичээлийн жагсаалтад хоёр ба түүнээс дээш улсын зөвшөөрөгдсөн хичээлүүдийн уялдаа холбоотой дараалал юм)
  - ❖ дараахын аль нэгт тэнцэнэ:
    - o Боловсролын зөвлөл CTE STEM-Н кредит шалгалт, эсвэл
    - o STEM чиглэлээр коллежийн түвшний кредит олгох Удирдах зөвлөлөөс баталсан шалгалт.

**Коллежид холбогдох сурагч тамирчны “NCAA” шалгуур**

Хэсэг I эсхүл Хэсэг II сургуулийн анхны жилдээ тамирчны тэтгэлэгтэй байх, өрсөлдөх, авахыг хүсэж байгаа бол “NCAA” шалгаруулалтын төвөөр эрхтэй гэдгээ нотолно. “NCAA” шалгаруулалтын төвийн гишүүдийн сурагчид, тэдний гэр бүл болон ахлах сургуулийн захиргааны ажилчид ба дасгалжуулагчтай түншилнэ. Дараах мэдээллийг жил бүр шинэчилдэг бөгөөд хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, удирдамжийг дараах хаягаар үзнэ үү: ncaa.org/playcollegesports

**“NCAA”-ийн Хэсэг I сургалтын шаардлагууд**

Хэсэг I сургуулиуд нь коллежид орох тамирчин сурагчдыг “NCAA”-аас баталсан үндсэн хичээлүүд, үндсэн хичээлийн “GPA” болон тестийн онооны стандартын шаардлагуудыг хангахыг шаардана. Хэсэг I-д та өөрийн эхний бүтэн жилдээ тамирчны тэтгэлэгтэй байх, өрсөлдөх, авах шалгуурыг хангахын тулд та анхлах сургуулийг төгсөж, дараах шалгууруудыг хангасан байх ёстой:

**“NCAA”-ийн Хэсэг II сургалтын шаардлагууд**

Хэсэг II сургуулиуд нь коллежид орох тамирчин сурагчдыг “NCAA”-аас баталсан үндсэн хичээлүүд, үндсэн хичээлийн “GPA” болон тестийн онооны стандартын шаардлагуудыг хангахыг шаардана. Хэсэг II-д та өөрийн эхний бүтэн жилдээ тамирчны тэтгэлэгтэй байх, өрсөлдөх, авах шалгуурыг хангахын тулд та анхлах сургуулийг төгсөж, дараах шалгууруудыг хангасан байх ёстой:

**Дүнгийн хэмжүүр** Дараах дүнгийн хэмжүүрийг ангийн ажил, “GPA”-д ашиглана:

| Үсгэн үнэлгээ | Хувь | Чанарын оноо | “AT”, “IB”, Давхар кредиттэй төгсөлтийн чанарын тоо |
|---|---|---|---|
| A | 90, 91, 92, 93, 94, 95, 96, 97, 98, 99, 100 | 4.0 | 5.0 |
| B+ | 87, 88, 89 | 3.5 | 4.5 |
| B | 80, 81, 82, 83, 84, 85, 86 | 3.0 | 4.0 |
| C+ | 77, 78, 79 | 2.5 | 3.5 |
| C | 70, 71, 72, 73, 74, 75, 76 | 2.0 | 3.0 |
| D+ | 67, 68, 69 | 1.5 | 2.5 |
| D | 60, 61, 62, 63, 64, 65, 66 | 1.0 | 2.0 |
| E | 0 – 59 | 0.0 | 0.0 |

Коллежид элсэх ихэнх өргөдлүүдийг төгсөх жилийн эхээр явуулах ёстой байдаг тул сурагчийн дүнгийн голчийг төгсөх ангид орохоос өмнөх жилийн эцэст тооцож гаргадаг. GPA-г эцсийн байдлаар төгсөх жилийн эхний улирлын дараа тодорхойлдог. Ахисан түвшний хичээлүүдэд авсан сурагчийн оноонуудын дүн нь (сурагч Ахисан түвшний шалгалт өгвөл) жирийн хичээлүүдэд авах онооноос өндөр байна. “GPA”-г Ахисан түвшний, Олон улсын бакалаврын, давхар кредиттэй төгсөлтийн дүнг сурагчийн одоо үзэж байгаа хичээлийн хувьд урьдчилсан тооцож гаргана.

**Ахисан түвшинд орох** Ахисан түвшинд бүртгүүлсэн сурагчид холбогдох заасан шалгалтуудыг өгөх ёстой. Эдгээр шалгалтуудыг өгснөөр сурагчид коллежийн кредит цуглуулах боломжтой төдийгүй мэргэшүүлэх дүнг илүү ахисан түвшинд авах давуу талтай. Хэрэв тухайн сурагч одоогийн хичээлийн жилд тухайн Энэхүү сургалтын хөтөлбөрт жагсаасан хичээлүүдийн Ахисан түвшний шалгалтуудын хураамжийг Арлингтоны улсын сургуульд төлнө.

**Давхар кредиттэй төгсөлт** Давхар кредиттэй төгсөлтөөр сурагчид дунд сургуулиа төгссөний дараах өөрийн сонирхлыг дагаж ахлах сургуульд гүнзгийрүүлсэн хичээлд суух боломжийг олгоно. Давхар кредиттэй төгсөлтийн хичээлийг амжилттай дүүргэснээр сурагчид ахлах сургуулийн болон коллежийн кредитийг аль алийг нь авна. Сурагч эдгээр хичээлүүдийг авахын тулд коллежид орох шаардлагыг хангасан байх ёстой. Авсан коллежийн кредитүүдийг бусад коллежид хүлээн зөвшөөрөх боломжтой.

"Northern Virginia Community College" (NOVA)-аас санал болгож буй давхар кредиттэй төгсөлтийн хичээлүүдэд анхлах сургуулийн төгсөхөөс өмнөх жил ба төгсөх жилийн сурагчид хичээл тус бүрд тавьсан урьдчилсан шаардлагыг хангасан бол сууж болно. Ахлах сургуулийн 1 болон 2-р ангийн сурагчдад холбогдох тохиолдолд хөнгөлөлт олгож болно. "NOVA" давхар кредитийн төгсөлтийн хичээлийг авахыг хүсэж байгаа сурагчид заасан шалгуурыудыг янз бүрийн замаар биелүүлж болно (жишээ нь: Виржиниагийн Элсэлтийн шалгалт [Virginia Placement Test ], хүчин төгөлдөр SAT, PSAT, ACT, AT, SOL оноотой байх). Давхар кредиттэй төгсөлтийн хичээлд суух эрх, хичээлийн саналууд, "DE" элсэлтээр авсан чанарын оноо, кредит шилжүүлэх боломжтой эсэх талаар өөрийн зөвлөхөөс асууна уу. "DE" хичээлд суух сурагчид тухайн газраас коллежийн хуулбар авна. Элсэж оруулах шалгалт, өөр элсэлтэд хамрагдах боломжууд, хаврын шалгалтуудын огноо, байршлыг дараах онлайн линкээр орж үзнэ үү www.apsva.us/dualenrollment .

.

**Сургалтын стандарт Үнэлгээ**

Виржиниагийн сургалтын стандарт (SOLs) дээр суурилсан сургалтын стандартыг шалгалтыг муж даяар мөрддөг. Үнэлгээ Сургууль төгсөхөд. Бүх сурагчид SOL-ын шалгалтыг хичээлийн жилийн эцэст өгдөг. 3, 4, 5, 6, 7, 8-р ангиудад анги төгсөхдөө бүх сурагч SOL-ын шалгалтыг өгнө. Түүнчлэн, дараах урсуудад элссэн бүх оюутнууд кредитийн шалгуур эсвэл холбооны хариуцлагыг баталгаажуулах шаардлагатай бол сургалтын төгсгөлд SOL үнэлгээ өгөх боломжтой.

| | |
|---|---|
| Англи хэл 11: Унших | Алгебр I |
| Англи хэл 11: Бичих | Геометр |
| Манай эриний 1500 он хүртэлх Дэлхийн түүх | Алгебр II |
| Манай эриний 1500 оноос хойших | Дэлхийн түүх |
| Дэлхийн газар зүй | Биологи |
| АНУ-ын түүх | Хими |

2018-19 он болон түүнээс хойш есдүгээр ангид элссэн бүх сурагчид хичээлийн төгсгөлийн [End-of-Course (EOC)] таван шалгалт өгч байж стандарт эсхүл ахисан түвшний диплом авна. Дээрхийг үзнэ үү. Диплом авах шалгалтад тэнцэх ёстой сурагч эдгээр шалгалтуудын аль нэгт тэнцээгүй бол дахин шалгалт өгөх боломж тэдэнд олгоно. Шалгалт өгөх боломжийг 1, 6, 8-р саруудад олгоно.

Виржиниагийн сургалтын стандартын шаардлагууд

9-р анги
- Бүх оюутнууд төгсгөлтийн математикийн сургалтын стандартын шалгалтыг өгөх ёстой (Хэрэв ЭЕШ-ын шалгалттай математикийн курст бүртгүүлсэн бол)
- Бүх сурагчид хичээлийн төгсгөлд Байгаль шинжлэлийн сургалтын стандартын шалгалтыг өгөх ёстой (Биологи эсхүл Байгаль шинжлэл хичээлийн төгсгөлд).

10-р анги

- Дараахаас БУСАД тохиолдолд сургалтын стандартын шалгалт авах шаардлагагүй:
    - Сурагч математик, шинжлэх ухаан, түүхийн хичээлийн баталгаажсан кредит авах шаардлагатай бол
    - Сурагч Биологийн хичээл аваагүй бол

11-р анги

- Бүх сурагчид хичээлийн төгсгөлд Унших, бичих сургалтын стандартын шалгалтыг өгөх ёстой.
- Математик, шинжлэх ухаан, түүхийн хичээлд баталгаажсан кредит (Сургалтын стандартын шалгалтад 400 ба түүнээс дээш оноо) аваагүй сурагчид

12-р анги

- Нэг эсхүл хэд хэдэн салбар хичээлд баталгаажсан кредит (Сургалтын стандартын шалгалтад 400 ба түүнээс дээш оноо) авах ёстой сурагчид зөвхөн

Виржиниагийн Боловсролын Зөвлөл баталгаажсан кредитээр тооцуулах боломжтой шалгалтууд болон хасалтуудын жагсаалтыг баталж гаргасан. Орлуулах тестүүдийн жагсаалтыг https://www.doe.virginia.gov/teaching-learning-assessment/student-assessment/virginia-sol-assessment-program/substitute-tests-for-verified-credithttps:/ хаягаас авах боломжтой. /www.doe.virginia.gov/teaching-learning-assessment/student-assessment/virginia-sol-assessment-program/subtitute-tests-for-verified-credit.

Хэрэв тухайн сурагч хичээлийг дүүргэсэн бол Хичээлийн төгсгөлийн шалгалтдаа тэнцээгүйтэй холбоотой гомдлыг гаргах боломжтой. Энэ нь сурагч төгсөхөд баталгаажсан кредит хэрэгтэй үед үйлчилнэ. Гомдол гаргахад холбогдох мэдээллийг Зөвлөх үйлчилгээний газраас авч болно.

**Шалгалтын дүн**

Сурагчдын өгсөн шалгалтын дүнг шалгалтууд дуусахад эцэг эх рүү нь ParentVUE Порталаар илгээж эсвэл шуудангаар хүргүүлнэ. Ахисан шатны түвшинд орох шалгалтын дүнг зөвхөн сурагчид өөрт нь илгээнэ. Арлингтоны сургуулиудын ерөнхий дүнг APS цахим хуудаснаа нийтэлнэ: http://www.apsva.us.

**Дэмжих, хадгалах**

*Бодлого 1-11.6.30 Төгсөх, анги дэвших, улирах*

**Анги дэвших:**

Анги дэвших нь бага, дунд ахлах сургуулийн хичээл бүрд  анги бүрийн төгсөлтөд шаардагдах тухайн оюутны эзэмшсэн мэдлэг, ур чадварын ахиц дэвшилд үндэслэн түвшнийг тогтооно.

- сургуулийн системээр дамжуулан сурагчдын төгсөлтийн ахиц дэвшлийг тодорхойлдог
- суралцагчийн амжилтыг ангийн түвшин тогтоох шалгалттай уялдуулан авч үздэг
- APS-ийг төгсөхөд шаардагдах оюутны шаардлагыг тодорхойлдог

*8-р ангиасаа есдүгээр ангид дэвших- сурагч наймдугаар ангид математик, англи хэл, байгалийн ухаан, нийгмийн ухааны хичээлийг амжилттай дүүргэсэн байх ёстой.

**Улирах:**

Улирах эрсдэлтэй оюутнуудыг оноонны хоёрдугаар үе дуусахад тодорхойлно. Эцэг эх/асран хамгаалагчдад сурлагын хүндрэл, мөн авах арга хэмжээний талаар мэдэгдэнэ.

- Сурлагын өсөлт нь дараагийн ангид элсэх үндэслэлгүй тохиолдолд сурагчийг ангид нь улираана.
- Анги тус бүрээр тогтоосон дотоод зорилтуудтай уялдуулан сурлагын гүйцэтгэлд тулгуурлана.

- Дунд ангийн хувьд наймдугаар ангид математик, англи хэл, байгалийн ухаан, дэлхийн газарзүйн хичээлийг амжилттай дүүргэж чадаагүй сурагчдыг улираана.
- Ахлах сургуулийн түвшинд ахлах сургуулиа төгсөх шаардлага хангаагүй оюутнуудыг улираана.

**Хураамж**

Зарим хичээлд Арлингтоны улсын сургуулиас олгохгүй материалд холбогдож хураамж авна. Холбогдох хураамжийн тухай мэдээллийг хичээлийн тодорхойлолтод зааж өгсөн байдаг. Сурагч/гэр бүл хураамжийг төлөх боломжгүй бол хураамжийн хэмжээг багасгах, хураамжаас чөлөөлөх хүсэлтийг сургуульд гаргаж болно.

Ахлах сургуулийн зөвлөхөөс холбогдох мэдээллийг авна уу.

## Сурагчид зориулсан үйлчилгээ

**Гэрээр хичээллэх заавар**

Биеийн ба/эсхүл сэтгэлзүйн эрүүл мэндийн шаардлагаар хичээлд хязгаартай хугацаанд явах боломжтой сурагчдад зориулан анги болон гэр буюу эмнэлгийн үйлчилгээний газар хоёрыг холбож сургалтыг үргэлжлүүлэхийн тулд гэрээр хичээллэнэ. Эрүүл мэндийн шалтгаанаар (жишээ нь сурагч нь диализ эсхүл туяаны/химийн эмчилгээ хийлгэж байгаа; өөр бусад эрүүл мэндийн асуудалтай сурагчид) сургуульд өдөр бүр явах боломжгүй сурагчдад хичээл нөхөх зорилгоор мөн гэрээр хичээллэх заавар өгнө. Гэрээр хичээллэх заавар авах өргөдөл гаргах талаар APS-ийн веб хуудаст мэдээлэл бий: https://www.apsva.us/homebound-instruction . Өргөдлийг мөн сургуулиас авч болно. Өргөдлийг сурагчийн сургуульд хянуулахаар өгсний дараагаар Тусгай боловсролын газрын зааварлагчид зөвшөөрөл авахаар хүргүүлнэ. Хувь хүнд тусгайлан зориулсан хөтөлбөрийн [Individual Education Programs (IEP)] сурагчид холбогдож IEP-ийн уулзалтыг гэрээр хичээллэх зааврыг зөвшөөрсний дараа үзүүлэх үйлчилгээний түвшин тодорхойлохын тулд хийнэ. Гэрээр хичээллэх зааварт хамрагдах эсэхийг есөн долоо хоног тутамд дахин хянаж үзнэ.

**504-р хэсэг**

1973 оны Ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хуулийн 504-р хэсгийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг холбооны улсын санхүүгийн дэмжлэгтэй аливаа нэг хөтөлбөрт ялгаварлан гадуурхахыг хориглодог. Арлингтоны улсын сургуулиуд нь боловсролд холбогдож ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхахаас сэргийлэх, алдааг засах бодлого баримталж, хөгжлийн бэрхшээлтэй сурагчид ийм бэрхшээлгүй сурагчидтай ижил байдлаар боловсрол олж авахыг хангадаг. 504-р зүйлийн дагуу (a) амьдралаа авч явахад нь ихээхэн нөлөөлөх биеийн эсхүл сэтгэл санааны (өөрийгөө авч явах, гар, хөл, хараа, сонсгол, хэл яриа, амьсгалын бэрхшээл, сурах эсхүл ажил хийх) бэрхшээлтэй, (b) ийм бэрхшээлтэй гэдэг талаар баримт нотолгоотой эсхүл (c) ийм бэрхшээлтэй гэж үзсэн хүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үзнэ. Хөгжлийн бэрхшээл, амьдралын голлох үйлдлийн жагсаалт нь нээлттэй жагсаалт юм. Мөн “ихээхэн хязгаартай” гэдгийг хэт нарийн тодорхойлж, ойлгож болохгүй.

Арлингтоны улсын сургуулиас хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад чөлөөтэй бөгөөд өөрт нь тохирсон сургалтыг үнэлж, олгоно. Өөрийн хүүхдийг нь 504-р хэсгийн дагуу эрхтэй эсэх талаарх бүх уулзалтад эцэг эхийг урих ба тэднийг оролцохыг уриалж байна. Эцэг эхчүүд 504-р хэсэгтэй холбоотой асуулт, асуудлаа Зөвлөхүүдийн үйлчилгээний захирал эсхүл сургуулийн захиралд тавих хэрэгтэй. Эцэг эхчүүд сургуулийн дэмжлэгийн (Сурагчид холбогдох үйлчилгээний) газрын 504-ийг хангуулах ажилтанд 703-228-6061 утсаар хандаж эрхтэй эсэх талаар шийдвэрт гомдол гаргаж болно.

## НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Сургуулийн номын сан сургуулийн заах болон суралцах үйл явцын гол цөм нь байна. Номын санч нь бүх сурагчдын оюуны, сэтгэл санааны, нийгмийн хөгжлийг хангах бие даан унших, суралцах хэвлэмэл болон дижитал нөөцийг бүрдүүлдэг. Сурагчдад шүүмжит болон бүтээлч сэтгэлгээ, харилцаа болон хамтран ажиллах ур чадварыг заах бөгөөд ингэснээр тэд амьдралынхаа туршид мэдээлэл амжилттай ашиглагч, хэрэглэгчид болох юм. Сургууль болон гэрээсээ нэвтэрч болох орчин үеийн цуглуулгыг номын санч бүрдүүлнэ. Цуглуулга нь сургалтын болон хүүхдийн хөгжлийн шаардлага төдийгүй бүх сурагчдын нийгэм, соёлын байдал, яс үндэсний ялгааг бодолцсон байна.

Сургуулийн номын санч сурагчдад төрөл бүрийн хичээлийн агуулгын хүрээнд тухайн агуулгын хичээлийн багш нартай хамтран, суралцах төрөл бүрийн арга хэлбэрт тохирсон мэдээлэл олох, тэдгээрийг дүгнэх, нийцүүлэн ашиглах зэргийг заана. Сурагчид мэдээлэл олох, зохион байгуулалтад оруулах, баримтжуулах, шинжлэх, дүгнэх, боловсруулах, танилцуулахын тулд номын сангийн хэвлэмэл болон дижитал материалыг ашиглана. Сурагчид мэдээллийг зохистой ашиглахдаа мөн Хүлээн зөвшөөрсөн хэрэглээний журмыг мөрдөнө. Номын санч мөн түүнчлэн ажилтнуудтай хамтран ажиллаж сургалтын хөтөлбөр болон тусгай хөтөлбөр боловсруулна. Сургуулийн номын сан уртасгасан цагаар ажиллаж, суралцах боломжийг нэмэгдүүлнэ.
Сурагчид болон тэдний гэр бүл сургуульд болон гэртээ сургуулийн номын сангийн цахим хуудсаар болон Canvas дахь номын сангийн үйлчилгээний эх сурвалжаар дамжуулан номын сангийн нөөцийг ашиглахыг уриалж байна.

## СОНГОХ ХӨТӨЛБӨРҮҮД

**H-B Woodlawn дунд сургуулийн хөтөлбөр**

H-B Woodlawn дунд сургуулийн хөтөлбөр нь дөрвөн тулганы чулуунаас бүрдэнэ: орчин нутагтаа анхаарах, бие даасан засаглал, тэгш байдал, өөрийн хүслээр суралцах. Сурагчид өөрсдөө удирдсан хурлууд, сурагчдын өөрсдийн сонголт, клубүүд болон сурагчид, багш нар, эцэг эхчүүд тэгш саналын эрхтэй оролцох долоо хоног тутмын Хотын уулзалтуудаар бүх сурагчдыг хөгжүүлэх, тэднийг сурлагын зорилгод нь хүргэхийн төлөө бүгд хамтран ажиллаж нэгэн хамт олныг бүрдүүлнэ.

H-B Woodlawn-ийн дунд сургуулийн сонгох хөтөлбөрийн гол цөм нь сурагчийн өөрийн сонголт байх болно. Сурагчид өөрсдийн үүргийг хэрхэн ухаалаг биелүүлэх талаар өөрсдөө шийдэх ёстой. Бие даалтын цаг 6-р ангиас 12-р анги хүртэл аажмаар нэмэгдэнэ. Энэхүү чөлөөтэйгөөр ажиллуулахын тулд сургууль өөрсдийн сурагчдын сайн санаа, чармайлтад итгэх бөгөөд тэдэнд хувийн хариуцлагыг зааж сургах болно. 1971 онд “зөвлөх л хангалттай” гэж сургуулийн хариуцлагатай, эрх чөлөөтэй нэгдлийн уриаг сонгосон байдаг.

Сурагч бүр янз бүрийн түвшний бие даах чадвар, идэвх санаачилгатайгаар H-B Woodlawn хөтөлбөрт орж ирдэг. Сургуулиас нэгж сурагч, жижиг бүлэг, ангийн түвшинд гэсэн байдлаар ажиллаж тэдэнд өөрийн сургалтын хөтөлбөрөө илүү ихээр өөрсдөө хянах боломжийг нэмэгдүүлж өгдөг. H-B Woodlawn нь мөн Багш-зөвлөхүүдийн хөтөлбөрөөрөө сурагч бүрд тулгарч буй асуудлыг анхаарч үздэг. Багш-зөвлөхийн хөтөлбөр нь сурагч бүр нэг насанд хүрэгчтэй холбоотой байж, бүх гэр бүлүүд нэг тодорхой хүнтэй холбогдох боломжийг бүрдүүлдэг. Багш, багш-зөвлөх нар сурагч бүр өөрсдийн хичээл сурлага, нийгмийн харилцаандаа амжилттай байж хэрэгцээ шаардлагаа хангах талаар гэр бүлүүдтэй хамтарч ажилладаг.

Бид гишүүд бүрээ үнэлж хүндэтгэсэн хамт олны дунд байж, суралцаж, өөрсдийн сонирхол, чадварыг хэрсүү, бодитойгоор ойлгож ахлах сургуулийн дараах амьдралд бэлтгэх боломжийг H-B Woodlawn-ийн төгсөгчдөд олгох зорилготой бөгөөд чингэхдээ суурь хүмүүжлийг онцгойлон анхаардаг.

**Шилжилтийн насны эцэг эхчүүдийн хөтөлбөр**

Шилжилтийн насны эцэг эхчүүдийн хөтөлбөрийг жирэмсэн, хүүхэдтэй Арлингтон каунтигийн шилжилтийн насныхны онцгой

Шилжилтийн насны эцэг эхчүүдийн хөтөлбөрийг жирэмсэн, хүүхэдтэй Арлингтон каунтигийн шилжилтийн насныхны онцгой хэрэгцээг анхаарч бий болгосон.

Хөтөлбөрөөр Карьерын төв, Арлингтоны дүүргийн ахлах сургууль, Langston, эсхүл гэрээр суралцахаар бүртгүүлсэн сурагчдад дэмжлэг үзүүлнэ. Хөтөлбөрөөр бие даан амьдрахад суралцаж буй шилжилтийн насны сурагчдын хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх халамжтай орчныг бүрдүүлэхийн тулд бүтээсэн. Үйлчилгээнд хүнсний дэмжлэг, орон байрны хэрэгцээ, санхүүгийн дэмжлэг, эрүүл мэндийн хэрэгцээг анхаарах ба шилжилтийн насныхны эрүүл мэнд, жирэмслэлт, хүүхэд хөхүүлэх зөвлөгөө, нялх хүүхэд арчлах, тэдний хүүхдүүдэд холбогдох эрүүл мэндийн эх үүсвэрүүдийг багтаана. Үйлчилгээнд аюулгүй байдлын хэрэгцээ, ажил эрхлэх чадварыг хөгжүүлэх, сурагчийн зорчих тээврийн хэрэгцээг анхаарна Хөтөлбөрөөр нийгэм сэтгэл санааны тайван байдал, эрүүл гэр бүл, харилцаанаас гадна бага насны хүүхэдтэй зөв харилцах, эцэг эх байх чадварыг нэмэгдүүлэхэд голчлон анхаарна. Хөтөлбөрөөр тухайн газарт тусгай зөвшөөрөлтэй Хүүхэд асрамжийн төв, нялх ба хөлд орж буй хүүхдийн тусламж, холбогдох хүмүүс, боловсролын дэмжлэгийг үзүүлнэ. Сурагчид сургуульд явж, сургуулиа төгсөхөд холбогдож хичээлийн дэмжлэг, тусламж авах болно. 703-228-5818, 5819 буюу 5767 утсаар мэдээлэл авна уу.

**Ахлах сургуулийг үргэлжлүүлэх хөтөлбөр**

**Langston** дахь Ахлах сургуулийг үргэлжлүүлэх хөтөлбөрөөр 16 ба түүнээс дээш насны сурагчдад жижиг бүлгийн, тусгайлсан дэмжлэгтэй орчинд ахлах сургуулийн кредит авах боломжийг санал болгодог. Манай жижиг хүрээний орчин ахлах сургуулийн диплом авах эрмэлзэлтэй сурагчдад тусгайлсан дэмжлэгийг авах боломж олгоно. Сурагчид олон шалтгааны улмаас хөтөлбөрт хамрагдах сонголт хийх боломжтой. Хөтөлбөрөөр сурагчид нэг, хоёр, гурав буюу дөрвөн блок хичээлийг улирал бүрд авах боломжтой. Улиралд дөрвөн хичээл авснаар сурагчид жилд 8 кредит цуглуулж болно. Үүний дээр сурагчид зэрэгцээ элсэлт, онлайн сургалт, NOVA-ийн давхар кредиттэй төгсөлтийн кредитийг авч болно. Сурагчид мөн Карьерын төвд хичээлд сууж, гэрээсээ сургуулийн үйл ажиллагаанд оролцож болно.

**Арлингтоны карьерын төвийн Арлингтон Тех Карьерын төв**

**Арлингтоны карьерын төвийн Арлингтон Тех**

“Arlington Tech” нь төсөлд суурилсан эрчимжүүлэх сургалтын хөтөлбөр ба сурагчдыг коллеж, ажлын байранд бусадтай хамтран ажиллахад бэлтгэдэг. Сурагчид өөрсдийн хичээл сурлагын мэдлэгийг Карьер, техникийн боловсролын [Career Technical Education (CTE)] хичээлүүдээр хөгжүүлэх чадвартай хослуулж, бодит амьдралын асуудлыг шийдэж, нутаг усандаа үйлчилгээ үзүүлэх талаар суралцана.

Arlington Tech нь сурагчдад олон төрлийн CTE салбарт гэрчилгээ авах, Norther Virginia Community College-ийн давхар кредиттэй сургалтад хамрагдаж Коллежийн эхэн үеийн кредит авч коллежийг товчлох боломжийг олгоно. Төсөлд суурилсан цогц сургалт болохын хувьд Arlington Tech-ийн сурагчид нэг жилийн турш үргэлжлэх төгсөх ангийн сурагчийн ажил хийх ба үүний хүрээнд тэд дадлагажигч, зөвлөх, хараат бус судлаачаар ажиллана. Arlington Tech-д суралцана гэдэг нь идэвхтэй (судалж, асууж), бодитой (тодорхой төслүүдээр), сурагчийн өөрийн сонирхлыг дагасан байна гэсэн үг юм.

Элсэх хүсэлт гаргах цаг хугацаа нь шилжилтийн хүсэлт гаргах үйл явцтай давхацна.

Карьерын төвийн хөтөлбөртэй холбоотой нэмэлт мэдээллийг 76-р хуудаснаас үзнэ үү.

**Олон улсын бакалаврын хөтөлбөр**

IB хөтөлбөр гэж нийтээр нэрлэдэг Олон улсын бакалаврын хөтөлбөр нь Washington-Liberty High School-д буй өндөр идэвхтэй коллежид орох 11, 12-р ангийн сурагчдын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр юм. Арлингтоны сурагч бүр сургуулийн системийн сонголтуудад холбогдох бодлого, журмын дагуу хөтөлбөрт орох өргөдлөө гаргаж болно. Энэхүү нь академик хичээлийн бүтэцтэй эрчимтэй, сурагчдыг дайчлах хөтөлбөр юм. IB хөтөлбөр нь сурагчийн оюуны, философийн, нийгмийн харилцааны хөгжлийг хангах цогц боловсролын үзэл санаанаас бүрддэг.

IB хөтөлбөр нь олон янзын хичээлийг багтаасан хоёр жилийн хөтөлбөр юм. Хөтөлбөрийн бүрдэл зүйл нь янз бүрийн салбарын зургаан хичээлийг амжилттай дүүргэх, салбар хичээл бүрд нэг гаднаас авах шалгалтыг өгөх, CAS (бүтээлч байдал, үйл ажиллагаа, үйлчилгээ)-д оролцох, тусгайлсан Мэдлэгийн онол хичээлд суух болон сурагч өөрийн сонирхсон салбарт бие даасан судалгааны ажил бичиж, өгөх юм. Сурагчид IB-ийн бүрэн диплом авахгүйгээр зарим IB-ийн хичээлийг сонгож болно. Ахисан түвшний сургалтын дипломд тавигдах шаардлагыг 6-р хуудаснаас үзнэ үү. IB хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гэр бүлүүд 703-228-6234 хаягаар авна уу.

**Ахлах сургуулийн "New Directions" хөтөлбөр**

Ахлах сургуулийн "New Directions" хөтөлбөрөөр 14 ба түүнээс дээш насны илүү дэмжлэг авах шаардлагатай сурагчдад жижиг, дэмжих орчинд сургалтын болон карьерын боломжийг олгоно. Хөтөлбөрөөр сурагчдад ахлах сургууль төгсөх кредит авах боломжийг олгож, хичээлд нь системтэйгээр дэмжих юм. Хөтөлбөрийн ажилчид сурагч ахиц гаргах, амжилт гаргахын тулд гэр бүлээрээ хамтарч ажиллах, сурагчийг нийгэмд тустай нэгэн гишүүн болгох боломжийг олгосон хичээлийн, зан харилцааны, ар гэрийн дэмжлэг сурагчид өгөхийн төлөө байна. Ажилчид амжилт авчрах боломжийг нэмэгдүүлэхийн тулд холбогдох бүх талуудтай ойр дотно ажиллана.

## НЭМЭЛТ СУРГАЛТ ӨГӨХ СОНГОЛТ

**Цахим хичээлүүд**

Хичээлийн 2013-14 оны жилээс эхэлж 9-р ангид орж буй сурагчид Виржиниагийн журмын дагуу нэг цахим хичээлийг амжилттай дүүргэх ёстой байдаг. Хичээл нь кредитгүй байж болох ба үүнд баталгаажуулах, сайжруулах хичээлүүд багтаж болох ба зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй.

Сурагчид сургуулиас гадуурх байгууллагуудаас санал болгож буй хичээлүүдийг авах боломжтой. Сурагчид сургуулийн зөвлөхтэй эхэлж ярилцсаныхаа дараа аливаа хичээлд бүртгүүлэх хэрэгтэй гэдгийг энд тэмдэглэх нь чухал юм. Энэ шаардлагыг хангаагүй бол хичээлийг дүүргэсэнтэй холбоотой ахлах сургуулийн кредит өгөхгүй байж болно. Бодлого хэрэгжүүлэх журмын I-7.2.8 PIP 2-д Цахим хичээл хийх/сонголтуудад холбогдож дараахыг заасан:

**<u>Цахим хичээлд зөвшөөрөл олгох шалгуур</u>**

Сургууль төгсөх шаардлагыг хангах эсвэл анги дэвших онооны дунджид багтааж тооцох аливаа цахим хичээл нь нэг бол:

1. Арлингтоны улсын сургуулийн Сургалтын хөтөлбөрт цахим орчинд заах хичээлийн жагсаалтад орсон байх, эсвэл
2. Арлингтоны улсын сургуулиас санал болгоогүй (эсвэл сурагчийн сурч буй сургуулиас зөвшөөрч, баталсан шалтгаанаар сурагч Арлингтоны улсын сургуулийн хичээлд суух боломжгүй) бол хичээл нь:
   a. Захирлаас эрх олгосон ажилтан урьдчилан зөвшөөрсөн.

b. Магадлан итгэмжлэгдсэн байгууллага эсхүл зөвшөөрөгдсөн үйлчилгээ үзүүлэгчийн Виржиниагийн боловсролын газрын шалгуурыг хангасан үйлчилгээ үзүүлэгч.
c. Холбогдох тохиолдолд Виржиниагийн Сургалтын стандартад нийцүүлсэн;
d. Аливаа суралцагч ашиглах боломжтой бөгөөд Арлингтоны улсын сургуулиудын хичээлийн эрчимт байдалтай дүйцэх зохих ангийн түвшин, агуулгатай харьцуулж болохуйц,
e. Цэцэрлэгээс 12-р анги хүртэлх цахим сургалтын олон улсын холбооны [the International Association for K-12 Online Learning (iNACOL)] сайн туршлагын стандартыг хангасан.

Хичээлийн сонголтын талаар сургуулийн зөвлөхтэй сурагч, эцэг эхчүүд ярилцах хэрэгтэй. Хичээлийн сонголтын талаарх Сургуулийн зөвлөлийн үзэл баримтлалын I-7.2.8-ын дагуу сургуулийн зөвлөхүүд сурагчийн хүсэлтээр урьдчилан зөвшөөрөл авах хүсэлт гаргана.

*Virtual@APS-аар дамжуулж, дунд сургуульд ахлах сургуулийн кредит авах хичээлийг амжилттай дүүргэсэн бол төгсөх шаардлагыг хангасан гэж үзэж болно. Өөрийн зөвлөхтэй уулзаж нэмэлт мэдээллийг авна уу.

**Энэ баримт бичигт буй хичээлийн танилцуулгыг холбогдох хэсгээс авна уу.**

**Virtual@APS-ийн талаарх нэмэлт мэдээлэл дараах хуудаст бий:**
***https://www.apsva.us/virtual-instruction/***

## ГОЦ АВЬЯАСТАЙ СУРАГЧДАД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХ СУРАГЧИД

Хамтран ажиллах багийн загвар нь гоц авьяастай сурагчдад үзүүлэх үйлчилгээг хүргэх загвар юм. Ахлах сургууль бүрд бүтэн цагаар ажиллах гоц авьяастай хүүхдийн харилцах багш (RTG) байна. Хамтран ажиллах багийн загварын хүрээнд RTG болон багш нар янз бүрийн арга замаар өдөр тутмыг тогтмол төлөвлөнө: гоц авьяастай сурагчдад зориулсан бичмэл эрх сурвалжийн дагуу хичээллэх; илүү эрчимжүүлсэн, гүнзгийрүүлсэн болон хүндрүүлсэн хэлбэрээр шүүмжит болон бүтээлч сэтгэлгээний стратегиудыг ашиглах; урьдчилсан шалгалт авах болон сургалтын хөтөлбөрийг шахах замаар ялгамжтай хичээллэх, уян хатнаар багт хуваах, сурагчийн сонирхол, сонголтыг сонсох, ялгавартай шат дараатай даалгавар өгөх, төсөл болон төсөлд суурилсан суралцах арга зам, хувь хүнд тохируулсан суралцах арга барил, бие даасан судалгаа ба/эсхүл судалгааны төслүүд.

Ахлах сургуульд хичээл сонгох замаар хичээлийг ялгамжтай заана. Хичээл болон урлагт авьяастай сурагчдад янз бүрийн ахисан шатны/эрчимжүүлсэн хичээл заах ба үүнд ахлах сургуулийн IB хөтөлбөр, бүх дөрвөн дунд сургуульд санал болгож буй AT хичээлүүд багтана. Үүний дээр сурагчид кредит авахаар бие даан сурах ба/эсхүл коллежийн хичээлд давхар сууж болно. Сурагчид Карьерын төвд ахисан түвшний техник мэргэжлийн хичээлд сууж болно. APS нь болзол хангасан сурагчдад Засаг даргын нутаг дэвсгэрийн хичээлийн жилд оролцох бүрэн тэтгэлэг олгоно (Thomas Jefferson High School for Science and Technology).

Авьяаслаг хүүхдийн үйлчилгээнд хамрагдаагүй явж ирсэн, ахисан түвшний хичээл аваагүй явж ирсэн сурагчдад RTG-ээс мэргэшүүлсэн семинар, хичээлийн ба нийгмийн харилцааны дэмжлэг өгч болно. Сурагчийн сонирхлыг дэмжих “Summer Residential Governor’s School program”, “PRIME” болон бусад зуны хөтөлбөрүүдэд оролцох өргөдөл хүсэлт гаргахад RTG нар мөн харилцагч, дэмжигч болж ажиллана.

Эцэг эхийн мэдээллийн үдэш, каунти даяарх арга хэмжээнд оролцох, Naviance, Canvas, listservs буюу Twitter зэрэг нийгмийн сүлжээг ашиглаж гэр бүлүүдэд шинэ мэдээлэл, зарлалыг илгээх зэргээр RTG бүр гэр бүлүүдэд мэдээлэл хүргэх янз бүрийн арга замуудыг хэрэглэдэг.

**Цэцэрлэгээс 12-р анги хүртэлх каунти даяарх боломжууд**

Академик хичээл, урлагт авьяастай гэж тооцогдсон сурагчдад зориулж каунти даяар арга хэмжээ зохион байгуулагдаг. Эдгээр нь сургуулийн хичээлд суурилсан арга хэмжээг цааш үргэлжлүүлэх ба сурагчийн сонирхолд нийцүүлэх зорилготой. Боломжуудад дараах багтана:

Академик арга хэмжээ:

- Карьерын төвөөс санал болгож буй хичээлүүд (4–12)
- Авьяастнуудад зориулсан нутгийн Засаг даргын сургууль—Thomas Jefferson High School for Science & Technology (9–12)
- Сонгох кредиттэй бие даасан сургалт(10–12)
- P.R.I.M.E. (Professionally Related Internship/Mentorship Experience [Мэргэжилтэй холбоотой дадлага/менторын арга хэмжээ]) (11, 12-р ангид орох)
- Академик сургалт/Менторын Засаг даргын зуны сургууль (11, 12-р ангийн)
- Гадаад хэлний академиудын Засаг даргын зуны сургууль (11, 12-р ангид орох)
- Захирлын зуны семинар (11, 12-р ангид орох)

Урлаг:

- Уран зургийн дадлагын хөтөлбөр (10–12-р анги)
- Сонгох кредиттэй бие даасан сургалт (10–12-р анги)
- Уран зураг, баримтал болон тайзны урлагийн Засаг даргын зуны сургууль (11, 12-р ангид орох)
- Захирлын зуны семинар (11, 12-р ангид орох)
- “Reflections Contest” (Цэцэрлэгээс–12-р анги), “Scholastic Arts Awards” (9–12 анги), эсхүл “District XII” гоцлол/хамтлагийн уралдаан (7–12 анги) гэх мэт урлагийн нутгийн, мужийн, үндэсний уралдаанууд.

## ARLINGTON COMMUNITY*, WAKEFIELD, WASHINGTON-LIBERTY, YORKTOWN-Д ХИЧЭЭЛИЙГ САНАЛ БОЛГОН

***Arlington Community-аас энэ хичээлүүдийг сурагчийн хувийн шаардлагаас шалтгаалж дэд сэдвээр санал болгодог. Хуваарь авахын тулд сургуулийн зөвлөхтэй холбогдоно уу**

## УРЛАГИЙН БОЛОВСРОЛ

Ахлах сургуулийн Урлагийн боловсролын хөтөлбөрөөр сурагчдад хөгжим, дүрслэх урлаг, театрын урлагийн хичээлийг үе шаттайгаар авах боломжийг олгодог. Урлагийн бүх салбарт ерөнхий туршлага мэдлэгээс гадна өндөр хэмжээний бөгөөд мэргэшсэн сургалтад суух боломжийг бий болгоно. Уран бүтээл хийх хувь хүний чадварыг цаашид хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техник ажиллагааны чадварын дадлагыг сурагчдаар хийлгэнэ. Энэ хичээлүүдийн аль нэгээр нь олж авсан кредит нь Ахуйн/Сонгомол урлагийн кредитийн шаардлагыг хангана.

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**<u>Дуу хөгжим</u>**

**Бэсрэг хоор (29252)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Хоорт дуулсан өмнөх туршлага болон хоорын удирдагчийн шалгаруулалт*
Хоорын цөөхүүл чуулгаар өндөр хэмжээний болон илүү хөгжсөн тоглогчдод эрчимжүүлсэн хөгжмийн дадлага хийх боломжийг өгнө. Суралцах зүйл нь ахисан түвшинд байх ба янз бүрийн төрөл, жанрыг хамарна. Давтлагад хоолойн дасгал, хөгжмийн түүх, хараагаар унших өргөн хүрээний дасгал багтана. Олон тооны сургуулийн тоглолт болон аялан тоглолтод оролцох шаардлага тавина.

**Концертын хоор (29260)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр хөгжмийн мэдрэмж, хоолой зөв гаргахыг хөгжүүлж, чуулгад дуулах, хараагаар уншихыг дадлагажуулна. Поп, шашин, сүмийн хөгжмийг багтааж янз бүрийн стиль, цаг үеийн хөгжмийн өргөн сонголтыг өгнө. Сурагчид бүх тоглолтод оролцох шаардлагатай.

**Ахисан түвшний хоор (29289)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Өмнө сургуулийн эсхүл нийгэмлэгийн хоорт байсан бол сайн боловч үүнийг заавал шаардахгүй. Шалгалт ба/эсхүл захирлын зөвшөөрөл шаардлагатай.*
Дунд зэргийн болон ахисан түвшний шашны болон поп хөгжмийг багтааж, янз бүрийн стилийн хоорын дууг давтаж, дуулах болно. Хараагаар унших, хоолой барих, хоолойн техникийн ахисан түвшний сургалт ба хөгжмийн суурь онолын мэдлэгийг өгнө. Сургуулийн тоглолт, нутгийн тоглолтууд болон дүүргийн баяр ба бусад шаардлагатай тоглолтууд орно. Тоглолтод оролцохыг шаардана.

**Трэбл хоор (29263)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Хичээлээр нэн ялангуяа сопрано, алто хоолойн хөгжмийн мэдрэмж, хоолой барихыг хөгжүүлэх зорилготой. Сопрано, алто хоолойн хоорын дуу дуулах, чуулга, хараагаар унших туршлага, чадварыг үл харгалзан бүх сурагчдад нээлттэй. Трэбл дуулах дадал, хоорын өнгийг хөгжүүлэхэд онцгой анхаарах болно. Янз бүрийн хөгжим тоглох болно. Поп, шашин, сүмийн хөгжмийг багтааж янз бүрийн стиль, цаг үеийн хөгжим. Сурагчид бүх тоглолтод оролцох шаардлагатай.

**Басс хоор (29266)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Хичээлээр нэн ялангуяа эрэгтэй хоолойн хөгжмийн мэдрэмж, хоолой барихыг хөгжүүлэх зорилготой. Туршлага, чадварыг үл харгалзан хөвгүүд, залуучуудад нээлттэй бөгөөд тэдэнд эрэгтэй хоорын дуу, чуулгад дуулах, хараагаар унших эрэгтэй хоорын ертөнцтэй танилцах боломжийг олгоно: Хоолой өөрчлөх, дуулах дадал, хоорын өнгийг хөгжүүлэхэд онцгой анхаарах болно. Поп, шашин, сүмийн хөгжмийг багтааж янз бүрийн стиль, цаг үеийн хөгжмийн өргөн сонголтыг өгөх болно. Сурагчид бүх тоглолтод оролцох шаардлагатай.

**Дунд шатны хамтлаг (29233)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Хамтлагийн удирдагчаас зөвшөөрөл авах эсхүл шалгалтаар*
Дунд шатны сургалтад орчин үеийн концертын хамтлагийн үлээвэр, цохивор хөгжмийн (сургуульд явсан/хувиараа хичээл авсан) туршлагатай сурагч бүр элсэж болно. Сургалтаар дунд зэргийн хүнд бөгөөд янз бүрийн төрлийн хөгжмийг тоглох суурь чадварыг цааш хөгжүүлнэ. Хараагаар унших, хөгжмийн түүхийг мөн танилцуулна. Хөгжимт жагсаал, хамтлагийн удирдагчаас гаргасан хуваарийн дагуух тоглолтод оролцох шаардлага тавина. Сургуулийн эзэмшлийн цөөн тооны хөгжмөөс түрээслэн хэрэглэх боломжтой.

**Ахисан шатны хамтлаг (29234)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Хамтлагийн өмнөх туршлага болон хамтлагийн удирдагчийн шалгаруулалт*
Ахисан түвшний хамтлаг хамтлагийн удирдагчийн зааж өгсөн дунд зэргийн хэцүү симфони найрал хөгжмийг давтаж, тоглоно. Сургууль, орон нутгийн арга хэмжээ, концерт, дүүргийн баяр, боломжит хамтлагийн аялан тоглолт, хөл бөмбөгийн тоглолтын бэлтгэлийн жагсаал, парад зэрэг олон нийтийн тоглолт багтаж болно. Хөгжимт жагсаал энэ хичээлийн үргэлжлэл байна. Удирдагчийн шийдвэрээр тоглолтод оролцох болон бусад хамтлагийн үйл ажиллагаанд оролцох шаардлага тавина.

**Хөгжимт жагсаалын хамтлаг (29254)**
**Хагас жил, хагас кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
*Хичээлийн дараах цагаар Wakefield, Yorktown, and Washington-Liberty-д тогтмол цагаар байх шаардлагатай. Давтлага, тоглолтод оролцохыг шаардана.*
Сурагчид хөл бөмбөгийн тоглолтын хагас цагаар тоглолт үзүүлэх, алхах арга барилыг суралцана. Эгнээ барих, жагсалт, бүжгийн алхалт, богино үзүүлбэр хийхийг хөгжимчин, тоглогчийн хувиар заана. Жагсаалын хамтлаг дээр нэмж үзүүлбэрийн баг, савхтай эмэгтэйчүүдийн үзүүлбэр, далбаа, туг, тууз, торготой үзүүлбэрүүд багтаж болно. Тоглолтод оролцохыг шаардана.

**Чуулга (29250)**
**Хагас жил, хагас кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Хамтлаг, чуулга, хоорын удирдагчийн зөвшөөрөл эсхүл шалгалт*
Жишээ нь жааз хөгжмийн чуулга, гурвал, дөрвөл, туг зэрэг хэрэглүүрт үзүүлбэрийн, үлээвэр, чавхдаст, гуулин, цохивор хөгжмийн, дууны чуулгын давтлагыг хичээлийн дараа эсхүл орой тогтмол хийх хуваарь гаргана. Оролцох шаардлагатай.

**Төгөлдөр хуур (29200)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Улирлаар судлах уг хичээлээр сурагчдад төгөлдөр хуурын үндсэн ур чадваруудыг заана. Сурагчид хөгжим тоглох анхан шатны түвшний SOL-ыг хангахын зэрэгцээ цөөн хэдэн өөр стандартуудыг мөн хангана. Сурагчдаас төгөлдөр хуур эсхүл даралтат хөгжим авахыг шаардахгүй. Сургуулиас цахилгаан даралтат хөгжим өгөх бөгөөд энэ нь сургуульдаа үлдэнэ.
Сурагчид:
- Төгөлдөр хуурын үндсэн ур чадварт суралцана.
- Хялбар ая, аялгуу уншиж, тоглож сурна.
- Хөгжмийн нот, тэмдэглэгээ уншиж, тоглож сурна.
- Хэд хэдэн төрлийн ритмийг ялгаж, тоглож сурна.
- Гишгүүр ашиглах үндсэн техникт суралцана.

**Чавхдаст хөгжмийн чуулга (29244)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Чавхдаст хөгжим өмнө тоглож байсан туршлага болон чуулгын удирдагчийн зөвшөөрөл*
Сурагчид янз бүрийн аялгууг чавхдаст, цөөхүүл, студи, симфони хөгжмийн хэлбэрээр сонгодог, поп маягаар тоглож техникийн хувьд ч, мөн хөгжмийн хувьд ч өөрийгөө сорих болно. Сургууль, орон нутгийн арга хэмжээ, концерт, дүүргийн баярт олон нийтийн тоглолт хийх шаардлагатай. Оркестрын аялан тоглолтод явах боломж гарч магадгүй. Сургуулийн эзэмшлийн цөөн тооны хөгжмөөс түрээслэн хэрэглэх боломжтой.

**Цөөхүүл оркестр (29242)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Оркестрын туршлага эсхүл зааварлагчийн зөвшөөрөл*
Цөөхүүл оркестроор өндөр мэргэшиж, хөгжсөн тоглогчдод эрчимжүүлсэн оркестрын туршлага олгоно. Тоглох хөгжим ахисан төвшнийх байх ба янз бүрийн цаг үе, жанрыг хамарч, ерөнхийдөө хөгжмийн зохиолчийн эх бүтээл байна. Ахисан шатны хөгжмийн техникийн сургалт, ансамбль, хараагаар унших сургалтыг давтлагад багтаах ба мөн агуулгыг тодруулах түүх, онолыг мэдээллийг өгнө. Олон тооны сургуулийн тоглолт болон аялан тоглолтод оролцох шаардлага тавина.

**Гитар I (29245)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл анхлан болон дунд шатны гитар суралцагчдад зориулагдсан. Аргачлалын ном, хөгжмийн хэвлэмэл хуудас, гитарын чуулгын хөгжмийг хэрэглэж нот унших, аялгуу ба хөгийн бүтцийг заах ба янз бүрийн стилийн хөгжим тоглоно. Сургуулийн эзэмшлийн цөөн тооны хөгжмөөс түрээслэн хэрэглэх боломжтой. Энэ хичээлд сууж байгаа сурагчид зааварлагчийн зөвшөөрлөөр Гитарын чуулгад орох боломжтой байж болох юм.

**Ахисан түвшний гитар (29247)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Гитар I эсхүл зааварлагчийн зөвшөөрөл*
Энэ хичээл дунд болон ахисан шатны гитар суралцагчдад зориулагдсан. Аргачлалын ном, хөгжмийн хуудас, чуулгын хөгжмийг хэрэглэж нот унших, аялгуу ба хөгийн бүтэц, стиль сонголт, хөгжмийн зохиолыг гүнзгийрүүлэн сурна. Удирдагч, захирлын шийдвэрээр тоглолтод оролцох болон бусад хамтлагийн үйл ажиллагаанд оролцох шаардлага тавина.

**Жааз хөгжим/Чуулга (29251)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Сурагчдыг симфони эсхүл концертын хамтлагуудаас шалгаж авч оруулна*
Жааз хөгжмийн лаборатори/хамтлагаар студийн орчинд ахисан түвшний жааз тоглолтыг заана. Жааз, поп хөгжмийн чиглэлээр чуулгын хөгжим, хослол, хөгжимчний сэтгэлгээ, стильд голчлон анхаарна. Гоцлол хөгжим, импровизаци хийх болон нутгийн жааз хөгжмийн уран бүтээлчидтэй хамтарч тоглох боломж олгоно. Олон тооны сургуулийн тоглолт болон аялан тоглолтод оролцох шаардлага тавина.

**Жааз/Поп дууны лаборатори/чуулга (29280)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Хоорт урьд дуулж байсан ба хоорын удирдагчаас сургууль даяар авсан шалгаруулалт*
Жааз/поп хөгжмийн лаборатори/хамтлагаар студиогийн орчинд ахисан түвшний жааз/поп тоглолтыг заана. Жааз, поп хөгжмийн чиглэлээр чуулгын хөгжим, хослол, хөгжимчний сэтгэлгээ, стильд голчлон анхаарна. Гоцлол хөгжим, импровизаци хийх болон нутгийн жааз хөгжмийн уран бүтээлчидтэй хамтарч тоглох боломж олгоно. Олон тооны сургуулийн тоглолт болон аялан тоглолтод оролцох шаардлага тавина.

**Хөгжимд дурлах: Хөгжмийн жанр, соёлын хувь чанар (29222)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Хөгжимд дурлах гэдэг нь хөгжмийн талаарх танилцуулга хичээл юм. Сурагчид бүх төрлийн хөгжмийг илүү ихээр ойлгож, үнэлэх боломж олгох төрөл бүрийн хөгжмийн талаар мэдэж авна. Хөгжмийн суурь мэдлэгийг шалгах болон аялгуу, хэмнэл, зохицол, хэлбэр, өнгө гэсэн хөгжмийн үндсэн элементүүдээр хичээл эхэлнэ. Хичээлээр ерөнхий төдийгүй гүнзгийрүүлсэн байдлаар гол стилиүд, цаг үе, хөгжмийн урсгалыг судлах ба маш өргөн хүрээ, сонгодог, рок, поп, хип хоп, реп, регги хөгжмийн төрлийг хамарна. Текст нь янз бүрийн стилийг хамрах хэдий ч ойролцоогоор 1954 оноос өнөөг хүртэл хийсэн нийтийн голлох хөгжимд анхаарал тавина. Хичээлийн төгсгөлд сурагчид хөгжим хаанаас гаралтай (уг гарал, түүхийн хувьд), юу хийж байгаа (хөгжмийн хувьд), хэрхэн хийгдсэн (технологийн хувьд) талаар илүү их ойлголттой болно.

**Хөгжмийн онол, AT (39226)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Төгөлдөр хуур, дуулах эсвэл хөгжмийн зэмсгийн сайн үндэс суурьтай байх*
AT-ийн хөгжмийн түүхийн хичээл нь хурд, агуулгаараа коллежийн хөгжмийн түүхийн хичээлтэй ижил байх болно. Энэ хичээлээр сонсож байгаа хөгжмийг суурь материал, үйл явцаар нь таньж, ойлгож, тодорхойлж сурах сурагчдын чадварыг хөгжүүлэх болно. Хичээлээр сонсгол, харж дуулах давтлага хийхийн зэрэгцээ өргөн хүрээний анализ хийх, зохиох чадварыг багтаана. Холбогдох хөвчинд хоолой сонгож нийдэмжүүлэх, хоолой хорших суурийг бий болгох басс шугам бүтээх, басс тэмдэглэгээ зэрэг хийсвэр, зохиох сэтгэлгээг шаардсан ажиллагаануудыг багтаана. Хичээлээр сурагчдыг AT-ын хөгжмийн түүхийн шалгалтыг амжилттай өгөхөд бэлтгэнэ. *AT-ийн хөгжмийн түүхийн шалгалт өгөх сурагчид хичээлийн жилийн төгсгөлд AT шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй (29226).*

**Хөгжим бичих, цахим аудио, хөгжмийн түүх (29225)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Дуулах эсхүл хөгжим тоглох суурьтай байх хэрэгтэй*
Хөгжим бичих, цахим аудио, хөгжмийн түүх хичээлээр цахилгаан, акустик хөгжмийн орчинд хөгжмийн бүтцийг суралцана. Сурагчийн дууны чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ онолыг амьдралд

хэрэгжүүлэх, оригинал хөгжим зохиох сурагчийн чадварт анхаарал хандуулна. Сурагчид холих, цахим хөгжмийг өөрчлөх зэргээс гадна дуу, зохиол бичихийг сурна. Сурагчид хөгжим бүтээх суурийг суралцана; бичлэг хийх зөв техник; янз бүрийн жанр, орчинд цахим аудио хөгжмийн студи, зохиол бичих, тэмдэглэх программ хангамжийг хөгжим бичихэд хэрхэн ашиглах талаар.

__Дүрслэх урлаг__

**Урлаг I (29120)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид дизайн, асуудлыг бүтээлчээр шийдэх урлагийн зарчмуудыг хэрэглэж, дүрслэх, зурах, график, 3-D урлагийн хэлбэртэй танилцана. Урлагийн хичээлийн ажлуудыг сурагчид өөрсдийн ажил, бүтээлээ эргэж харах портфолиод үлдээнэ. Энэ хичээл нь Урлаг II, III ба Студио, АТ-ийн урьдчилсан нөхцөл.

**Урлаг II (29130)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Урлаг I эсвэл дүрслэх урлагийн хичээлийн зааварлагчийн зөвшөөрөл*
Энэ хичээл нь Урлаг I хичээлээр үзсэн концепц, арга барил дээр суурилна. Сурагчид дүрслэх, зурах, хэвлэх эх бэлтгэх, баримлын ахисан шатны арга барилуудыг сурна. Сурагчид голлох уран бүтээлчдийн ажлыг өөрийн ажилдаа холбож судалж, ажиллана.

**Урлаг III (29140)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Урлаг II эсвэл дүрслэх урлагийн хичээлийн зааварлагчийн зөвшөөрөл*
Энэ хичээл нь студи урлагийг сурах чин хүсэлтэй сурагчдад зориулагдсан. Сурагчид дүрслэх, зурах, график, баримтал зэргийг хамарсан бүтээл хийнэ. Ажлын чанар, бүтээлийн концепцэд анхаарах, санаагаа илэрхийлэхэд голчлон анхаарна.

**Урлаг, дизайн, АТ (39149)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Урлаг III ба/эсхүл багшийн зөвлөгөө*
АТ-ийн Студио урлаг нь урлагийн нухацтай хичээл бөгөөд сурагчид чанарын нэмэлт оноо авахын тулд бүтэн портфолио дүүргэж өгөх ёстой. Хичээлээр гурван гол зүйлийг анхаарах болно: сурагчийн ажлын өндөр чанар; тодорхой нэг дүрслэх маяг, асуудалд анхаарлаа хандуулах; бүтээл хийхдээ албан, техник, илэрхийллийн байдалд тодорхой туршлага олж авсан. Сурагчид албан болон концепцийн асуудлаар бүтээлч, системтэй суралцахад оролцож, урлагийн бүтээл хийнэ гэдэг нь оновчтой, бодитой шийдвэр гаргах үйл явц гэдгийг ойлгож, техникийн чадвар, дүрслэх урлагийн элементүүдийг мэдэж авах байдлаа сайжруулна.
*Сурагчид энэ хичээлд АТ-ийн портфолио өгөх ёстой. Портфолио өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (29149)*

**Урлагийн түүх, АТ (39151)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ танилцуулах коллежийн хичээлээр сурагчид урлагийн бүтээлийг түүхэн талаас нь ойлгож сурах ба холбогдох улс төр, шашин, ивээн тэтгэлэг, хүйс, зориулалт, яс үндэс зэрэг асуудлыг авч үзнэ. Хичээл мөн сурагчдад урлагийн бүтээлийг харж шинжлэхийг зааж өгнө. Хичээлээр уран барилга, баримал, уран зураг болон бусад хэлбэрүүдийг багтаана. Сурагчид харж байгаагаа үнэлж, эдгээр урлагийн бүтээлүүдэд шүүмжтэй, оюунлаг, мэдрэмжтэйгээр харахад суралцана. Хичээлээр сурагчдыг АТ-ын хөгжмийн түүхийн шалгалтыг амжилттай өгөхөд бэлтгэнэ. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой АТ-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (29151)*

**Керамик I (29167)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэхүү хичээлээр амьдралын хэрэглээний болон гоёл чимэглэлийн 3D шавар зүйлсийг хамарна. Сурагчид гараар, хүрдээр хийх янз бүрийн арга барилуудыг сурна. Хичээлээр сурагчид шавартай анх харилцаж сурах буюу илүү ахисан түвшний сурагчид өөрийн чадвараа цааш хөгжүүлэх болно. Сурагчдыг янз бүрийн өнгөлөлт, дуусгах арга барилд суралцах туршилт хийхэд чиглүүлэх болно. $55.00-ын лабораторийн хураамжийг шавар, өнгөлгөөнд авна. *Хураамжийг хөнгөлөх чөлөөлөх талаар 13-р хуудаснаас харна уу.*

**Керамик II (29168)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Керамик I эсхүл зааварлагчийн зөвшөөрөл*
Энэхүү хичээлээр амьдралын хэрэглээний болон гоёл чимэглэлийн 3D шавар урлагийг цааш үргэлжлүүлэн суралцана. Энэ хичээлээр сурагчид гараар, хүрдээр хэлбэржүүлэх чадвараа сайжруулна. Мөн 3D уран бүтээлчдэд шавар ямар

боломжуудыг бий болгодог талаар цаашид судална. Сурагчид бусад өнгөлөх, дуусгах, хатаах техникийг суралцана. Шавар урлагийн уран бүтээлчид, тэдний ажлыг мөн багтаана. $55.00-ын лабораторийн хураамжийг шавар, өнгөлгөөнд авна. *Хураамжийг хөнгөлөх чөлөөлөх талаар 13-р хуудаснаас харна уу.*

**Керамик III (29169)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Керамик II эсхүл зааварлагчийн зөвшөөрөл*
Энэ хичээл нь керамик урлагийг сурах чин хүсэлтэй сурагчдад зориулагдсан. Сурагчид Керамик I, II хичээлээр сурснаа гүнзгийрүүлж, илүү нарийн, өргөн хүрээнд ажиллана. $55.00-ын лабораторийн хураамжийг шавар, өнгөлгөөнд авна. *Хураамжийг хөнгөлөх чөлөөлөх талаар 13-р хуудаснаас харна уу.*

**Гар урлалтай танилцах нь (29160)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид Америкийн уугуул иргэд, Гуатималчууд, Мексик, Ази, Колоничлолын үеийн Америкийн соёл, стилиэр сав суулга хийж, нэхэж, гоёл чимэглэл, маск гэх мэтийг хийнэ.

**Гар урлал (29162)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэхүү бүтэн жилийн хичээлээр сурагчид уран бүтээлчийн дизайнтай хослуулж гар урлалын баялаг соёлыг суралцана. Шавар, утас, мод зэргийг багтааж олон соёлын жишээгээр бүтээл бүтээх болно. Гар урлалыг ухаалаг, чадвартай, уран бүтээлчээр бүтээхэд шаардлагатай мэдлэгийг суулгана. Дизайн, үзэмжийн элемент, зарчмууд, бичгийн ба/эсхүл аман шүүмж, гар урлалын өв зэргийг илүү анхаарч үзнэ.

**Уран зураг, дүрс зураг (29163)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид натюрморт, байгалийн зураг, модельтой, чөлөөтэй сэтгэн зурах гээд янз бүрийн сэдвээр дүрслэх, зурах суурь арга барилыг суралцана. Шугам, зай, хэмжээ, хольц, өнгийг хүлээж авах байдлаар, стиль тодорхойлох зэрэгт асуудлыг хандуулна. Янз бүрийн медиаг ашиглана. Тухайн медиа төрлийн голлох уран бүтээлчдийн бүтээлийг судална.

**Компьютерын график (29152)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид бүтээгдэхүүний имиж, лого дизайн, бүтээгдэхүүн үзүүлэх, түүх харуулах, хуудас, нийтлэлийн макет зэргийг багтааж худалдаа бизнесийн дизайн гаргахад бүтээлчээр ажиллах чадварт суралцана. Сурагчид компьютерын графикийг ажил хийж гүйцэтгэхэд ашиглана.

**Компьютерын график II (29153)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Компьютерын график I*
Сурагчид бүтээгдэхүүний имиж, брэнд, үзүүлэх, түүх, зураглал, хуудас, нийтлэлийн макет зэргийг багтааж худалдаа бизнесийн дизайн гаргахад бүтээлчээр ажиллах чадварт суралцана.

**Компьютерын график III (29154)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Компьютерын график I, II*
Энэ нь ахисан шатны компьютерын хичээл бөгөөд Компьютерын график I, II-оор үзсэн дижитал урлагийн чадварыг цааш гүнзгийрүүлнэ. Энэ хичээлээр сурагчид дижитал уран зураг, худалдаа бизнесийн зурагт анхаарлаа төвлөрүүлж дизайн бүтээнэ. Сурагчид ахисан түвшний дижитал урлагийн техникийг суралцаж, өөрийн сонгосон дижитал хэрэгслээр портфолио ажил бүтээх боломжийг судална. Энэ нь AT-ийн 2-D дижитал портфолиогийн сайн суурийг сурагчид тавих портфолио юм.

**Дижитал гэрэл зураг I (29193)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид гэрэл зургийг урлагийн бүтээл гэдэг талаас нь харж ажиллана. Тэд дан линзтэй зургийн аппаратыг ашиглаж сурах ба дижитал технологийг багтааж янз бүрийн хэвлэлийн процессыг хэрэглэнэ. Гэрэл зургийн түүх, дизайны элемент, зарчмууд, гэрэлтүүлэг, аппаратын ажиллагаа зэргийг сэдэвт багтаана. **$55.00-ын лабораторийн хураамжийг хэвлэлийн зардалд авна. Хураамжийг хөнгөлөх/чөлөөлөх талаар 13-р хуудаснаас харна уу. Сурагчид аль болох өөрийн аппаратыг авчрах хэрэгтэй бөгөөд өөрийн гэрэл зургийн цаасыг авчрах хэрэгтэй. Хэрэгцээ гарсан үед хязгаартай тооны аппаратуудыг байлгана. Аппаратаа алдах, хулгайд алдах, гэмтээхэд холбогдох хариуцлагыг сурагчид өөрсдөө үүрнэ.**

**Дижитал гэрэл зураг II (29194)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Дижитал гэрэл зураг I эсхүл гэрэл зургийн зааварлагчийн зөвшөөрөл*
Энэхүү ахисан шатны хичээлээр Гэрэл зураг I-ээр сурсан суурь концепц, техникийг цааш гүнзгийрүүлж, гэрэл зургийн нэлээд хэдэн төрлийн урлаг, илэрхийллийн шийдэлд анхаарлаа хандуулна. Гэрэл зургийг ойлгохын тулд гэрэл зургийн голлох уран бүтээлчдийн ажлыг судална. **$50.00-ын лабораторийн хураамжийг хэвлэлийн зардалд авна. Хураамжийг хөнгөлөх/чөлөөлөх талаар 13-р хуудаснаас харна уу. Сурагчид аль болох өөрийн аппаратыг авчрах хэрэгтэй бөгөөд өөрийн гэрэл зургийн цаасыг авчрах хэрэгтэй. Хэрэгцээ гарсан үед хязгаартай тооны аппаратуудыг байлгана. Аппаратаа алдах, хулгайд алдах, гэмтээхэд холбогдох хариуцлагыг сурагчид өөрсдөө үүрнэ.**

**Дижитал гэрэл зураг III (29195) (98610W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Дижитал гэрэл зураг I, II*
Гэрэл зурагт нухацтай ханддаг сурагчдад зориулсан ахисан шатны хичээл юм. Сурагчид өөрсдийн мэргэжлийн гэрэл зурагчны портфолиог бий болгож, Гэрэл зураг I, II-оор сурсан чадвараа гүнзгийрүүлнэ. **$50.00-ын лабораторийн хураамжийг хэвлэлийн зардалд авна. Хураамжийг хөнгөлөх/чөлөөлөх талаар 13-р хуудаснаас харна уу. Сурагчид аль болох өөрийн аппаратыг авчрах хэрэгтэй бөгөөд өөрийн гэрэл зургийн цаасыг авчрах хэрэгтэй. Хэрэгцээ гарсан үед хязгаартай тооны аппаратуудыг байлгана. Аппаратаа алдах, хулгайд алдах, гэмтээхэд холбогдох хариуцлагыг сурагчид өөрсдөө үүрнэ.**

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Бармалтай танилцах нь (29165)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлийг гурван хэмжээст урлагт сонирхолтой сурагчдад зориулна. Сурагчид баримлын арга барилын зарчимд суралцаж, материал, хэрэгсэл, аюулгүй ажиллагааны суурь мэдлэгийг эзэмшинэ. Сурагчид нэлээд хэдэн баримал хийх ба шавар, гипс хэрэглэх янз бүрийн арга техникийн сурна. Баримлыг түүхчлэн ойлгох талаар суралцана.

**Баримал (29166)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Бармалтай танилцах, гар урлалтай танилцах хичээлүүд эсхүл Дүрслэх урлагийн зааварлагчийн зөвшөөрөл*
Энэ хичээлийг шавар, гипс, мод, утас зэрэг янз бүрийн материал, арга барилаар өөрийн чөлөөт сэтгэлгээгээр баримал хийх сонирхолтой сурагчдад зориулсан. Бодитой, хийсвэр, тогтсон бус тайлбарын замаар суралцана. Орчин үеийн баримлуудыг жишээгээр судална.

**<u>Театрын урлаг</u>**

**Театрын урлаг I (21400)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр жүжиг, тайзны урлагийн янз бүрийн салбарыг харилцааны хэрэгсэл болохынх нь хувьд суралцахыг хүсэж байгаа сурагчдад жүжиг, тайзны урлагийн техникийг танилцуулна. Сурагчид пантомим, импровизаци, үзэгдэл судлах гэсэн арга барилаар жүжиглэх суурь арга барилыг суралцана. Бүлгээр ажиллах замаар хоолой сайжруулах, асуудал шийдэх чадвар, жүжиг унших, жүжиглэх чадварыг дасгалжуулна. Үйл ажиллагаанд театрын урлагийн түүх, тайзны бүтээлийн техник, жүжгийн бүтцийн анализ, нэг үзэгдэлт бүтээлийн дизайн, хийх явцыг багтаана.

**Театрын урлаг II (21415)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Театрын урлаг I эсхүл жүжгийн урлагийн багшийн зөвшөөрөл*
Энэ хичээл нь Театрын урлаг I хичээлээр сурсан жүжгийн техник, жүжиглэх чадварыг цааш гүнзгийрүүлнэ. Дүр хөгжүүлэх, будалт, хувцас, жүжгийн түүх, тайзны техникт илүү анхаарна. Сурагчид янз бүрийн үзэгчдийн хүрээнд зориулж жүжиг бичиж, хийж, үзүүлнэ. Театрын урлагийн түүхийг цааш үргэлжлүүлж судална. Төгсөлтөд ангиас гадуур давтах багтаж магадгүй.

**Театрын урлаг III (21425)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Театрын урлаг II эсхүл жүжгийн урлагийн багшийн зөвшөөрөл*
Энэ хичээл нь бүтээл хийхэд идэвхтэй оролцохыг шаардсан жүжгийн урлагийн семинар юм. Сурагчид бүтэн продакшныг хүртэл хийж, продакшн компанийн гишүүн болохын хувьд жүжгийн студи, продакшны талаар сурч, туршлага олж авна. Сурагч бүр дараах гурван төрлийн ядаж хоёрыг нь багтаасан ажлуудыг багтааж ангийн продакшны ажилтай холбоотойгоор хоёр төслийг дүүргэх шаардлагатай: (1) тоглолт; (2)

продакшн/найруулах, зохицуулах, түүх, судалгаа; эсхүл (3) дизайн/гэрэл, хувцас, иж бүрдэл, эд зүйлс. Театрын урлагийн түүхийг цааш үргэлжлүүлж судална. Төгсөлтөд ангиас гадуур давтах багтаж магадгүй.

**Ахисан шатны Театр IV (21430)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Театрын урлаг III эсхүл жүжгийн урлагийн багшийн зөвшөөрөл*
Театрын урлаг IV хичээлээр сурагчид хэд хэдэн тайзны бүтээлийн хүрээнд продакшны бүх үйл явцын концепцийг гаргаж, хянана. Тоглолт, шоуг удирдаж, бүтээж, зохицуулах замаар Театрын урлаг IV-ийн сурагчид өмнө сурсан бүх техникийн элементүүд, жүжиглэлт, удирдах техникүүд, бүлгийн динамик чадваруудыг нэгтгэж, хэрэглэнэ. Төгсөлтөд ангиас гадуур давтах багтаж магадгүй.

**Театрын техник (21435)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Театрын урлаг I эсхүл Театрын урлагийн багшийн зөвшөөрөл*
Сурагчид гэрэлтүүлэг, байршуулалт, хувцас, будалт, эд зүйлсийн талаар суурь мэдлэг авч, тухай бүр янз бүрийн тоглолтууд дээр техникийн дэмжлэг үзүүлж идэвхтэй оролцоно. Сурагч бүр гэрэлтүүлэг, тавилт, хувцас, будалт, эд зүйлс гэсэн бүлгүүдэд холбогдож продакшнд хэрэгцээтэй байгаа зүйлээр хоёр төслийг нарийвчлан дүүргэх шаардлагатай. Хичээлийн дараах цагаар оролцох зарим талаар шаардлагатай.

**<u>Тусгайлан анхаарах зүйлс</u>**

Урлагаар бакалавр хийхийг хүсэж байгаа сурагчид заасан хичээлүүдийг шат дараатайгаар авах хэрэгтэй зөвлөж байна (жиш: Урлаг I, II, III, AT; Театрын урлаг I, II, III, IV). Зааварлагчийн зөвшөөрлөөр сурагчид AT-ийн Дүрслэх урлагийн портфолио дээр ахлах сургуулийн нэгдүгээр ангид Урлаг III-т элсэж, төгсөх жилээ AT-ийн Урлаг хичээлд бүртгүүлж хоёр жилийн хугацаанд ажиллаж болно. Төгссөнийхөө дараа цаашид хөгжмөөр суралцахыг сонирхож байгаа сурагчдад Хөгжмийн онолын хичээлийг авахыг зөвлөж байна.

**Дагалдан сурах, Урлаг**
**Бүтэн жил, нэг кредит**
**Урлаг I (29290), Анги: 6/11**
**Урлаг II (29291), Анги: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Урлаг I эсвэл зааварлагчийн зөвшөөрөл*
**Урлаг III (29292), Анги: 12.**
*Урьдчилсан шаардлага: Урлаг II эсвэл зааварлагчийн зөвшөөрөл*
Дүрслэх урлаг, хөгжим, жүжиг, бүжигт онцгой авьяас, сонирхолтой 10-12-р ангийн сурагчдыг Урлагийн боловсролын газраас Дадлагын хөтөлбөрт хамруулна. Эдгээр сурагчдад зориулж ганцаарчилсан, бүлгийн урлагийн арга хэмжээг зохион байгуулна. Сурагчдыг бичгээр өгсөн өргөдөл хүсэлт, ярилцлага, үзүүлбэр/портфолиор хавар сонгож авна. Өргөдөл хүсэлтийг ахлах сургуулийн урлаг, хөгжмийн ажилтан, зөвлөх болон Авьяастныг хариуцсан багшаар дамжуулж гаргана.

## КАРЬЕР, ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ

Карьер, техникийн боловсролын хичээлээр ахлах сургууль буюу дунд сургуулийн дараах ажлын байранд бэлтгэх замдаа олон мэргэжлийн арга барилыг сурахад сурагчдад тусална. Хичээлийг Бизнес, мэдээллийн технологи, Мэдээлэл зүй, Гэр бүл, хэрэглэгчийн шинжлэх ухаан, Маркетинг, Худалдаа, үйлдвэрлэлийн боловсрол, Технологийн боловсрол гэсэн хөтөлбөрийн хүрээнд ахлах сургуульд өргөн хүрээнд санал болгоно. APS-ийн ахлах сургуулийн бүх сурагчид Арлингтоны Карьерын төвд хичээлд суух эрхтэй бөгөөд энэ нь өргөн хүрээний ахлах сургуулиудад санал болгодоггүй хичээлийг санал болгож ирсэн. Эдгээр хичээлийн саналуудын талаар Карьерын төвийн хэсгээс үзнэ үү. Үүний дээр Карьер техникийн боловсролоор [Career & Technical Education (CTE)] ***Хосолсон төгсөлтийн олон хичээлийг санал болгоно. Хичээлийн жагсаалт, сургуулийн байршлыг үзнэ үү.***

*Карьер, техникийн хичээл бүрд Стандарт дипломын төгсөлтийн шаардлагад багтах карьер, техникийн гэрчилгээг авах боломжийг олгоно. Өөрийн зөвлөхтэй уулзаж нэмэлт мэдээллийг авна уу.*

| **Wakefield, Washington-Liberty, Yorktown ахлах сургуулиуд, Арлингтоны карьерын төвд санал болгох үе шаттай сонголтууд**<br>Стандарт дипломын төгсөлтийн шаардлагад хамгийн багадаа хоёр сонголтыг шат дараатайгаар шаарддаг. Доор CTE-ийн шат дараатай сонголтыг зарим жишээгээр харуулав. CTE-ийн шат дарааллын бүтэн жагсаалтыг өөрийн зөвлөхөөс авна уу. | | | |
|---|---|---|---|
| **I. Бизнес, харилцаа** | | | |
| **Урлаг, Аудиовизуал технологи, харилцаа** | <u>Үе шатны сонголт 1</u>:<br>Мэдээллийн технологийн удиртгал (26116), Компьютерын мэдээллийн системүүд (26614) | <u>Үе шатны сонголт 2</u>:<br>Мэдээллийн технологийн удиртгал (26116),<br>Вэб хуудасны дизайн, мультимедиа (26646) | <u>Үе шатны сонголт 3</u>:<br>Вэб хуудасны дизайн, мультимедиа (26646),<br>Вэб хуудасны дизайн, мультимедиа, ахисан шат (26631) |
| **Бизнес Менежмент, Захиргаа** | <u>Үе шатны сонголт 1</u>:<br>QuickBooks-ээр нягтлан бодох (26320)<br>Компьютерын мэдээллийн системүүд (26614) | <u>Үе шатны сонголт 2</u>:<br>Бизнес, маркетингийн удиртгал (26112), ОУБ-ын Бизнесийн удирдлага<br>(36114) | <u>Үе шатны сонголт 3</u>:<br>Мэдээллийн технологийн удиртгал (26116),<br>Компьютерын мэдээллийн системүүд (26614) |
| **Мэдээллийн технологи** | <u>Үе шатны сонголт 1</u>:<br>Мэдээллийн технологийн удиртгал (26116), Вэб хуудасны дизайн, мультимедиа (26646) | <u>Үе шатны сонголт 2</u>:<br>Мэдээллийн технологийн удиртгал (26116),<br>Дата сангийн дизайн, менежмент DE (96660W) | <u>Үе шатны сонголт 3:</u><br>Вэб хуудасны дизайн, мультимедиа DE (96646W);<br>Дата сангийн дизайн, менежмент DE (96660W) |
| **Мэдээлэл зүй** | <u>Үе шатны сонголт 1</u>:<br>Компьютерын програмчлал (26638),<br>Компьютерын програмчлал, ахисан түвшин (26643) | <u>Үе шатны сонголт 2</u>:<br>Мэдээлэл зүйн зарчмууд, AT (33186), Компьютерын шинжлэх ухаан, AT (33185) эсхүл ОУБ-ын Компьютерын шинжлэх ухаан, Хэсэг I (36560) ба Хэсэг II (36570) | <u>Үе шатны сонголт 3</u>:<br>Компьютерын програмчлал, DE (96638W), Компьютерын програмчлал DE (96644W),<br>ACC дээр Компьютерын програмчлал, Ахисан түвшин (96643W) |
| **Маркетинг** | <u>Үе шатны сонголт 1</u>:<br>Бизнес эрхлэлт (99094W) DE,<br>Бизнес эрхлэлт, ахисан түвшин (99095), DE | <u>Үе шатны сонголт 2</u>:<br>Биеийн тамир, Энтертайнмент, Рекрэйшн (28123), Бизнес ба маркетингийн удиртгал (26112) | <u>Үе шатны сонголт 3</u>:<br>Загварын салбарын мэргэжлийн удиртгал (28147),<br>Бизнес эрхлэлт (99094W) DE |
| **II. Үйлдвэрлэл, инженерчлэл** | | | |
| **Шинжлэх ухаан, Технологи, Инженерчлэл, Математик** | <u>Үе шатны сонголт 1</u>:<br>Инженерчлэл I:<br>Инженерчлэлийн дизайны удиртгал (28491),<br>Инженерчлэл II:<br>Инженерчлэлийн зарчмууд (28492) | <u>Үе шатны сонголт 2</u>:<br>Инженерчлэл I:<br>Инженерчлэлийн дизайны удиртгал (28491),<br>Инженерчлэл II:<br>Инженерчлэлийн зарчмууд (28492)<br>Инженерчлэлийн оргил: Дизайн, хөгжүүлэлт (28494) | <u>Үе шатны сонголт 3</u>:<br>(98439W) DE,<br>Компьютерын туслалцаатай архитекторын зураг (98408W) DE |
| **Шинжлэх ухаан, Технологи, Инженерчлэл, Математик** | <u>Үе шатны сонголт 4</u>:<br>Компьютерын туслалцаатай техникийн зураг (28439) (98439W),<br>Компьютерын туслалцаатай инженерчлэлийн зураг (28438) | | |

| II. Эрүүл мэнд, хүний үйлчилгээ | | | |
|---|---|---|---|
| **Газар тариалан, хүнс, байгалийн эх үүсвэр** | Үе шатны сонголт 1:<br>Дээд зэргийн амттан: Хоол хүнс, эрүүл мэнд (28274), Хүүхдийн хөгжил, эцэг эх байх (28232) | Үе шатны сонголт 2:<br>Дээд зэргийн амттан: Хоолны урлагийн удиртгал (28250), Дээд зэргийн амттан: Хоол хүнс, эрүүл мэнд (28274) | |
| **Хүний үйлчилгээ** | Үе шатны сонголт 1:<br>Хүүхдийн хөгжил, эцэг эх байх (28232), Бага насны хүүхдийн боловсрол I (28235) | Үе шатны сонголт 2:<br>Хүүхдийн хөгжил, эцэг эх байх (28232), Маргаашийн багш нар I (99062W) DE | Үе шатны сонголт 3:<br>Маргаашийн багш нар I (99062W) DE, Маргаашийн багш нар II (29063) |

DE – Хичээлийг хосолсон төгсөлтийн коллежийн кредит авах эрхтэй сурагчид авч болно. Хичээлийн талаар болон дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.
*ОУБ (IB) хичээлүүдийг зөвхөн Washington-Liberty Ахлах сургууль дээр
**Өргөн хүрээний ахлах сургуулиудад зарим шат дараатай сургалтын нэмэлт шатууд бий. Арлингтоны Карьерын төвд бусад CTE бий. Дэлгэрэнгүй мэдээллийг 56-р хуудаснаас авна уу. *Сурагчид CTE-ийн үе шатыг дүүргэсний дараа холбогдох үйлдвэрлэлийн дадлагын улсын гэрчилгээ авах шалгалтыг амжилттай өгч баталгаажсан кредит авч болно. CTE-ийн хичээл бүрээр 2013-2014 онд болон түүнээс хойш ахлах сургуульд орсон сурагчдад үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээ, Стандарт дипломын төгсөлтийн шаардлагыг хангах техникийн гэрчилгээг авах боломж олгоно.*

## БИЗНЕС
## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ (IT)

*Бүх хичээлүүд Карьер, техникийн/Урлагийн кредитийг хангана.*

*Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

***Аливаа дүйцэх хоёр жилийн хичээлээр үе шаттай сонгох хичээлийн шаардлагыг хангаж болно.***

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**QuickBooks-ээр нягтлан бодох (26320)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***

Нягтлан бодохын сурагчид бизнес, худалдааны нягтлан бодох бүртгэлийн зарчим, концепц, практикийн суурийг сурна. Сэдэвт гүйлгээнд анализ хийх, тэмдэглэл хөтлөх, өгөгдөл илгээх, цалингийн цэсийг бэлтгэх, санхүүгийн тайлан, бэлэн мөнгөний хяналтын системийг удирдах багтана. Бизнесийн ёс зүй, мэргэжлийн ёсзүйг анхаарч үзнэ. Сурагчид гараар бичих болон цахим системийг аль алиныг нь ашиглаж нягтлан бодох бүртгэлийн суурийг сурна. Сурагчид компьютержсон нягтлан бодох аппликейшн, QuickBooks буюу бусад компьютержсон нягтлан бодох системийг сурна.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**“Coop” нэгдлийн мэргэжлийн дадлага**
**Бүтэн жил, Ажилласан цагаас шалтгаалж янз бүр (1-3 кредит)**
**1 кредит (28951), 2 кредит (28953), 3 кредит (28954)**
*Урьдчилсан шаардлага: Карьер, техникийн (CTE) сонголтод зэрэг бүртгүүлсэн*

Нэгдлийн сургалт нь ангид үзэх онолын хичээл, ажлын байран дээрх дадлагыг хослуулсан бүтэцтэй аргачлал бөгөөд сурагчдад мэргэжилдээ бэлтгэх эсхүл зорилгоо тодорхойлоход тусална. Энэ цалинтай ажил. Сурагчид долоо хоногт 11 – 15 цаг дунджаар ажиллана. Нэгдлийн сурагчид тухайн сурагчид зориулсан дадлагын ажлыг албан ёсны, бичгээр гаргасан сургалтын төлөвлөгөөний дагуу хийнэ. Нэгдлийн багш, тэдэнд ажил олгогч зааварлагчийн үнэлгээний дагуу сурагчийн хичээл, дадлагын дүнг тавина. Сурагч карьер, техникийн боловсролын (CTE) давхар сургалтыг дүүргэж, хичээлийн болон ажлын дадлагын кредит тус бүрийг авна. Хичээлийн кредитээс гадна сурагчид ажлын дадлагад 1-3 кредит авч болно. Сурагчид 1 кредит авахын тулд 280, 2 кредитэд 560 цаг, 3 кредитэд хамгийн багадаа 840 цаг хичээлийн тухайн жилд ажиллах ёстой. Зуны улирлын дадлагын ажлын цагийг сурагч CTE-ийн хичээлд үргэлжлүүлэн суух тохиолдолд дараагийн хичээлийн жилийн ажлын кредитэд тооцно. Сурагчийн хөдөлмөрийн зохицуулалт нь холбооны улс, муж улс, орон нутгийн хүүхдийн хөдөлмөрийн хууль, журамд нийцнэ. CTE-ийн давхар сургалт нь 11-12-р ангиудад санал болгох Бизнес, мэдээллийн технологи, Мэдээлэл зүй, Худалдаа, үйлдвэрлэлийн боловсрол, Технологийн боловсрол, Гэр бүл, хэрэглэгчийн шинжлэх ухааны сонгох хөтөлбөрүүдийн аль нэг байна. Хичээлийн талаар нэмэлт мэдээллийг Сургалтын хөтөлбөрөөс үзнэ үү.

**Компьютерын мэдээллийн системүүд (26614) (96614W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан нөхцөл: байхгүй*

Сурагчид текст ажилбар, хүснэгт, дата сан, мультимедиа танилцуулга, программ хангамж оролцуулах замаар амьдралд хэрэгтэй чадваруудыг суралцана. Сурагчид компьютерын концепц, операторын систем, сүлжээ, харилцаа холбоо, шинээр гарч ирж буй технологиудын талаар бие даан болон бүлгээр ажиллаж суралцана. Энэ хичээлд ажлын дадлага хийх боломж бий *(сонголтоор).* Сурагчид танхимын хичээлийг хичээлийн жилийн туршид байнга зааварчилгаа авч зөвшөөрөгдсөн ажлын байранд хийх дадлагатай хослуулж болно. Энэ хичээлүүдээр сурагчид карьер, техник мэргэжлийн гэрчилгээтэй төгсөлт болон онлайн хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангаж болно.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Компьютерын мэдээллийн системүүд, ахисан түвшин (26614) (96614W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: МТ-ийн удиртгал, Компьютерын мэдээллийн системүүд эсхүл зааварлагчийн зөвшөөрөл ба/эсхүл өөр Бизнес, мэдээллийн технологийн хичээлтэй давхар.*

Сурагчид ахисан түвшний программ хангамжийн аппликейшнүүдаар, хэвлэл, цахим ба веб нийтлэлүүдээр амьдралд хэрэгтэй чадваруудыг суралцана. Сурагчид ахисан түвшний компьютерын техник үйлчилгээ, веб хуудасны хөгжүүлэлт, програмчлал, сүлжээ, шинээр гарч ирж буй технологи, ажилд ороход хэрэгтэй ур чадваруудын талаар бие даан болон бүлгээр суралцана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Кибер: Cisco академи, Түвшин 1, Хэсэг I (26542) (96542W)**
**Улирал, нэг хагас кредит +1.0 чанарын оноо**
**10-12-р анги-р анги**
*Урьдчилсан шаардлага: Кибертэй хамтарч авах: Cisco академи, Түвшин 1, Хэсэг II (26543) (96543W)*
Энэ хичээлээр сурагчдад Сүлжээний системүүдийн анхан шатны мэдэгдэхүүн олгоно. Сурагчид сүлжээний техникч, компьютерын туслах мэргэжилтэн, мэдээллийн системүүдийн оператор, сүлжээний аюулгүй байдлын шинжээчид хэрэгтэй чадваруудыг хөгжүүлнэ. Сүлжээ ашигладаг хэрэгслүүд, орон сууц болон худалдааны орчинд байдаг техник хангамжид холбогдох амьдралд ойр удиртгал хичээлийг өгнө. Дадлагад компьютерт программ суулгах, интернэт холболт, утасгүй сүлжээний холболт, файл ба хэвлэмэл зүйлсийг хуваалцах, тоглоомын хянах самбар, скан, дуран суулгах багтана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Кибер: Cisco академи, Түвшин 1, Хэсэг II (26543) (96543W)**
**Улирал, нэг хагас кредит +1.0 чанарын оноо**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Кибертэй хамтарч авах: Cisco академи, Түвшин 1, Хэсэг I (26542) (96542W)*
Энэ хичээлээр сурагчдыг сүлжээний техникчийн ажилд бэлтгэх ба компьютерын техникч, тусламжийн техникчийн зохих нэмэлт чадваруудыг хөгжүүлнэ. Рүүт, зайнаас нэвтрэх, хаяглах, аюулгүй байдал гэсэн үндсэн тоймыг өгнө. Сурагчид э-мэйл үйлчилгээ үзүүлэх серверүүдтэй танилцана. Бид зай гаргаж, нэвтрэлтийг танина. Сурагчид тусламж үйлчилгээ, хэрэглэгчийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай харилцааны чадварыг суралцаж, сүүлийн бүлгээр CCENT гэрчилгээт шалгалтад бэлдэнэ. Сүлжээний мониторинг хийх, гацааг арилгах суурь чадварыг контексттэйгээр заана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Ажил эрхлэлттэй холбоотой боловсрол, Жил 1 (29087)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 9-12 (IEP бүхий эсхүл Тусгай боловсролын үйлчилгээ авч буй сурагчид анги үргэлжлүүлэх)**
*Урьдчилсан нөхцөл: байхгүй*
Сурагчид сургуульд холбогдох шилжилт хийж, техникийн чадвар эзэмшиж, ажлын байранд дасаж байгаа тул хичээлээр карьер, цаашдын сургалтын оновчтой сонголт хийхэд суралцуулна. Сурагчдад ёс зүйтэй хандах, ажилтай холбоотой судалгаа хийх, ажилд орох, ажлын байранд бусадтай харилцах, өөрийгөө мэдэх, өөрийгөө өмгөөлөх, хэрэглэгчийн үйлчилгээ, амьдралын ур чадварыг заана. Хичээлээр ажилтанд холбогдох амьдралын боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад холбогдож олгоно.

**Ажил эрхлэлттэй холбоотой боловсрол, Жил 2 (29089)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 9-12 (IEP бүхий эсхүл Тусгай боловсролын үйлчилгээ авч буй сурагчид анги үргэлжлүүлэх)**

Сурагчид сургуульд холбогдох шилжилт хийж, техникийн чадвар эзэмшиж, ажлын байранд дасаж байгаа тул хичээлээр карьер, цаашдын сургалтын оновчтой сонголт хийхэд суралцуулна. Сурагчдад ёс зүйтэй хандах, ажилтай холбоотой судалгаа хийх, ажилд орох, ажлын байранд бусадтай харилцах, өөрийгөө мэдэх, өөрийгөө өмгөөлөх, хэрэглэгчийн үйлчилгээ, амьдралын ур чадварыг заана. Хичээлээр ажилтанд холбогдох амьдралын боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад холбогдож олгоно.

**Ажил эрхлэлтэд бэлтгэх боловсрол, Жил 1 (29083)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 9-12 (IEP бүхий эсхүл Тусгай боловсролын үйлчилгээ авч буй сурагчид анги үргэлжлүүлэх)**
Энэ хичээлээр сурагчдыг ажлын байран дээр суралцахад бэлтгэж, ажлын байр, ур чадвараа бэлдэхэд бэлтгэнэ. Сурагчид сургуульд холбогдох шилжилт хийж, техникийн чадвар эзэмшиж, ажлын байран дээр бусад харилцах, өөрийгөө мэдэх, өөрийгөө өмгөөлөх, хэрэглэгчийн үйлчилгээ, амьдралын чадварт холбогдож ажлын байранд дасаж байгаа тул хичээлээр карьер, цаашдын сургалтын оновчтой сонголт хийхэд суралцуулна. Хичээлээр ажилтанд холбогдох амьдралын боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад холбогдож олгоно.

**Ажил эрхлэлтэд бэлтгэх боловсрол, Жил 2 (29088)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 9-12 (IEP бүхий эсхүл Тусгай боловсролын үйлчилгээ авч буй сурагчид анги үргэлжлүүлэх)**
*Урьдчилсан шаардлага: Ажил эрхлэлттэй холбоотой боловсрол, Жил 1*
Энэ хичээлээр сурагчдыг ажлын байран дээр суралцахад бэлтгэж, ажлын байр, ур чадвараа нэмэгдүүлэхэд бэлтгэнэ. Сурагчид сургуульд холбогдох шилжилт хийж, техникийн чадвар эзэмшиж, ажлын байранд дасаж байгаа тул хичээлээр карьер, цаашдын сургалтын оновчтой сонголт хийхэд суралцуулна. Сурагчдад ёс зүйтэй хандах, ажилтай холбоотой судалгаа хийх, ажилд орох, ажлын байранд бусадтай харилцах, өөрийгөө мэдэх, өөрийгөө өмгөөлөх, хэрэглэгчийн үйлчилгээ, амьдралын ур чадварыг заана. Хичээлээр ажилтанд холбогдох амьдралын боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад холбогдож олгоно. (Сонголтоор, сурагчийн нас, ажлын байранд гарахад бэлэн байдал, бэлтгэлээс хамаарч ажлын байранд дадлага хийх боломж)

**Бизнес эрхлэлт (29094) (99094W)**
**Арлингтоны сурагчдын бизнес эрхлэлтийн хөтөлбөр**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид бие даасан бизнесийн талаар суралцана. Тэд байнга өөрчлөгдөж буй ажлын байрны шаардлагад нийцүүлж ур чадвараа хөгжүүлнэ. Сурагчид нэн ялангуяа шийдвэр гаргах, урт хугацаанд төлөвлөх, үр дүнтэй харилцах, хариуцлага үүрэх, хариуцлагатай байх, байнга боловсроход холбогдох чадварыг хөгжүүлнэ. Энэ хичээлийг өөрийн бизнесийг өмчилж/удирдах карьерын замд анхаарлаа хандуулахыг хүсэж байгаа сурагчдад зориулсан. Хэдийгээр хувь хүний ур чадварт анхаарах хэдий ч хичээлээр дараахыг багтаасан бизнесийн төлөвлөгөөг хөгжүүлэхэд анхаарна: бизнесийн төрлийг тодорхойлох, хууль журмыг авч үзэх, байршил сонгох, санхүү, бизнес эхлүүлэх алхмууд, маркетинг хийх стратеги, энтерпренерүүдтэй амжилттай харилцах.

Энтерпренерийн хичээлийн нэг хэсэг болгож сурагчид Арлингтоны Сурагчдын компанид [Arlington Student Enterprise (ASE)] өргөдөл хүсэлт гаргаж болно. Сурагчдын туршлагыг харгалзаж мэдээллийн технологийн салбарын төслүүд дээр сонгож ажиллуулна. Сурагчид өндөр зэргээр шаардлага хангасан, ASE-ийн үйлчлүүлэгчийн ажлууд дээр бие даан ажиллаж чадна гэдгээ харуулах ёстой.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Бизнес эрхлэлт, ахисан түвшин (99095), DE**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Бизнес эрхлэлт (29094) (99094W)*
Энэ хичээлийг Бизнес эрхлэлт (29094) (99094W) хичээл дээр нэмж бизнес эрхлэлтэд холбогдож ахисан түвшний мэдлэг олж авахад анхаарлаа хандуулж буй сурагчдад зориулсан. Хичээлээр бизнесийн төлөвлөгөө гаргах, жижиг бизнес удирдахад анхаарна. Сурагчид бизнес эхлүүлж, маркетинг хийж, ажиллуулна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Мэдээллийн технологийн удиртгал (26116)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид мультимедиа продакшн, танилцуулга хийх чадвар, компьютерын программ хангамжийн аппликейшнүүд, сүлжээний удирдлага, программын хэлнүүд, операторын системүүд, компьютерын техник хангамжийг багтааж APS-д буй янз бүрийн мэдээллийн технологийн талаар практик удиртгал, танилцуулга авна. Тэд IT-гаар мэргэжил эзэмших талаар мэдэж авсны үр дүнд A+, Network+, CNA, Cisco Academy гэх мэт салбарын гэрчилгээг авах замыг нээх шат дараатай IT сургалтыг ахисан түвшинд авах эсэх талаараа оновчтой сонголт хийх боломжтой болно. Хичээлийг амжилттай дүүргэснээр сурагчид Мэдээллийн технологийн шинжлэх ухааны нийгэмлэг буюу NOVA-ийн Мэдээллийн технологийн Хэрэглээний шинжлэх ухааны холбоонд холбогдох Northern Virginia Community College-ийн давхар төгсөлтөд хүргэх мэдээллийн технологийн цаашдын сургалтад бэлтгэгдэх болно.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно*

**Вэб хуудасны дизайн, мультимедиа (26646) (96646W)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 9-12**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид дизайн, дэлгэцийн нийтлэлийн төслүүд, мультимедиа танилцуулга/төслүүд, салбарын стандарт программ хангамжуудыг ашиглах веб хуудас хийх чадвараа хөгжүүлнэ. Сурагчид төслүүдийг дуусгахдаа загвар, дизайны зарчмуудыг хэрэглэнэ. Сурагчид товч хураангуй, хичээлийн янз бүрийн дэлгэцийн нийтлэл, мультимедиа, веб хуудасны төслүүдийг багтаасан портфолио хийнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Вэб хуудасны дизайн, мультимедиа, ахисан шат (26631)**
**(96631W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 10-12**
*Урьдчилсан шаардлага: Вэб хуудасны дизайн, мультимедиа (26646) (96646W)*
Сурагчид дэлгэцийн нийтлэл, хариу үйлдлийн мультимедиа, веб хуудсыг төслүүдийн ахисан түвшний чадвараа хөгжүүлнэ. Сурагчид амьдралд хэрэгтэй чадваруудыг эзэмшиж, өндөр түвшний техник, программ хангамжуудтай ажиллана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

## МЭДЭЭЛЭЛ ЗҮЙ

*Бүх хичээлүүд Карьер, техникийн/Урлагийн кредитийг хангана.*

Мэдээлэл зүй нь програмчлал, мэдээллийн технологи, математик, шинжлэх ухаан, инженерийн дунд сургуулийн дараах боловсрол, карьерт сурагчдыг бэлтгэх сургалтын хөтөлбөр юм. Сурагчид компьютерын шинжлэх ухааны ахисан түвшний хичээлүүдэд математик, шинжлэх ухааны кредит авна. Сонгосон хичээлүүд нь сурагчдад үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээ, цалинтай ажиллаж үзэх, коллежийн кредитийг санал болгохын зэрэгцээ Карьер, техник/Урлагийн кредит, төгсөлтийн баталгаажсан кредитийн шаардлагуудыг хангана.

**Компьютерын програмчлал (26638)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебрыг "B" ба түүнээс дээш дүнтэйгээр төгссөн байхыг чухалчлан зөвлөж байна.*
Сурагчид Java ба/эсхүл Python программын хэлийг чөлөөтэй хэрэглэх эсхүл Windows-ийн орчны программыг кодолж, хийхэд сурна. Хичээлийн агуулгад программын дизайн, асуудал шийдэх, хяналтын бүтэц, ажиллагаа, параметрт тэнцэх, өгөгдлийн бүтэц, өгөгдлийн цуваа, файл боловсруулах багтана. Программын дизайнд илүү анхаарна. Сурагчид мөн үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээнд бэлтгэж болно.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Компьютерын програмчлал, ахисан түвшин (26643)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Компьютерын програмчлал (26638)*
Ахисан түвшний компьютерын програмчлал нь програмчлалын суурь чадвар дээр үндэслэнэ. Ахисан түвшний програмчлалын сурагчид нь тоглоомын аппликейшн, гар утасны аппликейшн, веб аппликейшныг багтааж дата аппликейшн, интерактив мультимедиа аппликейшн хөгжүүлэхэд объектод чиглэсэн програмчлалын концепцууд, I/O хяналтын бүтцүүд, ажиллагаа ба/эсхүл аргачлал, өгөгдлийн товчлол, өгөгдлийн бүтцийг хэрэглэнэ. Хичээлээр сүлжээ, операторын системүүд, дата зохицуулалт, алгоритм, программ хангамжийн инженерчлэлийг багтааж компьютерын сүлжээний архитекторчлал, компьютерын техник хангамжийн ажиллагааны талаар авч үзнэ. Сурагчид мэдээллийн технологи, компьютерын шинжлэх ухааны салбарт боловсрол эзэмших, ажиллах замынхаа талаар судлах явцдаа ажилд орох чадваруудыг хөгжүүлж, карьерт холбогдох янз бүрийн ажиллагаанд оролцоно. Сурагчид мөн өндөр хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээнд бэлтгэж болно. *Сурагчид мөн өндөр хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээнд бэлтгэж болно.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Мэдээлэл зүй, AT (33185)**
**Бүтэн жил, нэг математикийн кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 10-12**
*Урьдчилсан шаардлага: Компьютерын програмчлал (26638 эсхүл MS 16640)-ийг "B" ба түүнээс дээш дүнтэй дүүргэх, эсхүл зааварлагчийн* зөвшөөрлөөр
Ахисан түвшинд орох Мэдээлэл зүй нь аргачлал, алгоритм, дата бүтцийг илүү анхаарсан эрчимжүүлсэн хичээл юм. Өгөгдлийн цуваа, линк үүсгэсэн жагсаалтууд, моднууд, ялгах техникт илүү анхаарна. Олон төслүүдээр ангиас гадуурх дадлага, сургалт, уншлага хийнэ. Энэ хичээлд орж ирэх оюутнууд Java програмчлалын хэлний талаар сайн ойлголттой байх ёстой. Энэ хичээл нь Коллежид орох шалгалтын комиссоос нийтэлсэн хичээлийн хөтөлбөрт заасанчлан AT-ийн Мэдээлэл зүйн хичээлийн шаардлагыг хангана. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (23185) Энэ хичээлийн зарим хэсгийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.*

**Мэдээлэл зүйн зарчмууд, AT (33186)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебрыг "B" ба түүнээс дээш дүнтэйгээр төгссөн байх.*
Энэ хичээлээр тооцооллын суурь зарчмуудыг заах олон төрлийн шинжлэх ухааны салбарыг нэгтгэсэн арга барилыг санал болгоно. Хичээлээр сурагчдад програмчлалын бүтээлч сэтгэлгээ, абстракчлал, алгоритм хэрэглэх, асар том дата цогцтой ажиллах, интернэт, кибер аюулгүй байдлыг ойлгох, хүн амд

нөлөөлөх тооцооллын хүчин зүйлийг танилцуулах болно. APS-ийн Мэдээлэл зүйн зарчмуудаар асуудал шийдэхэд орчин үеийн технологи ашиглах, учир утгатай компьютерчлэлийн артифактууд хийх боломжуудыг сурагчдад олгоно. (Коллежийн зөвлөл). *Сурагчид энэ хичээлтэй холбоотой АТ-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (23186). Энэ хичээлийн зарим хэсгийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.*

## ГЭР БҮР, ХЭРЭГЛЭГЧИЙН ШИНЖЛЭХ УХААН

*Бүх хичээлүүдээр Карьер, техник/Урлагийн кредит авна (бүтэн жил-нэг кредит, хагас жил-хагас кредит)*
*Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Хүүхдийн хүмүүжил, эцэг эхийн хичээл (28230)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**ээс 2-р анги 9-12**
*Урьдчилсан шаардлага: Сүрьеэ өвчний шинжилгээ хийлгэсэн байх шаардлагатай*
Энэ хичээл хүүхэд чанартай асрах, сайн эцэг эх байх чадварт сургах сурагчдыг зорилготой. Энэ нь гэр бүлтэй болох, хүүхдийн хажуугаар карьер хийх талаарх шийдвэр гаргах үйл явцаар эхэлнэ. Хоол хүнс, төрөхөөс өмнөх үеийн хүүхдийн хөгжил, нялх хүүхдийг хэрхэн асрах, хүүхдийн өсөлт, хөгжилт, хүүхэд яагаад ингэж харилцдаг вэ, тоглох хүүхдийн хувьд ямар учиртай вэ, хүүхдийг хэрхэн сахилгажуулах вэ, харилцааны арга барил, янз бүрийн насны хүүхдэд тохирсон үйл ажиллагааг төлөвлөхийг хичээлээр багтаана. Энэ хичээлийн ажлын зарим хэсэгт бага насны хүүхдийг оролцуулан зааварчилгаатай ажиглах багтана.

**Хүүхдийн хүмүүжил, эцэг эхийн хичээл - Жил (28232)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Сүрьеэ өвчний шинжилгээ хийлгэсэн байх шаардлагатай*
Энэ хичээл хүүхэд чанартай асрах, сайн эцэг эх байх чадварт сургах сурагчдыг зорилготой. Энэ нь гэр бүлтэй болох, хүүхдийн хажуугаар карьер хийх талаарх шийдвэр гаргах үйл явцаар эхэлнэ. Хоол хүнс, төрөхөөс өмнөх үеийн хүүхдийн хөгжил, нялх хүүхдийг хэрхэн асрах, хүүхдийн өсөлт, хөгжилт, хүүхэд яагаад ингэж харилцдаг вэ, тоглох хүүхдийн хувьд ямар учиртай вэ, хүүхдийг хэрхэн сахилгажуулах вэ, харилцааны арга барил, янз бүрийн насны хүүхдэд тохирсон үйл ажиллагааг төлөвлөхийг хичээлээр багтаана. Үүний дээр хүүхэд өргөж авах, хүүхдийн өвчлөл ба дархлаа, хүүхдийн өдрийн асаргааны сонголтууд, тогтмол хуваарьтай болох, ах дүүсийн маргаан, тоглоом сонгох, тоглох мөн багтана. Хичээлд орчин тойрны эх үүсвэртэй танилцах, яслид очиж үзэх, байлцах багтана.

**Дээд зэргийн амттан: Хүнс, эрүүл мэнд - Улирал (28272)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр сурагчдад хоолны дэглэм барихтай холбоотой өөрсдийн мэдлэгийг ахиулах, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх боломжийг олгоно. Үүнд өөртөө болон гэр бүлдээ тохирох хоол хүнсийг авахад цаг, эрч хүч, мөнгөө хэрхэн зохицуулах мөн багтана. Хоол хүнсний хэрэгцээ, аюулгүй байдал, ариун цэврийг сахих, гал тогооны тоног төхөөрөмжийг хэрэглэх, арчлахыг зааж, хоол бэлтгэх үндсэн мэдлэгийг өгнө.

**Дээд зэргийн амттан: Хоол хүнс, эрүүл мэнд (28274)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр сурагчдад хоолны дэглэм барихтай холбоотой өөрсдийн мэдлэгийг ахиулах, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх боломжийг олгоно. Үүнд өөртөө болон гэр бүлдээ тохирох хоол хүнсийг авахад цаг, эрч хүч, мөнгөө хэрхэн зохицуулах мөн багтана. Хоол хүнсний хэрэгцээ, аюулгүй байдал, ариун цэврийг сахих, гал тогооны тоног төхөөрөмжийг хэрэглэх, арчлахыг зааж, хоол бэлтгэх үндсэн мэдлэгийг өгнө. Агуулгад тусгайлсан дэглэмийн хүнс бэлтгэх, цаг хэмнэх хүнс бэлтгэх, дайлах хүнс бэлтгэж сурах, янз бүрийн үндэстний хоол бэлтгэх, хүнсний салбарт хөдөлмөр эрх талаар танилцах багтана.

**Дээд зэргийн амттан: Хоолны урлагийн удиртгал (28250)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Хоолны урлагийн удиртгал хичээлийн сурагчид хүнсний аюулгүй байдал, ариун цэвэр, хоол бэлтгэх суурь мэдлэг, хоол бэлтгэх суурь чадварууд, олон төрлийн хоол, үйлчилгээний арга барил, хоол хүнс ба цэс гаргах, хүнсний эдийн засгийн талаар судлах болно. Сурагчид дунд сургуулийн дараах боловсролын сонголтууд, хүнсний үйлдвэрлэлийн салбар ажиллах боломжуудын талаар мэдэж авна.

**Загварын салбарын мэргэжлийн удиртгал (28147)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Загварын салбарын мэргэжлийн удиртгал хичээлээр сурагчид хувцас, хэрэглэл, текстилийн дизайн, үйлдвэрлэл, худалдааны салбарын талаар мэдэж авч, танилцана. Хичээлийн сэдвүүд хувцасны үйлдвэрлэлийн нэгжүүдийн харилцаа; холбогдох глобал бөгөөд эдийн засгийн асуудлууд, хувцас, хэрэглэл, текстилийн технологи; холбогдох салбарт бизнес эрхлэхийг багтааж мэргэжлийн чигтэй танилцах; хувцас, хэрэглэл, текстилийн дизайн, үйлдвэрлэл, маркетингийн салбарт амжилт гаргахад шаардлагатай чадвар, хувь хүний чанаруудыг багтаана.

**Барилгын дотоод заслын удиртгал (28289)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Барилгын дотоод заслын удиртгал хичээлийн сурагчид дотор орон зай дизайнд хэрхэн нөлөөлөх, дотоод заслын салбарт ажиллах асуудалтай танилцаж, дотоод заслын салбарт ажилд ороход шаардлагатай техникийн ба харилцааны чадваруудад анхаарна. Сурагчид дизайны бүрдэл зүйл, зарчмууд зэрэг тодорхой шалгууруудыг хангасан дотоод заслын төслийг хөгжүүлнэ.

**Маргаашийн багш нар I (29062) (99062W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: 2.7 GPA*
Маргаашийн багш нар хичээлээр 11, 12-р ангийн сурагчид багшлах, боловсролын салбарын ажил мэргэжилтэй танилцана. Суралцагчид, сургууль, багш, сурган хүмүүжүүлэх нь хөтөлбөрийн голлох бүрдэл зүйлс байна. Тухайн сурагчийн мэргэжлийн зорилтоос хамаарч ихээхэн уян хатан байх үүднээс бүрдэл зүйлсийг зориудаар өргөн тодорхойлсон. Бүх сурагчид Маргаашийн багш нар хичээлийн гадуур дадлага хийхийг ажиглах, оролцох ёстой. Дадлагыг сургуулийн өмнөх шатнаас 12-р ангийн шатанд хийх боломжтой. *Тайлбар: "B" ба үүнээс дээш дүнтэй сурагчид Shenandoah Их сургуулийн дөрвөн кредитийг авах боломжтой.*

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Маргаашийн багш нар II (29062) (99062W)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Маргаашийн багш нар I*
Сурагчид Боловсрол, сургалтын салбарын мэргэжлүүдтэй танилцахаа үргэлжлүүлнэ. Сурагчид дунд сургуулийн дараа юу хийх талаар судлах явцдаа боловсролын салбарт ажил мэргэжил эзэмшихэд бэлтгэх боломжийг хичээлээр тэдэнд олгож, Виржиниад багшийн гэрчилгээ авах үйл явцыг зааж, дадлага хийх боломж олгоно.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

## МАРКЕТИНГ
*Бүх хичээлүүд Карьер, техникийн/Урлагийн кредитийг хангана.*
*Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

Маркетингийн хөтөлбөрийг дараах салбарт маркетингийн салбарт сурч, ажил мэргэжил эзэмших сонирхолтой сурагчдад зориулсан: маркетинг, маркетингийн судалгаа, санхүүгийн үйлчилгээ, биеийн тамир ба энтертайнмент, интернэт маркетинг, олон улсын худалдаа, энтерпенершип, загварын бүтээгдэхүүн, маркетинг менежмент, худалдааны менежмент, зочид

буудлын маркетинг, ажлын байранд шаардах ур чадварууд, сурталчилгаа. Сурагчид дунд сургуулийн дараах боловсрол, ажил эрхлэлтэд сайн бэлтгэх сайн суурьтай болно. Сурагчид ажлын дадлага өөрийн сонголтоор хийж болно. Сурагчдад олгох баталгаажсан кредит авах Үндэсний хэрэглэгчийн үйлчилгээний шалгалтыг мөн өгч болно.

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Бизнес, маркетингийн удиртгал (26112)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Бизнес, маркетингийн удиртгал хичээлийг Бизнес, мэдээллийн технологийн шаталсан сургалтын суурь болгож үзэхийг зөвлөж байна. Сурагчид глобал эдийн засаг дахь Америкийн ба олон улсын бизнесийн байгууллагуудын талаар суралцана. Хэрэглэгч, зах зээл, үйлдвэрлэгчийн үүрэг оролцооны талаар онцолж үзнэ. Сурагчид хувийн бизнес эрхлэлтийн тогтолцооны суурийг сурч, бизнесийн салбарт, үүний дотор энтерпренер болох, дэлхийн худалдааны талаар танилцах болно.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Маркетинг (28120)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Оюутнууд бүтээгдэхүүнийг хэрхэн боловсруулах, брэнджүүлэх, борлуулах талаар суралцах болно. Тэд салбарын чиг хандлагад дүн шинжилгээ хийж, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетингийн санааны талаар практик туршлага хуримтлуулж, дунд боловсролын дараах боловсрол, ажил эрхлэлтийн салбарт амжилтад хүрэхэд бэлэн байх болно. Сэдвүүдэд: ажлын байран дахь мэргэжлийн ур чадвар, бүтээгдэхүүний төлөвлөлт ба байршил, сурталчилгаа, үнэ, борлуулалт, эдийн засгийн асуудал, зах зээлийн өөрчлөлт зэрэг орно. Нөхцөл байдлын зааварчилгаа, оюутнуудын хамтарсан ажил болон мэргэжлийн оюутны байгууллагын (CTSO) үйл ажиллагаанд оролцох нь манлайлал, хүмүүстэй харилцах, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болно. Өндөр чанартай ажлын байрны сургалт (HQWBL) нь оюутнуудын карьерын зорилго ба/эсвэл сонирхолд нийцүүлэн, сургалттай уялдуулан, орон нутгийн бизнес, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх туршлага судлах боломжийг олгоно.

- ***Гэрчилгээ:*** *Оюутны сонгосон баталгаат кредитийг Хэрэглэгчийн үйлчилгээ, борлуулалтын баталгаажуулалтын үнэлгээ болон/эсвэл мужаас баталсан бусад курсийн гэрчилгээ зэрэг салбартай холбоотой гэрчилгээг давснаар авах боломжтой.*

**Спорт, энтертайнмент, амралт чөлөөт цаг (28123)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэхүү удиртгал хичээлээр сурагчид спорт, энтертайнмент, амралт чөлөөт цагийн салбартай холбож үзэж маркетингийн үндсэн концепцууд, онолын талаар сайтар ойлгож авна. Сурагчид брэндлэх, ивээн тэтгэх, дэмжих гэсэн бүрдлүүдийн талаар төдийгүй спорт, энтертайнмент, амралт чөлөөт цагийн арга хэмжээг сурталчлах төлөвлөгөөний талаар судална. Хичээлээр мөн ажил мэргэжлээрээ хөгжиж дэвших чадваруудыг дэмжиж, ажлын сонголтын талаар судална. Агуулгад холбогдох академик чадварууд (математик, шинжлэх ухаан, Англи хэл, түүх/нийгмийн ухаан) энэ хичээлийн нэг хэсэг юм.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

---

## ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ

Техникийн боловсролын хичээлүүд нь үйлдвэрлэл, технологийн талаар зүг чиг авч, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал, арга ажиллагаа, бүтээгдэхүүнтэй танилцаж мэдэж авах зориулалттай. Сурагчид ажил мэргэжил, техникийн боловсролын сонголтоо мэдээлэлд үндэслэж, утга

учиртай сонгохын тулд болон цаадын боловсролын замд бэлтгэхийн тулд хичээлийг сонгож болно.

*Бүх хичээлүүд Карьер, техникийн/Урлагийн кредитийг хангана.*

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Компьютерын туслалцаатай техникийн зураг (28439) (98439W)**
**Бүтэн жил, нэг мөчлөг, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэхүү механик зургийн анхан шатны хичээлээр график хэлээр үр дүнтэй харилцах ур чадваруудыг танилцуулна. Сурагчид гурван төрлийн график зураглалын арга хэрэглэнэ: гараар чөлөөтэй загварчлах, механик төсөл, компьютерын тусламжтай зураг. Хичээлд техникийн зураг, гараар хар зураг гаргах, үсэглэх техник, зураасны төрлүүд, геометрийн бүтцүүд, олон талаас харуулах зураг, хэмжээ багтаамж гаргах, хэсэгчлэн харуулах, туслах зургууд, компьютерын тусламжтай дизайн багтана. Хичээлийг барилгын худалдаатай холбоотой сурагчдыг багтааж ирээдүйн инженерүүд, архитекторууд, сууц баригчдад тусгайлан зөвлөж байна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Компьютерын туслалцаатай архитекторын зураг (28408) (98408W)**
**Бүтэн жил, нэг мөчлөг, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Компьютерын туслалцаатай техникийн зураг (28439) (98439W)*
Энэ нь архитектор, барилгын салбарт механик төсөл зураг, компьютерын тусламжтай зургийг ашиглаж дадлагажихад анхаарлаа хандуулах зургийн хичээл юм. Эдгээр баримт бичгүүдэд шалны план зураг, цахилгааны план зураг, ханын хэсгүүд, өндөрсгөх, шавардлага багтана. Сурагчид хэмжээст загвар бэлтгэж, янз бүрийн барилгын материал, тэдгээрийн чанаруудын талаар тайлбарлаж сурна. Хичээл нь орон байр өмчлөгч нарт тустай мэдээллийг өгөх ба нэн ялангуяа ирээдүйн архитектор, барилгын дотоод засал чимэглэлч, гэрээлэгчдэд тустай. Үүнд мөн барилгын худалдааны чадварын хичээлд оролцсон сурагчид багтана. AutoCAD ашиглан компьютерын тусламжтай загвар гаргах нь энэ хичээлийн нэг хэсэг юм.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Компьютерын туслалцаатай инженерчлэлийн зураг (28438)**
**Бүтэн жил, нэг мөчлөг, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Компьютерын тусламжтай техникийн зураг (28439)*
Энэ нь инженерчлэл, дизайны салбарт дадлагажихад анхаарсан зургийн хичээл юм. Сурагчид механик төсөл зураг, компьютерын тусламжтай зурах программыг ажиглаж бүрдэл хэсгүүд, дагалдах зүйлсийн дизайныг гаргаж, үйлдвэрлэхэд шаардлагатай ажлын зургуудыг бэлтгэнэ. Эдгээр баримт бичгүүд нь изометр, ортографикийн зургууд болон зургийн загваруудыг багтаана. Сурагчид мөн барилгын материал, тэдгээрийн чанаруудын талаар суралцана. Энэ хичээл ирээдүйн инженерүүдэд чухал программуудыг заах өгөх ба нэн ялангуяа коллежид орох гэж байгаа STEM-ийн сурагчдад хэрэгтэй. AutoCAD ашиглан компьютерын тусламжтай загвар гаргах нь энэ хичээлийн нэг чухал хэсэг юм.

**Ахисан шатны зураг, дизайн (28440)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Компьютерын тусламжтай инженерийн (28438) зураг эсхүл Компьютерын тусламжтай архитекторын зураг (28408)*
Сурагчид бүтээгдэхүүний дизайн, техникийн зурагт график хэлийг ашиглана. Тэд өмнөх хичээлүүдээр олж авсан техникийн зургийн ойлголтоо дээшлүүлнэ. Тэд үйлдвэрлэл, барилгын

ажиллагааны явцын ахисан шатны зураг, дизайнтай танилцаж, дизайны салбарт судалгаа хийнэ. Тэд ажиллагааг загварчилж, дизайны шийдлүүдэд дүн шинжилгээ хийж, инженерийн бүтээгдэхүүнийг байлгаж, CADD хэрэглэж 3-D загвар хийж, барилгын биет загвар хийж, бүтээж дууссан дизайны мультимедиа загварыг хийнэ. Тэд сонгосон график төсөлд үндэслэж ажлын портфолиог дуусгавар болгоно.

**Инженерчлэл I: Инженерчлэлийн дизайны удиртгал (28491)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан нөхцөл: Байхгүй*
Инженерчлэл I-ээр инженерийн загварт анхаарна. Сурагчид төслийн шийдлүүдийг хийж, эдгээрт дүн шинжилгээ, үнэлгээ хийх компьютерын программ хангамж ашиглана. Тэд хэлбэр, зориулалтын дизайн концепц сурч, хамгийн сүүлийн үеийн технологийн дизайны концепцийг үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болгож хэрэгжүүлэхэд ашиглана. Энэ хичээлээр сурагчдад дизайн хийх үйл явцыг ойлгож, хэрэглэх, загвар хөгжүүлэхдээ өөрчлөгдөх дизайны концепцийг хэрэглэх, хатуу загвар гаргах компьютерын дизайны программ хангамжийг ашиглаж бүтээгдэхүүний загварыг хөгжүүлж, бүтээж, дүн шинжилгээ хийх замаар дизайны шийдэл гаргахыг заана.

**Инженерчлэл II: Инженерчлэлийн зарчмууд (28492)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 10-12**
*Урьдчилсан нөхцөл: Инженерчлэл I: (28491)*
Энэ хичээл инженерийн технологийн талаар тойм өгнө. Сурагчид бодит амьдралын инженерчлэлийн асуудлыг шийдвэрлэж, асуудал шийдэх чадвар эзэмшинэ. Онол сурч, практик туршлага олсноор сурагчид технологийн өөрчлөлтөөс гарч ирэх нийгэм, улс төрийн үр дагавруудыг авч үзнэ. Судлах зарим зүйлд инженерчлэлийн өнцгөөс харах, дизайны үйл явц, харилцаа ба баримтжуулалт, инженерчлэлийн системүүд, статик, материал ба материалыг шалгах, термодинамик багтана.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Инженерчлэлийн оргил: Дизайн, хөгжүүлэлт (28494)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Инженерчлэл II (28492)*
Энэхүү төгсөх хичээлээр нутгийн менторуудын зааварчилгааг авах сурагчдын багууд судалгаа хийх, дизайн гаргах, инженерчлэлийн асуудлуудын шийдлүүдийг гаргах болно. Сурагчид инженерчлэлийн амьдралын жишээгээр мэдлэг, чадвар, чадамжуудаа хэрэглэнэ. Сурагчид бие даасан судалгааны төсөл болон багт чиглэсэн төслийг хөгжүүлж, албан ёсоор танилцуулах шаардлагатай ба эдгээрийг зөвлөл үнэлнэ.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Тоглоомын дизайны удиртгал (28461)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид шинжлэх ухаан, технологи, инженерчлэлийн дизайн, байршлын дата, ажиглалт, физикийн симуляцид үнэлэлт дүгнэлт өгөх, сургалтын зорилгоор тоглоом програмчлах, 3D загвараар харагдах байдлыг тодорхойлох, өргөжсөн буюу виртуал риалити болон хиймэл оюуныг багтааж жинхэнэ амьдралын шийдэлд загвар ашиглах, загварчлах, тоглоом хөгжүүлэх программ хангамжтай танилцана. Сурагчид систем, процесс, хэрэгслийг болон загварчлах, дуурайлгах технологийн салбар дахь хэрэгжилтийн талаар ойлголтоо бэхжүүлнэ.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Робот зохион бүтээх технологи (18421)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид автоматжуулалтын систем, бичил процессор болон тэдгээрийг үйлдвэрлэл, тээвэрлэлт болон харилцаа холбооны системд хэрэглэх хэрэглээний талаар судална. Хамрах сэдвүүдэд компьютер төхөөрөмж болон үйлдлийн систем, робот, програмчлал, удирдлагын систем болон тэдгээр технологиудын нийгэм/ соёлд үзүүлэх нөлөөлөл

хамаарна. Асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанууд сурагчдад дизайн гаргах, програмчлах болон компьютер системүүдтэй холбогдох сорил болдог. Сургалтын үйл ажиллагаанд робот, компьютерын тусламжтай үйлдвэрлэл болон дизайн, цахилгаан механик төхөөрөмжүүдийг удирдах зэрэг нь багтана.

## ЖОЛООНЫ СУРГАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Жолооны үнэмлэх авах хүсэлт гаргасан арван есөн наснаас доош насныхан Жолооны сургалтад орох зөвшөөрлийн карт (DEC-1)-ийг авсан байх ёстой. Энэ нь жолооны сургалтын хөтөлбөрийг дүүргэснийг батлах ба үүнд эцэг эх/сурагчийн жолооны сургалт багтана (§22.1-205). ***Хичээлийг дүүргээгүй бол жолооны үнэмлэх авах хүсэлтийг арван есөн нас хүрч байж гаргах шаардлага гарна.***

**Жолооны сургалт, аюулгүй байдал (27010)**
**Эхний улирал, хагас кредит**
**Жолооны сургалт, аюулгүй байдал (27011)**
**Хоёрдугаар улирал, нэг хагас кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага:*

- *Виржиниагийн Суралцагчийн үнэмлэх,*
- *Эцэг эх/асран хамгаалагчийн зөвшөөрөл,*
- *Улирал эхлэх өдөр арван таван нас зургаан сартай байх насны доод хязгаар. (Жолооны сургалтад насаар ах сурагчдыг тэргүүн зэрэгт сонгож авна).*

- *Жолооны ард сууж дадлага хийхэд (муж улс, APS-ийн санхүүжилт дээр тулгуурлаж) хураамж төлнө.* **Хураамжийг хөнгөлөх/чөлөөлөх талаар 13-р хуудаснаас харна уу.** *Хураамжийг хичээл эхэлснээс хойш долоо хоногийн дотор төлсөн байх ёстой.*

- *Сурагчид болон тэдний эцэг эх/асран хамгаалагчид Муж улсын хуулийн дагуу* (§22.1-205*; HB1782) эцэг эх/сурагчийн жолооны хичээлийн (90 минут) уулзалтад хичээлийн өмнө оролцох ёстой.*

Жолооны сургалт нь ангийн хичээл, жолооны дадлага гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Дадлагад сурагчид загвар дээр дадлагажих багтана. Амжилттай төгссөн сурагчид ½ кредит, Жолооны сургалтын гэрчилгээ (DEC-1), зааварлагчтай (эцэг эхийн бүртгэл) 45 цагийн дадлагын эрхтэй болно. *Сурагчид болон тэдний эцэг эх/асран хамгаалагчид Муж улсын хуулийн дагуу (HB1782) эцэг эх/сурагчийн жолооны хичээлийн (90 минут) уулзалтад хичээлийн өмнө оролцох ёстой.* **Эцэг эх/сурагчийн уулзалт заасан хугацаанд даруй эхлэх тул хоцорч ирсэн хүмүүсийг оруулахгүй.**

## АНГЛИ ХЭЛ, УРАН ЗОХИОЛ

Арлингтоны улсын сургуулийн англи хэлний хөтөлбөрөөр хичээлдээ болон хичээлээс гадуур амжилт гаргахад сурагчдад шаардлагатай харилцаа, давхар утгыг ойлгох, унших, бичих, судалгаа хийх чадварт анхаарна. Концепцэд суурилсан хөтөлбөр нь уран зохиол, уншлагад суурилна. Сурагчдаас уншиж, бичиж, ярьж, сонсож, шүүмжтэй сэтгэхээс эхлээд олон зүйлийг шаардана. Бүх ангийн түвшний хөтөлбөрүүд Виржиниагийн англи хэлний сургалтын стандартад нийцсэн.

Виржиниагийн ахлах сургуулийг төгсөхөд англи хэлний дөрвөн кредит шаардлагатай. Бүх ахлах сургуулиудад сурагчид Англи хэл, Эрчимжүүлсэн, Ахисан түвшний, Хос төгсөлтийн англи хэлний хичээлүүд гэх мэтээр олон төрлийн хичээлүүдээс сонгож болно.

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Англи хэл 9 (21130)**
**Бүтэн жил, нэг кредит**
*"Ахуй чанар"* нь 9-р ангийн голлох сэдэв байна. Сургалтын хөтөлбөрийн гол сэдвүүд ойлголтоо сайжруулах, гол чухал асуудлууд дээр төвлөрч, 9-р ангийн SOL-д нийцнэ.

- Уран зохиол болон баримтат зохиолыг харьцуулах хэлбэрээр уншсанаа ойлгох чадварт анхаарах болно. Уран зохиолын уншлагаар сурагчид уран зохиолын ойлголтын мэдлэгээ ашиглаж, төрөл жанрын талаар дүн шинжилгээ хийнэ. Есдүгээр ангиас эхлэж баримтад зохиолд илүү анхаарах ба сурагчид шууд илэрхийлсэн болон дам утгыг ойлгож, ялгана.

- Сурагчид үгийн үндэс, залгавруудын бүтцэд дүн шинжилгээ хийж үгийн баялгаа өргөжүүлнэ.
- Сурагчид янз бүрийн төрлийн бичиглэлээ төлөвлөж, хянан үзэж, засварлана. Эсрэг үндэслэл гаргах, учир шалтгааныг тайлбарлах, ач холбогдолтой эх үүсвэрээс нотолгоо гаргах зэргээр нэг санааг хамгаалах явцдаа дүн шинжилгээ хийж, ухуулан таниулахад илүү анхаарна.
- Сурагчид хэвлэл мэдээлэлд холбогдож нийгэм, худалдаа, улс төрийн шалтгааныг шинжилж, тайлбарлана. Сурагчид бие дааж болон бүлгээр танилцуулга хийхэд олон төрлийн арга хэрэгслийг ашиглана.
- Сурагчид төрөл бүрийн эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлдээ судалгааны арга техник ашиглан дүн шинжилгээ хийж, мөн "MLA", "APA" хэлбэрийг ашиглаж эшлэл авч эсхүл өөрийн үгээр давтаж буруу ойлголт болон аль нэг талыг илт баримталсан байдлыг олж илрүүлнэ.
- Сурагчид хамран ажиллах орчинд дүрэм журам тогтоох, зөвшилцөлд хүрэх замаар ажиллана.

**Англи 9 Эрчимжүүлсэн (22132)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх Англи хэлний хичээлүүд дээр өндөр оноо авсан байх. Багш болон/эсхүл зөвлөхийн зөвлөснөөр*
**Эдгээр тусгай хичээлүүд нь Англи хэл 9-ийн үндсэн бүтэц, агуулгыг дагах боловч илүү эрчимтэй байх болно**.
Энэ хичээлийг авьяастай, ахисан шатны сурагчдад зориулсан. Их уншиж, бичиж, дүрэм болон үгсийн санг эрчимтэй гүнзгийрүүлж, баримтат зохиол, уран зохиол, жүжиг, шүлгийг эрчимжүүлэн сурч, Англи хэл уран зохиолын хичээлийн бүх салбараар Англи 9-ийн түвшнээс илүү **өндөр** хэмжээнд үр дүн гаргахыг шаардана. Сурагчид уламжлалт, орчин үеийн уран зохиолыг өргөн хүрээнд уншиж, "хувь чанар" гэсэн сэдэвтэй холбож өөрийн ойлголтыг харуулж сайтар бичих чадвараа хөгжүүлж, ирээдүйд AT/IB/DE хичээлүүдийн шаардлагыг хангахад бэлтгэнэ.

**Англи хэл 10 (21140)**
**Бүтэн жил, нэг кредит**
*"Хамт олон, орчин"* нь 10-р ангийн голлох сэдэв байх болно. Сургалтын хөтөлбөрийн гол сэдвүүд ойлголтоо сайжруулах, гол чухал асуудлууд дээр төвлөрч, аравдугаар ангийн SOL-д нийцнэ.
- Уран зохиол болон баримтат зохиолын харьцуулах хэлбэрээр уншсанаа ойлгох чадварт үргэлжлүүлэн анхаарах болно. Сурагчид янз бүрийн үндэстний уран зохиолыг соёлын бөгөөд нийгмийн үүрэг талаас нь болон бүгдэд хамааралтай талаас нь шинжилнэ. Аравдугаар ангийн сурагчид асуудал шийдэх, асуулт асуух, шинэ мэдлэг түгээхийн тулд баримтад зохиолыг шинжилж, холбоо учрыг тунгаана.
- Сурагчид үгийн үндэс, дагаврыг хэрэглэж үгсийн сангаа үргэлжлүүлэн хөгжүүлэх ба дам утга, хэлц үг, ёгт үг, үгийг өөр утгаар ашиглахад анхаарал тавина.
- Сурагчид ятгах, шинжилж тайлбарлах бичиг/найруулгын аргачлалыг хэрэглэхийн зэрэгцээ байр сууриа, учир шалтгаанаа, найдвартай эх сурвалжаар баталсан нотолгоогоо харуулна.
- Сурагчид хэвлэлийн мэдээ бэлтгэж, олон нийтийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн үзэл бодлын чиг хандлагын хоорондын харилцааны учир шалтгааныг шинжилж үзнэ. Сурагчид бие дааж болон бүлгээр танилцуулга хийхэд олон төрлийн арга хэрэгслийг үргэлжлүүлэн ашиглана.
- Сурагчид "MLA", "APA" хэлбэрийг ашиглаж эх сурвалжийг үнэлэхийн зэрэгцээ янз бүрийн эх сурвалжаас олж авсан мэдээллийг танилцуулах чадвараа цааш бэхжүүлж, буруу ойлголт болон аль нэг талыг барьсан байж магадгүй эсэхийг таньж олно.
- Сурагчид бие даан, бүлгээр ажиллаж ур чадвартай харилцагч байх чадварт үргэлжлүүлэн суралцаж, өөр бусад үзэл санааг танилцуулж, нийтлэг зорилгын дагуу ажиллана.

**Англи 10 Эрчимжүүлсэн (21142)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх Англи хэлний хичээлүүд дээр өндөр оноо авсан байх. Багш болон/эсхүл зөвлөхийн санал болгосноор*
**Эдгээр тусгай хичээлүүд нь Англи хэл 9-ийн үндсэн бүтэц, агуулгыг дагах боловч илүү эрчимтэй байх болно**.
Энэ хичээлийг авьяастай, ахисан шатны сурагчдад зориулсан. Их уншиж, бичиж, дүрэм болон үгсийн санг эрчимтэй гүнзгийрүүлж, баримтат зохиол, уран зохиол, жүжиг, шүлгийг эрчимжүүлэн сурч, Англи хэл уран зохиолын хичээлийн бүх салбараар Англи 10-ийн түвшнээс илүү **өндөр** хэмжээнд үр дүн гаргахыг шаардана. Сурагчид уламжлалт, орчин үеийн уран зохиолыг өргөн хүрээнд уншиж, "нийгэмлэг" гэсэн сэдэвтэй холбож өөрийн ойлголтыг харуулж бичих чадвараа хөгжүүлж, ирээдүйд AT/IB/DE хичээлүүдийн шаардлагыг хангахад бэлтгэнэ.

**Англи хэл (10035)**
***Хичээлийн төгсгөлийн [end-of-course (EOC)]-ийн SOL шалгалтуудыг 11-р ангийн Англи хэлээр авна. Эдгээр шалгалтууд нь хоорондоо харилцан холбоотой, 9, 10, 11-ийг хамарна. SOL шалгалтад тэнцэх, мөн хичээлээр хоёр баталгаажсан кредит өгнө.***

> **Англи хэлний хичээлийн төгсгөлийн шалгалтад Бичих** (3-р сар), **Унших** (5-р сар) багтана.

**Англи хэл 11 (21150)**
**Бүтэн жил, нэг кредит**
*"Үндэстний харах өнцөг"* нь 11-р ангийн гол сэдэв байна. Сургалтын хөтөлбөрийн гол сэдвүүд ойлголтоо сайжруулах, гол чухал асуудлууд дээр төвлөрч, 11-р ангийн SOL-д нийцнэ.

- Уран зохиол болон баримтат зохиолоос уншсанаа ойлгох чадварт тогтвортой анхаарах болно. Сурагчид ижил сэдвийг тойрсон олон төрлийн зүйлийг уншиж, зохиогчид нь төсөөтэй буюу ялгаатай тайлбарыг хэрхэн хийж байгаа талаар харьцуулалт хийнэ. Сурагчид Америкийн түүх, соёлд илрэх соёл иргэншлүүдийн хувь нэмрийг тодорхойлж, өргөн дэлгэрсэн сэдвүүд, дүрслэлүүдийг зааж өгсөн Америкийн зохиолчдын уран зохиолыг үзэж, дүн шинжилгээ хийнэ.
- Сурагчид үгсийн сангаа үргэлжлүүлэн хөгжүүлэх ба дам утга, хэлц үг, ёгт үг, үгийг өөр утгаар ашиглахад анхаарал тавина.
- Сурагчид ятгах, олон талын зорилгоор үндэслэл гаргаж тайлбарлах буюу уншигчийн анхаарлыг татах, цэгцтэй, оновчтой бичих бичиг/найруулгын аргачлалыг үргэлжлүүлэн хэрэглэнэ.
- Сурагчид хэвлэлийн мэдээ бэлтгэж, олон нийтийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн үзэл бодлын чиг хандлагын хоорондын харилцааны учир шалтгааныг шинжилж үзнэ. Сурагчид өөр өнцгөөс харахыг итгүүлэн үнэмшүүлэх олон загвартай танилцуулгыг бүтээнэ.
- Сурагчид анхдагч болон дам эрх сурвалжаас мэдээлэлд синтез хийсэн судалгааны ажил хийх ба чингэхдээ мэдээлэл цуглуулах, хэрэглэх ёс суртахуун, хуулийн шаардлагуудыг анхаарна.
- Сурагчид бие дааж болон бүлгээр ажиллах харилцааны чадваруудаа үргэлжлүүлэн сайжруулна. Сурагчид өөр санаа оноог тайлбарлахын хамт хамтын зорилгын төлөө ажиллаж, бүлгийн ажилд оролцох чадвараа үргэлжлүүлэн харуулна.

Эдгээр тусгай хичээлүүд нь Англи хэл 11-ийн үндсэн бүтэц, агуулгыг дагах боловч илүү эрчимтэй байх болно.

**Англи хэл, найруулга зүй, AT (31196)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11.**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх Англи хэлний хичээлүүд дээр өндөр оноо авсан байх.*
*Багш/зөвлөхийн зөвлөснөөр*
Англи хэл, бичлэгийн ахисан түвшинд орох хичээлээр янз бүрийн цаг үе, төрөл жанр, илэрхийллийн Америкийн үргэлжилсэн үгийн зохиолуудыг унших чадвартай болж, олон янзын зорилгоор сайн бичих чадвартай болоход сурагчдад тусална. Сурагчид зохиогчийн зорилго, илэрхийллийн сонголт, уншигчдын хүлээлт, дүрүүдийн хоорондын холбооны талаар болон уран зохиолын төрөл, хэлний эх үүсвэр үр нөлөөтэй бичихэд хэрхэн нөлөөлдөг талаар мэдэж авна. Ангийн үнэлгээ шалгалтуудаар олон сонголттой тест, чөлөөт бичиглэлийн гэсэн хоёр хэсэгтэй Коллежийн зөвлөлийн шалгалтад бэлтгэнэ. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (21196)*

**Англи хэл 11, (Коллежийн Найруулга зүй) хос төгсөлт (91150W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 11.**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх Англи хэлний хичээлүүд дээр өндөр оноо авсан байх. Багш/зөвлөхийн зөвлөснөөр NVCC-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой.*
Энэ хичээлээр Виржиниагийн 11-р ангийн Сургалтын стандартыг авч үзэж, сурагчдад шүүмжит сэтгэлгээ, академик бичиглэлийн үндсийг танилцуулна. Бичих замаар сурагчид сэдвийг нарийвчилна; алив нэг санааг гаргаж, дэмжинэ; тохирох эх сурвалжийг судалж, үнэлж, нэгтгэнэ; үр дүнтэй арга барил хэрэглээний үүднээс засварлана; янз бүрийн контекст, уншигчид, зорилгын үүднээс тохирох зорилтыг тодорхойлно. Сурагчид ядаж нэг бичлэгийг танилцуулж, үүгээр

аргумент дэвшүүлэх бичих ажиллагаанд багтах ба үүний тулд эх сурвалжийг олж, үнэлж, нэгтгэж, баримтжуулж, хэв маяг, хэрэглээний үүднээс засварлана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College ENG 111 / ENG 112-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага [Remedial Independent Self-Paced Education (RISE)]**
**(RISE) Бичих (20201)**
**(RISE) Унших (20202)**
**Нэг улирал, хагас сонгох кредит**
**Ангиуд: 11-12**

Сурагчид хичээлийг дүүргэсэн боловч SOL шалгалтад унасан бол академик хичээлийн салбарт давтлага хийнэ. Багшийн зааврааc гадна сургалтын программ хангаж, онлайн хөтөлбөрийг хэрэглэж магадгүй. Ихэнх сурагчдын ажил нь бие даасан ажил байх болно. Шаардлагатай бол багш тусална.

**Англи хэл 12 (21160)**
**Бүтэн жил, нэг кредит**

*"Хүч"* нь 12-р ангийн голлох сэдэв байна. Сургалтын хөтөлбөрийн гол сэдвүүд ойлголтоо сайжруулах, гол чухал асуудлууд дээр төвлөрч, 12-р ангийн SOL-д нийцнэ.

- Уран зохиол болон баримтат зохиолоос уншсанаа ойлгох чадварт тогтвортой анхаарах болно. Сурагчид олон тооны зүйл уншиж, шийдвэр гаргах, асуудал шийдэх эх сурвалжийг олж, үнэлнэ. Сурагчид Их Британийн болон дэлхийн зохиолчдын уран зохиолыг уншиж, дүгнэлт хийх явцдаа зохиолчид хэрхэн утга агуулга өгөхийн тулд гол элементүүдийг хэрэглэж, сэдвүүд нь зохиолын явцад хэрхэн холбогдож байгаа талаар үнэлнэ.
- Сурагчид үгсийн сангаа үргэлжлүүлэн хөгжүүлэх ба дам утга, хэлц үг, ёгт үг, үгийг өөр утгаар ашиглахад анхаарал тавина.
- Сурагчид ятгах, олон талын зорилгоор үндэслэл гаргаж тайлбарлах буюу уншигчийн анхаарлыг татах, цэгцтэй, оновчтой бичих бичиг/найруулгын аргачлалыг үргэлжлүүлэн хэрэглэнэ. Сурагчид ажлын байранд, дунд сургуулийн дараа хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд бичнэ.
- Сурагчид хэвлэлийн мэдээ бэлтгэж, олон нийтийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн үзэл бодлын трендийн хоорондын харилцааны учир шалтгааныг шинжилж үзнэ. Сурагчид бие дааж болон бүлгээр ятгах/үндэслэл гаргах олон загварт танилцуулгуудыг хийнэ.
- Сурагчид анхдагч болон дам эрх сурвалжаас мэдээлэлд синтез хийсэн судалгааны ажил хийх ба чингэхдээ мэдээлэл цуглуулах, хэрэглэх ёс суртахуун, хуулийн шаардлагуудыг анхаарна.
- Сурагчид хамтын зорилгын төлөө ажиллаж, янз бүрийн гишүүдтэй бүлгүүд, ажлын хэсгүүдэд оролцох чадвараа үргэлжлүүлэн харуулна.

Эдгээр тусгай хичээлүүд нь Англи хэл 12-ийн үндсэн бүтэц, агуулгыг дагах боловч илүү эрчимтэй байх болно.

**Англи хэлний уран зохиол, найруулга зүй, AP/AP (31195)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 12**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх Англи хэлний хичээлүүд дээр өндөр оноо авсан байх.*
*Багш/зөвлөхийн зөвлөснөөр*

Англи хэлний уран зохиол, найруулга зүй гэсэн ахисанд шатны хичээлийг дэлхийн зөгнөлт уран зохиолыг нарийн тунгааж унших, шүүмж хийхэд сурагчдыг оролцуулахад зориулсан. Сонгож авсан зүйлсийг нарийн тунгааж унших замаар зохиогчид уншигчдад санаагаа илэрхийлж, таашамж өгөхөд хэлийг хэрхэн ашиглаж байгааг сурагчид илүү сайн ойлгох болно. Унших явцдаа сурагчид зохиолын бүтэц, хэв маяг, үндсэн санаа, орчин, сэдэв төдийгүй үгийг өөр утгаар ашиглах, имиж, бэлэг тэмдэг, хэмнэл, өгүүлбэр зүй, аяз гэх зэрэг илүү нарийн элементүүдийг авч үзэх болно. Ангийн үнэлгээ шалгалтуудаар олон сонголттой тест, чөлөөт бичиглэлийн гэсэн хоёр хэсэгтэй Коллежийн зөвлөлийн шалгалтад бэлтгэнэ. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (21195)*

**Англи хэл 12, (Коллежийн Найруулга зүй) хос төгсөлт (91160W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 12**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх Англи хэлний хичээлүүд дээр өндөр оноо авсан байх. Багш/зөвлөхийн зөвлөснөөр NVCC-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой.*

Энэ хичээлээр Виржиниагийн 11-р ангийн Сургалтын стандартыг авч үзэж, сурагчдад шүүмжит сэтгэлгээ, академик бичиглэлийн үндсийг танилцуулна. Бичих замаар сурагчид сэдвийг нарийвчилна; алив нэг санааг гаргаж, дэмжинэ; тохирох эх сурвалжийг судалж, үнэлж, нэгтгэнэ; үр дүнтэй арга барил хэрэглээний үүднээс засварлана; янз бүрийн контекст, уншигчид, зорилгын үүднээс тохирох зорилтыг тодорхойлно. Сурагчид ядаж нэг бичлэгийг танилцуулж, үүгээр аргумент дэвшүүлэх бичих ажиллагаанд багтах ба үүний тулд эх сурвалжийг олж, үнэлж, нэгтгэж, баримтжуулж, хэв маяг, хэрэглээний үүднээс засварлана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College ENG 111 / ENG 112-д давхар бүртгүүлж болно 112. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Англи хэл 12, (Их Британи, Дэлхийн уран зохиол) Хос төгсөлт (91161W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 12**
*Урьдчилсан шаардлага: Англи хэл 11, Коллежийн Найруулга зүй, DE (91150W) эсхүл Англи хэл 12, Коллежийн Найруулга зүй, DE (91160W)-ийг амжилттай төгсссөн байх. NOVA ENG 111 & ENG 112.*
Энэ хичээлээр Виржиниагийн 12-р ангийн сургалтын стандартыг анхаарч, Их Британи, Дэлхийн уран зохиолын гол зохиолуудыг үзнэ. Сурагчид Англосаксоны үеэс өнөөг хүртэлх англи хэлний уран зохиолыг сурч, Их Британийн уран зохиолын уламжлалын үндсэн санаа, шинжүүдийг тодорхойлно. Сурагчид каноны үеэс өнөөг хүртэлх дэлхийн уран зохиолын гол бүтээлүүдийг судална. Энэ хичээлээр шүүмжит уншлага, бичих дадлагыг хийнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College ENG 251 / ENG 243-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

## СОНГОХ АНГЛИ ХЭЛ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛҮҮД

Сурснаа баяжуулах, амжилтаа дээшлүүлэх, буюу өөрийн сонирхлоор сурагчид доор жагсаасан хичээлүүдийг өөрийн **Үндсэн англи хэл, уран зохиолын хичээлүүд** дээр нэмж авч болно.

**Уншлагын элементүүд ба стратеги (21180)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: TBD сургуулиар**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлийг авиа зүй, авиалбарын ойлголт, чөлөөтэй унших, үгсийн сан ба/эсхүл ойлголтын талаар нэмэлт сууpь авбал зохих сурагчдад ихээхэн хэмжээгээр зөвлөж байна. Хичээлээр нэгдсэн шалгах хэрэгслээр тодорхойлогдсон сурагчийн унших чадварын түвшинд тохирсон уран зохиол болон баримтат зохиолыг өгөх ба SOL шалгалтад бэлтгэхэд тохирох жижиг уншлагууд багтана.

**Англи хэл 11 Үргэлжлүүлэх (21185)**
**Бүтэн жил, нэг сонгох кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Англи хэл 11-д давхар бүртгүүлсэн Англи хэл суралцагчдын хичээлээс саяхан гарсан.*
Энэ хичээлийг Англи хэл суралцагчдын хөтөлбөрөөс саяхан гарсан бөгөөд Англи хэлний хичээл болон EOC Англи хэлний шалгалтад амжилт гаргахын тулд унших, бичих нэмэлт дэмжлэг хэрэгтэй байгаа сурагчдад зориулсан. Сурагчид ахлах сургууль ба түүнээс гадна шаарддаг ур чадвар болох анализ хийж унших, бичих чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг авна.

**Кино судлал (21446)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**Ангиуд: TBD сургуулиар**
*Урьдчилсан шаардлага:*
Энэ хичээлээр кино, киноны продакшн, түүхийн суурийг сурагчдад өгнө. Сурагчид хөдөлгөөнт зургийн кинонд хэрэглэх кино үйлдвэрлэгчдийн үндсэн концепц, аргачлалын талаар танилцана. Киног техник талаас нь сурсны дараа сурагчид сонгодог кинонуудыг үзэж, эдгээрийн уран бүтээлийн ач холбогдлыг үнэлнэ. Хичээлээр кино судлалын үндсэн зүйлс болохын хувьд сурагчид өөрсдийн ярих, бичих харилцааны чадваруудаа сайжруулна. *Энэ хичээлээ авсан кредит Карьер, техник/Урлагийн төгсөлтийн кредитийн шаардлагыг хангана.*

**Динамик харилцаа (21517)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр динамик харилцааны үйл явцыг онцгойлон үзнэ: ярих, сонсох, хариулах. Хоолой засах, нүүрний хувирал, сонсогчоо анхаарах нь энэ үйл явцын чухал бүрдэл хэсгүүд юм. Сурагчид үр дүнтэй харилцах, танилцуулах, үг хэлэх, ярилцлага болон бусад нийгэм/бизнесийн яриа хэлэлцүүлгийн дадлага туршлага хийнэ.

**Сэтгүүл зүй Радио телевиз (21518)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Англи хэлний багшийн зөвлөмж, өргөдөл гаргах, ба/эсхүл зааварлагчтай хийсэн ярилцлага.*
Энэ хичээлийн ангийн ажлаар сурагчид тогтмол цацах сургуулийн мэдээг хийнэ. Сурагчид мэдээлэх арга, техник, продакшн, радио, телевиз, интернэт, видео/кино медиагаар мэдээ, мэдээний хөтөлбөр гаргах талаар хичээлээр танилцана. Удиртгалаар мэргэжлийн сэтгүүлчид, найруулагчид, продюссерүүд, найруулагчид, менежерүүдийн мэргэжлийн хариуцлагын талаар мэдэж авна. Сурагчид мөн нэвтрүүлгийн технологийн зармууд; мэдээ нэвтрүүлэг; хөтөлбөр; дуу; видео/кино найруулах; хөтөлбөрийн дизайн, продакшн; мэргэжлийн стандарт, ёс зүйн талаар амьдралын туршлага олж авна. Хичээлийн тодорхой агуулга ахлах сургууль бүрд өөр; холбогдох мэдээллийг зааварлагчаас авна уу.

**Сэтгүүл зүй Уран зохиолын сэтгүүл (21207)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Англи хэлний багшийн зөвлөмж, өргөдөл гаргах, ба/эсхүл зааварлагчтай хийсэн ярилцлага.*
Энэ хичээлийн сурагчид сурагчдын уран зохиолын бичиглэл, дагалдах уран бүтээлийг сэтгүүлд нийтлэх ажил хийнэ. Зөгнөлт, баримтат зохиол, шүлэг, жүжиг, хөгжмийн зохиолыг нийтлэлийн үеэр зохиож ба/эсхүл найруулна. Дүрслэх урлаг, фото зураг, хэвлэлийн дизайныг нийтлэлийн мөчлөгөөр зохицуулж, сайжруулна. Хичээлийн тодорхой агуулга ахлах сургууль бүрд өөр; холбогдох мэдээллийг зааварлагчаас авна уу.

**Сэтгүүл зүй Сонин (21205)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Англи хэлний багшийн зөвлөмж, өргөдөл гаргах, ба/эсхүл зааварлагчтай хийсэн ярилцлага.*
Энэ ангийн ажлын сурагчид тогтмол нийтлэх сургуулийн хэвлэмэл сонин ба/эсвэл веб хуудас хийхэд ажиллана. Хэвлэл нийтлэлийн бичиглэлд энэ хичээлээр голлож анхаарна. Бичиглэлд мэдээ, голлох нийтлэл, эрхлэгчийн захидал, биеийн тамир, үзэл бодол, шүүмж багтана. Ярилцлага, судалгааны арга барилыг эх бэлтгэхэд ашиглана. Эх бичвэрийг найруулах, бүтэц ба дизайн, зураг чимэглэл, гарчиг өгөх, гэрэл зураг ба цахим зураг ажилбар, янз бүрийн хэвлэлийн арга замуудыг багтааж сонин хэвлэлийн продакшны арга ажиллагаа. Хичээлийн тодорхой агуулга ахлах сургууль бүрд өөр; холбогдох мэдээллийг зааварлагчаас авна уу.

**Сэтгүүл зүй Жилийн ном (21209)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Англи хэлний багшийн зөвлөмж, өргөдөл гаргах, ба/эсхүл зааварлагчтай хийсэн ярилцлага.*
Энэ ангийн ажлын сурагчид Хичээлийн жилийн номыг хэвлэхэд ажиллана. Сурагчид онцлох сэдэв, гарчиг, зурагт холбогдох бичиглэлийг багтааж ихэнх ажилд холбогдож нийтлэл бичнэ. Сурагчид сэтгүүл хийх арга барилыг суралцаж, дадлагажна: харагдах байдал, гол сэдэв, эх бичвэрийг найруулах, зураг чимэглэл, зураг засах, макет, нийтлэх аргачлал. Хичээлийн тодорхой агуулга ахлах сургууль бүрд өөр; холбогдох мэдээллийг зааварлагчаас авна уу.

## ЭРҮҮЛ МЭНД, БИЕ БЯЛДРЫН БОЛОВСРОЛ

Төгсөлтөд эрүүл мэнд, биеийн тамирын хоёр жилийн сургалт шаардлагатай. Энэ шаардлагыг биелүүлэхийн тулд сурагчид 9, 10-р ангийн эрүүл мэнд, биеийн тамирын хичээлийг хийх хуваарьтай байдаг. 11, 12-р ангийн биеийн тамирын хичээлийг улирал эсхүл жилээр сонгож болно. Тусгайлсан биеийн тамирын хичээлийн хөтөлбөрийг 9-12-р ангиудад мөн гаргасан байдаг.

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр*

*хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Эрүүл мэнд I (27320)**
**Нэг улирал, хагас кредит**
**Ангиуд: 9**
Энэ хичээлд эрүүл мэндийн талаарх янз бүрийн мэдээлэл, дадлыг багтаана. Сурагчид эрүүл мэндийн талаар мэдэж, өөртөө, гэр бүлдээ, орчин тойрондоо эрүүл амьдралын хэв маягийг түгээгч болно. Сурагчид анхны тусламжийн мэдлэг олж авч, AED багаж хэрэглэх, CPR хийхтэй холбоотой мэдлэгийг олж авна. Сургалтад сэтгэл хөдлөл, сэтгэл зүй, нийгэм, хүрээлэн буй орчны эрүүл мэнд, аюулгүй байдал, яаралтай тусламжид бэлэн байх, харилцаа, бодис буруугаар хэрэглэх, өвчнөөс урьдчилсан сэргийлэх, гэр бүлийн амьдралын боловсрол багтана.

**Эрүүл мэнд, Бие бялдрын боловсрол (27330)**
**зөвхөн Washington-Liberty ба Wakefield**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 9**
*Урьдчилсан шаардлага: ELD хичээлүүдэд давхар бүртгүүлэх*
Энэ хичээлийг англи хэлээр ярих чадвар хязгаартай сурагчдад эерэг бие бялдар/эрүүл мэндийн боловсрол олгоход зориулсан. Судлах сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд, аюулгүй байдал болон онцгой байдалд бэлэн байх, харилцаа, мансууруулах бодисын хэрэглээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гэр бүлийн амьдралын боловсрол зэрэг багтана.

**Эрүүл мэнд, Бие бялдрын боловсрол I (27300)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл эрүүл мэндтэй холбоотой олон янзын чадвар, хандлагыг нэгтгэж, өөрийн мэдлэг, чадварыг амьдралын янз бүрийн үйл ажиллагаанд биечлэн харуулах боломжийг сурагчдад олгоно. Сурагчид эрүүл мэндийн талаар мэдэж, өөртөө, гэр бүлдээ, орчин тойрондоо эрүүл амьдралын хэв маягийг түгээгч болно. Сурагчид яаралтай тусламж үзүүлэх, AED хэрэглэх, CPR хийхэд шаардлагатай бодит чадварыг багтааж өөрсдийн мэдлэгийг хэрэглэж, харуулна. Судлах сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд, аюулгүй байдал болон онцгой байдалд бэлэн байх, харилцаа, мансууруулах бодисын хэрэглээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гэр бүлийн амьдралын боловсрол зэрэг багтана. Хичээлд энерги, хоол хүнсний тэнцлийг хангах чухлыг харуулна. Сурагчид өөрсдийн биеэ тамиржуулахын тулд биеийн тамирын зорилтоо тодорхойлж, биеийн тамир, биохими, бие махбодын талаар ойлголт авна.

**Эрүүл мэнд болон бие бялдрын боловсрол II (27400)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 10**
*Урьдчилсан шаардлага: Эрүүл мэнд болон бие бялдрын боловсрол I*
Сурагчид эрүүл мэндийн мэдлэг, чадвараа харуулна. Сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд; аюулгүй байдал болон онцгой байдалд бэлэн байх; харилцаа; мансууруулах бодисын хэрэглээ; өвчнөөс урьдчилан сэргийлэх; гэр бүлийн амьдралын боловсрол; эрүүл мэнд/анагаахын мэргэжлийг сурталчлах зэрэг багтана. Сурагчид янз бүрийн дасгал үйл ажиллагаанд оролцох замаар биеийн биомеханик дасгал, бие махбодын зарчмуудыг ойлгоно. Энэ хичээлээр ганцаарчилсан, бүлгийн, бүжгийн, чөлөөт цагийн зорилтуудаар насан туршдаа биеэ хөнгөн сайн байхад анхаарна. Өөрийн биеийн тамирын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлж, үнэлж, өөрчлөх замаар биеийн тамирыг сахихад илүү анхаарна.

**Биеийн тамирын тусгай боловсрол (27670), 9-р анги**
**Биеийн тамирын тусгай боловсрол (27680) 10-р анги**
**Биеийн тамирын тусгай боловсрол (27690) 11-р анги**
**Биеийн тамирын тусгай боловсрол (27700) 12-р анги**

Эцэг эх, засалч ба/эсхүл эмч, эсхүл өрхийн эмчийн зөвлөснөөр сургуулийн сувилагч сурагчийг тусгайлсан Биеийн тамирын хичээлд бүртгэж авч болно. Тухайн хүнд тохирсон биеийн тамирын дасгалыг эцэг эх, сургуулийн сувилагч, өрхийн эмч, зааварлагчийн тусламж, хамтын ажиллагаагаар боловсруулна. Өрхийн эмч сурагчийн хөгжлийн бэрхшээлд үүдэж хийж болохгүй дасгалыг нэрлэж өгнө.

**Эрүүл мэнд, бие бялдар ба жолоочийн боловсрол II (27410)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 10**
*Урьдчилсан шаардлага: Эрүүл мэнд, бие бялдрын боловсрол I, жолооны сургалтын аюулгүй байдлын уулзалтад эцэг эх, сурагч байх ёстой (муж улсын хууль)*
Сурагчид эрүүл мэнд, биеийн тухтай байдлын тухай мэдлэг, чадварыг харуулж, жолооны ангийн

хичээлийг дүүргэнэ. Сэдвүүдэд сэтгэл зүйн, сэтгэл мэдрэлийн, нийгмийн болон орчны эрүүл мэнд; аюулгүй байдал болон онцгой байдалд бэлэн байх; харилцаа; мансууруулах бодисын хэрэглээ; өвчнөөс урьдчилан сэргийлэх; гэр бүлийн амьдралын боловсрол; эрүүл мэнд/анагаахын мэргэжлийг сурталчлах зэрэг багтана. Сурагчид янз бүрийн дасгал үйл ажиллагаанд оролцох замаар биеийн физиологи, биомеханик, бие махбодын зарчмуудыг ойлгоно. Энэ хичээлээр ганцаарчилсан, бүлгийн, бүжгийн, чөлөөт цагийн зорилтуудаар насан туршдаа биеэ хөнгөн сайн байхад анхаарна. Өөрийн биеийн тамирын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлж, үнэлж, өөрчлөх замаар насан туршдаа биеийн тамирыг сахихад илүү анхаарна. Жолооны танхимын сургалт нь аюулгүй жолоодох хандлага, чадварыг хөгжүүлэх, эрсдэлийн талаар ойлгох, сэрэмжтэй байх, жолоочийн анхаарал сарних, машин жолоодохтой холбоотой нийгэм, эдийн засгийн үр дагаврууд, машинд сууж байгаа хүмүүсийг хамгаалах, замд байгаа бусад хүмүүстэй эерэг харилцах, жолоочийн чадварт нөлөөлөх биеийн ба сэтгэл санааны байдалд анхаарлаа төвлөрүүлнэ. Сурагчид болон тэдний эцэг эх/асран хамгаалагчид Муж улсын хуулийн дагуу (§22.1-205; HB1782) эцэг эх/сурагчийн жолооны хичээлийн уулзалтад оролцох ёстой. Wakefield нь улиралд хоёр уулзалтыг зохион байгуулна. Энэ хичээлийг амжилттай дүүргэж, уулзалтад оролцсоноор сурагч Жолоочийн боловсролын гэрчилгээ (DEC-1) авна. Амжилттай төгссөнөөр 19 нас хүрээгүй сурагчид Виржиниагийн жолооны үнэмлэх авах зарим нөхцөлүүдийг хангана (сурагч жолооны дадлагын шалгалтыг өгөх ёстой).

## СОНГОХ БИЕИЙН ТАМИРЫН ХИЧЭЭЛҮҮД

**Биеийн тамир III (27510)**
**1-р улирал; (27515) 2-р улирал**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**Ангиуд: 11-12**
**Биеийн тамир IV (27610)**
**1-р улирал; (27515) 2-р улирал**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Биеийн тамир I, II*
Энэ хичээлээр сурагчдад тусгайлсан зорилгоор биеийн тамирын дасгал хийх боломж олгоно. Тусгайлсан дасгалын хичээлийг санал болгох боломжуудыг сурагчийн хэрэгцээний дагуу тохируулна. Сурагчид дараах жишээнүүдээс өөрийн анхаарч суралцах зүйлээ сонгоно:

- Айзамт гимнастик
- Усан спорт (сэлэх, завь, аврагч)
- Бүжиг
- Ганцаарчилсан спорт/үйл ажиллагаа
- Гадаа агаарт хийх спорт
- Ахисан шатны хүндийн өргөлт, фитнес
- Скейт
- Өөрийгөө хамгаалах

## АНГЛИ ХЭЛ СУРАЛЦАГСДЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Англи хэлний суралцагчийн (EL) үйлчилгээ нь EL үйлчилгээнд хамрагдах оюутнуудад англи хэлийг хөгжүүлэх боломжийг олгодог. Англи хэл хөгжүүлэх (ELD) сургалтын хөтөлбөрийг WIDA Англи хэл мэргэшлийн стандарт болон Виржиниа мужийн суралцах стандартад нийцүүлсэн.

Англи хэл суралцагчид ESOL болон англи хэлний урлагийн чиглэлээр давхар гэрчилгээ авсан багш нартай хамт хэлний сургалтыг (хоёр хугацааны блок) авдаг. EL-үүд шинжлэх ухаан, нийгмийн ухааныг ESOL-ийн сертификаттай багштай хамт ангид эсвэл ерөнхий сургалтаар хичээл заадаг. Мөн EL-үүд ерөнхий сургалтын сонголтоор болон биеийн тамирын хичээлд оролцдог. Сурагчдын бэлэн байдалд нь суурилан математикийн хичээл санал болгодог. Англи хэлний кредитийг EL-ийн англи хэлний мэдлэгийн түвшинтэй уялдуулан заавраар хангадаг англи хэлний сургалттай ангиудад суралцдаг. Эдгээр курсуудыг амжилттай дүүргэснээр EL-үүд төгсөлтийн англи хэлний шаардлагыг хангах боломжийг олгодог. Нэмэлт ELD хичээлээр доор зааснаар сонгох эсхүл агуулгын кредит авна.

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

## СОНГОХ АНГЛИ ХЭЛ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛҮҮД

**Бүтэн жил**
***Эдгээр сургалтууд нь англи хэл суралцагчид болон тэдний англи хэлний мэдлэгийн түвшинийг тогтоохоод зориулагдсан англи хэлний ангийн түвшиний сургалтууд юм. Хичээлийн тайлбарыг Англи хэлний сургалт хэсгээс үзнэ үү.***
**Англи 9 (21130E1, 21130E2, 21130E3, 21130E4)**
**Англи 10 (21140E1, 21140E2, 21140E3, 21140E4)**
**Англи 11 (21150E1, 21150E2, 21150E3, 21150E4)**
**Англи 12 (21160E1, 21160E2, 21160E3, 21160E4)**

**Англи хэл хөгжүүлэх (ELD) хичээлийн саналууд**
**Бүтэн жил**
*Англи хэлний түвшний үнэлгээ дээр үндэслэж бүртгэж авна*

**20775 ELD 1/SLIFE* Бичиг үсэг тайлал** *(сонгон суралцах кредит)*Шаардлагатай бол төрөлх хэлний дэмжлэг үзүүлнэ.

**20776 ELD 1/SLIFE Reading** *(сонгон суралцах кредит)*

**20780 ELD 1 Шинжлэх ухаан** *(сонгох кредит: шинжлэх ухааны хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангахгүй)*

**20781 ELD 2 Шинжлэх ухаан** *(сонгох кредит: шинжлэх ухааны хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангахгүй)*

**24317 ELD Биологи *(Байгалийн ухааны кредит)***

**24362 ELD Байгаль орчны *ухаан (Байгалийн ухааны кредит)***

**24501 ELD Физикийн зарчмууд** *(Байгалийн ухааны кредит)*

**20787 ELD 1 Уншлага** *(сонгон суралцах кредит)*

**20788 ELD 1 Ярих/Бичих** *(сонгон суралцах кредит)*

**20789 ELD 1 Нийгэм судлал** (*сонгон суралцах кредит)*

**22446 ELD Виржиниа, АНУ-ын засгийн газар**

**20791 ELD 2 Уншлага** *(сонгон суралцах кредит)*

**20794 ELD 3 Уншлага 9** *(сонгон суралцах кредит)*

**20796 ELD 3 Англи хэл 9** *(Англи хэлний кредит)*

**20797 ELD 4 Уншлага 10** *(сонгон суралцах кредит)*

**22345 ELD 3 – 4 Дэлхийн түүх, газарзүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл (Нийгмийн ухааны кредит)**

**22213 ELD Эдийн засаг, хувийн санхүү *(Нийгмийн ухааны кредит)***

## МАТЕМАТИК

Арлингтоны математикийн хичээлийн хөтөлбөрөөр сурагчдад ахлах сургуулийн дараа, ажил мэргэжилдээ, бүтээмжтэй иргэн байхад хэрэгтэй математикт илүү анхаарна. Сурагчдад математикийн хичээлийг жил бүр авахыг зөвлөж байна. Хичээлийн сонголтуудаар сурагчдад амжилт дээрээ үндэслэж цааш ахих боломжуудыг бий болгосон.

Хичээлийн урьдчилсан нөхцөлүүдэд холбогдож хөнгөлөлт, чөлөөлөлт авах эсхүл хос төгсөлтөд бүртгүүлэх сонирхолтой сурагч, гэр бүлүүд Хичээлийн урьдчилсан нөхцөлүүдээс чөлөөлөх гэсний 2-р хуудсыг үзнэ үү. Эдгээр сурагчид өөрсдийн математикийн багштай ярих хэрэгтэй.

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Ахлах сургуулийн ерөнхий математик (23120)**
**Бүтэн жил, нэг <u>сонгох</u> кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид бүхэл тоо, бутархай, аравтын бутархай, хувийг тооцоолж, тааварлахад холбогдох ойлголтоо гүнзгийрүүлнэ. Эдгээр концепцийг хэмжилт, магадлал, статистик, геометрийн салбарт амьдралд ойр асуудал шийдэх маягаар хэрэглэнэ. Сурагчид алгебрын өмнөх агуулгыг суралцах ба үүнд рационал тоо, хувь, бүхэл тоо, хувьсагч, тэгшитгэл, график багтана. ***Энэ хичээл нь математикийн кредитийн шаардлагыг <u>хангахгүй</u>; энэ нь сонгох кредит өгөхгүй.***

**ELD SLIFE Математикийн үндэс (23111)**
**Бүтэн жил, нэг <u>сонгох</u> кредит**
**Ангиуд: 9-11**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлийг ELD хөтөлбөрт бүртгүүлсэн сургууль завсардсан сурагчдад зориулсан. Сурагчид бүхэл тоо, бутархай, аравтын бутархай, хувийг тооцоолж, тааварлахад холбогдох ойлголтоо гүнзгийрүүлнэ. Эдгээр концепцийг хэмжилт, магадлал, статистик, геометрийн салбарт амьдралд ойр асуудал шийдэх маягаар хэрэглэнэ. Энэ хичээл нь математикийн кредитийн шаардлагыг хангахгүй; үүнд нэг сонгох кредит олгоно.

**ELD SLIFE Алгебрын өмнөх (23113)**
**Бүтэн жил, нэг <u>сонгох</u> кредит**
**Ангиуд: 9-11***
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлийг ELD хөтөлбөрт бүртгүүлсэн сургууль завсардсан сурагчдад зориулсан. Сурагчид алгебрын өмнөх агуулгыг суралцах ба үүнд рационал тоо, коэффициент ба хувь, бүхэл тоо, хувьсагч ба тэгшитгэл, график багтана. Агуулга, ажиллагаа, хэлний хөгжилд чиглэсэн янз бүрийн аргачлалыг хэрэглэнэ. **Энэ хичээлийг амжилттай төгссөний дараа Алгебр I эсхүл Алгебр I, Хэсэг I-т бүртгүүлэх гэж буй сурагчдад.** ***Энэ хичээл нь математикийн кредитийн шаардлагыг <u>хангахгүй</u>; үүнд нэг сонгох кредит олгоно.***

**Алгебр I, Хэсэг I (23131)**
**23132 эсхүл 23130-ийг амжилттай дүүргэсний дараа нэг жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Бүтэн жилийн, нэг үеийн хичээл нь бодит тооны системийн шинж чанар, координат, шугаман тэгшитгэл, тэнцэтгэл бусууд, тэнцэтгэлийн тогтолцоо, үйлдэл, шийдлийг багтаана. Стандарт дипломыг тусгай нөхцөлөөр авах сурагчдаас бусад сурагчид энэ хичээлээр сонгох кредит авна. Энэ хичээлээр стандарт дипломыг тусгай нөхцөлөөр авах бол математикийн кредит авна. Энэ хичээлийн дараа сурагчид Алгебр I, Хэсэг II-ийг авах хэрэгтэй. Сурагчид хичээлийн төгсгөлд SOL шалгалт өгөхгүй. Гэхдээ энэ хичээлийн агуулга Алгебр I, Хэсэг II. I-ийн дараах SOL шалгалтад багтана.

**Алгебр I, Хэсэг II (23132)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 9-11**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх математикийн хичээлүүдэд "D" эсхүл түүнээс дээш дүнтэй байсан эсхүл багшийн зөвлөмжөөр*
Бүтэн жил, нэг үеийн хичээлээр Алгебр I, Хэсэг I-ийг үзэх ба дараа нь эдгээр сэдвүүдийг нэмнэ: зэрэг дэвшүүлэгч, язгуур, олон гишүүнт, квадрат тэгшитгэл бодох ба график гаргах, статистик, бодлого бодох. Энэ хичээл нь бүх сурагчдын хувьд математикийн кредитэд тооцогдоно. Алгебр I, Хэсэг I-ийг энэ хичээлээс өмнө авах ёстой. *Сурагчид энэ хичээлийн төгсгөлд Алгебр I SOL шалгалт өгнө. Шалгалтад тэнцэж, хичээлийг дүүргэснээр төгсөлтийн дүнгийн баталгаажсан математикийн кредитийг авна.*

**Алгебр I (23130)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх математикийн хичээлүүдэд "D" эсхүл түүнээс дээш дүнтэй байсан эсхүл багшийн зөвлөмжөөр*
Энэ хичээлд бодит тооны системийн шинж чанар, шугаман тэгшитгэл ба тэнцэтгэл бусууд, тэнцэтгэл ба тэнцэтгэл бусын системүүд, зэрэг дэвшүүлэгч, язгуур, рационал ба тэнцэтгэл, олон гишүүнт, үржүүлэгч болгон задлах, шийдэл, квадрат тэгшитгэл бодох ба график гаргах, функц, статистик, бодлого бодох. Энэ хичээлийн төгсгөлд Алгебр I SOL шалгалтыг өгнө. *SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Алгебр I Стратеги (23124)**
**Бүтэн жил, нэг сонгох кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Алгебрын стратегиуд нь Алгебр I хичээлд амжилттай суралцахад нэмэлт дэмжлэг шаардлагатай сурагчдад зориулсан сонгон суралцах хичээл. Энэ хичээлийг авч буй сурагчид тухайн агуулгын цаад утга санааг ойлгож, түүхэн мэдээллийг авч, материалыг илүү бүрэн дүүрэн, зорилттой ойлгож авна. Алгебр I (23130)-д давхар бүртгүүлэх шаардлагатай.

**Алгебр, функц, дата шинжилгээ (AFDA) (23145)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебр I*
Энэ хичээл нь Алгебр II-ийн сэдвүүдийн концепцийн тоймыг өгөх Алгебр I-ийн үргэлжлэл бөгөөд математикийн загварчлал, дата анализ, статистикийн сэдвүүдийг илүү гүнзгийрүүлж үзэх хичээл байна. Сурахад сониучаар хандах аргачлалыг хэрэглэж, сурагчид функцийн шинж, түүний нөлөөг өргөн хүрээнд сурч, шугаман, квадрат, илтгэгч, логарифмын тэгшитгэл болон тэгшитгэлийн буюу тэгшитгэлийн бус системийн бодлого бодох шаардлагатай байна. Сурагчид эдгээр функцүүдийн талаар ерөнхийд нь ойлгох тул энэ нь дараагийн хичээлүүдээр нарийвчлан үзэх бэлтгэл болно. Магадлал, туршилтын дизайн, хэрэгжүүлэлт, дата анализыг функцийн судалгаанд багтаах ба өгөгдлийг бодит амьдралын бодит үйлдэлд тулгуурлаж гаргаж, боловсруулна. Энэ хичээлийн Алгебр I-ийн дараа болон геометрийн дараа эсхүл геометрийн дараа бөгөөд Алгебр II-ын өмнө авах боломжтой. Үүнийг Алгебр II-ийн дараа авахгүй байх зориулалттай.

**Алгебр II (13135)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебр I-д "C" эсхүл илүү сайн дүн (Алгебр I Эрчимжүүлсэн) ба Геометр (эсхүл Геометр, Эрчимжүүлсэн)*
Энэ хичээл нь Алгебр I, Геометрийн хичээлийн үргэлжлэл. Алгебр II-ийн хичээлийн хөтөлбөрт квадрат, олон өнцөгт, хүч, суурь, язгуур, рационал, функцтэй холбоотой сэдвүүд багтана. Логаритм, илтгэгч функц, цогц тоо, дараалал, цуваа, пермутатор, комбинац, магадлал, статистикийг сургалтад багтаана. Энэ хичээлийн салшгүй хэсэг нь технологи, аппликейшн ашиглах байх болно. *Хичээлийн төгсгөлийн [end-of-course] SOL шалгалтыг Алгебр II-т авахыг Холбооны улсын шаардлагыг хангах ба/эсхүл төгсөлтийн математикийн баталгаажсан кредит авахад шаардаж магадгүй.*

**Алгебр II/Тригонометр, гүнзгийрүүлсэн (23136)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Эрчимжүүлсэн геометр хичээлд "B" эсхүл дээш дүн авсан ба багшийн зөвлөснөөр эсхүл Алгебр, Геометр хоёрт хоёуланд нь "B" ба багшийн зөвлөснөөр*
Алгебр II (23135)-ийн агуулгыг гүнзгийрүүлэн сурахын дээр дараах гарчгуудыг энэ

гүнзгийрүүлсэн хичээлд багтаана: тригонометр, тригонометрийн функц. Энэ хичээлийн салшгүй хэсэг нь технологи, аппликейшн ашиглах байх болно. *Хичээлийн төгсгөлийн [end-of-course] SOL шалгалтыг Алгебр II-т авахыг Холбооны улсын шаардлагыг хангах ба/эсхүл төгсөлтийн математикийн баталгаажсан кредит авахад шаардаж магадгүй.*

**Алгебр III (23155)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II-т "C" эсхүл дээш дүн эсхүл Эрчимжүүлсэн Алгебр II-т "D" ба дээш болон багшийн зөвлөснөөр.*
Энэ хичээл нь тригонометр, ахисан шатны алгебрын сэдвүүдийн гүнзгийрүүлсэн сургалт юм. Тригонометрийн 12-18 долоо хоногийн сургалтад гурвалжин, нэгж тойрог тригонометр, тригонометрийн функц, хэрэглээ багтана. Ахисан шатны алгебрын сэдэв нь өмнөх алгебрын мэдлэгийг гүнзгийрүүлэх, илтгэгч, логарифмын функц, рационалийг багтаана. Нэмэлт сэдвүүдэд магадлал, дараалал, цуваа, дискрит математик багтаж магадгүй. Энэ хичээлийн салшгүй хэсэг нь технологи, аппликейшн ашиглах байх болно.

**Алгебр II Стратеги (23126)**
**Бүтэн жил, нэг сонгох кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Алгебр II стратегийн хичээл нь сонгон суралцах хичээл бөгөөд Алгебр II-т амжилт гаргахын тулд нэмэлт дэмжлэг хэрэгтэй байгаа сурагчдад зориулагдсан. Стратегийн хичээлд суралцаж буй сурагчид тухайн агуулгын цаад санаа, онолын талаас нь илүү харсан арга барилаар ажиллаж, үндсэн хичээлийн агуулгыг илүү бүрэн гүйцэд ойлгож авах болно. Алгебр II (23135)-д давхар бүртгүүлэх шаардлагатай.

**Геометр (23143)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Эрчимжүүлсэн Алгебр I, Алгебр I, Алгебр I Хэсэг II-т "C" ба дээш дүнтэй*
Сурагчид шалтгаант холбоо, шууд ба шууд бус нотолгоог хэрэглэж математикийн бүтцийг сурахад геометрийн үүрэг байдаг. Энэ хичээлээр хувирал, нийцэл, параллель, төсөөтэй байдал, перпендикуляр чанар болон тойрог, олон өнцөгт, биет дүрс зэрэг концепцуудыг багтаана. Алгебр I-ийн концепцуудыг геометрийг зүг чиг болгож хянаж, хэрэглэнэ. *Сурагчид Холбооны улсын шаардлага ба/эсхүл төгсөлтийн математикийн баталгаажсан кредитийг авахын тулд Геометрийн хичээлийн төгсөлтийн SOL шалгалт өгөх шаардлагатай байж магадгүй.*

**Геометр, гүнзгийрүүлсэн (23141)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Эрчимжүүлсэн Алгебр I-д "B" буюу дээш эсхүл Алгебр I-т "A" ба багшийн зөвлөснөөр*
Эрчимжүүлсэн геометр нь энгийн, биет дүрс болон Алгебр I-ийн концепцийг хэрэглэх замаар шалтгаанд холбоог гаргах эрчимтэй хичээл. Сурагчид анхны шууд, шууд бус, дам нотолгоог гаргаж, постулатын системээр шалтгаант холбоог гаргах хэрэгтэй болно. Энэ хичээлийг Ахисан түвшний хөтөлбөрт бүртгүүлэх зорилготой байгаа сурагчдад зориулсан. *Сурагчид Холбооны улсын шаардлага ба/эсхүл төгсөлтийн математикийн баталгаажсан кредитийг авахын тулд Геометрийн хичээлийн төгсөлтийн SOL шалгалт өгөх шаардлагатай байж магадгүй.*

**Геометр, зарчмууд (23142)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Хэрэв сурагч хичээлийг хоёр дахь удаагаа дүүргэж, төгссөн бол Алгебр I, эсхүл Алгебр I Хэсэг II-д "C" буюу дээш эсхүл Алгебр I буюу Алгебр I Хэсэг II-т "D" буюу дээш.*
Геометр, Зарчмууд хичээлээр сурагчид геометрийг хэрэглээ талаас нь ойлгоно. Геометрийн зарчмуудыг хөгжүүлэхэд тохирох алгебрыг хэрэглэж математикийн хичээлийн нэгдсэн байдлыг харуулна. Эдгээр сэдэвт өнцөг, конгруэнт чанар, параллель, гурвалжин, хувирал, дөрвөн өнцөгт, дугуй зэрэг багтана. Координатын болон шалтгаант холбоонд холбогдох шаардлагын хувьд Геометр (23143) хичээлээс илүү хялбар. *Сурагчид Холбооны улсын шаардлага ба/эсхүл төгсөлтийн математикийн баталгаажсан кредитийг авахын тулд Геометрийн хичээлийн төгсөлтийн SOL шалгалт өгөх шаардлагатай байж магадгүй.*

**Геометр Стратеги (23128)**
**Бүтэн жил, нэг сонгох кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Геометрийн стратеги хичээл нь сонгон суралцах хичээл бөгөөд геометрийн хичээлд амжилт гаргахад нэмэлт дэмжлэг хэрэгтэй байгаа сурагчдад зориулагдсан. Стратегийн хичээлд суралцаж буй сурагчид тухайн агуулгын цаад санаа, онолын талаас нь илүү харсан арга барилаар ажиллаж, үндсэн хичээлийн агуулгыг илүү бүрэн гүйцэд ойлгож авах болно. Геометр (23143) эсхүл Геометр, Зарчмууд (23142) хичээлд давхар бүртгүүлсэн байх ёстой.

**Өгөгдлийн шинжлэх ухаан (23195)**
**Бүтэн жил, нэг математикийн кредит (Хэрэв Алгебр II-ийн дараа авсан бол); нэг сонголтын кредит (Хэрэв Алгебр II-ээс өмнө авсан бол)**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебр I эсвэл түргэвчилсэн Алгебр I*
Энэ хичээл нь оюутнуудад өгөгдлийг хэрхэн дүрслэн харуулах, тайлбарлах, өгөгдлийн болзошгүй гажуудлыг тодорхойлох, өөрчлөлт, шинэчлэлийг дэмжих хэрэгсэл болгон өгөгдлийг ашиглах талаар ойлголт өгөх зорилготой юм. Оюутнууд асуулгад суурилсан арга замаар том хэмжээний мэдээллийн багц ашиглан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. Мэдээллийн шинжилгээг математик, статистик, компьютерын шинжлэх ухаан, мэдээллийн технологи ашиглан боловсруулна. Энэхүү сургалтын зорилго нь оюутнуудыг өгөгдөлд суурилсан дэлхий ертөнцийг удирдах чадвартай, дата мэдлэгтэй иргэн болгон бэлтгэхэд оршино.

**Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага (RISE) Алгебр (20203)**
**Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага (RISE) Геометр (20204)**
**Нэг улирал, хагас сонгох кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Холбогдох ангийг төгссөн боловч SOL үнэлгээ дээр унасан, төгсөхөд шаардлагатай баталгаажсан кредит дутуу байгаа сурагчид.*
Сурагчид хичээлийг дүүргэсэн боловч SOL үнэлгээнд тэнцээгүй хичээл дээрээ нөхөж, давтаж сурах/хийх ба үүнд программ хангамжаар өгөх хичээл ба/эсхүл онлайн хөтөлбөр ашиглана. Суралцахад багш туслах боловч ихэнх ажлыг сурагчид бие дааж суралцах маягаар хийнэ. Давтлага хичээлийг Англи хэл (бичих), Англи хэл (унших/уран зохиол, судалгаа), Алгебр I, Геометр, Биологи, Дэлхий шинжлэл, Дэлхийн газар зүй, Дэлхийн түүхээр санал болгоно. *Тайлбар: Сурагчид энэ хичээлийг давах/унах маягаар хийнэ.*

**Дээд тооны удиртгал/Тригонометр (23162)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Алгебр III эсхүл Эрчимжүүлсэн Алгебр II-т "C" буюу дээш эсхүл Алгебр II-т "A" ба багшийн зөвлөснөөр*
Хичээлээр дараах суурь функцүүдээс бүрдэнэ: олон гишүүнт, шугаман, илтгэгч, логарифм, тригонометр. Бусад үндсэн сэдвүүдэд аналитик геометр, параметрийн тэнцэтгэл, туйлын координат, дараалал ба цуваа, дискрит математик, вектор, матриц болон хязгаар, дифференциалын танилцуулга багтана. Сурагчид тригонемтрийн функцүүдийг бодож, тригонометрийн тэнцэтгэл, тригонометрийн адилтгалыг шийднэ. Энэ хичээлээр сурагчдад Дээд тоо AB-г дараа жил үзэхэд бэлтгэх шаардлагатай чадвар, концепцийг заах өгнө. Энэ хичээлийн салшгүй хэсэг нь технологи, аппликейшн ашиглах байх болно.

Тооцооллын өмнөх, ахисан түвшний түвшин (33164)
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Эрчимжүүлсэн Алгебр II/Тригонометрт "B" буюу дээш ба багшийн зөвлөснөөр эсхүл Алгебр III-т "A" ба багшийн зөвлөснөөр.*
Энэ курс нь коллежийн өмнөх тооцооллын хичээлд нийтлэг байдаг агуулга, ур чадварыг тодорхойлдог. Оюутнууд функцүүдийн хэд хэдэн сэдвийг график, тоон, үг хэллэг, аналитик дүрслэл, түүнчлэн янз бүрийн нөхцөл байдалд ашиглах замаар судлах болно. Оюутнууд мөн хувилбарууд, нөхцөлүүдийн багц, өгөгдлийн багцад тохирох функцийн загваруудыг байгуулж, баталгаажуулах замаар функцүүдийн талаарх ойлголтоо хэрэгжүүлэх бөгөөд ингэснээр функцийн төрөл бүрийн мөн чанар, зан үйлийн талаар илүү гүнзгий ойлголттой болно.

**Магадлал, статистик (23190)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II эсхүл Эрчимжүүлсэн Алгебр II-т "C" ба дээш дүнтэй.*
Энэ хичээлээр орчин үеийн статистик, магадлалын удиртгалыг санал болгоно. Сурагчид магадлалын үндсэн ойлголтыг авч, зармыг нь хичээлийн дараагийн хэсэгт статистикийн аргачлал хөгжүүлэхэд хэрэглэнэ. Статистикийн сургалтад статистикийн график гаргах, тайлбарлах, ерөнхий хандлага, хувилбарууд, түүвэрлэх арга, бином ба хэвийн хуваарилалт, таамаглалыг шалгах, найдвартай байдлын магадлал, регресс, корреляци, магадлал, пермутаци, комбинаци. Хэрэглээнд илүү анхаарах бөгөөд магадлалын туршилтын симуляци хийх, статистикийн концепцийг харуулах, статистикийн шинжилгээ хийхэд технологи ашиглана.

**Статистик, AT (33192)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II эсхүл Эрчимжүүлсэн Алгебр II, Магадлал, статистик эсхүл Алгебр III-т "C" буюу дээш эсхүл Алгебр II-т "A" ба багшийн зөвлөснөөр*
Энэ хичээлээр сурагчид Ахисан шатны статистикийн хичээлийг багтааж Коллежид орох шалгалтын зөвлөлөөс гаргасан математикийн ахисан шатны хөтөлбөрөөр сурна. Сэдэвт магадлал, магадлалын тархалт, ерөнхий хандлага ба

хувилбарууд зэрэг тодорхойлох статистик, тохиолдлын тоо ба симуляц, найдвартай байдлын магадлал, нэг ба хоёр жишээ өгөгдлөөр таамаглалыг шалгах, боломжийн хүснэгт, хамаарал, регрессийн шинжилгээ багтана. Дата шинжилгээний технологийн, компьютерын программ хангамжийг хэрэглэхийг илүү анхаарна. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (23192)*

**Дээд тоо AB, AP (33177)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Тооцооллын өмнөх "C" буюу түүнээс дээш, эрчимжүүлсэн. Дээд тооны удиртгал/Тригонометрт "B" буюу дээш ба багшийн зөвлөснөөр*

Эдгээр сэдвүүдийг тооцоолон бодохын хичээлийг сурахад давтах шаардлагатай; хязгаарын онол, дифференциал тооцоолол ба түүний хэрэглээ; интеграл тооцоолол ба түүний хэрэглээ; тооцооллын түвшинд бодлого бодох; Коллежид элсэх шалгалтын зөвлөлөөс өгсөн Ахисан түвшний Тооцоолол AB-ийн заавал үзэх хичээлд орсон сэдвүүд. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (23177)*

**Дээд тоо BC, AT (33179)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Тооцооллын өмнөх хичээлээр "B" буюу түүнээс дээш, Тооцооллын өмнөх хичээлээр эрчимжүүлсэн эсвэл "A" зэрэгтэй*

Дээд тоо AB-ийн сэдвүүд дээр нэмж векторын функц, туйлын хүрээ, агууламж, дараалал, цуваа багтана. Дээд тоо AB-тэй харьцуулбал хязгаар, нотолгоонд илүү анхаарна. Нарийвчилсан мэдээллийг Коллежид элсэх шалгалтын зөвлөлийн Дээд тоо AB-ийн сурах бичигт нийтэлсэн. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (23179)*

**Дараах давхар төгсөлтийн хичээлүүдийг зарим нэг байршилд бие даан сурах, онлайн хичээлийн хэлбэрээр зааж магадгүй. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.**

**Олон хувилбартай дээд тоо (93178W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 12**

*Урьдчилсан шаардлага: Дээд тоо BC-г амжилттай төгсгөж, сурагчид Northern Virginia Community College-ийн хос төгсөлтийн хичээлийн шаардлагыг хангасан байх ёстой.*

Олон хувилбартай дээд тоог сургууль төгсөх жилээсээ өмнө дээд тоо BC-г дүүргэсэн сурагчдад санал болгоно. Хичээлд багтах зарим нэг сэдвүүдэд гурван хэмжээст дүрсийн график, вектороор үнэлсэн функцүүдийн интеграци ба дифференциал, хязгаар, хоёр ба дээш хувилбаруудын функцийн тасралтгүй чанар, тухайн уламжлалууд, олон хувьсагчийн функцийн интеграл, чиглэлээр авсан уламжлал, градиент, вектор орон, Гриний теорем, Стоксын теорем багтана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Векторын тооцоолол (93175W)**
**Улирал, хагас кредит +1.0 чанарын оноо**
**Ангиуд: 12.**

*Урьдчилсан шаардлага: Дээд тоо BC, AT-г амжилттай төгсгөж, сурагчид Northern Virginia Community College-ийн хос төгсөлтийн хичээлийн шаардлагыг хангасан байх ёстой*

Векторын дээд тоог сургууль төгсөх жилээсээ өмнө Дээд тоо BC-г дүүргэсэн сурагчдад санал болгоно. Хичээлд багтах зарим нэг сэдвүүдэд гурван хэмжээст дүрсийн график, вектороор үнэлсэн функцүүдийн интеграци ба дифференциал, хязгаар, хоёр ба дээш хувилбаруудын функцийн тасралтгүй чанар, тухайн уламжлалууд, олон хувьсагчийн функцийн интеграл, чиглэлээр авсан уламжлал, градиент, вектор орон, Гриний теорем багтана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Шугаман алгебр (93165W)**
**Улирал, хагас кредит +1.0 чанарын оноо**
**Ангиуд: 12**

*Урьдчилсан шаардлага: Дээд тоо BC, AT-г амжилттай төгсгөж, сурагчид Northern Virginia Community College-ийн хос төгсөлтийн хичээлийн шаардлагыг хангасан байх ёстой*

Шугаман алгебрыг сургууль төгсөх жилээсээ өмнө Дээд тоо BC-г дүүргэсэн сурагчдад санал болгоно. Сурагчид шугаман тэнцэтгэл, векторын орон, шугаман хувирал, өөрийн утгын тухай сурна. Энэ хичээлээр сурагчийн тоон шинжилгээ, логик гаргалгааны чадварыг хөгжүүлнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Дифференциалын тэгшитгэл (93180W)**
**Улирал, хагас кредит +1.0 чанарын оноо**
**Анги: 12**

*Урьдчилсан шаардлага: Дээд тоо BC, AT-г амжилттай төгсгөж, сурагчид Northern Virginia Community College-ийн хос төгсөлтийн хичээлийн шаардлагыг хангасан байх ёстой*

Дифференциалын тэгшитгэл хичээлийг сургууль төгсөх жилээсээ өмнө Дээд тоо BC-г дүүргэсэн сурагчдад санал болгоно. Энэ хичээлээр дифференциалын тэгшитгэл, шугаман дифференциалын тэгшитгэл, тоон аргачлал, хэрэглээг танилцуулна. Хичээлийн зарим сэдвүүдэд дифференциалын тэгшитгэлийн нэгдүгээр эрэмбийг бодох аргачлал, тогтмол коэффициенттой нийтлэг ба нийтлэг бус шугаман дифференциалын тэгшитгэлүүд, өөрийн утгаар илэрхийлсэн шугаман дифференциалын системүүд, хэрэглээний бодлогууд багтана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Тоон дүн шинжилгээ (93167W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**

*Урьдчилсан шаардлага: NOVA-д орох шалгалт өгөх эрхийн оноо; Алгебр I, Геометр, Функц, Дата шинжилгээ, Алгебр II-т "C" буюу дээш*

Энэ хос төгсөлтийн хичээлээр пропорционалиар үндэслэх, загварчлал, санхүүгийн мэдлэг, хүчинтэй байдлын (логик, цогц онол) судалгаа гэсэн сэдвүүдийг танилцуулна. Бодит амьдралын жишээ, бодлого бодоход шаардлагатай математикийн үндсийг тодорхойлох, бодлого бодох, бодит нөхцөлд сурснаа хэрэглэхэд анхаарлаа төвлөрүүлнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу..*

Арлингтон улсын сургуулиудын ахлах сургуулийн математикийн явц, SY 2023-2024




**Анхаарах зүйл:**

- Энд дурдагдаагүй IB болон давхар элсэлттэй хичээлийн талаар мэдэхийн тулд ахлах сургууль бүрд заагдаж буй хичээлийн индексийг харна уу.
- Мэдээллийн шинжлэх ухааныг Алгебра II эсвэл Алгебр II, Intensified-ийн дараа, мөн өмнө нь авч болно.
- Нэмэлт дэмжлэг шаардлагатай сурагчид Алгебр I, Геометр, эсхүл Алгебр II болон Стратегийн хичээлүүдэд зэрэг элсэн суралцах боломжтой.

## БАЙГАЛИЙН УХААН

Арлингтоны Улсын Сургуулиуд нь байгалийн шинжлэлийн хичээлийг өргөн хүрээнд заахыг зорьдог. Байгалийн шинжлэлийн хичээлд бүх сурагчдыг оролцуулж, тэдний сонирхлыг татахын зэрэгцээ илүү өндөр сонирхол, чадвартай сурагчдад мөн боломж олгох хэрэгтэй гэж үздэг.

Бүх сурагчдад өргөн хүрээний сонголтуудыг бий болгосон. Үүний дээр эрчимжүүлсэн хичээл, ахисан түвшний хөтөлбөрөөр илүү гүнзгийрүүлсэн байгалийн ухааны хичээлийг ордог.

*Түвшин бүрд эрчимжүүлсэн болон ахисан түвшний байгалийн шинжлэл хичээлд ахиц гаргахад математикийн хичээл үндсэн суурь болно гэдгийг тэмдэглэж байна.*

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**ELD Биологи (24317) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Англи хэлний түвшний үнэлгээ дээр үндэслэж бүртгэж авна*
Энэ хичээл эс, ургамал, амьтан, хүний бие гэсэн суурь сургалтаас бүрдэнэ. Сурагчид лабораторийн шинжилгээ, хичээлийн ном материал дээр бие дааж, мөн бүлгээр ажиллана.
*Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Биологи (24310) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр өдөр тутмын амьдралд хэрэглэгдэх биологийн концепцийг орно. Агуулгад байгалийн шинжлэлийн янз бүрийн аргачлал, эс, микробиологи, ургамал, амьтан, ген, физиологи, экологийн талаар сурах багтана. Шүүмжит сэтгэлгээг бататгахын тулд лабораторийн ажилд илүү анхаарна. Сурагчдад янз бүрийн чадварыг өгөх, сургахад янз бүрийн нэмэлт материалыг ашиглана. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Эрчимжүүлсэн биологи (24315) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 9.**
Энэ хичээлээр сурагчдыг коллежийн түвшний биологид бэлтгэнэ. Молекулын биологи, цитологи, ген, эсийн физиологи, экологи, биологийн төрөл зүйлийн судалгаа сэдэвт багтана. Лабораторийн ажиллагаа, туршилт, шинжилгээг илүү хэрэглэхэд илүү анхаарна. Түүнчлэн сурагчид бие даан туршилтын эсвэл инженерчлэл загварын төсөл гүйцэтгэнэ. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Биологи, AT (34370) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит + Хоёр кредитийг авч, AT шалгалт, давхар цаг, (34371) давхар хичээлээр 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Эрчимжүүлсэн Байгалийн ухааны хичээл эсхүл Биологи, химийн анхан шатны хичээлүүдийг амжилттай дүүргэснээр болон зааварлагчийн зөвшөөрлөөр*
Биологийн Ахисан түвшний хичээл нь коллежийн түвшний биологийн хичээл бөгөөд сурагчдыг биологийн хичээлийн гол сэдвүүдээр гүнзгийрүүлэн суралцуулна. Хичээлийн агуулга нь Коллежид орох шалгалтын зөвлөлөөс гаргасан химийн ахисан шатны хөтөлбөрт багтсан сэдвүүдэд суурилна. Энэ хичээлээр сурагчид Ахисан түвшний Биологийн шалгалт өгөхөд бэлтгэх ба үүнд коллежийн кредит өгөх магадлалтай. Хичээлийг агуулга дараах гол сэдвүүдийг агуулна: Молекул ба эс, өв ба хувьсал, организмууд, бүлэг. Лабораторийн нарийн төвөгтэй хөтөлбөр нь коллежийн зөвлөлийн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагууд дээр суурилдаг. *Сурагчид хоёр шаардлагатай хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй. (24370) (24371)*

**Биологийн сонгосон сэдвүүд (34371)**
**Бүтэн жил, нэг кредит, давхар үе**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Ахисан түвшний биологи давхар элсэлт (34370)*
Энэ хичээлийн үндсэн элемент лабораторийн туршлага юм. Биологийн лабораторийн хувьд зөвлөсөн сэдвүүдэд диффузи ба осмиос, ферментийн катализатор, эсийн хуваагдал ба мейоз, ургамлын пигмент ба фото нэгдэл, эсийн амьсгал, молекулын биологи, организмын ген, бүлгийн ген ба хувьсал, транскрипци, эргэлтийн

системийн физиологи, амьтны араншин харилцаа, ууссан хүчил төрөгч, усны анхдагч бүтээмж багтана.

**Экологи (24365)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Биологийн хичээлийг амжилттай дүүргэх*
Энэ хичээлийг организм ба орчны харилцаа, харилцан үйлчлэлд төвлөрсөн биологийн концепцэд суурилж явуулна. Сэдвүүдэд экосистемийн амьд ба амьд бус бүрдэлд юм, энергийн урсгал, геохимийн үйл явц (нүүрстөрөгч, азот, фосфор, хүчил төрөгчийн цикл), амьд зүйлст чухал химийн ба биологийн үйл явц, амьд зүйлст усны үүрэг, орчин тойрны системийн үйл явц, шүтэлцээ багтана.

**Байгал орчны шинжлэх ухаан (24361)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ олон салбарыг нэгтгэсэн хичээлээр байгаль орчин, манай дэлхийд үзүүлэх хүний нөлөөнд анхаарлаа төвлөрүүлнэ. Сэдэвт шинжлэх ухааны асуулт, судалгаа, физик ертөнц, амьдрах орчин, эх үүсвэрийг хадгалах, хуулийн ба иргэний хариуцлагыг багтаана. Лабораторийн ба бодит туршлага нь энэ хичээлийн чухал бүрдэл бөгөөд шүүмжтэй сэтгэхийг өдөөхийн зэрэгцээ агуулгыг бэхжүүлж, өргөжүүлэхэд чиглэнэ. *Энэ хичээлийг Биологийн эсхүл Дэлхий шинжлэлийн кредитэд тооцож болно.*

**ELD Байгал орчны шинжлэх ухаан (24362)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Англи хэлний түвшиний үнэлгээ дээр үндэслэж бүртгэж авна*
Энэ хичээлийг байгаль орчны шинжлэх ухааны чухал санаануудыг танилцуулахад зориулсан. Сэдвүүдийг концепцийн түвшинд үзэх ба сэдвүүдэд шинжлэх ухааны асуулт, судалгаа, физик ертөнц, амьдрах орчин, эх үүсвэрийг хадгалах, хуулийн ба иргэний хариуцлагыг багтаана. Лабораторийн ба бодит туршлага нь энэ хичээлийн чухал бүрдэл бөгөөд шүүмжтэй сэтгэхийг өдөөхийн зэрэгцээ агуулгыг бэхжүүлж, өргөжүүлэхэд чиглэнэ. *Энэ хичээлийг Биологийн эсхүл Дэлхий шинжлэлийн кредитэд тооцож болно.*

**Хими (24410) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебр I эсхүл дүйцэх хичээлийг амжилттай дүүргэх*
Сурагчдад химийн суурь ойлголтуудыг өгөх нь анхдагч зорилт байх ба үүнийг химиэр цааш суралцах буюу өдөр тутмын амьдралдаа хэрэглэж болно. Концепцуудыг нэлээд тооны лабораторийн үйл ажиллагаагаар бэхжүүлнэ. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Эрчимжүүлсэн хими (24415) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 10-11**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II-ийг төгсгөсөн эсхүл үүнийг давхар авах эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*
Энэ хичээлээр сурагчдыг коллежийн түвшний химид бэлтгэнэ. Хичээлээр атом, молекулын бүтэц, байдал, химийн үйлчлэлийн зарчмуудыг сайтар ойлгох ойлголтыг өгнө. Тоон дата анализад онцгой анхаарч, лабораторийн ажлыг түлхүү хийнэ. Түүнчлэн сурагчид бие даан туршилтын эсвэл инженерчлэл загварын төсөл гүйцэтгэнэ. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Хими (34470) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит + Хоёр кредитийг авч, AT шалгалт, давхар цаг, (34371) давхар хичээлээр 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Эрчимжүүлсэн Байгалийн ухааны хичээл эсхүл Химийн анхан шатны хичээлийг амжилттай дүүргэснээр болон зааварлагчийн зөвшөөрлөөр*
Ахисан түвшний Хими нь химийн голлох салбаруудын талаар гүнзгийрүүлсэн ойлголт авахад зориулагдсан коллежийн түвшний хичээл юм. Хичээлийн агуулга нь Коллежид орох шалгалтын зөвлөлөөс гаргасан химийн ахисан шатны хөтөлбөрт багтсан сэдвүүдэд суурилна. Химийн урвал, зарчмуудын математикийн илэрхийлэл, лабораторийн ажилд анхаарна. *Сурагчид хоёр шаардлагатай хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй. (24470) (24471)*

**Химийн сонгосон сэдвүүд (34471)**
**Бүтэн жил, нэг кредит, давхар үе**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Ахисан түвшний хими хичээлийг давхар авах (34370)*
Сонгосон сэдвүүд хичээлээр сурагчид уламжлалт лабораторийн ажлын туршлага олж авах, өөрсдийн судалгаа шинжилгээг төлөвлөж, хийх боломжтой байх лабораторийн ажилд анхаарна. Сургалтын сэдвүүдэд атомын онол, атомын бүтэц, химийн нэгдэл, цөмийн хими, хий, шингэн, хатуу, уусмал,

үйлчлэх хэлбэрүүд, стехиометри, тэнцвэр, кинетик, термодинамик зэрэг нэн ялангуяа багтана.

**Дэлхий шинжлэл (24210) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: р ангийн түвшинд ба түүнээс дээш шатанд унших*
Дэлхий шинжлэл нь геологи, далай судлал, цаг уур судлал, агаар мандал судлалыг танилцуулах хичээл юм. Хичээлд чулуу, эрдэс бүрдэх, газрын хэв ба өөрчлөлт, дэлхийн дотоод, гадаргуу, газар зүйн харилцан үйлчлэл, нарны систем ба сансар огторгуй судлалыг багтаана. Эдгээр сургалтын сэдвүүдээр лабораторийн туршилт хийнэ. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Эрчимжүүлсэн дэлхий шинжлэл (24215) Лабораторийн хичээл,**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: р ангийн түвшинд ба түүнээс дээш шатанд унших*
Энэ хичээлээр сурагчдыг геологи, далай судлал, цаг уур судлал, агаар мандал судлалын коллежийн сургалтад бэлтгэнэ. Хичээлд чулуу, эрдэс бүрдэх; газрын хэв ба өөрчлөлт; дэлхийн дотоод, гадаргуу, газар зүйн харилцан үйлчлэл; нарны системийн судлал; ба оддын идэвхтэй байдал, унтрахыг багтаана. Лабораторийн ажиллагаа, туршилт, шинжилгээг хэрэглэхэд илүү анхаарна. Түүнчлэн сурагчид бие даан туршилтын эсвэл инженерчлэл загварын төсөл гүйцэтгэнэ. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Физикийн зарчмууд (24500) Лабораторийн хичээл, Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлийг физикийн чухал санаануудыг танилцуулахад зориулсан. Сэдвүүдийг концепцийн түвшинд үзнэ. Эхний улиралд хөдөлгөөн ба хүчний талаар голлож судална. Хоёрдугаар улиралд гэрэл, цахилгаан, соронз, цөмийн физикийг голчилж үзнэ.

**ELD Физикийн зарчим (24501) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Англи хэлний түвшин тогтоох шалгалт*
Энэ хичээлийг физикийн чухал санаануудыг танилцуулахад зориулсан. Сэдвүүдийг концепцийн түвшинд үзнэ. Хөдөлгөөн, хүч, инерц, энерги, халуун, гэрэл, цахилгаан, соронзонд голлож анхаарна.

**Физик (24510) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II эсхүл дүйцэх хичээлийг дүүргэсэн байх буюу давхар авах*
Энэ хичээлийн анхны зорилт нь физикийн гол асуудлууд/санааны талаар өргөн хүрээний танилцуулга өгөхөд оршино. Хөдөлгөөн, хүч, инерц, энерги, халуун, гэрэл, цахилгаан, соронзонд холбогдох бодлого бодох математикийн чадварт илүү анхаарна.

**Эрчимжүүлсэн физик (24515) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II эсхүл дүйцэх хичээлийг дүүргэсэн байх буюу давхар авах*
Энэ хичээлээр сурагчдыг коллежийн түвшний физикт бэлтгэнэ. Эрчимжүүлсэн физик нь ахлах сургуулийн түвшинд сонгодог механик, термодинамик, долгион, гэрэл, электрон соронзон, квантын механик, харьцангуй, цөмийн физиктэй танилцах суурьтай, эрчимтэй хичээл юм. Хичээлээр математикийн болон бусад бодлого бодох чадварыг хөгжүүлэхэд илүү анхаарна. Тоон өгөгдөл цуглуулах, шинжлэх лабораторийн ажилд ач холбогдол өгнө. Түүнчлэн сурагчид бие даан туршилтын эсвэл инженерчлэл загварын төсөл гүйцэтгэнэ.

**Физик I, AT (34578) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит + Хоёр кредитийг авч, AT шалгалт, давхар цаг, (34371) давхар хичээлээр 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Дээд тооны удиртгал эсхүл Алгебр III-ийг дүүргэсэн эсхүл эдгээрт давхар бүртгүүлсэн эсхүл Физик буюу Эрчимжүүлсэн физикийг дүүргэсэн байх Физикийн сонгосон сэдвүүд I, AT-д давхар элссэн байх шаардлагатай.*
Хичээлийн агуулга нь Коллежид орох шалгалтын зөвлөлөөс гаргасан химийн ахисан шатны хөтөлбөрт багтсан сэдвүүдэд суурилна. Энэхүү алгебрт суурилсан физикийн хичээл нь алгебрт суурилсан физикийн коллежийн эхний улирлын хичээлтэй дүйцнэ. Хичээл нь Ньютоны механик (хөдөлгөөн, инерцийн момент); ажил, энерги, хүч; механик долгион; ба дууг багтаана. Энэ нь мөн цахилгааны схемийг багтаана. *Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй. (24578) (24568)*

**Физик I, AT (34568)-ийн сонгосон сэдвүүд**
**Бүтэн жил, нэг кредит, давхар үе**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Физик I, AT (34578)-д давхар бүртгүүлж суух*

Сонгосон сэдвүүд хичээлээр бодит амьдралын мэдлэгээ хэрэгжүүлэх сорилтыг сурагчид өгч, гүнзгийрүүлсэн лабораторийн ажилд голчлон анхаарна. Хичээлийн сэдвүүд нь Физик I, АТ-аар заасан зүйлийг үргэлжлүүлнэ.

**Физик II, АТ (34579) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит + Хоёр кредитийг авч, АТ шалгалт, давхар цаг, (34569) давхар хичээлээр 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Дээд тооны удиртгал эсхүл Алгебр III-ийг дүүргэсэн эсхүл эдгээрт давхар бүртгүүлсэн эсхүл Физик буюу Эрчимжүүлсэн физикийг дүүргэсэн байх Физикийн сонгосон сэдвүүд II, АТ-д давхар элссэн байх шаардлагатай.*
Хичээлийн агуулга нь Коллежид орох шалгалтын зөвлөлөөс гаргасан химийн ахисан шатны хөтөлбөрт багтсан сэдвүүдэд суурилна. Энэхүү алгебрт суурилсан физикийн хичээл нь алгебрт суурилсан физикийн коллежийн хоёрдугаар улирлын хичээлтэй дүйцнэ. Энэ хичээлээр шингэний тухай үзнэ; термодинамик; цахилгаан ба соронз; оптик; атомын ба цөмийн физик. *Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй. (24579) (24569)*

**Физик II, АТ (34569)-ийн сонгосон сэдвүүд**
**Бүтэн жил, нэг кредит, давхар үе**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Физик I, АТ (34579)-д давхар бүртгүүлж суух*
Сонгосон сэдвүүд хичээлээр бодит амьдралын мэдлэгээ хэрэгжүүлэх сорилтыг сурагчид өгч, гүнзгийрүүлсэн лабораторийн ажилд голчлон анхаарна. Хичээлийн сэдвүүд нь Физик II, АТ-аар заасан зүйлийг үргэлжлүүлнэ.

**Физик С: Механик, Цахилгаан, Соронз, АТ (34570) Лабораторийн хичээл,**
**Бүтэн жил, нэг кредит + Хоёр кредитийг авч, АТ шалгалт, давхар цаг, (34571) давхар хичээлээр 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 12**
*Урьдчилсан шаардлага: Эрчимжүүлсэн Байгалийн ухааны хичээл эсхүл Физикийн анхан шатны хичээлийг амжилттай дүүргэснээр болон зааварлагчийн зөвшөөрлөөр Дээд тоо АВ, АТ эсхүл ВС, АТ-г амжилттай дүүргэсэн эсхүл давхар бүртгүүлсэн.*
Хичээлийн агуулга нь Коллежид орох шалгалтын зөвлөлөөс гаргасан химийн ахисан шатны хөтөлбөрт багтсан сэдвүүдэд суурилна. Физик С, АТ хичээлээр их сургуулийн түвшний физикийн эхний хэсгийг үзнэ. Дээд тоог физикийн зарчмуудыг тодорхойлох, бодлого бодоход ашиглана. Ахисан шатны сургалтын хөтөлбөр дээр нэмэлт болгож эрчимжүүлсэн лабораторийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Эхний улиралд Ньютоны Механикийг гүнзгийрүүлж сурах ба хоёрдугаар улирлаар Цахилгаан, соронзон оронд бүхэлд нь анхаарна. *Сурагчид хоёр шаардлагатай хичээлтэй холбоотой АТ-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй. (24570) (24571)*

**Физик С (34571)-ийн сонгосон сэдвүүд**
**Бүтэн жил, нэг кредит, давхар үе**
**Ангиуд: 12**
*Урьдчилсан шаардлага: Ахисан түвшний Физик С хичээлийг давхар авах Механик, Эрчим хүч, Татах хүч (34570)*
Физикийн сонгосон сэдвүүдээр сурагчид механик, цахилгаан, татах хүчид холбогдох лабораторийн туршлагаа гүнзгийрүүлэх боломжтой. Үүний дээр сурагчид физикийн бусад салбаруудыг сурна. Эдгээр сэдвүүдээр танин мэдэх, шүүмжтэй сэтгэх, хараат бус судалгаанд оролцох боломжоор хангахад анхаарна. Сэдвүүдэд харьцангуй, долгион, схемийн өөрчлөлт, энергийн хувирал нэн ялангуяа багтана.

**Одон орон судлал (24700) Лабораторийн хичээл**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Дэлхий судлал эсхүл Физикийн хичээлийг амжилттай дүүргэсэн байх*
Одон орон судлал нь ертөнц, түүний агуулга, физикийн хуулиудтай танилцах хичээл юм. Агуулгад нарны системийн физик, астронавигаци, одны орд судлал, сансар судлал багтана. Лабораторийн ажлаар астронавигацийн дасгал, одон оронд холбож ажиглалт, таамаглал дэвшүүлэх дасгалууд хийнэ.

**Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага (RISE) Биологи (20205) (RISE) Дэлхий судлал (20206)**
**Нэг улирал, хагас <u>сонгох</u> кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Анги төгсссөн боловч SOL үнэлгээ дээр унасан, төгсөхөд шаардлагатай баталгаажсан кредит дутуу байгаа сурагчид.*
Сурагчид хичээлийг дүүргэсэн боловч SOL үнэлгээнд тэнцээгүй хичээл дээрээ нөхөж, давтаж сурах/хийх ба үүнд программ хангамжаар өгөх хичээл ба/эсхүл онлайн хөтөлбөр ашиглана. Суралцахад багш туслах боловч ихэнх ажлыг сурагчид бие дааж суралцах маягаар хийнэ. *Тайлбар: Сурагчид энэ хичээлийг давах/унах маягаар хийнэ.*

## БҮТЭН ЖИЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ ХӨТӨЛБӨР (КАРЬЕРЫН ТӨВ)

**Эрүүл мэнд, байгалийн шинжлэлийн биотехнологи (28326)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Энэ хичээлийн тодорхойлолтыг 82-р хуудаснаас хар.*

**Эмнэлгийн анхны тусламжийн техникч I (98334W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Энэ хичээлийн тодорхойлолтыг 90-р хуудаснаас хар.*

**Эмнэлгийн анхны тусламжийн техникч II (98335W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Энэ хичээлийн тодорхойлолтыг 90-р хуудаснаас хар.*

## Байгалийн шинжлэлийн хичээлийг авах дарааллын зөвлөмж

(Тэмдэглэл: Хичээл авах дараалллыг тодорхойлохдоо сургуулийн салбарууд Магадлан итгэмжилсэн, Зөвлөлөөс баталсан хичээлүүдийн стандартыг дагах ёстой.)

Ангиуд: 9-р анги, 10-р анги, 11-р анги, 12-р анги

### Стандарт диплом – байгалийн шинжлэлийн 2 төрөл, нийт 3 кредит

**Хувилбар 1**

- 9-р анги: Биологи[1]
- ↓ Дэлхий судлал[1], Хими[3], Физик[4]
- ↓ Хими[3], Физик[4]; **Дэлхий судлал II**: Далай судлал[6], Одон орон судлал[6]; **Биологи II**: Анатоми[6], Экологи[6]; **AT/IB/Хос төгсөлтийг** сонгох боломжтой (сургуулиас хамаарна)

**Хувилбар 2**

- 9-р анги: Байгал орчны шинжлэх ухаан[5]
- ↓ Биологи[1]
- ↓ Дэлхий судлал[1], Хими[3], Физик[4]; **Дэлхий судлал II**: Далай судлал[6], Одон орон судлал[6]; **Биологи II**: Анатоми[6], Экологи[6]; **AT/IB/Хос төгсөлтийг** сонгох боломжтой (сургуулиас хамаарна)

### Ахисан шатны сургалтын диплом – 3 төрөл, 4 кредит[8]

**Хувилбар 1**

- 9-р анги: Биологи[1]
- ↓ Хими[3]
- ↓ Физик[4]; **Байгалийн шинжлэлийн AT/ОУБ/Хос төгсөлт Хичээл** сонгох боломжтой эсэх онь (сургуулиас хамаарна); **Дэлхий судлал II**: Далай судлал[6], Одон орон судлал[6]; **Биологи II**: Анатоми[6], Экологи[6]

**Хувилбар 2**

- 9-р анги: Байгал орчны шинжлэх ухаан[5]( (Байгалийн шинжлэлийн кредит болгож тооцуулах)
- ↓ Биологи[1]
- ↓ Хими[3]
- ↓ Физик[4]; **Байгалийн шинжлэлийн AT/IB/Хос төгсөлтийг** сонгох боломжтой (сургуулиас хамаарна); **Дэлхий судлал II**: Далай судлал[6], Одон орон судлал[6]; **Биологи II**: Анатоми[6], Экологи[6]

# Байгалийн шинжлэлийн хичээлийг авах дарааллын зөвлөмж

(Тэмдэглэл: Хичээл авах дарааллыг тодорхойлохдоо сургуулийн салбарууд Магадлан итгэмжилсэн, Зөвлөлөөс баталсан хичээлүүдийн стандартыг дагах ёстой.)

ТАЙЛБАР: Зарим хичээлүүд урьдчилсан эсхүл хамтарсан нөхцөлтэй. Карьерын төвд санал болгож буй нэмэлт Байгалийн шинжлэлийн хичээл Байгалийн шинжлэлийн төгсөлтийн кредитийг хангаж болно. Тухайн Байгалийн шинжлэлийн хичээлийн тодорхойлолтыг үзнэ үү.

**<u>Байгалийн шинжлэлийн хичээлийн эшлэл (АТ-ын бус/ОУБ-ын хичээлүүд)</u>**

[1]Биологийн хичээлд Биологи (24310), Эрчимжүүлсэн биологи (24315), ELD Биологи (24317), Биологи Хэсэг 1 ба Хэсэг 2 (сурагчид кредит авах боломжтой, эшлэл 7-г үзнэ үү) багтана

[2]Дэлхий судлалын хичээлд Дэлхий судлал (24210), Эрчимжүүлсэн дэлхий судлал (24215), Дэлхий судлал Хэсэг 1 ба Хэсэг 2 (сурагчид кредит авах боломжтой, эшлэл 7-г үзнэ үү) багтана

[3]Химийн хичээлд Хими (24410), Эрчимжүүлсэн хими (24415) багтана

[4]Физикийн хичээлд Физик (24510), Физикийн зарчмууд (24500), ELD Физикийн зарчмууд (24501) ба Эрчимжүүлсэн физик (24515) багтана.

[5]Байгал орчин судлалын хичээлд Байгал орчин судлал (24361), ELD Байгал орчны судлал (24362) багтана

[6]Гурван хичээлийн урьдчилсан агуулга нь тухайн хичээлийн анхан шатны SOL үндсэн хичээл. Энэ хичээлээр анхан шатны хичээлийг аваагүй сурагчид холбогдох SOL шалгалтыг өгөх ёстой.

[7]Кредит өгөхөд холбогдох Боловсролын зөвлөлийн удирдамжийн дагуу Байгалийн шинжлэлийн хичээлд кредит авах эрхтэй хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад Дэлхий судлал, Хэсэг 1 ба 2, Биологи, Хэсэг 1 ба 2-ийн хэсэг бүрд Стандарт дипломд шаардсан гурван байгалийн шинжлэлийн кредит авах стандарт кредит авах боломж олгоно. Дэлхий судлал ба Биологийг хоёр хэсгээр авч стандарт кредит авах сурагчид хоёр хичээлийн *хоёр* хэсгийг дүүргэж байж наад захын шаардлагыг хангах ба Байгалийн шинжлэлийн хичээлд гурван стандарт кредит, мөн нэмэлт сонгох хичээлийн кредит авна. Хоёр хэсэгтэй хичээлийг мөн Байгалийн шинжлэлийн хичээлийн зөвлөлөөс зөвшөөрсөн бусад бүтэн жилийн хичээлүүдтэй хослуулж шаардлага хангаж болно.

**[8]Коллежид элсэх хүсэлт гаргах буюу Коллежид орох гэж байгаа сурагчид Биологи, Хими, Физикийг багтааж дөрвөн Байгалийн шинжлэлийн хичээлийг авахыг ихээхэн зөвлөж байна.**

## НИЙГЭМ СУДЛАЛ

Арлингтоны Улсын Сургуулиуд ардчилсан, харилцан холбоотой ертөнцийн мэдээлэлтэй, хариуцлагатай, ухаалаг иргэн болгохын тулд сурагчдын суурь мэдлэг, чадвар, үнэт зүйлийг хөгжүүлэх нийгмийн ухааны цогц хичээлүүдийг санал болгодог.

Эрчимжүүлсэн болон ахисан түвшний сургалтаас эхлээд олон төрлийн хичээлүүдийг бүх сурагчдад зориулж гаргасан.

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Дэлхийн түүх, газар зүй**
Төгсөлтийн шаардлагыг хангахад сурагчдад түүх эсхүл газар зүй буюу хоёуланд нь нэг эсхүл олон кредит хэрэгтэй. Кредитийг дараах хэлбэрээр авч болно:

- **22345 ELD 3 – 4 Дэлхийн түүх & Газарзүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл (22345)**
- **Дэлхийн түүх, газар зүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл (22216)**
- **Дэлхийн түүх, Эрчимжүүлсэн (22343)**
- **Дэлхийн түүх, газар зүй: Эртнээс МЭ-ий 1500 он хүртэл (22215)**
- **Дэлхийн түүх, газар зүй: Эртнээс МЭ-ий 1500 он хүртэл, Эрчимжүүлсэн (22219)**
- **Дэлхийн түүх: Орчин үе, АТ (32400)**
- **Дэлхийн газар зүй (12210)**

**22345 ELD 3 – 4 Дэлхийн түүх & Газарзүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл (22345)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 9**
*Урьдчилсан шаардлага: Англи хэл суралцагсдыг хариуцсан газрын Нийгмийн ухааны хичээлийн газруудтай хамтарч Зөвлөгөөний газраас өгөх даалгавар*
Энэ хичээлийг Англи хэлээр ярих чадвар нь хязгаартай сурагчид Дэлхийн түүхийн төгсөлтийн шаардлагыг хангах кредитийг хангахад зориулсан. Хичээл нь Дэлхийн түүхийн хичээлтэй агуулгаараа ижил боловч тэдний унших болон бусад чадварт нь илүү тохирсон материалыг хэрэглэнэ. Хичээлээр Дэлхийн түүхийг сурагчийн туршлага, суралцах арга барилтай холбох ба цаг мөчлөгөөр хуваасан уламжлалт заах арга барилаас илүү концепцийг танилцуулна. Нийгмийн ухааны чиглэлээр баталгаажсан кредит шаардлагатай оюутнууд сургалтын төгсгөлийн SOL шалгалтын оронд гүйцэтгэлийн үнэлгээг оруулах орон нутгийн үйл явцад оролцоно. Тодорхой тохиолдолд тухайн оюутан орон нутгийн үйл явцаас гадна сургалтын төгсгөлийн SOL шалгалтыг өгөх эрхтэй байж болно.

**Дэлхийн түүх, газар зүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл (22216)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 9**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр барууны болон барууны бус соёлуудын МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэлх голлох үйл явдал, хүмүүс, санаанд төвлөрнө. Энэ хичээлийн зүйлийг ангилах хүчин зүйл нь “хувь чанар” гэсэн концепц юм. Сурагчид МЭ-ий 1500 оноос хойших орчин цагийн түүхийн улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, газар зүйн хөгжлийн өөрчлөлтийг холбож үзнэ. Хичээлийн эхэнд эртний түүхийг багахан тоймлоно. Оюутнууд түүхийн дөрвөн эрин үеийг судлах болно: дэлхийн хүн амын тоо ойролцоогоор МЭ 1500, хайгуулын уулзалт, солилцоо, хувьсгалын эрин үе, Дэлхийн 1-р дайнаас хойших дэлхий. сургалтын төгсгөлийн SOL шалгалтын оронд гүйцэтгэлийн үнэлгээг оруулах үйл явц. Тодорхой тохиолдолд тухайн оюутан орон нутгийн үйл явцаас гадна сургалтын төгсгөлийн SOL шалгалтыг өгөх эрхтэй байж болно.

**Дэлхийн түүх, Эрчимжүүлсэн (22343)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 9**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлийг Дэлхийн түүхийн сэдвүүд болох хувь чанар, соёл, зөрчил гэснийг суралцах ахисан түвшний сурагчдын шаардлагад тохируулсан. Хичээлд Дэлхийн түүх, газар зүйн Виржиниагийн стандартуудын дагуух бөгөөд үүнээс гаднах агуулга багтана. МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл. Нийгмийн ухааны чиглэлээр баталгаажсан кредит шаардлагатай оюутнууд сургалтын төгсгөлийн SOL шалгалтын оронд гүйцэтгэлийн үнэлгээг оруулах орон нутгийн үйл явцад оролцоно. Тодорхой тохиолдолд тухайн оюутан орон нутгийн үйл явцаас гадна сургалтын төгсгөлийн SOL шалгалтыг өгөх эрхтэй байж болно.

**Дэлхийн түүх, газар зүй: Эртнээс МЭ-ий 1500 он хүртэл (22215)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэхүү хурдтай, сурагчид сорилт болох хичээлээр хүн төрөлхтөн үүссэн үеэс МЭ-ий 1500 он хүртэлх эртний барууны ба барууны бус соёлуудад төвлөрнө. Сурагчид уншиж, философи ба шашныг харьцуулж, ялгааг гаргаж, археологийн олдворуудыг шинжилж, бичиг үсэг үүссэн үеийг судалж, урлагийн бүтээл, хөгжим, бүжгийг шинжилж, хүн ба орчны харилцан холбооны үндсэн шинжийг шинжилж, тухайн үеийн соёлуудыг тодорхойлсон түүхэн ба хуулийн баримт бичгүүдийг шинжилнэ. *Энэхүү сургалт нь тухайн хичээлд тэнцсэн тохиолдолд ахисан түвшний болон стандарт судлалын дипломын аль алинд нь тавигдах шаардлагыг хангаж, тухайн оюутан нийгмийн ухааны кредитийг шалгах орон нутгийн үйл явцыг дуусгах эсвэл SOL шалгалтад тэнцсэн бол. Нийгэм судлалаар баталгаажсан кредит авах шаардлагатай сурагчид л SOL шалгалт өгөх эрхтэй. Тайлбар: Энэ хичээл нь дунд сургуулийн 8-р ангид заадаг Дэлхийн газар зүй хичээлтэй ижил юм.*

**Дэлхийн түүх, газар зүй: Эртнээс МЭ-ий 1500 он хүртэл, Эрчимжүүлсэн (22219)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Ахисан түвшний сурагчдад зориулсан, хүн төрөлхтний түүх үүссэн үеэс МЭ-ий 1500 оны хүртэлх эртний дэлхийн түүхийг эрчимтэй үзэх хичээл юм. Хүн төрөлхтний уран зохиол, урлаг, жүжиг, философийг багтааж барууны ба барууны бус ертөнцийн хүний хөгжлийн ойлголтыг сурагчдад өргөн хүрээнд өгнө. Хүний анхны сууринаас эхлээд эртний ертөнцийн хамгийн хөгжсөн соёл иргэншил хүртэл сурагчид “нийгэм”-ийн эх, өсөлтийг суралцах нь энэ хичээлийн зорилт юм. Үүний үр дүнд энэ хичээлээр сурагчдад манай орчин үеийн глобал нийгмийг аюулгүй байдал, байгуулал, үнэт зүйлс, итгэл үнэмшил, соёл, бусад нийгмүүдтэй харилцах харилцаа талаас нь ойлгох сайн суурийг тавьж өгнө. Нэн ялангуяа сурагчид Чулуун зэмсгийн үе, Эртний грек ба Ром, Византиний эзэнт гүрэн, Христийн ба Муслим шашин түгсэн тухай, эртний дундад зуун, Зүүн Ази, Энэтхэг, Африк Месоамерикт соёл иргэншил хөгжсөн тухай сурна. *Энэ хичээл Ахисан сургалтын дипломын шаардлага болон Стандарт дипломын сонгох хичээлийн шаардлагыг хангана. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. Нийгэм судлалаар баталгаажсан кредит авах шаардлагатай сурагчид л SOL шалгалт өгөх эрхтэй.*

**Дэлхийн түүх: Орчин үе, AT (32400)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Багшийн зөвлөгөө; өмнөх нийгмийн ухааны хичээлд “B” буюу дээш дүн*
Энэ хичээл нь Коллежид орох шалгалтын зөвлөлийн ахисан түвшний хөтөлбөрийн хэсэг бөгөөд коллежийн удиртгал хичээлтэй ижил хэмжээнд сурагчдад сорилт болно. AT Дэлхийн түүх: Орчин цагийн, сурагчид 1200 оноос өнөөг хүртэлх голлох үйл явдал, хүмүүс, хөгжил, үйл явцыг судална. Сурагчид түүхчид хэрэглэдэг чадвар, дадал, аргачлалыг хэрэглэнэ: анхан ба хоёрдогч эх сурвалжийг шинжлэх; түүхчилсэн аргумент гаргах; түүхэн холбоог тогтоох; харьцуулалттай холбоотой шалтгааныг хэрэглэх; харьцуулалт, шалтгаант холбоо, үргэлжлэл, цаг хугацааны явцад өөрчлөгдөх тухай үндэслэл гаргахыг хэрэглэх. Энэ хичээлээр сурагчид цаг хугацаа, байршлын хувьд түүхэн үйл явцуудын хоорондын холбоог ойлгохын тулд зургаан сэдвийг үзнэ: хүн ба байгаль орчин, соёлын хөгжил ба харилцаа, засаглал, эдийн засгийн системүүд, нийгмийн харилцаа ба байгуулал, технологи ба инновац.
Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт хичээлийн бүрэн тодорхойлолт бий. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (22400)*
* Yorktown High School-ээс энэ хичээлийг зөвхөн 10 - 12-р ангид санал болгодог.

**Дэлхийн газар зүй (12210)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр хүмүүс хоорондын харилцаа болон бүс нутгууд дахь орчинтойгоо тэдний харилцах харилцаанд төвлөрнө, тухайлбал, Африк, Ази, Австрали, Төв Америк, Кариб, Европ, Ойрх Дорнод, Хойд Америк, Өмнөд Америк болон хуучнаар Зөвлөлт Холбоот Улс. Газар зүй, байршил, газар, хүн ба байгаль орны харилцаа, шилжилт хөдөлгөөн ба шашин гэсэн таван сэдвийг биет, соёлын, улс төрийн, эдийн засгийн болон бусад төрлийн газар зүйн сургалтад хэрэглэнэ. *Хэрэв хичээлийг дүүргэж, SOL шалгалтад тэнцвэл энэ хичээл нь ахисан түвшний ба стандарт дипломын шаардлагыг хангана. Нийгэм судлалаар баталгаажсан кредит авах шаардлагатай сурагчид л SOL шалгалт өгөх эрхтэй. Тайлбар: Энэ хичээл нь*

*дунд сургуулийн 8-р ангид заадаг Дэлхийн газар зүй хичээлтэй ижил юм.*

**Эдийн засаг, хувийн санхүү**

Энэ хичээлээр эдийн засаг, хувь хүний санхүүгийн талаар ерөнхийд нь үзнэ. Тэд Америкийн бизнесийн тогтолцоо, эдийн засгийн зарчмууд, нийлүүлэлт/эрэлтийн эдийн засаг, хөдөлмөр ба үйлдвэрлэл, Холбооны улсын нөөцийн тогтолцоо, засгийн газрын мөнгөний бодлого, голлох улсуудын эдийн засгийн системийн харьцуулалт, эдийн засгийн философитой глобал худалдааны нөлөөний талаар ойлгохын тулд танилцана. Сурагчид санхүү, хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээл, хураамж, хөрөнгө оруулалтаас авах зүйл, тэтгэвэрт гарах, өмчийн төлөвлөлт, хэрэглэгчийн зээл, мөнгөний менежмент, төсөвлөх, санхүүгийн тайлан, даатгал ба эрсдэлийн менежмент, орон байрны өмчлөл, коллежийн боловсролын төлөвлөлт, цалингийн татвар, хэрэглэгчийг хамгаалах хууль ба санхүүгийн хариуцлагын талаар суралцана. *WISE Санхүүгийн мэдлэгийн шалгалтыг сурагчид Карьер, техникийн төгсөлтийн кредит авахын тулд өгөх шаардлагатай байж болно. Энэ хичээлээр бүх эдийн засаг, санхүүгийн төгсөлтийн шаардлагыг багтаана. Сурагчид мөн AP-ийн болон ОУБ-ийн Эдийн засгийн хичээлийг амжилттай дүүргэх замаар энэхүү төгсөлтийн шаардлагыг хангаж болно. Энэ хичээл болон CTE хичээлийг амжилттай дүүргэсэн сурагчид "биелүүлсэн" статус авч болно. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

Кредитийг дараах хэлбэрээр авч болно:

**Эдийн засаг, хувийн санхүү (22212)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Байхгүй*

Энэ хичээл нь биечлэн суух хичээл. Энэ хичээлийн зарим хэсгийг онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.

**Эдийн засаг, хувийн санхүү**
**Жил, улирал, нэг кредит (22212V)**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Байхгүй*

Энэ хичээл нь EPF (22212) хичээлийн агуулгатай ижил боловч бүрэн хэмжээгээр цахимаар явагдана. Энэ нь цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.

**Эдийн засаг, хувийн санхүү (22213)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Англи хэлний түвшиний үнэлгээ дээр үндэслэж бүртгэж авна*

Энэ хичээлийн зарим хэсгийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.

**Эдийн засаг, AT (32806)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Байхгүй*

Энэ хичээл нь Ахисан шатны хөтөлбөрийн хэсэг бөгөөд "коллежийн нэгдүгээр курсийн эдийн засгийн удиртгал хичээлтэй ижил" шаардлагыг сурагчдад тавина. Энэ хичээлд бүртгүүлсэн сурагчид Макро эдийн засгийн хичээлийг нэг улирал авах ба үүгээр эдийн засгийн тогтолцоонд бүхэлд нь хамаарах эдийн засгийн зарчмуудыг сайтар ойлгоход чиглэнэ. Үүний дээр сурагчид Микро эдийн засгийн хичээлийг нэг улирал авах ба үүгээр эдийн засгийн системд хэрэглэгч, үйлдвэрлэгч хоёул тодорхой шийдвэр гаргахад холбогдох эдийн засгийн зарчмуудад анхаарна. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын хоёр шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй (22806). Энэ хичээлийг амжилттай дүүргэснээр сурагчдын Эдийн засаг, хувийн санхүүгийн төгсөлтийн шаардлагыг хангана.* Энэ хичээлийн зарим хэсгийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.*
**Хэрэв энэ хичээлийг Virtual Virginia-аар авбал сурагчид Эдийн засаг, хувийн санхүү хичээлийг дүүргэхийн тулд өөрийн гэрээрээ хувийн санхүүгийн хичээл нэмж авах шаардлагатай*

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх**

Энэ нь дунд сургууль төгсөхөд шаардах хичээлүүдийн нэг юм. Үүнийг 11-р ангид авах боловч зөвлөхтэй ярилцаж өөр ангиудад авч болно. Кредитийг дараах хэлбэрээр авч болно:

- **Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх (22360)**
- **Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх (22360V)**
- **Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх, AT (32319)**

*Карьерын жагсаалтад орсон нэмэлт хичээлүүдийг үзнэ үү Төв, Уэйкфилд, Вашингтон-Либерти, болон Энэ шаардлагыг хангасан Йорктаун*

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх (22360)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл нь харах өнцгүүдэд холбогдох сэдвүүдээр хуваарилагдсан. Хичээлээр нөлөө, байр суурь, харах өнцөг талаасаа газар зүй, байгаль орчин, ардчилах үйл явц, бизнесийн хөгжил, глобал харилцааны өөрчлөлт, шинжлэх ухаан ба технологийн хөгжлийн нөлөө, Америк мөрөөдөлд нөлөөлсөн Америкийн ба Виржиниагийн түүхэн хүмүүс, газар, үйл явдалд анхаарлаа төвлөрүүлнэ. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. Нийгэм судлалаар баталгаажсан кредит авах шаардлагатай сурагчид л SOL шалгалт өгөх эрхтэй.*

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх**
**Жил, улирал, нэг кредит (22360V)**
**Ангиуд: 11**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл нь харах өнцгүүдэд холбогдох сэдвүүдээр хуваарилагдсан. Энэ хичээлээр нөлөө, байр суурь, харах өнцөг талаасаа газар зүй, байгаль орчин, ардчилах үйл явц, бизнесийн хөгжил, глобал харилцааны өөрчлөлт, шинжлэх ухаан ба технологийн хөгжлийн нөлөө, Америк мөрөөдөлд нөлөөлсөн Америкийн ба Виржиниагийн түүхэн хүмүүс, газар, үйл явдалд анхаарлаа төвлөрүүлнэ. Энэ хичээлийн улирлын блок нь бүтэн жилийн хувилбарын 140 цагийг багтаана. *Энэ хичээлийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. Нийгэм судлалаар баталгаажсан кредит авах шаардлагатай сурагчид л SOL шалгалт өгөх эрхтэй.*

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх, AT (32319)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11**
*Урьдчилсан шаардлага: Багшийн зөвлөгөө; өмнөх ахлах сургуулийн нийгмийн ухаан ба Англи хэлний хичээлд "B" буюу дээш дүн*
Энэ хичээл нь Коллежид орох шалгалтын зөвлөлийн ахисан түвшний хөтөлбөрийн хэсэг бөгөөд коллежийн удиртгал хичээлтэй ижил хэмжээнд сурагчдад сорилт болно. Виржиниа, АНУ-ын түүхийн ердийн хичээлийн оронд энэ хичээлийг сонгож байгаа сурагчид маш их уншиж, абстракт концепц ба эргэцүүлэлд цаг гаргаж, Америкийн түүхийн янз бүрийн сэдвүүдийг сурах шаардлагатай. Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт хичээлийн бүрэн тодорхойлолт бий. Энэ хичээлийг сонгож байгаа сурагчид ахисан түвшний материал, текстийг унших шаардлагатай. *Хичээлийн төгсгөлд SOL болон AT шалгалтуудыг хоёуланг нь авна. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө. Баталгаажсан кредит авах шаардлагатай сурагчид л SOL шалгалт өгөх эрхтэй. Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (22319)*

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд**
Энэ нь дунд сургууль төгсөхөд шаардах хичээлүүдийн нэг юм. Кредитийг дараах хэлбэрээр авч болно:

- **Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд (22440)**
- **Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд (22440V)**
- **Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд (22446)**
- **Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд, AT (32445)**
- **Виржиниа, АНУ-ын Засгийн газар, хосолсон төгсөлт, Хос төгсөлт (92240W)**

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд (22440)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 12**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл нь "эрх мэдэл" сэдвээр хуваарилагдсан. Америкийн засгийн газрын байгууллагууд үйл ажиллагааны эрх мэдлээ олж авч байгаа эх үүсвэрүүд ба эдгээр эрх мэдлийг чухал үйл явц, ажиллагаа, системд хэрэглэх талаар зорилт тавьж анхаарна. Дэлхийн бусад улсуудын засгийн газруудын янз бүрийн бүлгүүд ба хандлагын нөлөөг мөн судална. Сургалтын гол концепцууд нь засгийн газар, эрх, хариуцлага, эрх чөлөө, байгууллага, улс төрийн үйл явц, бүх нийтийн хөтөлбөр, бодлого боловсруулах, улс төрийн ба эдийн засгийн харьцуулсан системүүд байна.

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд**
**Жил эсхүл улирлын блок, нэг кредит (22440V)**
**Ангиуд: 12**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл нь "*эрх мэдэл*" сэдвээр хуваарилагдсан.

Америкийн засгийн газрын байгууллагууд үйл ажиллагааны эрх мэдлээ олж авч байгаа эх үүсвэрүүд ба эдгээр эрх мэдлийг чухал үйл явц, ажиллагаа, системд хэрэглэх талаар зорилт тавьж анхаарна. Дэлхийн бусад улсуудын засгийн газруудын янз бүрийн бүлгүүд ба хандлагын нөлөөг мөн судална. Сургалтын гол концепцууд нь засгийн газар, эрх, хариуцлага, эрх чөлөө, байгууллага, улс төрийн үйл явц, бүх нийтийн хөтөлбөр, бодлого боловсруулах, улс төрийн ба эдийн засгийн харьцуулсан системүүд байна. Энэ хичээлийн улирлын блок нь бүтэн жилийн хувилбарын 140 цагийг багтаана. *Энэ хичээлийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.*

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд (22446)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**

Энэ хичээлээр засгийн газар, иргэн байх талаар үндсэн мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд анхаарна. Америкийн үндсэн баримт бичгүүд, муж ба нутгийн удирдлага, Америкийн улс төрийн систем, улс төр үндэсний ба мужийн түвшинд хэрхэн хийгддэг талаар анхаарах болно. Энэ хичээл сурагч бүрд засгийн газар хэрхэн ажилладаг, хүн бүр засгийн газарт оролцогч иргэн болох талаар зааж өгөхөд зориулагдсан.

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд, AT (32445)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 12**

*Урьдчилсан шаардлага: АНУ ба Виржиниагийн түүхийн 11-р ангийн багшийн зөвлөмж*

Энэ хичээл нь Коллежид орох шалгалтын зөвлөлийн ахисан түвшний хөтөлбөрийн хэсэг бөгөөд коллежийн улс төрийн ухааны удиртгал хичээлтэй ижил хэмжээнд сурагчдад сорилт болно. Хичээлийг Америкийн засгийн газар, улс төр ба Харьцуулсан засгийн газар ба улс төрийг гүнзгийрүүлэн үзэх хүсэлтэй бөгөөд энэ сорилтыг давахыг хүсэж буй сурагчдад зориулсан. Үүний дээр, хичээлээр улс төрийн онол ба нутгийн ба мужийн засгийн газрын талаар илүү анхаарна. Бичихэд их анхаарах ба сурагчид маш их унших шаардлагатай. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (22445)*

**Виржиниа, АНУ-ын Засгийн газар, хосолсон төгсөлт, Хос төгсөлт (92240W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 12**

*Урьдчилсан шаардлага: Сурагчид NOVA-д элсэх шаардлагыг хангах ёстой*

Америкийн засгийн газрын байгууллагууд үйл ажиллагааны эрх мэдлээ олж авч байгаа эх үүсвэрүүд ба эдгээр эрх мэдлийг чухал үйл явц, ажиллагаа, системд хэрэглэх талаар зорилт тавьж энэ хичээлд анхаарна. Дэлхийн бусад улсуудын засгийн газруудын янз бүрийн бүлгүүд ба хандлагын нөлөөг мөн судална. Сурагчид зориулсан гол концепцууд нь засгийн газар, эрх, хариуцлага, эрх чөлөө, байгууллага, улс төрийн үйл явц, бүх нийтийн хөтөлбөр, бодлого боловсруулах, улс төрийн ба эдийн засгийн харьцуулсан системүүд байна. Үүний дээр Америкийн Засгийн газар, улс төрийг илүү судлах боломжийг бүрдүүлж, шүүмжит сэтгэлгээ ба бичих чадварыг анхаарна. *Энэ хичээлийн зарим хэсгийг цахимаар заана. Энэх хичээлийг хичээлийн дараах цагаар, каунти даяарх байршилд санал болгоно. Энэ хичээлд холбогдож NOVA-ийн коллежийн хуваарийн дагуу долоо хоногт хоёр удаа уулзана.*

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага**
**(RISE) Дэлхийн газар зүй (20208)**
**(RISE) Дэлхийн түүх II (20207)**
**(RISE) Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх (20209)**
**Нэг улирал, хагас <u>сонгох</u> кредит**
**Ангиуд: 11-12**

*Урьдчилсан шаардлага: Анги төгссөн боловч SOL үнэлгээ дээр унасан, төгсөхөд шаардлагатай баталгаажсан кредит дутуу байгаа сурагчид.*

Сурагчид хичээлийг дүүргэсэн боловч SOL үнэлгээнд тэнцээгүй хичээл дээрээ нөхөж, давтаж сурах/хийх ба үүнд программ хангамжаар өгөх хичээл ба/эсхүл онлайн хөтөлбөр ашиглана. Суралцахад багш туслах боловч ихэнх ажлыг сурагчид бие дааж суралцах маягаар хийж дуусгана. Давтлага хичээлийг Англи хэл (бичих), Англи хэл (унших/уран зохиол, судалгаа), Алгебр I, Геометр, Биологи, Дэлхий шинжлэл,

Дэлхийн газар зүй, Дэлхийн түүх, Виржиниа ба АНУ-ын түүхээр санал болгоно. *Тайлбар: Сурагчид энэ хичээлийг давах/унах маягаар хийнэ.*

## НИЙГЭМ СУДЛАЛЫН СОНГОХ ХИЧЭЭЛҮҮД

**Африк Америкийн судлал (22371)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Африкийн Америкийн судлал хичээл нь Африкийн америкийн түүхэн сургамжийн шалтгаан, шинж, үр дагавар ба үүний дэлхий, Америкийн Нэгдсэн Улс, Африк гаралтай Америкчуудад үзүүлсэн нөлөөг ойлгоход зориулагдсан ба хичээлээр сурагчид Африк ба Америкийн түүхэн сургамжийг тодорхойлох, зөв ойлгох тоймыг өгнө.

**Европын түүх, AT (32399)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 10-12**
*Урьдчилсан шаардлага: Багшийн зөвлөгөө; өмнөх нийгмийн ухааны хичээлд "B" буюу дээш дүн*
Энэ хичээл нь Коллежийн зөвлөлийн ахисан түвшний хөтөлбөрийн хэсэг бөгөөд коллежийн удиртгал хичээлтэй ижил хэмжээнд сурагчдад сорилт болно. Энэхүү эрчимжүүлсэн хичээлээр сурагчдад манай ертөнцийг бий болгоход сууръ хүчин зүйл болсон соёл, эдийн засаг, улс төр, нийгмийн хөгжлийг танилцуулна. Сурагчид 1400-ээд оны Сэргэн мандалтын үеэс эхэлж, Европын Холбоо үүссэн 1990-ээд оныг хүртэлх орчин үеийн Европын түүхийн үндсэн хуанли, гол үйл явдлууд, хөдөлгөөнүүд, өөрчлөлтүүд, трендийн талаар мэдлэг олж авах ёстой. Энэ хичээлээр баримт бичигт суурилсан асуултад хариулсан эссэ, семинар, ангийн хэлэлцүүлэг ба/эсвэл мэтгэлцээнийг хэрэглэж дүн шинжилгээ хийж сэтгэх, бичих чадварт анхаарна. Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт хичээлийн бүрэн тодорхойлолт бий. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (22399)*

**Хүний амын газар зүй, AT (32212)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Одоогийн нийгэм судлалын хичээлийн багшийн зөвлөгөө*
Энэ хичээл нь Коллежийн зөвлөлийн ахисан түвшний хөтөлбөрийн хэсэг бөгөөд коллежийн удиртгал хичээлтэй ижил хэмжээнд сурагчдад сорилт болно. AT Хүн амын газар зүй хичээлээр сурагчдад хүний Дэлхийн гадаргууг ойлгох, хэрэглэх, өөрчлөх шинж хандлага, үйл явцыг системтэйгээр танилцуулна. Сурагчид орон зайн концепц, газар нутгийн шинжилгээг хүний нийгэм эдийн засгийн зохион байгуулалт ба байгаль орчны нөлөөг шинжлэхэд хэрэглэж сурна. Газрын зураг тайлбарлах, гео орон зайн өгөгдөл шинжлэх, ойлгох ба газар орон дахь холбоо сүлжээг тайлбарлаж, янз бүрийн анализын түвшинд чиг хандлага ба үйл явцыг таньж, тайлбарлаж, бүсийг тодорхойлж, бүс нутгийн үйл явцыг үнэлж, эдгээр газруудын харилцан нөлөөлөх өөрчлөлтүүдийн шинжийг гаргаж, дүгнэлт хийх чадварыг сурагч энэ хичээлийг амжилттай дүүргэснээс эзэмшинэ. Хичээлээр анхаарах газар зүйн концепцод байршил, орон зай, газар, хэмжээ, чиг хандлага, бүс нутаг, даяарчлал байна. Багтсан сэдвүүд нь газар зүйн шинж, чиг хандлага; хүн ам ба шилжилт хөдөлгөөн; соёлын чиг хандлага ба үйл явц; орон зайн улс төрийн зохион байгуулалт, хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, газар ашиглах; үйлдвэржилт ба эдийн засгийн хөгжил; их хотууд ба хотуудын газрын хэрэглээ байна. Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт хичээлийн бүрэн тодорхойлолт бий. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (*22209*)*

**Хуулийн тухай танилцуулга (22218)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр манай нийгэмд хуулийн гүйцэтгэх үүргийн талаар танилцуулна. Энэ нь Америкийн хуульд холбогдох процесс, хуулийн эх сурвалж, холбооны болон муж улсын шүүхийн зохион байгуулалтын тухай тоймыг багтаана. Сурагчид хэрэг маргаан шийдэх үйл явцыг эрүү ба иргэний маргааны хувьд харьцуулж үзнэ. Хичээлд үндсэн хуулийн хамгаалалт, хууль шүүхийн бодлого боловсруулах, гэм хор арилгах, гэрээний ба үндсэн хуулийн эрх зүй, эрүүгийн шүүхийн талаар үзэж, хэлэлцэнэ. Сурагчид шүүхийн процессын талаар суралцаж, загвар шүүх хурал, жүжиг, хуулийн хэргийг судалж үзнэ.

**Латин Америкийн судлал (22373)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр Латин Америкийн эртний соёлуудаас эхлээд 21-р зууны түүх хүртэлх

түүхийг багтаана. Сурагчид Латин Америкийн соёлууд, тэдгээрийн улс төр ба эдийн засгийн бүтэц, тэдгээрийн даяарчлагдсан ертөнцөд үзүүлэх нөлөөг янз бүрийн нүдээр харахад суралцана. Түүхэн болон одоогийн үйл явцад шинжилгээ хийх замаар сурагчид Латин Америкийг илүү ойлгож, бүс нутгийн түүх дэлхий даяарх харилцан холбоо, чиг хандлагад ямар байдлаар нөлөөлсөн талаар танилцана.

**Олон талын оролцоог хангах талаар дасгалжуулагчдын манлайллын чадвар (22700)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр сурагчдыг олон талын оролцоог хангах, бусдыг хүлээн зөвшөөрөх, харилцан хүндлэх тухай өөрийн нөхдөд семинар хийхэд дасгалжуулна. Сурагчид (1) урьдчилсан өрөөсгөл төсөөлөл, ялгаварлан гадуурхах, стереотипд хуваарилах талаар болон (2) тэд сургууль, нийгэмд илүү ихээр шууд оролцох талаар мэдэж, ойлгож авна.

**Сэтгэл судлал (22900)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр сурагчдад сэтгэл судлалын талаар ерөнхий удиртгал өгнө. Сургалтад зан харилцааны сэтгэлзүйн суурь, хүүхдийн өсөлт, хөгжил, сурах, хувь хүн ба нийгмийн сэтгэл зүй, ердийн бус сэтгэлзүй, шилжилтийн нас, хүний биеийн ерөнхий сэтгэлзүйн өсөлт багтана.

**Сэтгэл судлал, АТ (32902)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Одоогийн нийгэм судлалын хичээлийн багшийн зөвлөгөө*
Зан харилцааны шинжлэх ухаан бол сэтгэлзүй юм. Ахисан түвшний сэтгэлзүйн хичээлийн зорилго нь хүн болоод бусад амьтдын зан харилцаа, тархины үйл явцыг системтэй ба шинжлэх ухааны үүднээс судлахыг сурагчдад танилцуулах юм. АТ-ийн хичээлийн гол сэдвүүдэд дараах багтана: I. аргачлал, арга, түүх. II. зан харилцааны биологийн суур. III. мэдрэмж ба хүлээн авах. IV. ухамсар. V. сурах. VI. танин мэдэх. VII. шалтгаан ба сэтгэл хөдлөл VIII. өсөлт хөгжлийн сэтгэлзүй. IX. хувь хүний чанар. X. шалгах ба хувь хүмүүсийн ялгаа. XI. сэтгэлзүйн эмгэг. XII. сэтгэлзүйн эмгэгийг эмчлэх. XIII. нийгмийн патологи.
*Сурагчид энэ хичээлтэй холбоотой АТ-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (22902)*

**Социологи (22500)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Социологи бол хүмүүсийн бүлэг, түүний хувь хүнд нөлөөлөх нөлөөний тухай шинжлэх ухаан юм. Хүн бүрийн амьдрал дахь “нийгмийн фактыг” ойлгоход илүү анхаарна. Эцэг эх, багшаас, найз нөхөд хүртэл хүмүүсийн бүлэг биднийг хэн гэдгийг, бидэнд юу чухлыг, бид хэн болохыг тодорхойлдог. Арьс өнгөөр ялгаварлах, ядуурал, гэмт хэрэг зэрэг нийгмийн асуудлыг гүнзгийрүүлж үзнэ. Социологийн үндсэн зорилго нь хувь хүн болон хүний нийгмийн үүрэг дэх нийгмийн нөлөөг сурагч сайн ойлгоход чиглэнэ.

**Дэлхийн нийгэм, улс төр (22388)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**Ангиуд: 10 - 12**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Хичээл нь Америкийн гадаад бодлогын түүхээр Нэгдсэн Улсын дэлхийн улс төр дэх үүргийг үзэх замаар эхэлнэ. Бид Америкийн Нэгдсэн Улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын янз бүрийн зөрчлүүдэд гүйцэтгэсэн үүрэг, гадаад бодлогын шийдвэрийг хэрхэн гаргадаг талаар ярилцана. Бусад сэдвүүдэд дипломат ёс, олон улсын харилцаа, институт ба байгууллагууд, хүний эрх, терроризм, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дэлхийн ба бүс нутгийн зөрчлүүд ба асуудлууд, сүүлийн үеийн ба одоогийн үйл явц багтана.

## Санал болгож буй Арлингтоны улсын сургуулийн Ахлах Сургуулийн Нийгэм Судлалын хөтөлбөр

Энэ хөтөлбөр нь янз бүр байж болох тул өөрчлөлт нь нэг баганаар хязгаарлагдахгүй. Сурагчид түргэвчилсэн хэлбэрээр суралцах боломжтой. Стандарт ба Ахисан шатны дипломын төгсөлтийн шаардлагуудыг үзнэ үү.

| **8-р анги** | Дэлхийн газар зүй<br>**Санал: 9-р ангийн хичээлийн сонголтууд дараа жилийн сонголтуудыг тодорхойлно.** | | | | |
|---|---|---|---|---|---|
| **9-р анги** | • Дэлхийн түүх, газар зүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл (22216) эсхүл Англи хэл 9, Дэлхийн түүх, Газар зүй: МЭ-ий 1500-аас өнөөг хүртэл (зөвхөн Yorktown) (22216/21130) эсхүл Дэлхийн түүх, Эрчимжүүлсэн (22343) | • Дэлхийн түүх, газар зүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл ELD (22345) | • Дэлхийн түүх, Эрчимжүүлсэн (22343) эсхүл Дэлхийн түүх, Газар зүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл ELD (22345) эсхүл Дэлхийн түүх (зөвхөн W-L & Wakefield) (32400) | • Дэлхийн түүх (зөвхөн W-L & Wakefield) (32400) | • ВИ/АНУ Хэсэг 1 (IEP зөвхөн) ** |
| **10-р анги** | • Эдийн засаг, хувийн санхүү Эдийн засаг, хувийн санхүү цахим хичээл (22212V), ELD Эдийн засаг, хувийн санхүү (22213) эсхүл АТ Эдийн засаг (32806)<br>• Дэлхийн түүх, газар зүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл ELD (22345) эсхүл Дэлхийн түүх, Газар зүй: Эртнээс МЭ-ий 1500 он хүртэл, Эрчимжүүлсэн (22219)<br>• Хүний амын газар зүй, АТ (32212)<br>• Хуулийн тухай танилцуулга (22218)<br>• Сэтгэл судлал (22900)<br>• Олон талын оролцоог хангах талаар дасгалжуулагчдын манлайллын чадвар (22700)<br>• Сэтгэл судлал, АТ (32902)<br>• Социологи (22500)<br>• Дэлхийн нийгэм, улс төр (22388) | • Эдийн засаг, хувийн санхүү (22212) Эдийн засаг, хувийн санхүү цахим хичээл (22212V), ELD Эдийн засаг, хувийн санхүү (22213) эсхүл АТ Эдийн засаг (32806)<br>• Дэлхийн түүх, газар зүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл ELD (22345) эсхүл Дэлхийн түүх, Газар зүй: Эртнээс МЭ-ий 1500 он хүртэл, Эрчимжүүлсэн (22219)<br>• Хүний амын газар зүй, АТ (32212)<br>• Хуулийн тухай танилцуулга (22218)<br>• Сэтгэл судлал (22900)<br>• Олон талын оролцоог хангах талаар дасгалжуулагчдын манлайллын чадвар (22700)<br>• Сэтгэл судлал, АТ (32902)<br>• Социологи (22500)<br>• Дэлхийн нийгэм, улс төр (22388) | • АТ Засгийн газар (зөвхөн WL дэх ОУБ-ын өмнөх сурагчид) (32445) | • АТ Эдийн засаг (32806) АТ Европын түүх (32399) | • ВИ/АНУ Хэсэг 1 (IEP зөвхөн) ** |
| **11-р анги** | • ВИ/АНУ-ийн Түүх (22360), ВИ/АНУ-ийн Түүх цахим хичээл (22360V)<br>• Эдийн засаг, хувийн санхүү (22212)<br>• Хүний амын газар зүй, АТ (32212)<br>• Хуулийн тухай танилцуулга (22218)<br>• Олон талын оролцоог хангах талаар дасгалжуулагчдын манлайллын чадвар (22700)<br>• Сэтгэл судлал (22900) эсхүл Сэтгэл судлал, АТ (32902)<br>• Социологи (22500)<br>• Дэлхийн нийгэм, улс төр (22388) | • ВИ/АНУ Түүх (22360), ВИ/АНУ Түүх, цахим (22360V), эсхүл ВИ/АНУ Түүх, АТ (32319) ба<br>• Хүний амын газар зүй, АТ (32212)<br>• Хуулийн тухай танилцуулга (22218)<br>• Сэтгэл судлал (22900) эсхүл Сэтгэл судлал, АТ (32902)<br>• Олон талын оролцоог хангах талаар дасгалжуулагчдын манлайллын чадвар (22700)<br>• Социологи (22500)<br>• Дэлхийн нийгэм, улс төр (22388) | • ОУБ Америкийн түүх HL Хэсэг 1 (32385) &<br>• ОУБ Эдийн засаг SL (32802)<br>• ОУБ Газар зүй SL (32210)<br>• ОУБ Сэтгэлзүй SL (32901) HL Хэсэг I (32904)<br>• ОУБ Философи SL (32600)<br>• ОУБ Нийгмийн антропологи SL (32372) HL Хэсэг I (32374) | • ВИ/АНУ-ын түүх, АТ (32319) | • Хувь хүний амьдрал, санхүү (20055) (IEP зөвхөн) ** |
| **12-р анги** | • ВИ/АНУ-ын засгийн газар (22440), ВИ/АНУ-ын засгийн газар, цахим (22440V), ELD 1 ВИ/АНУ-ын засгийн газар (22446) эсхүл ВИ/АНУ-ын засгийн газар DE (92240W), Эдийн засаг, хувийн санхүү (22212)<br>• Хуулийн тухай танилцуулга (22218) | • ВИ/АНУ-ын засгийн газар (22440). ВИ/АНУ-ын засгийн газар, цахим (22440V), ELD ВИ/АНУ-ын засгийн газар (22446), ВИ/АНУ-ын засгийн газар, АТ. (32445), ВИ/АНУ-ын засгийн газар DE (92240W),<br>• Хуулийн тухай танилцуулга (22218) | • 20-р зууны Дэлхийн түүх HL хэсэг 2 (32386) ОУБ-ын сэдвүүд<br>• ОУБ Эдийн засаг SL (32802)<br>• ОУБ Сэтгэлзүй SL (32901) HL Хэсэг II (32904)<br>• ОУБ Философи (32600)<br>• ОУБ Газар зүй SL (32210) | • ВИ/АНУ-ын засгийн газар, АТ. (32445) эсхүл ВИ/АНУ-ын засгийн газар, Харьцуулсан ЗГ, АТ (32245) эсхүл ВИ/АНУ-ын засгийн газар DE (92240W)<br>• Сэтгэл судлал, АТ (32902) | • ВИ/АНУ-ын засгийн газар (20018) (IEP зөвхөн) ** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | • Олон талын оролцоог хангах талаар дасгалжуулагчдын манлайллын чадвар (22700)<br>• Сэтгэл судлал (22900) эсхүл Сэтгэл судлал, AT (32902)<br>• Социологи (22500)<br>• Дэлхийн нийгэм, улс төр (22388) | • Олон талын оролцоог хангах талаар дасгалжуулагчдын манлайллын чадвар (22700)<br>• Сэтгэл судлал (22900) эсхүл Сэтгэл судлал, AT (32902)<br>• Социологи (22500)<br>• Дэлхийн нийгэм, улс төр (22388) | • ОУБ Нийгмийн антропологи SL (32372) HL Хэсэг II (32374) | | |

* Сурагчид Виржиниа, АНУ-ын түүхийн нэг хувилбар болон Виржиниа, АНУ-ын Засгийн газрын нэг хувилбарыг заавал авах ёстой ба нэг хичээл нь нэг бол дэлхийн түүх эсхүл газар зүй эсхүл хоёулаа байж байж Стандарт дипломын эсхүл энэ төрлийн хоёр хичээл Ахисан түвшний дипломын төгсөлтийн шаардлагыг хангана.

**Энэ хичээлд нийгмийн ухааны кредит авахын тулд сурагч нь Хэсэг I ба II-ыг дүүргэх ёстой ба одоогоор Хувь хүнд тохируулсан хөтөлбөртэй, үүнд энэ хичээлийг тусгайлан заасан ба VA SOL-той холбоотой шалгалтыг өгнө.

***Сурагчид Стандарт эсхүл Ахисан түвшний дипломын шаардлагыг хангахын тулд Эдийн засаг, хувийн санхүүгийн хувилбарыг авах ёстой.

## ТУСГАЙ БОЛОВСРОЛ

Тусгай боловсрол нь тусгай зааварчилгаа шаардлагатай сурагчдад зориулсан үйлчилгээнээс бүрдэнэ. Зааварчилгааг сурагчийн хэрэгцээнд зориулж тусгайлан өгнө. Хувь хүнд тохируулсан сургалтыг [Individualized Education Program (IEP)] холбооны улс болон Виржиниагийн хууль журмын дагуу боловсруулсан. Тусгай боловсролын бодлого, дүрэм журамд холбогдож нэмэлт мэдээллийг Тусгай боловсролын оффистой холбогдож авна уу.

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Англи хэл 9 (20001)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Хичээл нь богино өгүүллэг, шүлэг болон роман ашиглан уншиж ойлгох, зөв бичих, үгсийн сан ашиглах, өгүүлбэрийн бүтэц, догол мөр бүтээх, уран зохиол судлах зэрэгт анхаарна. Материал болон сурах бичгийг сурагчийн унших түвшинд нийцүүлэн сонгоно.

**Англи хэл 10 (20002)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн.
Хичээл нь богино өгүүллэг, шүлэг болон роман ашиглан уншиж ойлгох, зөв бичих, үгсийн сан ашиглах, өгүүлбэрийн бүтэц, догол мөр бүтээх, уран зохиол судлах зэрэгт анхаарна. Материал болон сурах бичгийг сурагчийн унших түвшинд нийцүүлэн сонгоно.

**Англи хэл 11 (20003)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээл нь Хэрэглээний сургалтын диплом авахаар сурч байгаа сурагчид эсхүл 2013-2014 оноос өмнө 9-р ангид орсон бөгөөд IEP дээрээ үндэслэж Тохируулсан стандарт диплом авах эрхтэй байх боломжтой сурагчдад нэг сонголт юм. Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Хичээлээр уншиж ойлгох, үгсийн сангийн хөгжил, найруулж бичихэд анхаарах ба судалгааны бичиглэл, дүрэм ба хэлзүйн сургалт, уран зохиол буюу богино түүх, шүлэг, номд анхаарна. Материал болон сурах бичгийг сурагчийн унших түвшинд нийцүүлэн сонгоно. Хэрэглээний сургалтын диплом эсхүл Өөрчилсөн стандарт дипломыг авахаар сурч байгаа сурагчид энэ хичээлийг амжилттай төгсөж Англи хэлний кредит авах болно. *Энэ хичээлийн сурагчид хичээлийн төгсгөлийн SOL шалгалт өгөх шаардлагагүй.*

**Англи хэл 12 (20004)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Агуулгад зөгнөлт, баримтат зохиол, хэлний хэрэглээ, үгсийн сангийн сургалт, нийтлэлийн бичлэг агуулгад багтана. Ажиллагааны чадварууд мөн багтана. Материал болон сурах бичгийг сурагчийн унших түвшинд нийцүүлэн сонгоно.

**Уншлага (20015)**
**Бүтэн жил, нэг кредит**
**(20006) Нэг улирал, нэг хагас кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээлийг нэмэлт дэмжлэг унших чадварт хэрэгтэй байгаа ба академик хичээлд ерөнхий дэмжлэг хэрэгтэй, SOL шалгалтад бэлтгэх сурагчдад ихээхэн зөвлөж байна. Хичээлд сурагчдын хувьд шинэ зөгнөлт, баримтат зохиол багтах ба богино өгүүлэмжүүд нь шалгалтад бэлтгэхэд тохиромжтой бөгөөд ойлгох чадварыг дээшлүүлэх шүүмжит уншлагыг багтаана. Энэ хичээл нь унших чадварыг сайжруулахад анхаарах ба сурагчид бусад хичээлд уншихад туслах материалуудыг багтаана.

**Алгебр I, Хэсэг I (20008)**
**Бүтэн жил, нэг кредит**
**ээс 2-р анги 9-12**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*

Хичээл нь бодит тооны систем, нэгдүгээр шатны тэнцэтгэл, тэнцэтгэл бус, бодлого бодох, график гаргах, шугаман загварчлалыг багтаана.Стандарт диплом авахаар сурч байгаа сурагчид Алгебр I, Хэсэг II-ийг энэ хичээлд математикийн кредит авахын тулд дүүргэнэ. Энэ шаталсан сургалтын Хэсэг 1 ба Хэсэг II-ийг дүүргэснээр кредиттэй стандарт диплом авах математикийн хоёр кредит авна. Алгебр I хичээлийн (23130) агуулга нь Алгебр I SOL шалгалтад хэсэг II-ийг дүүргэсэн тохиолдолд багтана. SOL шалгалтад тэнцсэнээр баталгаажсан кредит авна.

**Геометрийн сонгосон сэдвүүд (20054)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Сурагч нь Тусгай боловсролын үйлчилгээнд хамрагдсан байх ёстой ба Алгебр I, Хэсэг I-д "D" эсхүл дээш дүнг авсан байна.*
<u>Энэ хичээл нь Хэрэглээний сургалтын диплом авахаар сурч байгаа сурагчид эсхүл 2013-2014 оноос өмнө 9-р ангид орсон бөгөөд IEP дээрээ үндэслэж Тохируулсан стандарт диплом авах эрхтэй байх боломжтой сурагчдад нэг сонголт юм.</u> Энэ хичээл нь хоёр ба гурван хэмжээст үндэслэлийн чадварт анхаарч хэрэглээний замаар геометрийг харах, геометрийн координат, бодлого бодоход геометрийг ашиглахад сургахад зориулагдсан. Эдгээр сэдэвт өнцөг, конгруэнт чанар, параллель, гурвалжин, хувирал, дөрвөн өнцөгт, дугуй зэрэг багтана. Хэрэглээний сургалтын диплом эсхүл Өөрчилсөн стандарт дипломыг авахаар сурч байгаа сурагчид энэ хичээлийг амжилттай төгсөж Математикийн кредит авна. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай.*

**Хувийн амьдрал, санхүү (20055)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
<u>Энэ хичээл нь Хэрэглээний сургалтын диплом авахаар сурч байгаа сурагчид эсхүл 2013-2014 оноос өмнө 9-р ангид орсон бөгөөд IEP дээрээ үндэслэж Тохируулсан стандарт диплом авах эрхтэй байх боломжтой сурагчдад нэг сонголт юм.</u> Энэ хичээлээр сурагчид хувийн ба бизнесийн санхүүгийн асуудлаа шийдэхэд шаардлагатай чадваруудыг зааж өгнө. Банк ба чек, цалин авах, зээл, төсөв гаргах гэсэн асуудлаар асуудал шийдэхэд анхаарна. Хэрэглээний сургалтын диплом эсхүл Хэрэглээний стандарт дипломыг авахаар сурч байгаа сурагчид энэ хичээлийг амжилттай төгсөж Математикийн кредит авна. Коммвэлтийн 21 ажлын байрны бэлэн байдлын чадварууд [the 21 Workplace Readiness Skills (WRS)]-д оролцож байгаа ба энэ хичээлийн хэсэг болгож WRS үнэлгээг амжилттай дүүргэсэн сурагчдыг Стандарт дипломын кредит өгөхөд харгалзаж болно.

**Дэлхийн газар зүй (20040)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээлээр хүмүүс хоорондын харилцаа болон бүс нутгууд дахь орчинтойгоо тэдний харилцах харилцаанд төвлөрнө, тухайлбал, Африк, Ази, Австрали, Төв Америк, Кариб, Европ, Ойрх Дорнод, Хойд Америк, Өмнөд Америк болон хуучнаар Зөвлөлт Холбоот Улс. Газар зүй, байршил, газар, хүн ба байгаль орны харилцаа, шилжилт хөдөлгөөн ба шашин гэсэн таван сэдвийг биет, соёлын, улс төрийн, эдийн засгийн болон бусад төрлийн газар зүйн сургалтад хэрэглэнэ. *Хэрэв хичээлийг дүүргэж, SOL шалгалтад тэнцвэл энэ хичээл нь ахисан түвшний ба стандарт дипломын шаардлагыг хоёуланг нь хангана.*(Энэ хичээл нь дунд сургуулийн 8-р ангид заадаг Дэлхийн газар зүй хичээлтэй ижил юм.)

**Дэлхийн түүх, газар зүй, МЭ-ий 1500-аас өнөөг хүртэл, Хэсэг I (20051)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Хичээлээр чухал үйл явдал, хүмүүс, МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэлх Барууны европын ойлголтыг дараалаар нь үзэхэд анхаарлаа төвлөрүүлнэ. Газар зүй түүхэд нөлөөлсөн янз бүрийн замуудтай өнөөгийн нийгмүүдэд нөлөөлсөн улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөд илүү анхаарч танилцана. Энэ хичээл нь Дэлхийн түүх, газар зүйн ерөнхий боловсролын эхний улиралд санал болгосон агуулгатай параллель юм. МЭ-ий 1500-аас өнөөг хүртэлх (22216) хичээлийг тусгай материал ба заах/сурах аргачлалаар хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан. *Хэрэглээний сургалтын диплом эсхүл Өөрчилсөн стандарт дипломыг авахаар сурч байгаа сурагчид энэ хичээлийг амжилттай төгсөж нийгмийн ухааны кредит авна. Стандарт дипломыг кредиттэйгээр авахаар зорьж байгаа сурагчид МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэлх Дэлхийн түүх ба газар зүй, Хэсэг II хичээлийг нийгмийн ухааны хичээлийн кредит авахын тулд дүүргэх ёстой. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай.*

**Дэлхийн түүх, газар зүй, МЭ-ий 1500-аас өнөөг хүртэл, Хэсэг II (20052)**
*Урьдчилсан шаардлага: Дэлхийн түүх, газар зүй, МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл, Хэсэг I хичээлийг амжилттайгаар дүүргэх*
Хичээлээр чухал үйл явдал, хүмүүс, МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэлх Барууны европын ойлголтыг бүс нутгийн үүднээс авч үзэхэд анхаарлаа төвлөрүүлнэ. Сурагчид Хэсэг I-ийн агуулгыг давтаж үзээд дараах түүхийн заасан хугацааны үе дэх дэлхийн бүсүүдэд холбогдож гүнзгийрүүлэн сурна. *Сурагчид энэ хичээлээр нийгмийн ухааны хичээлийн кредит авна. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай.*

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх, Хэсэг I (20016)**
**Бүтэн жил, ВИ/АНУ-ийн түүх, Хэсэг II-ийг дүүргэснээр нэг сонгох хичээлийн кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Дэлхийн газар зүй эсхүл Дэлхийн түүх хичээлийг амжилттай дүүргэсэн ба сурагч нь Тусгай боловсролын үйлчилгээг авах эрхтэй бөгөөд кредит авах шаардлагатай байх ёстой.*

Энэ хичээл нь Америкийг нээсэн үеэс эхлээд Сэргээн босгох үе хүртэлх үеийг хамарна. Хичээлээр Америкийн улс төр ба эдийн засагт газар зүйн нөлөө; өөрчлөгдөж буй нийгмийн шаардлагыг хангахад Америкийн засаг төрийн хөгжил; Америкийн нийгэм дэх хүн амын шилжилтийн нөлөө; Америк дахь амьдралд технологийн болон шинжлэх ухааны дэвшил нөлөөлсөн байдал; жижиг улсуудын нэгдлээс өсөн дэвжих үндэстэн болсон Америкийн үүрэг гэсэн асуудлуудад тэргүүн зэрэгт анхаарна. Виржиниа болон АНУ-ын түүхийн хуанлийн голлох зүйлс, үйл явдалд илүү анхаарах болно. Тусгай боловсролын материал, багшлах/сурах аргачлалыг сурагчийн унших чадварын хөгжилд тохируулна. Кредит авах Стандарт диплом авахаар зорьж байгаа сурагчид хэрэв энэ хичээлийн Хэсэг II-ийг авбал энэ хичээлээр нийгмийн ухааны хичээлийн кредит авна. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалт бий.

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх, Хэсэг II (20019)**
**Нэг жил, нийгмийн ухааны нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Нэгдсэн Улс ба Виржиниагийн түүх, Хэсэг I хичээлийг амжилттай дүүргэсэн ба сурагч нь Тусгай боловсролын үйлчилгээг авах эрхтэй бөгөөд кредит авах шаардлагатай байх ёстой.*
Энэ хичээл нь Америкийн сэргээн босголтын дараах үеэс дэлхийн II дайны дараах үеийг хамарна. Хичээлээр Америкийн улс төр ба эдийн засагт газар зүйн нөлөө; өөрчлөгдөж буй нийгмийн шаардлагыг хангахад Америкийн засаг төрийн хөгжил; Америкийн нийгэм дэх хүн амын шилжилтийн нөлөө; Америк дахь амьдралд технологийн болон шинжлэх ухааны дэвшил нөлөөлсөн байдал; жижиг улсуудын нэгдлээс дэлхийн их гүрэн болсон Америкийн үүрэг гэсэн асуудлуудад тэргүүн зэрэгт анхаарна. Виржиниа болон АНУ-ын түүхийн хуанлийн голлох зүйлс, үйл явдалд илүү анхаарах болно. Тусгай боловсролын материал, багшлах/сурах аргачлалыг сурагчийн унших чадварын хөгжилд тохируулна. ВИ/АНУ Түүх Хэсэг I ба ВИ/АНУ Түүх Хэсэг II-ийн агуулгыг багтаасан хичээлийн төгсгөлийн SOL шалгалт бий. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.

**Америкийн Нэгдсэн Улсын түүх, Хэрэглээ (20053)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээл нь Америкийг нээсэн үеэс эхлээд Сэргээн босгох үе хүртэлх үеийг хамрах болно. Хичээлээр Америкийн улс төр ба эдийн засагт газар зүйн нөлөө; өөрчлөгдөж буй нийгмийн шаардлагыг хангахад Америкийн засаг төрийн хөгжил; Америкийн нийгэм дэх хүн амын шилжилтийн нөлөө; Америк дахь амьдралд технологийн болон шинжлэх ухааны дэвшил нөлөөлсөн байдал; дэлхийн их гүрэн болохын хувьд Америкийн үүрэг гэсэн асуудлуудад тэргүүн зэрэгт анхаарна. Материал, багшлах/сурах аргачлалыг сурагчийн унших чадварын хөгжилд тохируулна. *Хэрэглээний сургалтын диплом эсхүл Өөрчилсөн стандарт дипломыг авахаар сурч байгаа сурагчид энэ хичээлийг амжилттай төгсөж нийгмийн ухааны кредит авах болно.* ***Тохируулсан стандарт диплом*** *авах гэж байгаа сурагчдад энэ хичээлд нийгмийн ухааны кредит өгнө. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай.*

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх (20017)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид арван нэгдүгээр ангид байх ёстой ба Тусгай боловсролын үйлчилгээ авах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээл нь сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангах маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр юм. Сурагчид нийгмийн түүхийг анхнаас нь эхлээд түүхчлэн үзнэ. Виржиниа болон АНУ-ын түүхийн хуанлийн голлох зүйлс, үйл явдалд илүү анхаарна. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай.*

**Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд (20018)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид арван хоёрдугаар ангид байх ёстой ба Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээлээр засгийн газар, иргэн, чадвар хөгжүүлэхийг практик талаас авч үзэхэд анхаарна. Америкийн үндсэн баримт бичгүүд, муж ба нутгийн удирдлага, Америкийн улс төрийн систем, улс төр орон нутгийн түвшинд хэрхэн хийгддэг талаар анхаарах болно.

**Биологи, Хэсэг I (20020)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээлээр эсийг багтааж биологид нийтлэх ерөнхий концепцууд; өв ба эволюц; организмуудын харилцан нөлөөлөл; юмс; энерги; амьд системүүдийн зохион байгуулалт; организмын зан үйлдлийн талаар үзнэ. Энэ нь хоёр хэсэгтэй цуврал хичээлийн эхнийх бөгөөд агуулгад холбогдож өөрийн унших чадвараа дээшлүүлэх, мөн янз бүрийн мэдээллийг сурах, эмхлэх, мэдээллийн харилцан хамааралд холбогдож сурагчдад туслах арга барилуудыг багтаана. *Хэрэглээний Стандарт диплом эсхүл Тохируулсан стандарт диплом авах гэж байгаа сурагчдад энэ хичээлд байгалийн шинжлэлийн кредит өгнө. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. Энэ хичээл мөн Стандарт дипломын лабораторийн кредитэд тооцогдож, кредит авч болно. Үүний тулд Биологи, Хэсэг II-т сууж, Биологи SOL шалгалтыг өгөх ёстой.*

**Биологи, Хэсэг II (20021)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид тусгай боловсролын үйлчилгээг авах хэрэгцээтэй гэсэн тодорхойлолттой байх ёстой ба Биологи, Хэсэг I хичээлийг дүүргэсэн байх ёстой*
Энэ хичээлээр эсийг илүү нарийн судлахыг багтааж биологид нийтлэх ерөнхий концепцууд; өв ба эволюц; организмуудын харилцан нөлөөлөл; юмс; энерги; амьд системүүдийн зохион байгуулалт; организмын зан үйлдлийн талаар үргэлжлүүлэн үзнэ. Энэ нь хоёр хэсэгтэй хичээлийн хоёр дахь хэсэг бөгөөд агуулгад холбогдож өөрийн унших чадвараа үргэлжлүүлэн дээшлүүлэх, мөн янз бүрийн мэдээллийг сурах, эмхлэх, тайлбарлах чадварт холбогдож сурагчдад туслах арга барилуудыг багтаана. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. Энэ хичээлийг дүүргэж, Биологийн хичээлийн төгсгөлийн SOL шалгалтыг давсан сурагчид шинжлэх ухааны баталгаажсан кредит авна.*

**Физикийн зарчмууд (20049)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ авах эрхтэй байх шаардлагатай*
<u>Энэ хичээл нь Хэрэглээний сургалтын диплом авахаар сурч байгаа сурагчид эсхүл 2013-2014 оноос өмнө 9-р ангид орсон бөгөөд IEP дээрээ үндэслэж Тохируулсан стандарт диплом авах эрхтэй байх боломжтой сурагчдад нэг сонголт юм.</u>
Энэ нь физикийн хичээлийн үндсэн концепцууд, хөдөлгөөн, хүч, гэрэл, цахилгаан, соронз, цөмийн физикийн талаарх суран хичээл юм. Энэ хичээлээр өөрийн унших чадвараа үргэлжлүүлэн дээшлүүлэх, мөн янз бүрийн мэдээллийг сурах, эмхлэх, тайлбарлах чадварт холбогдож сурагчдад туслах арга барилуудыг багтаана.

**Заах арга зүй судлал**
**Бүтэн жил, нэг кредит (20028)**
**Нэг улирал, нэг хагас кредит (20030)**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Хичээлийг IEP-ийн дагуу тухайн хүнд тохируулсан байх бөгөөд энэ нь сурагч тус бүрийн ерөнхий боловсролын хичээлүүд дэх хэрэгцээг хангасан байна. Түүнчлэн, сонсох, бичих, зохион байгуулах болон ерөнхий суралцах чадварт онцгой анхаарал хандуулна.

**Нийгэмших чадвар (20023)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
Нийгэмших чадварын хичээлээр дунд сургуулийн сурагч бусадтай зохистой нийгмийн харилцаанд ороход шаардлагатай ур чадварыг олж авч, дадлага хийх боломжтой. Заах ур чадварт дараах багтана: Найз нөхөдтэй болох, бусадтай харилцах, өөр өнцгөөс харах, өөрийгөө дайчлах, багаар ажиллах, стресс болон бухимдлаа дарах стратегиуд, нийгмийн зан араншин дахь “бичигдээгүй хуулиуд” зэрэг нь орно. Зохион байгуулалт болон бие даан нөлөөлөл хийх ур чадварыг мөн багтаана.

## АМЬДРАЛЫН СУРГАЛТ

Дараах хичээлийг Хэрэгцээтэй амьдралын ур чадвар өгнө. Сургалтын агуулга нь сурагчийн Хувьчилсан заах арга зүйн төлөвлөгөө (IEP)-т тусгагдсан хэрэгцээ шаардлагын дагуу байх бөгөөд Виржиниа мужийн өөр хэлбэрээр үнэлэх хөтөлбөр (VAAP)-ийг дэмжлэг Нийцүүлсэн суралцах стандартын дагуу байна. Сургалтын хөтөлбөр нь харилцаа, өөртөө туслах, нийгэмших ур чадвар, мэргэжлийн бэлтгэл ур чадвар болон суралцах ур

чадвар зэрэгт амьдралын ур чадварыг хөгжүүлэхэд анхаарна. Сургууль болон олон нийт зэрэг төрөл бүрийн байдаг л орчинд заавар зөвлөгөөг өгнө.

**Англи хэл (20035)**
**Бүтэн жил, нэг кредит**
Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Хичээл нь богино өгүүллэг, шүлэг болон роман ашиглан уншиж ойлгох, зөв бичих, үгсийн сан ашиглах, өгүүлбэрийн бүтэц, догол мөр бүтээх, уран зохиол судлах зэрэгт анхаарна. Материал болон сурах бичгийг сурагчийн унших түвшинд нийцүүлэн сонгоно.

**Математик (20036)**
**Бүтэн жил, нэг кредит**
Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Хичээлээр бүхэл, бутархай, аравтын бутархай, хагас бүхэл тоо, харьцаа, пропорц, хувь, хэмжээ гэсэн үйлдлүүдэд анхаарна.

**Нийгэм судлал (20039)**
**Бүтэн жил, нэг кредит**
Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Сурагчид нийгмийн түүхийг анхнаас нь эхлээд түүхчлэн үзнэ. Виржиниагийн болон Америкийн Нэгдсэн Улсын түүхийн хуанлийн гол шинж, үйл явдлуудад илүү анхаарна.

**Уншлага (20014)**
**Бүтэн жил, нэг кредит**
Энэ хичээл нь маш сайн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагч тус бүрийн IEP-т тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэгдсэн. Хичээл нь тухайн сурагчийн үзүүлсэн унших дутагдлыг хангахад чиглэгдсэн. Түүнчлэн тодорхой ур чадварыг эзэмшихийн тулд таалан унших болон ойлгож унших шаардлагатай бөгөөд ангиас гадуурх материал ашиглахыг онцолно.

**Бичих (20005)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
Энэ хичээлээр нэг санааг илэрхийлэхийг хөгжүүлэхэд анхаарна. Бүтэц, найруулах, шалгаж үзэх чадварыг тодорхойлсон, тоймлосон, дэлгэрэнгүй бичиглэлээр илүү анхаарна. Сурагчийн олон догол мөртэй тайлан. Өгүүлбэрийн зөв бүтэц, догол мөрний тухай зөв ойлголт шаардлагатай.

**Амьдралын чадварууд (20026)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид Амьдралд холбогдох Карьерын сургалтын хөтөлбөрт хамрагдах ёстой.*
Энэ хичээлээр Эрүүл мэнд, хоол хүнс, Мэргэжлийн бэлтгэл, Гэр орноо авч явах, Орчин тойронтойгоо танилцах гэсэн дөрвөн гол салбарт анхаарал тавина. Багтааж үзэх концепцод хувийн эрүүл мэнд, орчноо мэдрэх, ажилтны зан харилцааг бэхжүүлэх, цэс төлөвлөх, хоол бэлтгэх, бусадтай харилцаа тогтоох болон бусад зүйлс багтана. Хичээлийн кредит авахад хэд хэдэн удаа авч болно.

**Шинжлэх ухаан (10038)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Амьдралын чадварууд (20026)*
Энэ хичээлээр хувийн эрүүл мэнд ба орчноо мэдрэхэд анхаарна. Хүний биеийн эрүүл мэндийн байдал ойр тойронд нь хэрхэн нөлөөлдөг талаар илүү авч үзнэ. Янз бүрийн материалыг хэрэглэнэ. Бүх сэдвүүд нь өдөр тутмын амьдралд холбогдоно.

## САЙН ДУРЫН АЖИЛ

**Сайн дурын ажил**
**Бүтэн жил, (20155)**
**Нэг улирал, (20156)**
**9-12-р анги**
Энэ хөтөлбөрийн зорилго нь хамт олны нэг байх мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлж, сургуулийн үйл ажиллагааны олон зүйлд оролцож суралцах боломжийг сурагчид олгоно. Багш, нарийн бичиг, захиргааны ажилтнуудтай ажиллаж байгаа сурагч бүрд зааварчилгаа чиглэл өгнө. Үүний дээр сайн дурын ажилтан сурагчийн насанд хүрсэн зааварлагчийн ажлын тодорхойлолтыг захиргааны ажилтанд зөвшөөрөл авахаар өгнө. Олон ажилчид, газрууд сурагчдад өргөн хүрээнд суралцах боломжийг олгосон нарийн бичиг ба нарийн бичгийн бус ажлуудыг өгч, сайн дурын ажилтнуудыг үр дүнтэй ашигладаг.

## АТ СОНГОХ ХИЧЭЭЛҮҮД

**АТ оюутнуудад зориулсан зөвлөгөө (20184)**
**Бүтэн жил, нэг мөчлөг, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Эхний АТ хичээлдээ бүртгүүлсэн эсхүл 2 ба түүнээс дээш АТ хичээлд*

*бүртгүүлсэн бөгөөд ахисан түвшний диплом авахаар сурч байгаа сурагчид*

- Унших, чимээгүй орчинд суралцах
- AT-ийн хичээлийн сэдвээр хичээл/ганцаарчилсан
- AT курсийн ажилд дэмжлэг үзүүлэх
- Суралцах бүлгэм байгуулах
- AT шалгалтад дүгнэлт хийх уулзалтууд
- PSAT/SAT семинар
- AT хувийн зохион байгуулалтын семинар (жишээ нь: цагийн менежмент, зохион байгуулах чадвар, стрессээ хянах)
- Коллежид бэлтгэж төлөвлөх семинар

## ДЭЛХИЙН ХЭЛНҮҮД

Арлингтоны улсын сургуулийн 7-12-р ангийн сурагчид төрөлх хэл судлалаар болон дэлхийн хэл судлалаар дэлхийн хэлний кредит авах боломжтой. Дэлхийн хэлний кредит авахын тулд дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- Кредит тус бүрд 140 цагаас доошгүй <u>албан ёсны</u> хэлний сургалтад хамрагдсан болохыг илтгэх дүнгийн хуулбар.
- Сурагч тэнцсэн дүн авсан байх шаардлагатай.
- Хэрэв сурагч үргэлжлүүлэн Арлингтоны улсын сургуульд хэл үзэх бол "C" болон түүнээс дээш дүнг баталгаажуулах шаардлагатай.
- Мужаас баталсан шалгалтаар-авах-кредит шалгалтыг өгсөн бөгөөд сурагч дөрөв хүртэл кредит авах боломжтой мэргэшсэн байдлаа харуулсан.

Арлингтон улсын сургуулиудад заадаг бусад хэлээр ярьдаг хүмүүс өөрсдийн зөвлөхтэйгөө шалгалтын талаар зөвлөлдөөрэй.

*Ахисан шатны сургалтын диплом авах хүсэлтэй сурагчид гурван жил/ түвшний нэг хэл эсхүл хоёр жилийн хоёр хэл суралцсанаар дэлхийн хэлний шаардлагыг хангана. Дэлхийн хэл бүрийн хичээлийг амжилттай дүүргэснээр Ахисан шатны сургалтын диплом авах нэг кредит авна. Зарим коллеж дэлхийн хэлний сургалтыг ахлах сургуульд мөн үргэлжлүүлсэн байхыг шаарддаг. Хэрэв танай сурагч ахлах сургуулийн эхний жил гурван жилийн сургалтаа амжилттай дуусгасан бол сурагчийн сонгосон коллежийн элсэлтийн шалгуурыг хараарай. 2020 оны SB323-ын дагуу Ахисан түвшний диплом авах зорилготой байгаа ба Хувь хүнд зориулсан боловсролын хөтөлбөр (IEP)-т нь дэлхийн хэлний кредит авахыг заасан сурагчид дэлхийн хэлийн хоёр стандарт кредитийн оронд компьютерын шинжлэх ухааны хоёр стандарт кредитийг тооцуулж болно.*

*8VAC20-131-51 (2018-19 он болон үүнээс хойш 9-р ангид элсэж байгаа сурагчдын төгсөлтийн шаардлага)-ын дагуу Ахисан түвшний дипломд холбогдож дэлхийн хэл болон сонгох хичээлүүдийн хувьд дараалсан сонгох хичээлийн шаардлага бий. Иймээс дэлхийн хэлний дөрөв, тав дахь жилүүд л сонгох дараалсан хичээлийн шаардлагыг хангана.*

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Карьерын төвөөс санал болгож буй Герман хэлний I-III түвшний сургалт. Ахлах сургуулийн сурагчид герман хэл сурахаар Карьерын төв руу явж болно. Вэйкфилдийн оюутнууд Латин хэлний 1-р түвшинд бүртгүүлсэн - Хос элсэлт нь Латин хэл сурахаар Карьерын төвд очно. Хятад хэлний II, III түвшинд суралцаж буй Уэйкфилдийн оюутнууд мөн Карьерын төвд очих болно. Зорчих тээврийг өдөрт 3 удаа олгодог. Япон хэлний I-III түвшнийг л өргөн хүрээний хөрш ахлах сургуулиудад санал болгодог. Зарим тохиолдолд, Хятад гэх мэт хэлний хичээлийг сургуулиас гадуурх эх үүсвэрээс зөвхөн онлайн хэлбэрээр өгөх боломжтой байж болно (Washington Liberty HS-ээс бусад). Улсын эсхүл мужийн өөр газарт үйл ажиллагаа явуулдаг онлайн зайн сургалтын газрын хичээлүүд APS-үйнхаас өөр дүгнэх, даалгавар өгөх болон ирц бүртгэх журамтай байж болно. Америкийн дохионы хэл (ASL) нь Виржиниа мужийн улсын их сургуулиуд болон олон нийтийн коллежийн элсэлтийн хэлний шаардлагыг хангадаг. Зарим өөр мужийн их, дээд сургуулиуд ASL-ийг дэлхийн хэлд тооцдоггүй. ASL-ийг ОУБ-ын хэлд тооцохгүй.**

**Америкийн дохионы хэл I (25990)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид өдөр тутмын харилцаанд, өөрийн гэр, сургууль болон нийгэмд бусад харилцахдаа ашиглах хүлээн авах болон илэрхийлэх хэлний ур чадвар эзэмшинэ. Сурагчид гэр бүл, сургуулийн арга хэмжээ болон тэмдэглэлт баярын талаар асуулт асууж, хариулж сурна. Тэд танилцуулга хийх, салах ёс хийх, анхаарал татах, гарын үсэг зурах орчинд хэлэлцээ хийх зэрэгт зохион хөшингө

бус зан байдлыг (тухайлбал, нүүр хувирал, биеийн хөдөлгөөн, хувийн орон зай) ашиглан чухал мэдээлэл солилцоно. Сурагчид Америкийн дохионы хэлний түүхийг судалж, сонсголгүйчүүдийн соёлыг таньж мэднэ.

**Америкийн дохионы хэл II (25995)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: ASL I-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид ASL-ийн ярианы ур чадвараа улам сайжруулна. Тодруулга хийх зорилгоор асуулт асуух, хариулахын зэрэгцээ өөрийн өдөр тутмын амьдрал болон эргэн тойрны тухай өөрийн үзэл бодол, хүсэл сонирхлыг илэрхийлнэ. Сурагчид илүү хийсвэр сэдэв болон уран зохиол судлах замаар үгийн баялаг болон харилцан ярианы ур чадвараа нэмэгдүүлнэ. Сонсголгүй хүмүүсийг нийгэмлэгийн журам, үнэт зүйлийн тухай хэлэлцүүлгээр илүү сайн ойлгох нь энэ түвшний зорилт байна. Сурагчид сонсголгүй хүмүүсийн хувьд байдаг онцгой шинж, хэл сурахад түүний нөлөөг илүү сайн ойлгох болно. ASL-ээ ашиглан хичээлийн танхимаас гадуур бусадтай харилцахыг бид тэднээс уриалах болно.

**Америкийн дохионы хэл III (25997)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: ASL II -ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид өмнөх түвшинд сурсан хэлний чадвар ба үгийн баялгаа хэрэглэж, өөрсдийн ярианы чадварыг илүү абстракт сэдэвт анхаарч сайжруулна. Эдгээр сэдэвт уран зохиол, сонсголгүйчүүдийн нийгэмлэгийн одоогийн арга хэмжээ, асуудлууд багтана. Сонсголгүй хүмүүсийг нийгэмлэгийн журам, үнэт зүйлийн тухай хэлэлцүүлгээр сурагчид тэдний талаарх ойлголтоо гүнзгийрүүлнэ. ASL-ийн үндэс, хэл зүйг илүү сайн суралцсанаар сурагчид хэлний талаар илүү сайн ойлгохын зэрэгцээ эдгээрийн өөрийн хэлтэйгээ харьцуулж үзэх боломжтой болно. Сурагчдад хэлийг сургууль дээр болон гадуур хэрэглэх боломж олгоно. Жишээ нь өөрийн хувийн сонирхол, нийгэм, дэлхийн асуудлаар сонсголгүй хүмүүсээс ярилцлага авна.

**Америкийн дохионы хэл IV (25992)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: ASL III-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид өмнөх түвшинд сурсан хэлний чадвар ба үгийн баялгаа хэрэглэж, өөрсдийн ASL-ийн чадварыг дараагийн түвшинд хүргэх тусгай нарийн аргачлалуудад анхаарах ба сурагчдыг ASL-ийн коллежийн түвшний хичээлд бэлтгэж, мөн ASL-д холбогдох боломжит ажил мэргэжилд бэлтгэнэ. Сэдэвт уран зохиол, сонсголгүйчүүдийн урлаг, арга хэмжээ, сонсголгүйчүүдийн асуудлууд багтана. Сурагчид ASL-ийн богино хэмжээний орчуулгаар сонсголгүй хүмүүсийн ертөнцийг ойлгох ойлголтоо гүнзгийрүүлнэ. Нэн ялангуяа ангилагч, параметрүүдийг багтааж ASL-ийн үндэс, хэл зүйг илүү сайн суралцсанаар сурагчид хэлний талаар илүү сайн ойлгохын зэрэгцээ эдгээрийн өөрийн хэлтэйгээ харьцуулж үзэх боломжтой болно. Сурагчдад ASL-ийг сургууль дээр болон гадуур хэрэглэх боломж олгоно. Үүний дээр тэд өөр сургуулийн ASL IV-ийн нөхөдтэйгөө хамтарч ажиллах болно. Жишээ нь сонсголгүйчүүдийн уран зохиолын номын клубт оролцож сургуулиас гадуур уншина. Тэд өөрийн ангидаа буцаж очиж, өөрийн олж авсан мэдлэгээ ASL-аар танилцуулна.

**Карьерын төв дээрх Араб хэлний I, II түвшнийг зайнаас суралцах технологиор зааж болно. Манай дунд сургуулийн хөтөлбөрт Араб хэлийг гадны нөөцөөр онлайн хэлбэрээр санал болгож болно.**

**Араб хэл I (25800)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ түвшинд сурагчдыг Араб хэлний цагаан толгой болон авианы системтэй танилцуулна. Энэ хичээл соёлын болон түүхийн мэдээллээр баялаг. Араб хэлний түүх, Араб хэлний гэр бүлийн мод болон бичвэрийг олгоно. Анхны авиа зүйд болон бичих системд хандуулах анхаарлын зэрэгцээ сурагчид хэлний авиа, өргөлт болон өнгийг сурч, хэрэглэж сурна. Хэл зүйн дүрмийн үндсэн бүтэц, үгсийн санг танилцуулснаар сурагчид анхан шатны албан харилцааг энгийн хялбар өгүүлбэр болон харилцан яриагаар зохих түвшинд өрнүүлнэ. Сурагчид сонссон үг болон өгүүлбэрээ бичих чадвартай болох бөгөөд өмнө сурсан үг болон өгүүлбэрийг уншиж, мэндчилж, бусдыг танилцуулж, энгийн хялбар асуулт, хариулт зохиож, анхан шатны нийгмийн харилцаанд орно, өөрсдийн болон өөрийн гэр бүлийн гишүүд болон бусдын талаар ярьж, өөрийн хувийн үндсэн мэдээллийг солилцоно. Хэл сурах үндсэн сэдэв нь хувийн болон гэр бүлийн амьдрал байна.

**Араб хэл I (25822)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Араб хэл I-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*

Энэ хичээл нь анхлан суралцагчийн эзэмших түвшинд үргэлжлүүлэн сонсох, ярих, унших болон бичих чадвар хөгжүүлэн Арабаар ярьдаг улсуудад тохиож болох өдөр тутмын амьдралын нөхцөл байдлын хүрээний сэдвийг хөндөнө. Сурагчид үгийн сангаа нэмэгдүүлж, Араб хэлний өгүүлбэрийн энгийн бүтцийг үргэлжлүүлэн сурч, ажил хэргийн ярианд хэл зүйн дүрмийн суурийг хэрэглэнэ. Араб хэл II хичээлийг дүүргээд сурагчид нийгмийн харилцааг өөрөө эхлүүлэх чадвартай болж, соёлын талаас нь үндсэн ойлголттой болно. Сурагчид энгийн хялбар асуултыг ойлгож, хариулж чадах бөгөөд богино өгүүлбэрүүд, ялангуяа танил сэдвээр өргөн хэрэглэгддэг тушаал зааврыг өгч чаддаг болно. Өмнө дадлага хийж, цээжилсэн өгүүлбэрүүд, хэллэгүүдийг ашиглан сурагчид хүмүүсийг дүрсэлж, ямар харагдаж, ямар мэдрэмж төрж буйг тайлбарлаж, сонирхлынхоо талаар мэдээлэл солилцож, өмнө сурсан материал ашиглан энгийн өгүүлбэр, богино хэмжээний догол мөр уншиж, зохиож бичиж чаддаг болно. Түүнчлэн тэд албан болон ярианы Араб хэлний зарим ялгааг мэддэг болно. Хамрах сэдэвт сургууль, гэрийн амьдрал, нийгмийн амьдрал, хувийн сонирхол, олон нийтийн амьдрал, дэлгүүр хэсэх, ресторан болон хоол багтана.

**Араб хэл III (25830)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Араб хэл II-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*

Сурагчид сонсох, ярих, унших, бичих чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлнэ. Агуулга нь ахлах сургуулийн амьдралтай холбоотой асуудлууд ба сорилтуудад төвлөрнө. Сэдвүүд нь өдөр тутмын амьдралаас гадна сурагчдын орчин тойронтой холбоотой нийгмийн асуудлууд байна. Хөтөлбөрийн хүрээнд поп дуу, шүлэгт агуулагдсан Арабчуудыг сонирхдог зүйлстэй холбож энгийн текстийг уншиж, ойлгох чадвартай болно. Сурагчид дотно сэдвүүдээр энгийнээс илүү нарийн үгтэй дуу, видеоны үгийг ойлгож, өөртэйгөө болон өөрийн орчны хүмүүстэй холбоотой зүйлсийг энгийн үгээр илэрхийлэх чадвартай байна. Сурагчид нийгмийн амьдралтай холбоотой хэцүү биш харилцааны хэд хэдэн даалгаврыг хийж, цэс, зүг чиг заах, замын тэмдэг зэрэг энгийн заавар, давтагдах зүйлс, илэрхийллийг ойлгох чадвартай байна. Агуулгыг нь тод томруун харуулсан гол санааг ойлгох болно. Сэдвүүдэд хувийн ба гэр бүлийн амьдрал, шилжилтийн насныхны соёл, ирээдүйн төлөвлөгөө, сонголт, орчны нэмэлт ба илүү нарийн зүйлсийг ойлгоно.

**Араб хэл IV (25840)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Араб хэл III-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*

Энэ хичээл нь III-р түвшний хөтөлбөрт заасан хэлний чадварыг хөгжүүлж, ярианы болон бичгийн хэлний илүү нарийн харилцааны чадварыг хөгжүүлэхийг үргэлжлүүлнэ. Сэдэвт ирээдүйн төлөвлөгөө, сонголт, одоогийн ба өнгөрсөн үйл явдлууд, орчин тойронд голчлон анхаарах ба карьер, ажил, боловсролын төлөвлөгөө, үндэсний баяр, урлаг, байгаль, экологи, байгалийг хадгалах, эко аялал жуулчлал багтана. Сурагчид сэдэвт холбогдож дүгнэлт хийж, асуулт асууж хариулах чадвартай болно. Үүний дээр, сурагчид Араб соёлын дадал, бүтээгдэхүүн, харах өнцгийг ойлгох ойлголтоо харуулах, сурагчдын өөрийн соёлоос ямар ялгаатай байгаа талаар илэрхийлэх чадвартай байна.

**Араб хэл V (25841)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Араб хэл IV-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*

Араб хэл IV нь Арабын ертөнцийн янз бүрийн өнцгөөс эхтэй сонин мэдээнд суурилна. Нийтлэл нь олон тооны сэдвийг хамрах ба хэлний бүтцийг ярилцаж, авч үзнэ. Хичээлийн материал нь эрүүл мэнд, эдийн засаг, бүх нийтийн соёл зэрэг өдөр тутамд холбогдолтой мэргэжлийн сэдвүүдэд анхаарна: Араб зах (түүхэн захууд, Жедах захууд, Ом Дерман зах) ба Араб дуунууд. Хичээлийн төгсгөлд сурагчид нэн ялангуяа дотно сэдвүүдээр ерөнхий ойлголтой сайтайгаар Араб сонин унших чадвартай болно. Сурагчид өөрсдийгөө мэдэх зүйлээ нэгтгэж, дахин нэгтгэж илэрхийлэх чадвартай байна.

**Washington Liberty нь бүх түвшний хятад хэлний ганцаарчилсан багштай. Йорктаунд хятад хэлний II, III түвшнийг ганцаарчлан заадаг. Хятадын Вэйкфилдийн II, III түвшний оюутнууд Карьерын төвд очиж, ганцаарчлан заадаг. Washington-Liberty-ээс бусад сургуульд бүх түвшний ахлах сургуулийн Хятад хэлийг Хятад эх хэлтэй туслахын тусламжтайгаар сургуулиас гадуурх эх үүсвэрээр онлайн хэлбэрээр заах болно.**

**Хятад хэл I (25615)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид өөрийн тухай болон өөрийн ойр орчны тухай хялбар бүтэцтэй энгийн өгүүлбэр ашиглан ярьж ойлгуулах чадвар эзэмшинэ. Уг харилцаа нь хэлний бүх дөрвөн чадвар болох сонсох, ярих, унших болон бичир чадвараар илэрнэ. Энэ хичээл нь сонсох болон ярих ур чадварт илүү анхаарал хандуулна. Сурагчдад пиньинийг танилцуулж, хялбарчилсан Хятад дүрс үсэг заана. Тэдгээр нь энэ түвшинд зорьсон сэдэв болон хэлзүйн дүрмийн элементийн хүрээнд байна. Сурагчид зөвхөн уншиж чаддаг болох төдийгүй бичиж, компьютер болон бусад электрон төхөөрөмж дээр оруулж чаддаг байх зорилгоор дүрс үсгийг таньж мэддэг болно. Сурагчид хувийн болон гэр бүлийн амьдрал, сургуулийн амьдрал, нийгмийн болон олон нийтийн дундах амьдрал зэрэг сэдвийн хүрээнд хэлийг судална.

**Хятад хэл II (25625)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Хятад хэл I-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид өөрийн тухай болон өөрийн ойр орчны тухай хялбар бүтэцтэй энгийн өгүүлбэр ашиглан ярьж ойлгуулах чадвар үргэлжлүүлэн эзэмшинэ. Энэ харилцаа нь хэлний дөрвөн ур чадвар болох сонсох, ярих, унших болон бичихээр харагдах бөгөөд ярихад илүү анхаарал хандуулна. Сурагчид I түвшинд сурсан хувийн болон гэр бүлийн амьдрал, сургуулийн амьдрал, нийгмийн болон олон нийтийн амьдрал сэдвүүдийг илүү өргөжүүлэн үргэлжлүүлэн сурна. Сурагчид хялбарчилсан Хятад хэлээр бичих чадвараа сайжруулна. Сурагчид зөвхөн уншиж чаддаг болох төдийгүй бичиж, компьютер болон бусад электрон төхөөрөмж дээр оруулж чаддаг байх зорилгоор дүрс үсгийг таньж мэддэг болно. I түвшинд сурсан дүрс үсгүүд дээр нэмээд сурагчдад шинэ хялбарчилсан Хятад дүрс үсэг заана.Тэдгээр нь энэ түвшинд зорьсон сэдэв болон хэлзүйн дүрмийн элементийн хүрээнд байна.

**Хятад хэл III (25630)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Хятад хэл II-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид сонсох, ярих, унших, бичих гэсэн хэлний бүх дөрвөн зүйлд чадвараа цааш хөгжүүлж, гүнзгийрүүлэх ба ингэхдээ харилцан ярианд онцгой анхаарна. Тэд бодитоос хийсвэр концепц хүртэл янз бүрийн сэдвээр илүү цогц хэлний бүтцийг ашиглаж харилцах болно. Бүх түвшинд сурагчил уншиж сонсож байгаа эх материалынхаа үндсэн санааг ойлгож, дотно сэдвээр илүү нарийвчилсан мэдээллийг таньж олно. Сурагчид эрх, хариуцлага, ирээдүйн төлөвлөгөө, сонголт, шилжилтийн насныхны амьдрал, байгаль орчин, хүн төрөлтний талаар судлах явцдаа ертөнцийг илүү ойлгохын зэрэгцээ өмнөх түвшний сэдвүүдийг дахин давтана. Гэхдээ тойрог сэдэвт суурилсан сургалтын аргачлал нь сурагчдаас шинэ түвшинд гарсан харилцааны чадвараа харуулах, өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох зар, тайлбарыг ойлгохыг шаардана. Сурагчид амаар ба/эсхүл бичгээр суралцаж буй сэдвээр тайлан тавина. Тэд өөрсдийн өдөр тутмын орчин, сургуулийн хүмүүс, зүйлсийг тодорхойлж бичиж чадна. Сурагчид мөн сурч байгаа сэдвээрээ янз бүрийн эрх үүсвэрээс мэдээлэл авна. Сурагчийн ажлыг хичээлийн цагаас гадуур хийхийг шаардана.

**Хятад хэл IV (25640)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Хятад хэл III-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид сонсох, ярих, унших, бичих гэсэн хэлний бүх дөрвөн зүйлд чадвараа цааш хөгжүүлж, гүнзгийрүүлэх ба ингэхдээ харилцан ярианд болон бичигт онцгой анхаарна. Тэд бодит концепцод илүү анхаарч, янз бүрийн сэдвээр илүү цогц хэлний бүтцийг ашиглаж харилцах болно. Бүх түвшинд сурагчид уншиж сонсож байгаа эх материалынхаа үндсэн санааг ойлгож, дотно сэдвээр илүү нарийвчилсан мэдээллийг таньж олно. Бээжин, Хятадын соёлын ерөнхий шинжүүд, нийгмийн амьдрал, хобби, байгаль орчин, ажил, коллежийг талаар сурахын зэрэгцээ сурагчид өөрийн орчны илүү ойлгох болно. Үүний зэрэгцээ I, II, III түвшинд танилцсан сэдвүүдийг эргэн давтаж магадгүй. Гэхдээ тойрог сэдэвт суурилсан сургалтын аргачлал нь сурагчдаас шинэ түвшинд гарсан харилцааны чадвараа харуулахыг шаардана. Сурагчдад Ахисан түвшний Хятад хэлний хичээл болон Коллежийн зөвлөлийн шалгалтын талаар танилцуулна.

**Хятад хэл ба соёл, AT (35860)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх түвшинд Хятад хэл IV-ийг B буюу дээш дүнтэйгээр амжилттай дүүргэсэн эсхүл багшийн зөвлөснөөр*
Энэ хичээл нь сурагчийг 5-р сарын AT шалгалтад бэлтгэх зорилготой. Энэ нь Коллежийн 4-р курсийн Мандарин Хятад хэлний хичээлтэй ижил эрчимтэй

коллежийн түвшний хичээл юм. Сурагчид танилцуулах ба хүмүүсийн хоорондын болон тайлбарлах харилцаанд сонсох, ярих, унших, бичих өндөр чадвараа харуулна; орчин үеийн болон түүхэн Хятадын соёлтой танилцана; Коллежийн зөвлөлөөс тодорхойлсон Хятад хэл, соёлтой холбоотой янз бүрийн сэдэвтэй танилцана; өөрсдийн ерөнхий ойлголтыг гүнзгийрүүлж, Хятадын соёлыг өөрийн соёлтой харьцуулна. Виржиниагийн Дэлхийн хэлний онлайн хичээлд бүртгүүлсэн сурагчид энэ хичээлийн нэг хэсэг болгож улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтыг өгөх ёстой. *Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй ( 25860).*

**Франц хэл I (25110)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид хэлний сонсогдох байдал, ерөнхий шинж, дуудлагыг сурна. Сонсох, ярих, унших, бичих дадлагын замаар үндсэн бүтэц, үгсийн санг сурах ба яриа харилцаанд илүү анхаарна. Сурагчид үгсийн санг, хэлний бүтцийг бүтээмжтэй ашиглаж өөрсдийгөө яриагаар болон бичгээр илэрхийлнэ. Сурагчид өдөр тутмын үйл ажиллагаа, сонирхолд холбогдох энгийн хялбар асуулт, мэдэгдлийг ойлгож, уншина. Сурагчид мөн Франц хэлтэй улсуудын газар зүй, уламжлал, соёлын талаар суурь ойлголтыг авч сурна.

**Франц хэл II (25120)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Франц хэл I-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид сонсох, ярих, унших, бичих чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлэх ба харилцан ярианд илүү анхаарна. Тэд сурсан үгсийн сан, дүрмээ ашиглаж дотно сэдвүүдээр энгийн ярианд оролцоно. Тэд дотно сэдвийн материалыг уншиж, өөрийн үгсийн сан ба дүрмийн мэдлэгийн хүрээнд зааврын дагуух богино бичлэгийг хийнэ. Тэд Франц хэлтэй улсуудын уламжлал, соёлын талаарх мэдлэгээ өргөжүүлэх ба үүнд нийгмийн харилцаа, үйл ажиллагаа, үүрэг багтана.

**Франц хэл III (25130)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Франц хэл II-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид дөрвөн зүйлд чадвараа цааш хөгжүүлж, гүнзгийрүүлнэ: сонсох, ярих, унших, бичих. Тэд богино яриа өрнүүлэх ба тэдний яриаг гадаад хүмүүстэй харилцаж сурсан эх хэлтэй хүн ойлгоно. Ангийн ажилд хэлийг байнга ашиглахад илүү анхаарна. Сурагчид тайлбарлахад илүү хэцүү үйл явдал, туршлагын талаар ярьж, үндсэн санааг ойлгож эх материал уншиж, илүү нарийн дүрмийн бүтцийг ашиглаж дотно сэдвээр бичнэ. Зорилтот соёлыг илүү сайн ойлгохыг хөгжүүлнэ.

**Франц хэл IV (25140)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Франц хэл III-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
IV шатны сурагчид илүү нарийн, тохирох байдлаар бусдад танилцуулга хийхэд болон тоймлож, санамсаргүй тохиолдлоор тодорхойлж, мэдээлэл хайж, өгөхөд илүү анхаарна. Сурагчид дотно сэдвээр эх материалыг уншиж, орчин үеийн сэдвээр ярилцана. Тэд энэ сэдвээр мөн зарим зүйлийг нарийвчлан бичнэ. Франц хэлтэй ертөнцийн урлаг, түүх, одоогийн үйл явцад оруулсан соёлын хувь нэмрийн талаарх мэдлэгийг илүү сайн ойлгохыг хөгжүүлнэ.

**Франц хэл V, (25150)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Франц хэл IV-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид (мэдээ, эх хэлтэй хүний ярианы хэсэг зэрэг) эх материалыг ойлгохын тулд одоо болж буй үйл явдлын талаар ярилцана. Тэд зорилтод хэлний соёл, түүх, уран зохиолын сонгосон сэдвүүдийг илүү нарийвчилж уншиж, бичиж, ярилцах ба үгчилж ойлгохоос илүүгээр ойлгох чадвараа өргөжүүлж эхэлнэ. Хичээлд мөн зорилтот хэлний уран зохиолд зарим нэг шинжилгээ хийх багтана.

**Ахисан түвшний Франц хэл**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх түвшинд "B" буюу дээш дүнтэй эсхүл багшийн зөвлөснөөр*
**9-12-р анги**
Энэ хичээлийг зорилтод хэл дээр илүү өндөр түвшинд чөлөөтэй ярих чадвартай сурагчдад зориулсан. Сургалтын хөтөлбөрөөр асуулт асууж, өргөн ярилцлага өрнүүлэх үндсийг өгсөн орчин үеийн сэдвүүдээр ярилцах замаар сурагчид илүү сайн ярилцах, харилцах чадварыг хөгжүүлэхэд илүү анхаарна. Сурагчид янз бүрийн хэвлэл мэдээллийн эх сурвалжийг ашиглаж Франц хэлтэй ертөнцийн эх материалыг ойлгох чадвартай байна. Тэд зорилтот хэлний соёлын уран зохиол, кино, түүх, бүх нийтийн соёлд холбогдох сонгосон сэдвүүдээр уншиж, бичиж, яриа өрнүүлнэ.

**Франц хэл ба соёл, AT (35165)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх түвшинд "B" буюу дээш дүнтэй эсхүл багшийн зөвлөснөөр*
Энэ хичээлийг өндөр хэмжээнд чөлөөтэй харилцах, тодорхой бөгөөд хийсвэр сэдвийн материалыг ойлгох чадвартай сурагчдад зориулсан. Хичээлээр сурагчдыг Франц хэлний Ахисан түвшний элсэлтийн шалгалтад бэлтгэнэ. Сурагчид тодорхой дүгнэлт бичих, тайлбарлах, дүгнэх, эссэ бичих зэргээр янз бүрээр өөрсдийн хэлний бүх чадвараа (сонсох, ярих, унших, бичих) харуулна. Тэд уран зохиол, орчин үеийн амьдрал, бүх нийтийн соёлыг харуулсан янз бүрийн ярианы болон бичгийн материалыг ойлгож, шинжилж, ярилцана. Сурагчид хэлийг илүү сайн эзэмшиж, илүү сайн ойлгож, хийсвэр илэрхийллийг хэрэглэж, франц хэлний өгүүлбэр зүй, ажиллагааг амаар болон бичгээр ойлгохоо илүү гүнзгийрүүлнэ. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй. (25165).*

**Герман хэл I (25210)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид хэлний сонсогдох байдал, ерөнхий шинж, дуудлагыг сурна. Сонсох, ярих, унших, бичих дадлагын замаар үндсэн бүтэц, үгсийн санг сурах ба яриа харилцаанд илүү анхаарна. Сурагчид үгсийн санг, хэлний бүтцийг бүтээмжтэй ашиглаж өөрсдийгөө яриагаар болон бичгээр илэрхийлнэ. Сурагчид өдөр тутмын үйл ажиллагаа, сонирхолд холбогдох энгийн хялбар асуулт, мэдэгдлийг ойлгож, уншина. Сурагчид мөн Герман хэлтэй улсуудын газар зүй, уламжлал, соёлын талаар суурь ойлголтыг авч сурна.

**Герман хэл II (25220)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Герман хэл I-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид сонсох, ярих, унших, бичих чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлэх ба харилцан ярианд илүү анхаарна. Тэд сурсан үгсийн сан, дүрмээ ашиглаж дотно сэдвүүдээр энгийн ярианд оролцоно. Тэд дотно сэдвийн материалыг уншиж, өөрийн үгсийн сан ба дүрмийн мэдлэгийн хүрээнд зааврын дагуух богино бичлэгийг хийнэ. Тэд Герман хэлтэй улсуудыг уламжлал, соёлын талаарх мэдлэгээ өргөжүүлнэ.

**Герман хэл III (25230)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Герман хэл II-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид зорилтот хэлээр дөрвөн зүйлд чадвараа цааш хөгжүүлж, гүнзгийрүүлнэ: сонсох, ярих, унших, бичих. Тэд богино яриа өрнүүлэх ба тэдний яриаг эх хэлтэй бус хүмүүстэй харилцаж сурсан Герман эх хэлтэй хүн ойлгоно. Ангийн ажилд хэлийг байнга ашиглахад илүү анхаарна. Сурагчид тайлбарлахад илүү хэцүү үйл явдал, туршлагын талаар ярьж, үндсэн санааг ойлгож эх материал уншиж, илүү нарийн дүрмийн бүтцийг ашиглаж дотно сэдвээр бичнэ. Соёлын талаарх мэдээллийг өргөжүүлнэ.

**Япон хэл I (25910)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид Япон хэлээр ойлгож, ярих чадварыг эзэмшиж эхэлнэ. Өдөр тутмын амьдрал, хэрэгтэй яриа, Япон хэлний соёлын ярианд хэрэглэдэг анхан шатны дүрэм, үгсийн санг сурна. Япон хэлний үечилж бичих тогтолцоо Хирагана болон гадаад хэлний үгийг бичих Катаканаг заана. Хятад хэлний дүрс бичиг ханз цөөн тоогоор танилцуулна. Хэлээр сурагчид Японы түүх, газар зүй, соёл, уламжлалыг сурна.

**Япон хэл II (25920)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Япон хэл I-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид Япон хэлээр ойлгох, ярих, унших, бичих чадвараа цаашид сайжруулна. Ойролцоогоор 100 ханз үсгийг заана. Илүү цогц ярианд оролцохын тулд сурагчдад нэмэлт үгсийн сан, дүрмийг заана. Японы түүх, газар зүй, соёл, уламжлалд илүү анхаарна.

**Япон хэл III (25930)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Япон хэл II-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Япон хэл III нь сурагчдын ярих, унших, бичих чадварыг цаашид дээшлүүлэхэд зориулагдсан. Хичээлээр Японы орчин үеийн амьдралтай холбоотой сэдвүүдийг сурах замаар шинэ чадваруудыг заана. Ойролцоогоор 100 шинэ ханз үсгийг танилцуулна. Хичээлийн төгсгөлд сурагчид янз бүрийн ярианы хэлбэрээр ярилцаж,

байр сууръ, сэтгэл санаагаа илэрхийлэх чадвартай болно.

**Латин хэл I (25310)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэхүү анхны Латин хэлний хичээлээр сурагчид эртний Ромчуудын хэл болон аж амьдралтай танилцана. Латин хэлний анхан шатны үгсийн сан, дүрмийн анхны элементүүдийг сурч, сурагчид илэрхийлж, дурлаж чангаар уншихыг сурна. Нэн ялангуяа гэр бүлийн амьдрал, Грек ба Ромын домог гээд Ромын соёлыг танилцуулна. Латин үндэстэй Англи хэлний үг, үгсийн санд илүү анхаарна.

**Латин хэл II (25320)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Латин хэл I-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Энэ хичээлээр Латин I хичээлийн хөтөлбөрийг цааш үргэлжлүүлнэ. Сурагчид жинхэнэ Латин хэлний текстийг уншиж ажиллах замаар Латинаар унших зүйл аажмаар уртсаж, илүү хүндэрнэ. Сурагчийн Сонгодог ертөнцийг ойлгох ойлголтыг гүнзгийрүүлэхийн тулд Ромын соёл, түүх, домгийг сурна. Сурагчдад латин өгүүлэмж, шүлгийг танилцуулах замаар дүрмийн зарчмуудыг авч үзнэ.

**Латин хэл III (25330)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Латин хэл II-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид Латин хэлний дүрмээ дүүргэж, үгсийн сангаа өргөжүүлж, хоёрдогч эх сурвалжийг ойлгох чадвараа илүү сайн харуулна. Тэд зохиолч бүрд нийтлэг өгүүлбэрийг ойлгож, тайлбарлана. Тэд Латинаар чанга уншихаа үргэлжлүүлэх ба шүүмжтэй шинжлэх замаар уншсан зүйлсээ тайлбарлаж, урлагийн хэлбэрт хариулна.

**Латин хэл IV (25340)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх түвшинд "C" буюу дээш дүнтэй эсхүл багшийн зөвлөснөөр*
Сурагчид дүрмийг контекстээр нь авч үзэж, уншиж, үгсийн сангаа дээшлүүлж, хоёрдогч сурвалжийн ойлголтоо гүнзгийрүүлнэ. Тэд зохиолч бүрийн өгүүлбэр зүйг тодорхойлж, тайлбарлаж, шүүмжит шинжилгээ хийхээ дээшлүүлж, дадлагажуулна. Сурагчид уншиж буй зүйлээ соёлын ба түүхийн талаас нь ойлгоно.

**Латин хэл V (25350)**
**Бүтэн жил, нэг кредит**
*(Энэ хичээлийг Латин хэл, AT-тэй хослуулж болно.)*
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх хичээлд "B" буюу дээш дүнтэй эсхүл багшийн зөвлөснөөр*
Сурагчид дүрмийг контекстээр нь авч үзэж, уншиж, үгсийн сангаа дээшлүүлж, хоёрдогч сурвалжийн ойлголтоо гүнзгийрүүлнэ. Тэд зохиолч бүрийн өгүүлбэр зүйг тодорхойлж, тайлбарлаж, шүүмжит шинжилгээ хийхээ дээшлүүлж, дадлагажуулна. Сурагчид уншиж буй зүйлээ соёлын ба түүхийн талаас нь ойлгоно.

**Латин хэл, AT (35350)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
(Энэ хичээлийг Латин хэл, V-тэй хослуулж болно.)
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх хичээлд "B" буюу дээш дүнтэй эсхүл багшийн зөвлөснөөр*
Энэ хичээлийг Латин хэлний дүрэм, өгүүлбэрзүйг бүрэн ойлгодог, эх текстийг уран зохиол болон билэгдлийн талаас нь шинжилж чадах сурагчдад зориулсан ба тэднийг Латин хэлний ахисан шатны шалгалтад бэлтгэнэ. Сургалтын хөтөлбөрөөр Латин хэлний хамгийн дээд зэргийн шүлгийн болон үргэлжилсэн үгийн зарим нэг зохиолыг сурагчид үзнэ. Вержилийн шүлэг, Цейзерийн үргэлжилсэн үгийн зохиолыг үзэх замаар сурагчид эдгээр зохиолчдын уран зохиол, соёлыг илүү нарийн судалж, эдгээр зохиолчдын уран зохиолын жанрын ар дахь нарийн санааг нэн ялангуяа шүүмжит уншлага, шинжилд бичихэд анхаарах замаар ойлгох байдлаа харуулна. Үүний дээр хичээлээр янз бүрийн соёлын агууламжаар сонгодог зохиолтой харилцаж, өөрсдийн уншиж байгаа эртний өгүүлэмж болон бусад өөр зүйлс төдийгүй өөрсдийн амьдралын хоорондох холбоо харилцааг олж тунгаах боломжийг сурагчдад өгнө. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй ( 25351).*

**Ахисан түвшний Латин хэл (25360)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх хичээлд B буюу дээш дүнтэй эсхүл багшийн зөвлөснөөр*
Энэ хичээлийг AP-ийн туршилт хийх бол зөвлөж байгаа бөгөөд Латин хэлний дүрэм, өгүүлбэр зүйн талаар бүрэн ойлголттой, эх текстийг уран зохиол болон хийсвэр утгаар нь шинжлэх чадвартай сурагчдад зориулсан. Сурагчид ангид уншсан зүйлийнхээ дүрмийг контекстээр нь авч үзэж, үгсийн сангаа дээшлүүлж, хоёрдогч сурвалжийн ойлголтоо гүнзгийрүүлнэ. Сурагчид ангийн уншлагад зохиолч бүрийн өгүүлбэрзүйг тодорхойлж, тайлбарлаж, шүүмжит шинжилгээ

хийхээ дээшлүүлж, дадлагажуулна. Сурагчид уншиж буй зүйлээ соёлын ба түүхийн талаас нь ойлгоно.

**Испани хэл I (25510)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид хэлний сонсогдох байдал, ерөнхий шинж, дуудлагыг сурна. Сонсох, ярих, унших, бичих дадлагын замаар үндсэн бүтэц, үгсийн санг сурах ба яриа харилцааг шинэ түвшинд гаргаж илэрхийлэхэд илүү анхаарна. Сурагчид үгсийн санг, хэлний бүтцийг бүтээмжтэй ашиглаж өөрсдийгөө яриагаар болон бичгээр илэрхийлнэ. Сурагчид өдөр тутмын үйл ажиллагаа, сонирхолд холбогдох энгийн хялбар асуулт, мэдэгдлийг ойлгож, уншина. Сурагчид мөн Испани хэлтэй улсуудын газар зүй, уламжлал, соёлын талаар суурь ойлголтыг авч сурна.

**Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл I (25517)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Багшийн тодорхойлсноор Испани хэлээр чөлөөтэй ярьж чаддаг байх*
Энэ хичээл нь Испани хэлээр чөлөөтэй ярьдаг болович уншиж, бичих чадвар хангалттай эзэмшээгүй сурагчдад зориулагдсан. Сурагчид унших, бичих, ярих харилцааны ур чадвар эзэмшиж, Испани хэл зүйн дүрэм суралцаж эхлэх болно. Сурагчид Испани хэлтнүүдийн соёл дадал, харах өнцгийн талаар гүнзгий ойлголт авна.

**Испани хэл II (25520)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Испани хэл I-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид сонсох, ярих, унших, бичих чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлэх ба шинэ түвшинд гарсан харилцан ярианд илүү анхаарна. Тэд сурсан үгсийн сан, дүрмээ ашиглаж дотно сэдвүүдээр энгийн ярианд оролцоно. Тэд дотно сэдвийн материалыг уншиж, өөрийн үгсийн сан ба дүрмийн мэдлэгийн хүрээнд зааврын дагуух богино бичлэгийг хийнэ. Тэд өөрсдийн мэдлэгийг соёлын үүднээс, харилцаа талаас нь өргөжүүлнэ.

**Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл II (25527)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл I-ийг C эсхүл дээш дүнтэй дүүргэсэн буюу үүнтэй ижил хэлний түвшинтэй*
Энэ хичээл нь Испани хэлээр анхан шатны түвшинд хэдийнээ уншиж, бичиж чаддаг хүмүүст зориулагдсан. Сурагчид зөв бичих, механик болон богино зохион бичлэг хийх чадвараа дээшлүүлнэ. Тэд эх бүтээл уншиж, орчуулж эхлэх бөгөөд/эсхүл хүүрнэл өгүүллэг болон шүлгийг шинжилнэ. Хэл зүйн дүрмийг үргэлжлүүлэн судална. Сурагчид ангидаа илтгэл тавих болон хоорондоо харилцах бусад үйл ажиллагаагаар ярианы чадвараа сайжруулна. Соёл, ёс заншлыг судалж, уран зохиолоор дамжуулан илүү гүнзгий ойлголттой болно.

**Испани хэл III (25530)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Испани хэл II-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид зорилтот хэлээр дөрвөн зүйлд чадвараа цааш хөгжүүлж, гүнзгийрүүлнэ: сонсох, ярих, унших, бичих. Тэд богино яриа өрнүүлэх ба тэдний яриаг эх хэлтэй бус хүмүүстэй харилцаж сурсан Испани эх хэлтэй хүн ойлгоно. Ангийн ажилд хэлийг байнга ашиглахад илүү анхаарна. Сурагчид тайлбарлахад илүү хэцүү үйл явдал, туршлагын талаар ярьж, үндсэн санааг ойлгож эх материал уншиж, илүү нарийн дүрмийн бүтцийг ашиглаж дотно сэдвээр бичнэ. Мэдлэгээ соёлын үүднээс, харилцаа талаас нь өргөжүүлнэ.

**Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл III (25537)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл III-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Энэ хичээл нь илүү ахисан түвшинд уншиж, бичиж чаддаг сурагчдад зориулагдсан. Сурагчид захидал, зохион бичлэг, тайлан бичиж чадах ба илүү нарийн төвөгтэй, урт өгүүллэгүүдийг орчуулах болон/эсхүл шинжилдэг болно. Түүнчлэн, сурагчид төрөл бүрийн сэдвээр тайлан бичих буюу амаар илтгэл тавина. Соёл, ёс заншлыг хуваалцаж, уран зохиолоор дамжуулан илүү гүнзгий ойлголттой болно. Англи хэлээр ярьдаг хүмүүст зориулсан испани хэл III сургалтыг амжилттай дүүргэсний дараа оюутнуудыг Испани хэлний дунд шатны I/II хос элсэлт (95501W) бүтэн жил, нэг кредит, +1.0 чанарын оноо эсвэл Испани хэл, соёл, AP-д элсүүлэхийг уриалж байна.

**Испани хэл IV (25540)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Испани хэл III-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
IV шатны сурагчид илүү нарийн, тохирох байдлаар бусдад танилцуулга хийхэд болон тоймлож, санамсаргүй тохиолдлоор тодорхойлж, мэдээлэл хайж, өгөхөд илүү анхаарна. Сурагчид дотно сэдвээр эх материалыг уншиж, соёлын контекст бүхий орчин үеийн сэдвээр ярилцана. Тэд энэ сэдвээр мөн зарим зүйлийг илүү нарийвчлан бичнэ. Соёл, ёс заншлыг хуваалцаж, уран зохиол, эх материалаар дамжуулан илүү гүнзгий ойлголттой болно.

**Испани хэл V, (25550)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Испани хэл IV-ийг C буюу дээш дүнтэй буюу багшийн тодорхойлсноор дээд түвшинд хүрсэн гэж амжилттай төгссөн.*
Сурагчид (мэдээ, эх хэлтэй хүний ярианы хэсэг зэрэг) эх материалыг ойлгохын тулд одоо болж буй үйл явдлын талаар ярилцах чадвартай байна. Тэд холбогдох хэлний соёл, түүх, уран зохиолын сонгосон сэдвүүдийг илүү нарийвчилж уншиж, бичиж, ярилцах ба үгчилж ойлгохоос илүүгээр ойлгох чадвараа өргөжүүлж эхэлнэ. Хичээлд мөн зорилтот хэлний уран зохиолд зарим нэг шинжилгээ хийх багтана.

**Дунд шатны Испани хэл I/II, хосолсон төгсөлт (95501W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Испани хэл IV-ийг амжилттай дүүргэсэн эсхүл багшийн тодорхойлсноор үүнтэй ижил түвшинтэй ба коллежийн түвшний хурдтай хичээлд бүртгүүлэхэд бэлэн*
Сурагчид одоо болж буй үйл явдлуудын талаар хэлэлцэж, уран зохиолын бүтээлийг сурч, шинжилж эх материалыг ойлгоно. Тэд холбогдох хэлний соёл, түүх, уран зохиолын сонгосон сэдвүүдийг илүү нарийвчилж уншиж, бичиж, ярилцах ба үгчилж ойлгохоос илүүгээр ойлгох чадвараа өргөжүүлнэ. Хичээлээр Испани хэлний ертөнцийн бүтээл, дадлыг бий болгогч харах өнцгийг шинжилж соёлын талаас нь багтаана. Энэ хичээл нь ACTFL (American Council on the Teaching of Foreign Languages [Америкийн Гадаад хэлний сургалтын зөвлөл])-ийн хэлний түвшний журамд заасан дунд төвшнөөс дээш түвшинд хүрч Испани хэлээ сайжруулахад зориулагдсан.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлнэ. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Испани хэл ба, соёл, AT, (35565)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх түвшинд “B” буюу дээш дүнтэй эсхүл багшийн зөвлөснөөр*

Энэ хичээлийг өндөр хэмжээнд чөлөөтэй харилцах, тодорхой бөгөөд хийсвэр сэдвийн материалыг ойлгох чадвартай сурагчдад зориулсан. Хичээлээр сурагчдыг Испани хэлний Ахисан түвшний элсэлтийн шалгалтад бэлтгэнэ. Сурагчид тодорхой дүгнэлт бичих, тайлбарлах, дүгнэх, эссэ бичих зэргээр янз бүрээр өөрсдийн хэлний бүх чадвараа (сонсох, ярих, унших, бичих) харуулна. Тэд уран зохиол, орчин үеийн амьдрал, бүх нийтийн соёлыг харуулсан янз бүрийн ярианы болон бичгийн материалыг ойлгож, шинжилж, ярилцана. Сурагчид хэлийг илүү сайн эзэмшиж, илүү сайн ойлгож, хийсвэр илэрхийллийг хэрэглэж, Испани хэлний өгүүлбэр зүй, ажиллагааг амаар болон бичгээр ойлгохоо илүү гүнзгийрүүлнэ. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй (25555).*

**Испани уран зохиол, AT (35580)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх түвшинд “B” буюу дээш дүнтэй эсхүл багшийн зөвлөснөөр*
Энэ хичээлийг өндөр хэмжээнд чөлөөтэй харилцах, уран зохиолыг багтааж тодорхой бөгөөд хийсвэр сэдвийн материалыг ойлгох чадвартай сурагчдад зориулсан. Хичээлээр сурагчдыг Испани хэлний Уран зохиол, AT, Ахисан түвшний элсэлтийн шалгалтад бэлтгэнэ. Сургалтын хөтөлбөрөөр сурагчид Испани хэлтэй улсуудын уран зохиолыг өргөн хүрээнд судална. Сурагчид уран зохиол, соёлыг илүү гүнзгийрүүлэн үзэж, хэлний бүх төрлийн чадваруудаа Испани хэлээр харуулах ба шүүмжит уншлага, шинжилгээ хийж бичихэд онцгой анхаарна. Үүний дээр энэ хичээлээр уран зохиолыг янз бүрийн соёлын контекстээр үзэх тул сурагчид уншиж байгаа уран зохиолоо ойлгохын зэрэгцээ агуулгыг суралцаж буй бусад олон салбартай болон өөрийн амьдралтай холбож үзнэ. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй.* (25580)

**Ахисан түвшний Испани хэл (25560)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх түвшинд "B" буюу дээш дүнтэй эсхүл багшийн зөвлөснөөр*
**9-12-р анги**
Энэ хичээлийг зорилтод хэл дээр илүү өндөр түвшинд чөлөөтэй ярих чадвартай сурагчдад зориулсан. Сургалтын хөтөлбөрөөр асуулт асууж, өргөн ярилцлага өрнүүлэх үндсийг өгсөн орчин үеийн сэдвүүдээр ярилцах замаар сурагчид илүү сайн ярилцах, харилцах чадварыг хөгжүүлэхэд илүү анхаарна. Сурагчид янз бүрийн мэдээллийн эх сурвалжийг ашиглаж, Испани хэлээр ярьдаг улсуудын баялаг эх материалыг ойлгох чадвартайгаа харуулна. Тэд зорилтот хэлний соёлын уран зохиол, кино, түүх, бүх нийтийн соёлд холбогдох сонгосон сэдвүүдээр уншиж, бичиж, яриа өрнүүлнэ.

## Дэлхийн хэлний сургалтын үе шатууд[1]

**Америк дохионы хэл**

| 10-р анги | 10-р анги | 10-р анги | 10-р анги | 11-р анги | 11-р анги |
|---|---|---|---|---|---|
| 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | | |
| | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | |
| | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин |
| | | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин |
| | | | | 1-р түвшин | 2-р түвшин |

**Араб хэл**

| 10-р анги | 10-р анги | 10-р анги | 10-р анги | 11-р анги | 11-р анги |
|---|---|---|---|---|---|
| 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | 5-р түвшин ОУБ/I | ОУБ II |
| | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | 5-р түвшин |
| | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин |

**Хятад хэл**

| 10-р анги | 10-р анги | 10-р анги | 10-р анги | 11-р анги | 11-р анги |
|---|---|---|---|---|---|
| 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | Хятад хэл ба соёл, AT/IB I | ОУБ II |
| | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | Хятад хэл ба соёл, AT |
| | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин |

**Франц хэл**

| 10-р анги | 10-р анги | 10-р анги | 10-р анги | 11-р анги | 11-р анги |
|---|---|---|---|---|---|
| 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | 5-р түвшин эсхүл Франц хэл ба соёл, AT эсхүл ОУБ I* | Франц хэл ба соёл, AT эсхүл Ахисан түвшний Франц хэл эсхүл ОУБ II |
| | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | 5-р түвшин эсхүл Франц хэл ба соёл, AT |
| | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин |
| | | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин |
| | | | | 1-р түвшин | 2-р түвшин |
| | | | | | 1-р түвшин |

**Герман хэл**

| 10-р анги | 10-р анги | 10-р анги | 10-р анги | 11-р анги | 11-р анги |
|---|---|---|---|---|---|
| | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | |
| | | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин |
| | | | | 1-р түвшин | 2-р түвшин |
| | | | | | 1-р түвшин |

**Япон хэл**

| 10-р анги | 10-р анги | 10-р анги | 10-р анги | 11-р анги | 11-р анги |
|---|---|---|---|---|---|
| | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | |
| | | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин |

[1] Энэ дараалал нь ердийн хөтөлбөрийнх болно. Олон улсын бакалаврын хичээлийн сонголтуудын бүрэн тодорхойлолтыг 117-121-р хуудаснаас үзнэ үү.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 1-р түвшин | 2-р түвшин |
| | | | | | 1-р түвшин |

**Латин хэл**

| 10-р анги | 10-р анги | 10-р анги | 10-р анги | 11-р анги | 11-р анги |
|---|---|---|---|---|---|
| 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | 5-р түвшин эсвэл латин хэл, АТ эсвэл ОУБ I | Латин хэл, АТ эсхүл Ахисан түвшний Латин хэл эсвэл ОУБ II |
| | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | 5-р түвшин эсхүл Латин хэл, АТ |
| | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин |
| | | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин |
| | | | | 1-р түвшин | 2-р түвшин |
| | | | | | 1-р түвшин |

**Испани хэл**

| 10-р анги | 10-р анги | 10-р анги | 10-р анги | 11-р анги | 11-р анги |
|---|---|---|---|---|---|
| 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | 5-р түвшин эсхүл Испани хэл ба соёл, АТ<br><br>эсвэл<br>ОУБ I | Испани хэл ба соёл, АТ эсхүл Испани уран зохиол, АТ эсвэл Ахисан түвшний Испани хэл эсвэл IB II |
| | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин | Түвшин 5 эсхүл Испани хэл ба соёл, АТ |
| | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | 4-р түвшин |
| | | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин |
| | | | | 1-р түвшин | 2-р түвшин |
| | | | | | 1-р түвшин |

**Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан испани хэл**

| 7-р анги | 8-р анги | 9-р анги | 10-р анги | 11-р анги | 12-р анги |
|---|---|---|---|---|---|
| 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | Испани хэл ба соёл, АТ | Испани уран зохиол, АТ | Ахисан түвшний Испани хэл |
| | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | Испани хэл ба соёл, АТ | Испани уран зохиол, АТ эсвэл Ахисан түвшний Испани хэл |
| | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин | Испани хэл ба соёл, АТ |
| | | | 1-р түвшин | 2-р түвшин | 3-р түвшин |
| | | | | 1-р түвшин | 2-р түвшин |
| | | | | | 1-р түвшин |

Тайлбар:

1. Герман, япон хэлийг зөвхөн ахлан сургуулийн түвшинд санал болгоно.
2. Вашингтон Либерти ахлах сургуулийн бүх шатны хятад хэлийг ганцаарчилсан багш заадаг. Вэйкфилдийн II ба III түвшний оюутнууд Карьерын төвд шууд сургалтад хамрагдах боломжтой. Йорктауны II, III түвшний Хятад хэлний оюутнууд ганцаарчилсан багштай болно. Бусад бүх түвшний хятад хэлийг уугуул хятад хэлтэй туслахын тусламжтайгаар онлайн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан санал болгодог.
3. AT шалгалтыг Америк дохионы хэл эсхүл Араб хэлээр өгөх боломжгүй.
4. ОУБ-ын түвшний хэлийг Washington Liberty ахлах сургуульд зөвхөн судлах боломжтой.
5. AT хичээлийг Герман болон Япон хэл дээр авах боломжгүй.
6. Нэг буюу түүнээс дээш гадаад хэлийг ахисан түвшинд эзэмшсэн болохыг харуулсан APS сурагчид Шалгалтаар олох кредитэд амжилттай оролцох замаар 4 хүртэл кредит (1-4-р түвшин) цуглуулах боломжтой. Илүү мэдээлэл авахын тулд www.apsva.us/worldlanguages хаягаар орно уу. Давхар кредитийг зөвшөөрөхгүй.

# АРЛИНГТОНЫ КАРЬЕРЫН ТӨВ
# 2022-23

Арлингтоны карьерын төв нь академик хөтөлбөр, Карьер ба Техникийн боловсрол (CTE)-ын хөтөлбөрүүд болон Засаг даргын Арлингтоны Карьер, техникийн академийн хос төгсөлтийн коллежийн хичээлүүдийг санал болгож Арлингтоны Улсын сургуулийн бүх сурагчдад үйлчилдэг. Карьерын төвийн зорилго нь гардаж хийх замаар сурахад дурлах юм. Үүний дээр Карьерын төв дөрвөн салбарт илүү гүнзгийрүүлсэн сургалтыг хийнэ: 1) Төсөлд суурилсан хичээлийн хөтөлбөр; 2) үйлдвэрийн гэрчилгээ; 3) коллежийн кредит; ба 4) дадлага, үйлчлүүлэгчийн төслүүд зэрэг ажилд суурилсан туршлагууд.

Засаг даргын Арлингтоны Карьер, техникийн академи (GCTAA) нь өндөр түвшний боломж бүхий, олон салбарыг багтаасан төслүүд, Northern Virginia Community College (NOVA)-ийн хос төгсөлтийн боломжуудаар "Харилцаа, ач холбогдол, эрчимтэй байдал"-д холбогдож хөтөлбөрүүд гаргадаг. Сурагчдад Бизнес, мэдээллийн технологи, Компьютерын шинжлэх ухаан, Кибер аюулгүй байдал, харилцаа холбоо ба Үйлдвэрлэл, инженерчлэл, Эрүүл мэнд, хүний үйлчилгээ, Боловсрол, Засаглал гэсэн замаар боломж олгодог. Арлингтоны Карьерын төвд хос төгсөлтийн элсэлтийн CTE хичээлүүдэд бүртгүүлсэн сурагчид нь Академийн нэг хэсэг байна (GCTAA). Тэд мөн Карьерын төвийн кампус дээр NOVA-ийн нэг кредитийн зүг чиг авах хичээлийг (SDV 100) авч болно. Арлингтоны Карьерын төв ба хөтөлбөрийнх нь тухай илүү мэдээллийг 703-228-5800 утсаар, болон https://careercenter.apsva.us/ веб хуудаст зочилж үзнэ үү.

## Хөтөлбөрийн саналууд

### АРЛИНГТОНЫ КАРЬЕРЫН ТӨВ ДЭЭРХ КАРЬЕР, ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛҮҮДИЙН ДАРААЛСАН СОНГОЛТУУД

### АРЛИНГТОНЫ КАРЬЕРЫН ТӨВИЙН КАРЬЕР, ТЕХНИКИЙН ХИЧЭЭЛҮҮД

### АРЛИНГТОНЫ КАРЬЕРЫН ТӨВД НЭМЭЛТ ХИЧЭЭЛҮҮДИЙГ САНАЛ БОЛГОНО

### ДАДЛАГА ХИЙХ БОЛОМЖ

### АРЛИНГТОН ТЕХ

### АКАДЕМИК ХИЧЭЭЛИЙН АКАДЕМИ

### АНГЛИ ХЭЛ СУРАЛЦАГЧДЫН ИНСТИТУТ

### АЖИЛ ЭРХЛЭЛТЭД БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР (PEP)

| Арлингтоны карьерын төв дээрх карьер, техникийн боловсролын хичээлүүдийн дараалсан сонголтууд<br><br>Стандарт дипломын төгсөлтийн шаардлагад хамгийн багадаа хоёр сонголтыг шат дараатайгаар шаарддаг. CTE дээр энэ шаардлагыг доор жагсаасан сонголтуудын нэгийг хэрэглэж биелүүлж болно. Зарим тохиолдолд сонголт нь хоёр кредит, хоёр цаг хичээл байх ба үүнд сурагч шаталсан сургалт авна. Илүү мэдээлэл авахын тулд өөрийн зөвлөхтэй уулзана уу. | | | | |
|---|---|---|---|---|
| **I. Бизнес, харилцаа** | | | | |
| **Урлаг, Аудиовизуал технологи, харилцаа** | Үе шатны сонголт 1:<br>Гэрэл зураг, дүрс бичлэг I (28625), Гэрэл зураг, дүрс бичлэг II (28626) | Үе шатны сонголт 2:<br>Цахим анимац (28457), График харилцааны систем (28458) | Үе шатны сонголт 3:<br>Телевизийн продакшн I (28689) (98689W)<br>Телевиз, мультимедиа продакшн II (28690) (98690W) DE<br>Телевиз, мультимедиа продакшн III (28691) (98691) DE | |
| **Мэдээллийн технологи: Кибер аюулгүй байдал/Сүлжээ** | Үе шатны сонголт 1:<br>Мэдээллийн технологийн удиртгал (26116), Компьютерын мэдээллийн системүүд (26614) | Үе шатны сонголт 2:<br>**Кибер аюулгүй байдлын түвшин I:** Кибер аюулгүй байдлын үндэс (96659W)<br><br>**Кибер аюулгүй байдлын түвшин I:** Кибер аюулгүй байдлын системүүд (96667W) DE<br><br>*(дээрх бүх хичээлүүдийг зэрэг авч болно* | Үе шатны сонголт 3:<br>**Кибер аюулгүй байдлын түвшин II:** Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа (96657W) DE,<br>**Кибер аюулгүй байдал II:** Кибер аюулгүй байдал<br>Программ хангамжийн ажиллагаа (96662W) DE<br><br>*(дээрх бүх хичээлүүдийг зэрэг авч болно)* | Үе шатны сонголт 4:<br>**Кибер аюулгүй байдлын түвшин III:**<br>Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа, Ахисан түвшин (96658W) DE,<br>Кибер аюулгүй байдал III: Кибер аюулгүй байдлын программ хангамжийн ажиллагаа, ахисан түвшин (96663W) DE<br><br>*(дээрх бүх хичээлүүдийг зэрэг авч болно)* |
| **Мэдээллийн технологи: Компьютерын програмчлал** | Үе шатны сонголт 1:<br>Компьютерын програмчлал (26638)<br>(96638W) DE | Үе шатны сонголт 2:<br>Компьютерын програмчлал, эрчимжүүлсэн, DE (96644W) | Үе шатны сонголт 3:<br>Компьютерын програмчлал, ахисан түвшин (96643W) DE | |
| **Мэдээллийн технологи: Вэб хуудасны дизайн эсхүл өгөгдлийн сангийн удирдлага** | Үе шатны сонголт 1:<br>Вэб хуудасны дизайн, мультимедиа I (26646) (96646W) DE.<br>Вэб хуудасны дизайн, мультимедиа, ахисан шат (26631) (96631W) DE | Үе шатны сонголт 2:<br>Вэб хуудасны дизайн, мультимедиа (26646) (96646W) DE.<br>Дата сангийн дизайн, менежмент (26664) (96660W) DE | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **II. Үйлдвэрлэл, инженерчлэл** | | | | |
| **Тээвэр, түгээлт, логистик** | Үе шатны сонголт 1:<br>Автомашин, төхөөрөмжийн технологи I (98509W) DE<br>Автомашин, төхөөрөмжийн технологи II (98507W) DE ** | Үе шатны сонголт 2:<br>Автомашины эвдрэл засвар I (28677)<br>Автомашины эвдрэл засвар II (28678)<br>Автомашины эвдрэл засвар III (28680) | | |
| **Архитектур, барилга** | Үе шатны сонголт 1:<br>Компьютерын тусламжтай архитекторын зураг (98408W) DE,<br>Барилгын технологи (28512) | Үе шатны сонголт 2:<br>Материал, процесс, шинэчлэн технологи (28460) | Үе шатны сонголт 3:<br>Цахилгаан I (28534)<br>Цахилгаан II (28535) | |
| **Шинжлэх ухаан, Технологи, Инженерчлэл, Математик** | Үе шатны сонголт 1:<br>Инженерчлэл I: Удиртгал, инженерчлэл II: Инженерчлэлийн зарчмууд (28492) | Үе шатны сонголт 2:<br>Компьютерын тусламжтай техникийн (28439) зураг,<br>Компьютерын тусламжтай архитекторын зураг (28408) DE | Үе шатны сонголт 3:<br>Компьютерын тусламжтай техникийн зураг (28439) DE,<br>Компьютерын тусламжтай инженерийн зураг (28438) | Үе шатны сонголт 4:<br>Дижитал электроник (26671),<br>Инженерчлэлийн оргил: Дизайн, хөгжүүлэлт (28494), компьютер оролцуулсан үйлдвэрлэлийн инженерчлэл<br>(28493) |
| **III. Эрүүл мэнд, хүний үйлчилгээ** | | | | |
| **Газар тариалан, хүнс, байгалийн эх үүсвэр** | Үе шатны сонголт 1:<br>Мал эмнэлгийн шинжлэх ухаан I (28064)<br>Мал эмнэлгийн шинжлэх ухаан II (28061) | Үе шатны сонголт 2:<br>Жижиг амьтныг арчлах I (28062),<br>Жижиг амьтныг арчлах II (28063), | | |
| **Эрүүл мэндийн шинжлэх ухаан** | Үе шатны сонголт 1:<br>Эрүүл мэндийн шинжлэх ухаан (28303)<br>Эмнэлгийн технологи (98383W) DE** | Үе шатны сонголт 2:<br>Эрүүл мэндийн шинжлэх ухаан (28303)<br>Эмийн сангийн техникч (28305) | Үе шатны сонголт 3:<br>Эрүүл мэндийн шинжлэх ухаан (28303)<br>Физик эмчилгээ/Хөдөлмөрийн эмчилгээ (28340/98340W) | Үе шатны сонголт 4:<br>Эрүүл мэндийн шинжлэх ухаан (28303)<br>Эмнэлгийн анхны тусламжийн техникч I (28334) (98334W) DE |
| **Зочлох, аялал жуулчлал** | Үе шатны сонголт 1:<br>Хоолны урлаг, шинжлэх ухаан I (28522)<br>Хоолны урлаг, шинжлэх ухаан II (28523) | | | |
| **Хүний үйлчилгээ** | Үе шатны сонголт 1:<br>Бага насны хүүхдийн боловсрол I (98235W) DE, Бага насны хүүхдийн боловсрол II (28236) | Үе шатны сонголт 2:<br>Гоо сайхан I (28528) Гоо сайхан II (28529)<br>Гоо сайхан III (28530) | Үе шатны сонголт 3:<br>Үсчин I (28531)<br>Үсчин II (28532)<br>Үсчин III (28526) | |

| IV. Боловсрол, засгийн газар | | | | |
|---|---|---|---|---|
| **Засгийн газар, засаг захиргаа** | Үе шатны сонголт 1:<br>Залуу агаарын цэрэг ROTC I (29911)<br>Залуу агаарын цэрэг II (29912) | Үе шатны сонголт 2:<br>Залуу агаарын цэрэг ROTC III (29913), Залуу агаарын цэрэг ROTC IV (29914) | | |
| **Хууль, нийтийн тайван байдал, залруулга, аюулгүй байдал** | Үе шатны сонголт 1:<br>Биотехнологи хэрэглэх шинжилгээний технологи (28325), Эрүүл мэнд, анагаахын биотехнологи (28326) | | | |

S – Хичээлд байгалийн шинжлэлийн кредит өгнө. DE – Хичээлийг хосолсон төгсөлтийн кредит авах эрхтэй сурагчид авч болно. Хичээлийн талаар болон дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.
**Зарим шатлалын нэмэлт түвшнүүд бий. *Бүх хичээлүүд ахлах сургууль төгсөх Карьер, техник/Урлагийн хичээлийн шаардлагыг хангана. Сурагчид СТЕ-ийн үе шатыг дүүргэсний дараа холбогдох үйлдвэрлэлийн дадлагын улсын гэрчилгээ авах шалгалтыг амжилттай өгч баталгаажсан кредит авч болно. СТЕ-ийн хичээл бүрээр 2013-2014 онд болон түүнээс хойш ахлах сургуульд орсон сурагчдад үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээ, Стандарт дипломын төгсөлтийн шаардлагыг хангах техникийн гэрчилгээг авах боломж олгоно.*

## КАРЬЕР, ТЕХНИКИЙН ХИЧЭЭЛҮҮД АРЛИНГТОНЫ КАРЬЕРЫН ТӨВД

*Бүх хичээлүүд Карьер, техникийн/Урлагийн кредитийг хангана.*

*Карьер, техникийн хичээл бүрд Стандарт дипломын төгсөлтийн шаардлагад багтах карьер, техникийн гэрчилгээг авах боломжийг олгоно. Өөрийн зөвлөхтэй уулзаж нэмэлт мэдээллийг авна уу.*

*Тайлбар: 15-с доош сурагчтай хичээлүүдийг сурагчийн сонирхол, зардал төсвийг харгалзан үзээд явуулахгүй байж болно. Зарим тохиолдолд, нэмэлт төсөв санхүүг харгалзан үзэж тухай жилд зарим хичээлийг явуулах боломжгүй болж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд сурагчид өөр хичээл сонгох хэрэгтэй. Түүнчлэн, хангалттай тооны сурагч элсэн ороогүй хичээлийг зайнаас хийх эсхүл онлайн сургалтаар зааж болно.*

**Агаарын хөлгийн инженерчлэл (28498)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Инженерчлэл I: Инженерчлэлийн удиртгал (28491)*
Энэхүү мэргэшсэн хичээлээр сурагчид аэродинамик, сансрын нисгэгчид, агаар мандлын шинжлэх ухаан, системийн инженерчлэлийг амьдралд ойр инженерчлэлийн асуудал, төслөөр заана.

**Залуу агаарын цэрэг ROTC I (29911)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид хамгийн багадаа 14 настай байна*
SFJROTC-оор өөрийн улс, нийгэмд үйлчлэхийн төлөө иргэнийг хөгжүүлнэ. Үүнд өөрийн сахилга бат, хүндэтгэл, дадал, эелдэг байдал, шударга байдал, үйлчилгээ, манлайллыг хөгжүүлж хүрнэ. SFROTC-д бүртгүүлсэн бол заавал цэрэгт явах үүрэг үүсэхгүй.
SFROTC-ийн хичээлүүдэд Нисэх хүчний түүх, Манлайлал, Глобал судлал, Агаар мандлын судалгаа, Цэргийн суралцагчийн эрүүл мэнд, Цэргийн суралцагчдын анги, нэгтгэлийн удирдлага багтана. I, II түвшний цэргийн суралцагч болохын хувьд сурагчид динамик тушаал гүйцэтгэгч, багийн ажил, мэргэжлийн байхыг сурч, цэргийн сургагчийн ангид хуваарилагдана.

**Залуу агаарын цэрэг ROTC II (29912)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: SFJROTC I болон сурагчид хамгийн багадаа 14 настай байх ёстой ба USAF шаардлагад нийцэх ёстой*
SFJROTC-оор өөрийн улс, нийгэмд үйлчлэхийн төлөө иргэнийг хөгжүүлнэ. Үүнд өөрийн сахилга бат, хүндэтгэл, дадал, эелдэг байдал, шударга байдал, үйлчилгээ, манлайллыг хөгжүүлж хүрнэ. SFROTC-д бүртгүүлсэн бол заавал цэрэгт явах үүрэг үүсэхгүй.
SFROTC-ийн хичээлүүдэд Нисэх хүчний түүх, Манлайлал, Глобал судлал, Агаар мандлын судалгаа, Цэргийн суралцагчийн эрүүл мэнд, Цэргийн суралцагчдын анги, нэгтгэлийн удирдлага багтана. I, II түвшний цэргийн суралцагч болохын хувьд сурагчид динамик тушаал гүйцэтгэгч, багийн ажил, мэргэжлийн байхыг сурч, цэргийн сургагчийн ангид хуваарилагдана.

**Залуу агаарын цэрэг ROTC III (29912)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: SFJROTC I, II-ийг дүүргэх, USAF шаардлагын стандартыг биелүүлэх*
SFJROTC-оор өөрийн улс, нийгэмд үйлчлэхийн төлөө иргэнийг хөгжүүлнэ. Үүнд өөрийн сахилга бат, хүндэтгэл, дадал, эелдэг байдал, зан чанар, үйлчилгээ, шударга байдал, үйлчилгээ, манлайллыг хөгжүүлж хүрнэ. SFJROTC-д бүртгүүлсэн бол заавал цэрэгт явах үүрэг үүсэхгүй.
SFROTC-ийн ангиудад Нисэх хүчний түүх, Манлайлал, Глобал судлал, Агаар мандлын судалгаа, Цэргийн суралцагчийн эрүүл мэнд, Цэргийн суралцагчдын анги, нэгтгэлийн удирдлага багтана. III, IV түвшний цэргийн сурагчийн хувьд сурагчид манлайллын тухай суралцаж, цэргийн ангид манлайлах үүрэгт томилогдоно.

**Залуу агаарын цэрэг ROTC IV (29914)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: SFJROTC I, II, III-т нийцэх, USAF-ийн шаардлагыг хангах, SFJROTC III-д зэрэгт элсэж бүртгүүлсэн байх*
SFJROTC-оор өөрийн улс, нийгэмд үйлчлэхийн төлөө иргэнийг хөгжүүлнэ. Үүнд өөрийн сахилга бат, хүндэтгэл, дадал, эелдэг байдал, зан чанар, үйлчилгээ, шударга байдал, үйлчилгээ, манлайллыг хөгжүүлж хүрнэ. SFJROTC-д бүртгүүлсэн бол заавал цэрэгт явах үүрэг үүсэхгүй.
SFROTC-ийн хичээлүүдэд Нисэх хүчний түүх, Манлайлал, Глобал судлал, Агаар мандлын судалгаа, Цэргийн суралцагчийн эрүүл мэнд, Цэргийн суралцагчдын анги, нэгтгэлийн удирдлага багтана. III, IV түвшний цэргийн сурагчийн хувьд сурагчид манлайллын тухай суралцаж, цэргийн ангид манлайлах үүрэгт томилогдоно.

**Автомашины эвдрэл засвар I (28677)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Глобал автомашины засварын салбарт мэргэшсэн автомашины техникчийн эрэлт ихсэж байна. Хичээлээр сурагчид бүтэцгүйгээр шинжилгээ хийх, эвдрэлийг засах, гагнах талаар сурна. Сурагчид янз бүрийн материалтай ажиллаж, металлаар өнгөлөх, эхийг дүүргэх аргачлалыг гадаргуу, янз бүрийн хэсгийн засварт бэлтгэхэд сурна. Үүний дээр сурагчид аюулгүй байдлын дадлага хийж, мэргэжлийн чадварыг эзэмшинэ.

**Автомашины эвдрэл засвар II (28678)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Автомашины эвдрэл засвар I.*
Энэ хичээлээр сурагчдыг автомашины эх биеийн салбарт ажилд ороход нь бэлтгэх зорилготой. Мэргэших хоёр салбар бий: автомашин будах, эвдрэл засах. Сурагчид хоёуланд нь туршлага олж авах боловч нэг салбарт мэргэших боломжтой. Ихэнх цагийг амьдралын практик туршлагад зарцуулна.

- ***Гэрчилгээ:*** *II шатыг амжилттай дүүргэснээр сурагчид Автомашин үйлчилгээний чадвар/АНУ-ын автомашины техникчийн будгийн шалгалтыг өгч болно.*

**Автомашины эвдрэл засвар III (28680)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Автомашины эвдрэл засвар I (28677), II (28678)*
Энэ хичээлээр сурагчид Автомашины эвдрэл засвар I, II хичээлээр олж авсан дадал/чадвараа цааш хэрэглэх боломжтой байна. Энэ хичээлийг “оргил” хичээл болгож ашиглах боломжтой ба сурагчид ажилд орохын тулд автомашинд холбогдох чадвараа улам дээшлүүлэхэд ашиглаж болно. Хөтөлбөрийн үе шатуудыг амжилттай дүүргэсэн сурагчид ASE/NATEF шалгалт өгч тэнцэхэд бэлтгэгдэх ба дунд сургуулийн дараа үргэлжлүүлэн сурахад бэлтгэгдэнэ.

**Автомашины засвар, гэрлийн засвар (28675)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй. Автомашины эвдрэлийн засвар I (28677) хичээлтэй хамт энэ хичээлийг авч болно.*
Хичээлээр сурагчид моторын засвар, автомат дамжуулагч, кроп, гараар жолоодох хурдны хайрцаг, тэнхлэг, амортизаторын тогтолцоо, жолооны систем, тоормосны анхан шатны үйлчилгээнд суралцаж, дадлагажна. Автомат технологийн хөтөлбөрийг амжилттай төгссөн сурагчид Автомат үйлчилгээний салбарын суралцагчийн гэрчилгээний (ASE) шалгалтыг өгч болно. ASE суралцагчийн гэрчилгээ нь автомашины салбарт үйлчилгээний ажилтан байх ажил мэргэжлийн эхний алхам юм.

**Автомашины технологи I (28509) (98509W)**
**Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Автомашины технологи I нь Карьерын төв дэх Ахисан шатны автомашины технологийн хөтөлбөрийн анхан шатны хичээл юм. Үүнийг мөн сонирхлоороо авч болно. Сурагчдад автомашины салбарт ажил мэргэжил сонгох талаар, Автомашины салбарын залуусын боловсролын тогтолцоо (AYES) тэдэнд автомашины салбарт ажил олоход хэрхэн туслах талаар танилцуулна. Сурагчид тоормос, хөдөлгүүрийн засварыг багтааж автомашины технологийн ASE гэрчилсэн салбаруудад ур чадвар эзэмшинэ. Сурагчид мөн багаж хэрэгсэлтэй хэрхэн ажиллах талаар суралцаж, машины засвар үйлчилгээг хийнэ. Ихэнх хичээлүүд нь амьдралд ойр, сурагчдад машинтай бие даан ажиллах боломж олгоно.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Автомашины технологи II (28507) (98507W)**
**Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Автомашины технологи I (28509)*
Автомашины технологи II хичээлд ажлын байранд дээр “жинхэнэ амьдралын” дадлага хийнэ. Хамгийн сүүлийн үеийн технологи дээр дадлага хийснээр сурагчид энэхүү гайхамшигтай, хурдан өсөж буй салбарт туршлага олж авна. Орчин үеийн нарийн мэргэжлийн багаж төхөөрөмжийг хэрэглэж, “амьдрал” дээрх дадлагыг хийх тул энэ хичээл нь ирээдүйн техникчид төдийгүй автомашин өмчлөгчдөд ашиг тустай. Энэ хичээл нь Автомашины технологи III хичээлийн урьдчилсан нөхцөл.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:** ASE/AYES/SkillsUSA Автомашины техникчийн Хөтөлбөрийн төгсөлтийн шалгалт*

**Автомашины технологи III (28508) (98508W)**
**Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Автомашины технологи II*
Автомашины технологи III хичээл нь Ахисан шатны автомашины технологи гэсэн гурван жилийн хөтөлбөрийн оргил юм. Сурагчид компьютерын хяналттай системүүд, шатахууны шахуурга, өмнө талын дугуйг холбох зэрэг мэргэшсэн салбаруудыг багтааж, автомашины технологийн ASE гэрчилгээний чадваруудаа бэхжүүлнэ. Илүү нарийн шалгах төхөөрөмж болон бусад орчин үеийн тоног төхөөрөмжийг хэрэглэх нь сурагчдыг автомашины салбарын ажил мэргэжил амжилт гаргахад шаардах чадварт бэлтгэнэ. Хаврын улирлаар сурагчид Карьерын төвийн улсаас хүлээн зөвшөөрөгдсөн дадлагын хөтөлбөрт оролцох боломжтой ба сурагчид нутгийн автомашин худалдагчид дээр болон хараат бус үйлчилгээ үзүүлэгч дээр төлбөртэй дадлага хийх ярилцлага хийнэ. Зуны явцад энэ дадлагуудын ихэнх нь бүтэн цагаар ажиллах цалинтай ажил болно.

- ***Коллежийн кредит:** Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:** ASE/AYES/SkillsUSA Автомашины техникчийн Хөтөлбөрийн төгсөлтийн шалгалт*

**Агаарын хөдөлгүүрийн технологи**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Хичээлийг төгсөхөөс өмнө сурагчид 15 нас хүрсэн байх ёстой.*
Агаарын хөдөлгүүрийн технологиор агаарын болон сансрын үйлдвэрлэлтэй танилцуулна. Энэ нь нисгэгч болох гэж байгаа буюу агаарын нислэгийн салбарт ажил мэргэжил сонгох гэж байгаа сурагчдад зориулагдсан. Энэ нь сурагчид жинхэнээсээ онгоцоор нисэх Виржиниа даяар байх дөрвөн хичээлүүдийн нэг юм. Хичээлийн агуулгад агаарын болон сансрын салбарын ажил мэргэжил, агаарын тээврийн түүх, нисэх зарчмууд, онгоцны систем, ажиллагаа, нисгэгчдэд зориулсан цаг агаар судлал, үндсэн жолоо, автомат жолоо, агаарын нислэгийн философи, нислэгийг төлөвлөх, шийдвэр гаргах багтана. Сурагчид нислэгийн сургалтыг бүрэн болон дадлагажих суурин онгоц дээр хийж, нутгийн онгоцны буудлаас хоёр удаа жинхэнээсээ нисэнэ. Сургалтын хөтөлбөрийг Smithsonian-ий агаар, сансрын музей, Reagan-ий Үндэсний нисэх онгоцны буудал, Lockheed Martin-ий нислэгийн үзүүлбэрийн төвд очиж баяжуулна.

- ***Гэрчилгээ:** Сурагчид хувийн агаарын хөлгийн нисгэгчийн үнэмлэхийн Холбооны улсын агаарын хөлгийн захиргааны (FAA) бичгийн шалгалтыг өгнө.*

**Агаарын хөдөлгүүрийн технологи II (28732)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид 15 нас хүрсэн байх ёстой ба Агаарын хөдөлгүүрийн технологи I (28731) хичээлийг дүүргэсэн байх ёстой*
Сурагчид нислэгийн дасгал, сургууль, хиймэл орчны хичээлд оролцож нислэгийн хөтөлбөрөө хангахын зэрэгцээ цаг агаар, аэродинамик, навигаци, сэтгэл зүй, агаарын болон нислэгийн орчин, агаарын маневр, агаарын хөлгийн жин ба тэнцвэрийг сурна. Сурагчид нислэгийн сургалтыг бүрэн болон дадлагажих суурин онгоц дээр үргэлжлүүлэн хийж, нутгийн онгоцны буудлаас хоёр удаа жинхэнээсээ нисэнэ. Сургалтын хөтөлбөрийг Smithsonian-ий агаар, сансрын музей, Reagan-ий Үндэсний нисэх онгоцны буудал, Lockheed Martin-ий нислэгийн үзүүлбэрийн төвд очиж баяжуулна.

- ***Гэрчилгээ:** Сурагчид хувийн агаарын хөлгийн нисгэгчийн үнэмлэхийн Холбооны улсын агаарын хөлгийн захиргааны (FAA) бичгийн шалгалтыг өгнө.*

**Үсчин I (28531)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**Ангиуд: 10-11**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Үсчин нь үс, хуйх, арьсны сургалт юм. Сурагчид туршилтын лабораторийн орчинд хүүхэлдэй дээр болон хүн дээр туршилт хийнэ. Хөтөлбөрөөр аюулгүй байдал, эрүүл ахуй, харилцаа, менежментийн чадварыг онцгойлж үзнэ. Холбоотой сэдвүүдэд сэтгэл судлал, ёс зүй, мэргэжлийн имиж багтана. Хичээлийг ажилттай дүүргэснээр нутгийн үсчин, гоо сайханд ажиллах эсхүл дадлагажигчаар ороход сурагчийг бэлтгэнэ.

**Үсчин II (28532)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**Ангиуд: 10-11**
*Урьдчилсан шаардлага: Үсчин I*
Сурагчид үсчний чадвараа туршилтын лабораторийн орчинд хүүхэлдэй болон хүн дээр дадлага хийж хэрэглэнэ. Хөтөлбөрөөр аюулгүй байдал, эрүүл ахуй, үсчний газар болон гоо сайхны газрын менежментэд илүү анхаарна. Холбоотой

сэдвүүдэд сэтгэл судлал, ёс зүй, мэргэжлийн имиж багтана. Хичээлийг амжилттай дүүргэснээр сурагчид Виржиниагийн улсын лиценз авах шалгалтад бэлтгэгдэнэ.

**Үсчин III (28526)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**Ангиуд: 10-11**
*Урьдчилсан шаардлага: Үсчин I, II (28531, 28532)*
Энэ ахисан шатны хичээлээр сурагчид үсчний ерөнхий боловсрол болон дадлагын онолын суурь дээр тулгуурлаж, мэргэжлийн байх, үйлчлүүлэгчтэй харилцах, аюулгүй байдал, халдвараас сэргийлэхэд анхаарч үс засах чадвараа сайжруулах, хүн дээр стиль гаргах дадлага хийх болно. Сурагчид химийн бодистой аюулгүй харилцах, ахисан түвшний үс будах технологид суралцана. Тэд мөн хиймэл үс, үсний залгаасыг ашиглаж уран бүтээлчийн чадварыг хөгжүүлнэ. Ахисан түвшний хичээлийн бүлэгт Үсчний газрын удирдахад анхаарна. Хичээлийг амжилттай дүүргэснээр сурагчид Виржиниагийн улсын лиценз авах шалгалтад бэлтгэгдэнэ: Сурагчид танхимын хичээлийг хичээлийн жилийн туршид байнга зааварчилгаа авч зөвшөөрөгдсөн ажлын байр эсхүл хийх дадлагатай хослуулж болно.

- ***Гэрчилгээ:*** *Виржиниагийн үсчин, гоо сайхны зөвлөлийн шалгалт (сурагчид Үсчин I, II, III-ийг дүүргэсний дараа).*

**Эрүүл мэнд, анагаахын биотехнологи (28326)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Биологи (24310) ба Шинжилгээний технологи/Биотехнологийн хэрэглээ (28325) хичээлд давхар бүртгүүлэх*
Хичээлээр янз бүрийн орчин үеийн технологи ба эрүүл мэнд, эмчилгээний шинжлэх ухааны салбарт чухал техникт анхаарна. Сурагчид бүх организмууд ба орчны эрүүл мэндийн харилцан холбоотой танилцана. Сурагчид дезоксирибонуклейн хүчил (ДНХ)-ийн шинжилгээ, био мэдээлэл, биотехнологийн ёс зүйн асуудлуудын талаар суралцана. Сурагчид эрүүл мэнд, анагаахын салбарын биотехнологийн карьерын талаар ойлголт авна.

- ***Ахлах сургуулийн нэмэлт кредит:*** *Энэ хичээлээр авсан кредит нь стандарт дипломын гуравдугаар байгалийн шинжлэлийн лабораторийн кредит буюу ахисан түвшний дипломын дөрөвдүгээр лабораторийн кредитийн шаардлагыг хангана. Байгалийн шинжлэлийн кредитээс гадна сурагчид нарийн/практик сургалтын хоёр кредит авна.*

**Карьерын стратегийн судалгаа (22010)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл нь янз бүрийн судлах шинжлэх ажлаар ажил мэргэжлүүдийн талаар нарийн судлахаас бүрдэнэ. Сурагчид ажилчдад тавих шаардлагууд, ажилтны мэргэшил, зохион байгуулалтын бүтэц, чанарын хяналтын арга хэмжээ, сонгосон бодлогууд ба зохицуулалтууд, ёс зүйн асуудлууд, ажлын урамшууллын талаар ажиглаж, шинжилж, тайлагнана. Сурагчийн карьерын үнэлгээний дүнгүүд, янз бүрийн боловсролын сонголтуудыг харьцуулж, өөрсдийн академик болон карьертай холбоотой зорилтуудаа гаргаж, авч үзнэ.

**Мужаан I (28519)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Мужаан I нь барилгын салбарын өндөр мэргэжлийн үндэс бөгөөд сонирхолтой бөгөөд их ашигтай карьерыг авчирч болно. Аюулгүй байдалд анхаарч, сурагчид багаж төхөөрөмжийг ашиглах, ирлэх, хэрчих, зүсэх, барилгын математикийг хэрэглэх, блюпринтийг унших, угсралтын суурийг ойлгоно. Сурагчид хананы хүрээ, шал, тааз, дээвэр, хаалга, цонх гэсэн орон сууцны барилгын бүрдэл зүйлсийг сайн таньдаг болно. Сурагчид холбогдох барилгын салбарын OSHA 10 аюулгүй байдлын гэрчилгээ авна.

**Мужааны II (28520)**
**Нэг жил, хоёр кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Мужаан I*

Мужааны II нь оюутнуудыг мужааны болон барилгын менежмент, архитектур гэх мэт холбогдох чиглэлээр мэргэжлээр төгсөхөд бэлтгэдэг. Оюутнууд Мужааны I мэргэжлээр эзэмшсэн Барилгын салбарын OSHA 10 аюулгүй байдлын гэрчилгээгээ нөхөхийн тулд салбарт нийтлэг байдаг гар болон цахилгаан хэрэгслийг аюулгүй ашиглахыг заадаг. Оюутнууд орон сууцны барилгын суурь, хүрээний шал, хана, тааз, дээвэр, ферм, дээврийн материал, шат, гадна хаалга цонх гэх мэт янз бүрийн эд ангиудыг үйлдвэрлэлийн стандартын дагуу угсарч суурилуулах, тэр дундаа бүрэх зэрэг ур чадвартай болно. Нөхцөл байдлын зааварчилгаа, оюутнуудын хамтарсан ажил мэргэжлийн болон техникийн оюутны байгууллагын (CTSO) үйл ажиллагаанд оролцох нь манлайлал, хүмүүстэй харилцах, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болно. Өндөр чанартай ажлын байрны сургалт (HQWBL) нь оюутнуудын карьерын зорилго ба/эсвэл сонирхолтой холбоотой, сургалттай уялдуулан, орон нутгийн бизнес,

байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх туршлага судлах боломжийг олгоно.

*Тайлбар: Ангийн дээд хэмжээ 20 сурагч байна.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Мужааны III (28540)**
**Нэг жил, хоёр кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Мужааны I ба II*

Мужааны III сургалт нь оюутнуудад барилгын ур чадварын талаар гүнзгий мэдлэг, практик туршлага олж авах боломжийг олгодог ахисан түвшний сургалт юм. Оюутнууд барилгын тавцан, үүдний танхим, өөр хүрээ, дотоод засал чимэглэл, хуурай хананы угсралт, өнгөлгөө, эрчим хүчний хэмнэлт, ногоон технологи зэрэг мужааны чиглэлээр мэргэшсэн чиглэлээр суралцдаг. Лицензийн шаардлага, бизнес эрхлэх боломжийг судлахыг онцлон тэмдэглэв. Нөхцөл байдлын зааварчилгаа, оюутнуудын хамтарсан ажил мэргэжлийн болон техникийн оюутны байгууллагын (CTSO) үйл ажиллагаанд оролцох нь манлайлал, хүмүүстэй харилцах, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болно. Өндөр чанартай ажил дээр суурилсан сургалт (HQWBL) нь оюутнуудын карьерын зорилго ба/эсвэл сонирхолтой холбоотой, сургалттай уялдуулан, орон нутгийн бизнес, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх туршлага судлах боломжийг олгоно.

*Тайлбар: Ангийн дээд хэмжээ 20 сурагч байна.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Компьютерын туслалцаатай техникийн зураг (28439) (98439W)**
**Бүтэн жил, нэг мөчлөг, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэхүү механик зургийн анхан шатны хичээлээр график хэлээр үр дүнтэй харилцах ур чадваруудыг танилцуулна. Сурагчид гурван төрлийн график зураглалын арга хэрэглэнэ: гараар чөлөөтэй загварчлах, механик төсөл, компьютерын тусламжтай зураг. Хичээлд техникийн зураг, гараар хар зураг гаргах, үсэглэх техник, зураасны төрлүүд, геометрийн бүтцүүд, олон талаас харуулах зураг, хэмжээ багтаамж гаргах, хэсэгчлэн харуулах, туслах зургууд, компьютерын тусламжтай дизайн багтана. Хичээлийг барилгын худалдаатай холбоотой сурагчдыг багтааж ирээдүйн инженерүүд, архитекторууд, сууц баригчдад тусгайлан зөвлөж байна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Компьютерын туслалцаатай архитекторын зураг (28408) (98408W)**
**Бүтэн жил, нэг мөчлөг, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Компьютерын тусламжтай техникийн зураг (28439) (98439W) эсхүл давхар элсэлт.*
Энэ нь архитектор, барилгын салбарт механик төсөл зураг, компьютерын тусламжтай зургаар дадлагажихад анхаарлаа хандуулах зургийн хичээл юм. Эдгээр баримт бичгүүдэд шалны план зураг, цахилгааны план зураг, ханын хэсгүүд, өндөрсгөл, шавардлага багтана. Сурагчид хэмжээст загвар бэлтгэж, янз бүрийн барилгын материал, тэдгээрийн чанаруудын талаар тайлбарлаж сурна. Хичээл нь орон байр өмчлөгч нарт тустай мэдээллийг өгөх ба нэн ялангуяа ирээдүйн архитектор, барилгын дотоод засал чимэглэлч, гэрээлэгчдэд тустай. Үүнд мөн барилгын худалдааны чадварын хичээлд оролцсон сурагчид багтана. AutoCAD, Revit ашиглан компьютерын тусламжтай загвар гаргах нь энэ хичээлийн нэг хэсэг юм.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Компьютерын туслалцаатай инженерчлэлийн зураг (28438)**
**Бүтэн жил, нэг мөчлөг, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Компьютерын тусламжтай техникийн зураг (28439) (98439W) эсхүл давхар элсэлт.*
Энэ нь инженерчлэл, дизайны салбарт дадлагажихад анхаарсан зургийн хичээл юм. Сурагчид механик төсөл зураг, компьютерын тусламжтай зурах программаар бүрдэл хэсгүүд, дагалдах зүйлсийн дизайныг гаргаж, үйлдвэрлэхэд шаардлагатай ажлын зургуудыг бэлтгэнэ. Эдгээр баримт бичгүүд нь изометр, ортографикийн зургууд болон зургийн загваруудыг багтаана. Сурагчид мөн барилгын материал, тэдгээрийн чанаруудын талаар суралцана. Энэ хичээл ирээдүйн инженерүүдэд чухал программуудыг зааж өгөх ба нэн ялангуяа коллежид орох гэж байгаа STEM-ийн сурагчдад хэрэгтэй. AutoCAD, Inventor ашиглан компьютерын тусламжтай загвар гаргах нь энэ хичээлийн нэг чухал хэсэг юм.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

| |
|---|
| Компьютерын мэдээллийн системийн дараалллууд: 26614 ба эсхүл 26646. |

**Компьютерын мэдээллийн системүүд (26614) (96614W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан нөхцөл: байхгүй*
Сурагчид текст ажилбар, хүснэгт, дата сан, мультимедиа танилцуулга, программ хангамж оролцуулах замаар амьдралд хэрэгтэй асуудал шийдэх чадваруудыг суралцана. Сурагчид компьютерын концепц, операторын систем, сүлжээ, харилцаа холбоо, шинээр гарч ирж буй технологиудын талаар бие даан болон бүлгээр ажиллаж суралцана. Энэ хичээлд ажлын дадлага хийх боломж бий *(сонголтоор).* Сурагчид танхимын хичээлийг хичээлийн жилийн туршид байнга зааварчилгаа авч зөвшөөрөгдсөн ажлын байранд хийх дадлагатай хослуулж болно. Энэ хичээлүүдээр сурагчид карьер, техник мэргэжлийн гэрчилгээтэй төгсөлт болон онлайн хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангаж болно.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

| |
|---|
| Компьютерын мэдээллийн системийн ахисан шатны дараалллууд: 26614 ба эсхүл 26649. |

**Компьютерын мэдээллийн системүүд, ахисан түвшин (26649) (96649W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: МТ-ийн удиртгал, Компьютерын мэдээллийн системүүд эсхүл зааварлагчийн зөвшөөрөл ба/эсхүл өөр Бизнес, мэдээллийн технологийн хичээлтэй давхар.*
Сурагчид ахисан түвшний программ хангамжийн аппликейшнүүдаар, хэвлэл, цахим ба веб нийтлэлүүдээр амьдралд хэрэгтэй чадваруудыг суралцана. Сурагчид ахисан түвшний компьютерын техник үйлчилгээ, веб хуудасны хөгжүүлэлт, програмчлал, сүлжээ, шинээр гарч ирж буй технологи, ажилд ороход хэрэгтэй ур чадваруудын талаар бие даан болон бүлгээр суралцана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Эрүүгийн шүүх I (28702)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 10-11**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчдад эрүүгийн шүүхийн тогтолцооны ажил мэргэжлийн талаар танилцах хуулийн суурь ойлголт, процесс, зарчим, аргачлал, практикийн талаар танилцуулна.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Эрүүгийн шүүх II (28703)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Эрүүгийн шүүх I (28702)*
Сурагчид эрүүгийн шүүхийн тогтолцооны ажил мэргэжилтэй танилцах, АНУ дахь терроризмын түүхийг мэдэж авахын тулд хуулийн суурь ойлголт, процесс, зарчим, практикийн талаар суралцана. Сурагчид ангид хийх хичээл, сургалтыг хичээлийн жилийн турш дахь практик туршлагатай хослуулна.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Мэдээллийн технологийн удиртгал (26116) (96116W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл нь компьютер, сүлжээ, вебд суурилсан аппликейшн, программыг сонирхдог бүх сурагчдад зориулсан чухал суурь юм. Мэдээллийн технологи (IT) эсхүл Кибер аюулгүй байдлын карьерт сонирхолтой, гэрийн компьютер, сүлжээгээ байгуулах буюу компьютер хэрхэн ажилладаг талаар мэдэх хүсэлтэй сурагчид энэ хичээлийг авах хэрэгтэй. Компьютерын гэрийн сүлжээ байгуулах, хувийн ба бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэх компьютерын шийдлүүд нь технологид багтсан. Сурагчид мөн өндөр хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээнд бэлтгэж болно. Эрх бүхий сурагчид хос төгсөлтийн кредит авна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Компьютерын програмчлал ДС (26638) (96638W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Хосолсон төгсөлтөд: Алгебр I-ийг амжилттай дүүргэж, DE Дээд тооны удиртгал-д давхар бүртгүүлсэн ба NOVA-ийн Математикийн Дээд тооны шалгалтад тэнцсэн оноо.*
*Урьдчилсан шаардлага: Хосолсон бус төгсөлтөд: Алгебр I-ийг амжилттай дүүргэх.*
Сурагчид Java ба Python программын хэлийг чөлөөтэй хэрэглэх эсхүл Windows-ийн орчны программыг кодолж, хийхэд сурна. Хичээлийн агуулгад программын дизайн, асуудал шийдэх, удирдлагын бүтэц, ажиллагаа, параметр, пасс, дата бүтэц, өгөгдлийн цуваа, файл боловсруулах багтана. Программын дизайнд илүү анхаарна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Компьютерын програмчлал, эрчимжүүлсэн, (96644W) (26637)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Хосолсон төгсөлтөд: DE Компьютерын програмчлалыг амжилттай дүүргэх ба DE Дээд тооны удиртгал-ыг амжилттай дүүргэх ба NOVA-ийн Математикийн Калкулусын шалгалтад тэнцсэн оноо; DE математикийн калкулуст давхар бүртгүүлэх.*
Энэ хичээлээр асуудал шийдэхийн тулд компьютерын программыг хөгжүүлэхэд анхаарна. Сурагчид ойлгомжтой, тохируулж болох, дахин ашиглаж болох программуудыг бичих боломжийг олгох программын дизайны зарчмуудын талаар суралцана. Сурагчид алгоритм хийх, дүгнэх, янз бүрийн программын хэлийг ашиглаж дата бүтцийн суурийг хөгжүүлж, хэрэглэхийг багтааж компьютерын шинжлэх ухааны бусад чухал концепцүүд болон протоколуудын талаар мөн суралцана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлнэ. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Компьютерын програмчлал, ахисан түвшин (26643) (96643W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Хосолсон төгсөлтөд: DE Компьютерын програмчлал, ахисан түвшинийг амжилттай дүүргэх, Аналитик Геометртэй хамт DE Калкулст давхар бүртгүүлэх*
*Урьдчилсан шаардлага: Хосолсон бус төгсөлтөд: Компьютерын програмчлалыг амжилттай дүүргэх (26638).*
Ахисан түвшний компьютерын програмчлал нь програмчлалын суурь чадвар дээр үндэслэнэ. Ахисан түвшний програмчлалын сурагчид нь тоглоомын аппликейшн, гар утасны аппликейшн, веб аппликейшныг багтааж дата аппликейшн, интерактив мультимедиа аппликейшн хөгжүүлэхэд объектод чиглэсэн програмчлалын концепцууд, I/O хяналтын бүтцүүд, ажиллагаа ба/эсхүл аргачлал, өгөгдлийн товчлол, өгөгдлийн бүтцийг хэрэглэнэ. Хичээлээр сүлжээ, операторын системүүд, дата зохицуулалт, алгоритм, программ хангамжийн инженерчлэлийг багтааж компьютерын сүлжээний архитекторчлал, компьютерын техник хангамжийн ажиллагааны талаар авч үзнэ. Сурагчид мэдээллийн технологи, компьютерын шинжлэх ухааны салбарт боловсрол эзэмших, ажиллах замынхаа талаар судлах явцдаа ажилд орох чадваруудыг хөгжүүлж, карьерт холбогдох янз бүрийн ажиллагаанд оролцоно.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Барилгын технологи (28512)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр сурагчид архитектур, иргэний инженерчлэл, мужаан, цахилгаанчин, сантехникч, судалгаа хийгч, гэрээлэгч, өрлөгч, барилгын ба байгаль орчны менежмент зэрэг ажлуудын бүтэц, холбогдох салбаруудын талаар суралцах болно. Сурагчид загвар бүтэц гаргах, талбайг бэлтгэх, бүтэц болон дэд бүтцийн төслүүдийн дизайныг гаргах, компьютерын программ хангамж болон ийм салбарт хэрэглэх бусад хэрэгслүүдийг хэрэглэх мужааны чадварыг хөгжүүлж, хэрэглэнэ.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Тогтвортой, шинэчлэгдэх технологи (28460)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр дэлхий нийт ба түүний ирээдүйд нөлөөлөх түүхэн, эдийн засгийн, улс төрийн, байгаль орчин, соёлын асуудлуудын талаар сурагчдад танилцуулна. Сурагчид бидний байгаль орчинд нөлөөлж байгаа зүйлсийг авч үзэж, тогтвортой газар тариалан, эрчим хүч хэмнэх барилгын загвар, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд гэсэн шийдлүүдтэй танилцана. Тэд мужааны чадвараа нэмэгдүүлэх явцдаа материалын шинжлэх ухаан, сэргээгдэх эрчим хүчний системүүд, тогтвортой технологиуд, холбогдох салбаруудад анхаарч, загвар бүтэц ба/эсхүл прототипийн тухай сурч, барина. Сурагчид архитектор, архитекторын инженерчлэл, мужаан, цахилгаан, сантехник, халаалт ба агааржуулагч, судалгаа хийх, гэрээний менежмент, өрлөг, барилгын инженерчлэл, барилгын менежмент, байгаль орчны менежмент гэсэн холбогдох ажлуудын талаар судална. Сурагчид загвар бүтэц гаргах, талбайг бэлтгэх, бүтэц болон дэд бүтцийн төслүүдийн дизайныг гаргах, компьютерын программ хангамж болон ийм салбарт хэрэглэх бусад хэрэгслүүдийг хэрэглэх мужааны чадварыг хөгжүүлж, хэрэглэнэ.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Гоо сайхан I (28528)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Гоо сайхан I хичээл нь лицензтэй гоо сайханч болох сонирхолтой сурагчдад зориулагдсан. Сурагчид өнгөрснийг шинжилж, одоо тодорхойлж, гоо сайхан бүхэл үр дүнг гаргаж мэргэжлийн гоо сайхан байх ухаан, урлагийг сурна. Сурагчид мэргэжлийн ёс зүй, бактери судлал, анатоми/физиологи, суурь хими/цахилгаан, үс ба хуйхны бүтэц, үсний дизайны зарчим, шампунь/ангижруулагч, үс тайрах, үсний стиль гаргах, нүүр арчлах, хумс арчлах, хөлийн хумс арчлах талаар суурь мэдлэг олж авна. Хичээл нь сурагчдыг Гоо сайхан II (28529)-т шалгарахад бэлтгэхэд зориулагдсан. Сурагчийн хэрэгцээнд гоо сайхны арчилгааны иж бүрдлийг өгөх буюу тэд өөрсдийн хэрэгслийг худалдаж авч болно (ойролцоогоор $170).

**Гоо сайхан II (28529)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Гоо сайхан I.*

Сурагчид гоо сайхныг шинжлэх ухаан талаас нь суралцаж Гоо сайхан I хичээлийг үзнэ. Сурагчид үс уртасгаж сүлжих, байнгын хиймэл үс, үсэнд долгионтой хими хийх, үсийг химийн аргаар тордох, зөөлөн ороох болон өнгө, арьс арчилгаа, үс авах, нүүр будалт, хумс арчилгаа, хумсны ахисан түвшний техник, гоо сайхны бизнесийн онол, хэрэглээний талаар сурна. Сургалтын хүрээнд салоны жинхэнэ туршлага олж авахын тулд салонд ажиллаж, гоо сайхны шоу үзэж, янз бүрийн төвүүд дээр туршлагатай иргэдтэй хамт ажиллана. Сурагчийн хэрэгцээнд гоо сайхны арчилгааны иж бүрдлийг өгөх буюу тэд өөрсдийн хэрэгслийг худалдаж авч болно (ойролцоогоор $170).

**Гоо сайхан III (28530)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**Ангиуд: 11-12**

*Урьдчилсан шаардлага: Гоо сайхан I.*

Гоо сайхан III хичээл нь Гоо сайхан II хичээлийг амжилттай дүүргэсэн сурагчдад зориулсан ахисан түвшний хичээл юм. Сурагчид мэргэжлийн гоо сайханч болох шинжлэх ухааны сургалтаа үргэлжлүүлнэ. Сурагчид Виржиниа мужийн Үсчин, гоо сайхны зөвлөлийн шалгалтад эрчимтэй бэлтгэж эхлэх замдаа бүх практик ажиллагааны чадвараа дээшлүүлнэ. Үүний дээр, сурагчид бизнесийн туршлага олж авах замдаа сургуулийн салоныг удирдана. Мөн сурагчид салонд дадлагажигчаар ажиллана. Хөтөлбөрийг төгсгөснөөр сурагчид Виржиниагийн гоо сайхны зөвлөлийн шалгалтыг өгөх, шампунийн туслах, стилистийн туслах, жижүүр, худалдааны төлөөлөгч ба/эсхүл мужийн зөвлөлийн судлаачаар ажиллах болно. Энэ хичээлийн хангамжийг сурагчийн хэрэгцээнд тэдний зардлаар гаргана.

- ***Гэрчилгээ:*** *Виржиниагийн үсчин, гоо сайхны зөвлөлийн шалгалт (сурагчид Гоо сайхан I, II, III-ийг дүүргэсний дараа).*

**Хоолны урлаг, шинжлэх ухаан I (28522)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Сурагчид цээжний рентген зураг эсхүл сүрьеэгийн арьсны шинжилгээ өгөх ёстой.*

Энэ хичээлээр сурагчид хүнсний салбарт амжилт авчрах мэдлэг, чадвар, ажлын дадлыг сурч эхэлнэ. Карьерын төвийн гал тогоо, хоолны өрөөг ашиглаж сурагчид аюулгүй байдал, ариун цэврийн суурийн тухай болон мах ногоог тосонд шарах, чанах, шарах шүүгээнд шарах үндсэн арга барилыг сурна. Үүний дээр сурагчид талх жигнэмэг барих, будаа, гоймон, салатыг хэрхэн зохих байдлаар бэлтгэх талаар ойлголттой болно. Сурагчдыг мэргэжилтэй холбогдолтой шийдвэр гаргахад туслах жинхэнэ амьдралын орчинд ажиллуулна.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Хоолны урлаг, шинжлэх ухаан II (28523)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Хоолны урлаг, шинжлэх ухаан I, цээжний рентген зураг эсхүл сүрьеэгийн арьсны сөрөг тест*

Хоолны урлаг, шинжлэх ухаан II нь сурагчдыг дунд сургуулийн дараах боловсрол, хүнсний үйлдвэрт ажилд ороход бэлтгэх эрчимтэй хөтөлбөр юм. Хичээлээр дараахад анхаарна: чанаж бэлтгэх дараалал; мах, загас, ногоог зөв болгох; пицца, талх хийх; бизнесийн үйл ажиллагаа; хүнсний шинжлэх ухаан, хоол хүнс.

Сурагчид жинхэнэ үйлчлүүлэгчид хоол бэлтгэж жинхэнэ гал тогоонд ажиллана. Үүний дээр бүтээгдэхүүний зардал, ашиг, алдагдал, тоог нэмэгдүүлж ашиг олох аргачлал, жижиг бизнес амжилттай удирдахад анхаарч, ахисан түвшний талх нарийн боов жигнэх чадварт сургана. Шалгарсан сурагчид тэтгэлэг авах ба бусад чухал шагнал авах SkillsUSA тэмцээнд орж болно.

Хоолны урлаг, шинжлэх ухаан II нь хүнсний салбарт амжилт олоход шаардлагатай хими, математик, технологийн суурийг багтаана. Сурагчид тоог нэмэгдүүлэх арга, жор; хүлээн авалтын үйлчилгээ; мөн эцсийн бүтээгдэхүүнд нөлөөлөх нөлөөний талаар янз бүрийн чухал (цуу, суурь, ууpaг, тос) орцуудын хослолын талаар суралцана.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Хоолны урлаг III: Талх, жигнэмэг (28524)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**

*Урьдчилсан шаардлага: Хоолны урлаг III-т зэрэг бүртгүүлэх: Хүлээн авалтын үйлчилгээ (28525). Хоолны урлаг, шинжлэх ухаан I (28522), II (28523)*

Жигнэх, жигнэмгийн мэргэшсэн хичээлээр сурагчдад хүнсний үйлдвэрт ажиллах чадвар, мэдлэгийг өгнө. Бодит амьдралын орчинд сурагчид хүнс тэжээлийн зарчмыг хэрэглэж, цэс төлөвлөж, бизнесийн ба математикийн ур чадварыг хэрэглэж, хүнсний үйлчилгээний тоног төхөөрөмжийг арчилж, аюулгүй байдал ба эрүүл мэндийн стандартыг дагаж мөрдөнө.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Хоолны урлаг III: Хүлээн авалтын үйлчилгээ (28525)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**

*Урьдчилсан шаардлага: Хоолны урлаг III-т зэрэг бүртгүүлэх: Талх, жигнэмэг (28524. Хоол хүнсний урлаг, шинжлэх ухаан I (28522), II (28523)*

Хоол хүнсний үйлчилгээ, хүлээн авалтын мэргэшлийн хичээлийн хөтөлбөрөөр сурагчдад хүнсний үйлдвэрлэлийн талаар өргөн хүрээнд ойлгож, хоол хүнсний үйлчилгээнд хэрэглэх техник чадвараа өргөжүүлэх боломжийг олгоно. Сурагчид мэргэжилтэй танилцаж, аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартын чадвараа сайжруулж, хүнс тэжээлийн зарчмыг хэрэглэж, цэс төлөвлөж, бизнесийн бөгөөд математикийн чадвараа ашиглаж, хүнсний үйлчилгээний тоног төхөөрөмжийг арчлах талаар суралцана.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

*Кибер аюулгүй байдлын хичээлүүдэд давхар хичээлийн шаардлага бий.*
Кибер аюулгүй байдал Жил 1: 26659, 26667.
Кибер аюулгүй байдал Жил 2: 26657, 26662.

**Кибер аюулгүй байдал I: Кибер аюулгүй байдлын үндэс**
**(26659) (96659W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Кибер сүлжээний аюулгүй байдалд (26667) (96667W) давхар бүртгүүлэх*

Сурагчдад кибер аюулгүй байдлын зарчмуудыг танилцуулж, тэд шинэ технологийн талаар мэдэж авч, халдлага ба хамгаалах арга хэмжээг шалгаж үзэж, кибер аюулгүй байдлын салбарын өндөр мэргэшлийн, өндөр цалингийн, өндөр хэрэгцээний ажил мэргэжлийн тухай судалж үзнэ. Энэ хичээлээр сурагчдад сүлжээний дизайн, кибер аюулгүй байдлын үйл явц, гэрийн ба бизнесийн сүлжээний процедурын талаар танилцуулна. Сурагчид сүлжээг өргөжүүлэх шинэчлэх стандарт процессыг мөрдөнө. Үүнд шалгах мөрдөх, төслийн менежмент гэсэн шаардлагууд багтана. Суулгах заавар, тохируулгын удирдлага, Windows ба/эсхүл Linux үйлдлийн системийн удирдлагад анхаарч, Linux-ийг сүлжээний үйлчлүүлэгч, ажлын цэг маягаар хэрэглэхэд анхаарна. Энэ хичээлээр сүлжээний техникч, компьютерын техникч, кибер аюулгүй байдлын анхан шатны мэргэжлээр ажиллахад хэрэгтэй сурагчийн чадварыг хөгжүүлнэ. Сүлжээ ашигладаг хэрэгслүүд, гэр ба жижиг бизнесийн орчинд байдаг техник хангамжид холбогдох амьдралд ойр удиртгал хичээлийг өгнө.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Кибер аюулгүй байдлын системүүд (26667) (96667W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**

*Урьдчилсан шаардлага: Кибер аюулгүй байдал I-тэй хамтарч авах: Кибер аюулгүй байдлын үндэс (26659) (96659W).*

Энэ хичээлээр сурагчдад сүлжээний дизайн, кибер аюулгүй байдлын үйл явц, гэрийн ба бизнесийн сүлжээний процедурын талаар танилцуулна. Сурагчид сүлжээг өргөжүүлэх шинэчлэх стандарт процессыг мөрдөнө. Үүнд шалгах мөрдөх, төслийн менежмент гэсэн шаардлагууд багтана. Суулгах заавар, тохируулгын удирдлага, Windows ба/эсхүл Linux үйлдлийн системийн удирдлагад анхаарч, Linux-ийг сүлжээний үйлчлүүлэгч, ажлын цэг маягаар хэрэглэхэд анхаарна. Иймээс сурагчид кибер аюулгүй байдлын мэргэжил ажиллаж эхлэх, сүлжээний админ, сүлжээний техникийн компьютерын техникч, кабел суулгагч, техникийн тусламж үйлчилгээнд ажиллах сурагчийн чадварыг хөгжүүлнэ. Сүлжээ ашигладаг хэрэгслүүд, гэр ба жижиг бизнесийн орчинд байдаг техник хангамжид холбогдох амьдралд ойр удиртгал хичээлийг өгнө. Дадлагад компьютерт программ суулгах, интернэт холболт, утасгүй сүлжээний холболт, файл ба хэвлэмэл зүйлсийг хуваалцах, тоглоомын хянах самбар, скан, дуран суулгах багтана. Үүний дээр сурагчид Микрософт Оффист сайн болж, үүнд цахим мэдлэгийн суурь болох үг, хүснэгт, дата сан, танилцуулах программ хангамжийн чадварууд багтана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын ажиллагаа (26662) (96662W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Кибер аюулгүй байдал II-той хамтарч авах: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа (26657) (96657W).*
Энэ хичээл нь компьютерын дэмжлэг, сүлжээний админд холбогдох олон зүйлсийг заахад зориулагдсан. Сурагчид хэрэглээнээс бүрдлүүд хүртэл компьютерын сүлжээний концепцийг сурч, зэрэгцээ сүлжээний систем ба үйлчлүүлэгчийн серверийн сүлжээг хийнэ. Сурагчид сүлжээний картыг хэрхэн суулгаж, удирдлагыг тохируулах, үйлдлийн системийг суулгахын тулд тэднийг сүлжээнд хэрхэн суулгах; программ хангамжид суурилсан сүлжээний админыг суулгах аккаунтыг бүтээж, суулгаж, удирдах  талаар сурна. Рүүт, зайнаас нэвтрэх, хаяглах, аюулгүй байдал гэсэн үндсэн тоймыг энэ хичээлээр сурагчдад өгнө. Энэ нь мөн сурагчдад э-мэйл үйлчилгээ, веб орон зай, аюулгүй байдал, баталгаажуулах нэвтрэлтийг бий болгох серверүүдтэй танилцуулна. Сурагчид системийн админы харилцааны чадвар ба техник хангамжийн анхан шатны тохируулгын удирдлагын тухай сурна. Сурагчид техник хангамж, программ хангамжийн тохируулгын удирдлагын анхан шатны мэдлэг, кибер аюулгүй байдал, Коллежийн кредитийн тухай заах агуулагдсан.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Кибер аюулгүй байдал II: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа (26657) (96657W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид Кибер аюулгүй байдлын түвшин I хичээлийг дүүргэсэн байх ёстой эсхүл заавварлагчийн зөвшөөрөл ба Кибер аюулгүй байдал II-т давхар элсэх: Кибер аюулгүй байдлын ажиллагаа (26662) (96662W).*
Энэ хичээл нь компьютерын дэмжлэг, сүлжээний админд холбогдох олон зүйлсийг заахад зориулагдсан. Сурагчид хэрэглээнээс бүрдлүүд хүртэл компьютерын сүлжээний концепцийг сурч, зэрэгцээ сүлжээний систем ба үйлчлүүлэгчийн серверийн сүлжээг хийнэ. Сурагчид сүлжээний картыг суулгаж, тохируулгын удирдлагыг хийж, сүлжээнд холбоно. Сурагчид операторын системийг хэрхэн суулгаж, аккаунт үүсгэж, удирдах, программ хангамж ачаалах, аюулгүй байдлын төлөвлөгөөг бий болгож, хэрэгжүүлэх талаар сурна. Энэ хичээл нь Windows Server эсхүл Linux зэрэг программ хангамжид суурилсан сүлжээний операторын системүүдийг багтааж болно.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Кибер аюулгүй байдал III: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа, Ахисан түвшин (26658) (96658W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын ажиллагаа (26662) (96662W);*
*Кибер аюулгүй байдал II: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа (26657) (96657W) ба*
*Кибер аюулгүй байдал III-тай хамтарч авах: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа (26663) (96663W), эсхүл заавварлагчийн зөвшөөрөл.*
Энэ хичээлээр сүлжээний аюулгүй байдлын үндсэн концепцууд, архитектор, протоколыг заана. Сурагчид сүлжээний хэрэглэгч, системүүдийг удирдах, дэмжихэд анхаарч, сүлжээний удирдлагыг сурна. Сурагчид харилцааны протокол, системийн техникийн алдааг арилгах, үйлчлүүлэгчийн сервер сүлжээ, веб хуудасны удирдлага болон бусад ахисан түвшний сүлжээний сэдвүүдийг үзнэ. Багтсан сэдвүүдэд сүлжээний аюулгүй байдлын тойм; криптологи ба түлхүүрлэлтийн суурь; халдлагын загварууд; зөвшөөрөл ба эрх өгөх арга зам, стандартууд; олон нийтийн гол дэд бүтэц; цахим шуудангийн аюулгүй байдал; тээвэрлэлтийн давхарга, вебийн аюулгүй байдал; баглааг шүүх, хамгаалалтын хана, хулгайгаар нэвтрэхийг олох, цахим операторын систем, аккаунт бүтээх, удирдах, программ хангамж

ачаалах, аюулгүй байдлын төлөвлөгөөг бүтээх, хэрэгжүүлэхийг заана. Энэ хичээлээр Windows Server эсхүл Linux зэрэг программ хангамжид суурилсан сүлжээний операторын системүүдийг заана. Хичээлээр салбарын гэрчилгээ авах бэлтгэлд анхаарна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Кибер аюулгүй байдал III: Кибер аюулгүй байдлын программ хангамжийн ажиллагаа, ахисан түвшин (26663) (96663W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Урьдчилсан шаардлага: Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын ажиллагаа (26662) (96662W);*
*Кибер аюулгүй байдал II: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа (26657) (96657W) ба*
*Кибер аюулгүй байдал III-тай хамтарч авах: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа, Ахисан түвшин (26658) (96658W)*
Кибер аюулгүй байдал III хичээлээр сүлжээний удирдлагыг үргэлжлүүлэн сурах ба сүлжээний үйлчлүүлэгч, системийн удирдлага, дэмжлэгт анхаарна. Багтсан сэдвүүдэд компьютерын мэргэжилтнүүдийн хариуцлагыг ойлгох, эцсийн хэрэглэгчийг сургах, шинэ технологийг үнэлэх, системийн бодлогыг боловсруулах, ажлын цэгийг засах, сүлжээний сервер ба протоколыг удирдах, э-мэйл ба бизнесийн харилцааг үр дүнтэй ашиглах багтана. Сурагчид харилцааны протокол, системийн техникийн алдааг арилгах, үйлчлүүлэгчийн сервер сүлжээ, веб хуудасны удирдлага болон бусад ахисан түвшний сүлжээний сэдвүүдийг үзнэ. Операторын системийг суулгахад хэрэглэх арга ажиллагаа, аккаунт үүсгэх, удирдах, программ хангамж суулгах, аюулгүй байдлын төлөвлөгөөг гаргах, хэрэгжүүлэхийг заана. Нэмэлт сэдвүүдэд сүлжээний аюулгүй байдлын тойм; криптологи ба түлхүүрлэлтийн суурь; халдлагын загварууд; зөвшөөрөл ба эрх өгөх арга зам, стандартууд; олон нийтийн гол дэд бүтэц; цахим шуудангийн аюулгүй байдал; тээвэрлэлтийн давхарга, вебийн аюулгүй байдал; баглааг шүүх, хамгаалалтын хана, хулгайгаар нэвтрэхийг олох, цахим операторын систем, аккаунт бүтээх, удирдах, программ хангамж ачаалах, Windows Server эсхүл Linux зэрэг аюулгүй байдлын төлөвлөгөөг бүтээх, хэрэгжүүлэхийг заана. Хичээлээр салбарын гэрчилгээний бэлтгэлд анхаарна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Дата сангийн дизайн, менежмент (26664) (96660W) DE)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги:10-12**
*Урьдчилсан шаардлага: Мэдээллийн технологийн удиртгал (26116)*
Энэ нь дата сангийн дизайн, “Structured Query Language (SQL)”программыг багтаана. Сурагчид дата сангийн хөгжил, загварчлал, дизайн, хэвийн байдлыг багтааж дата сангийн үндсийг сурна. Үүний дээр, дата сан програмчлалыг сурагчдад танилцуулна. Сурагчид өгөгдөл удирдаж, хянаж нэвтрэхэд хэрэглэх дата сангийн программ хангамж, програмчлалыг зүйлсийн мэдлэг, чадварыг эзэмшинэ. Сурагчид эхний хоёр гэрчилгээний шалгалтад бэлтгэнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Дижитал анимац (28457)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: График харилцааны системүүдэд зэрэг бүртгүүлэх (28458)*
Сурагчид график дизайн, дизайны концепцийг ашиглаж компьютерын анимацын туршлагыг олж авна. Сурагчид 3-D объектын манипуляц, түүхийг дэлгэцжүүлэх, текстлэх/маплах, гэрэлтүүлэх концепц, байгаль орчны геометрийг ашиглаж асуудал шийднэ. Сурагчид бодит амьдралын хэрэглээг харуулах янз бүрийн анимацийг бүтээх ба 3-D анимацийн интерактив программ хангамжтай

танилцана. Сурагчийн оригинал ажлыг жишээгээр харуулах портфолио мөн багтана.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Дронууд: Нисгэгчгүй нисэх онгоцны систем (28910)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Оюутнууд Холбооны Нисэхийн Захиргааны (FAA) 107-р хэсгийн удирдамжийн дагуу нисгэгчгүй онгоцоор нисэхэд бэлэн байдаг. Оюутнууд үндэсний агаарын орон зайн систем, FAA дүрэм журам, жижиг дронуудын дизайн, ашиглалтын талаар ерөнхий ойлголттой болно. Оюутнууд цаг агаарыг хянаж, нисгэгчгүй онгоцны ачаалал, гүйцэтгэлийг хянаж, нислэгийн үйл ажиллагааны логистикийг зохицуулдаг. Тэд удирдлагын даалгавруудыг гүйцэтгэж, нисэхийн тулд сургаж, эцэст нь жижиг нисгэгчгүй нисэх онгоцны системийг ашиглан (sUAS) нисдэг. Нөхцөл байдлын зааварчилгаа, оюутнуудын хамтарсан ажил мэргэжлийн болон техникийн оюутны байгууллагын (CTSO) үйл ажиллагаанд оролцох нь манлайлал, хүмүүстэй харилцах, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болно. Өндөр чанартай ажил дээр суурилсан сургалт (HQWBL) нь оюутнуудын ажил мэргэжлийн зорилго ба/эсвэл сонирхолд нийцсэн туршлага судлах боломжийг олгож, зааварчилгаатай нэгтгэж, орон нутгийн бизнес, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

- ***Гэрчилгээ:*** *FAA алсын нисгэгч бага оврын нисгэгчгүй онгоцны системийн гэрчилгээ олгох шалгалт.*

**График харилцааны систем (28458)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Дижитал анимацид давхар бүртгүүлэх (28457)*
График харилцааны систем хичээлээр World Wide Web дээр харуулах компьютер графикийн зургуудыг хийхэд анхаарна. Сурагчид веб график, хэвлэлийн графикийн ялгааны талаар мэдлэгийг олж авна. Ангийн ажлаар сурагчид янз бүрийн зураг хийх программ хангамжийг хэрэглэж сурна. Чанартай зургийг хөгжүүлснээр сурагчид визуал харилцааны ихээхэн хэрэгтэй чадварыг сурна. Энэ чадварын хэрэгцээ вебээр холбогдсон ертөнцөд илүү хэрэгцээтэй болсоор байна. Сурагчид бэлэн болсон ажлаараа мэргэжлийн дижитал портфолио бүтээнэ.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Бага насны хүүхдийн боловсрол I (28235) (98235W)**
**Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Сүрьеэгийн шинжилгээ эсхүл цээжний рентген зураг шаардлагатай.*
Бага насны хүүхдийн боловсрол I хичээлийг хүүхдийн асаргаа ба бага сургуулийн багш болоход бэлтгэх сонирхолтой сурагчдад зориулсан. Сурагчид нялх, мөлхөө, сургуулийн өмнөх, бага сургуулийн, тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах ангийн хичээл үзэж, практик туршлага олж авна. Сурагчид хүүхдийн өсөлт, хөгжлийн тухай суурь зарчмуудыг сурч, бага насны хүүхдийн хөтөлбөр, бага насны хүүхдийн сургалтын хөтөлбөрийн талаар мэдэж авна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу*
- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Бага насны хүүхдийн боловсрол II (28236) (98236W)**
Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо
**Анги: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Бага насны хүүхдийн боловсрол I эсхүл Хүүхдийн хөгжил, эцэг эх байх; сүрьеэгийн шинжилгээ эсхүл цээжний рентген зураг*
Энэ хичээлээр сурагч бага насны хүүхдийг сургах чадвараа үргэлжлүүлэн гүнзгийрүүлнэ. Сурагчид Бага насны хүүхдийн боловсролын салбарын янз бүрийн мэргэжлийн боломжуудын талаар мэдэж авна. Сурагчид практик ажил, сурагч багшийн туршлагаар Бага насны хүүхдийн сургалтын хөтөлбөрийн янз бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Сурагчид багшийн туслах буюу багшийн туслах болох ParaPro үнэлгээг хийх ёстой.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Бага насны хүүхдийн боловсрол I, II-ийг дүүргэх нь сурагчид Бага насны хүүхдийн хөгжлийн холбооны (CDA) Үндэсний гэрчилгээг авахад тусална.*

**Цахилгаан I (28534)**
**Бүтэн жил, нэг мөчлөг, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Цахилгаан I нь сурагчид орон сууцны барилгад ажиллах цахилгаанчны чадварыг хөгжүүлнэ. Сурагчдад нийтлэг цахилгааны багаж хэрэгслийг ашиглах, цахилгаан утас тавих аргачлал, цахилгаан хагас дамжуулагч, цахилгаан төлөвлөгөөг унших, цахилгааны асуудлыг шийдвэрлэх талаар заана. Сурагчдад худалдааны шинэ барилгын, харилцаа холбооны цахилгаан шугамын талаар танилцуулна. Танилцуулгыг Үндэсний цахилгааны хуульд тулгуурлана. Хичээлийг практик байдлаар ихэвчлэн заана. Аюулгүй байдал, ажлын сайн дадлыг онцгой анхаарна.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Цахилгаан II (28535)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Цахилгаан I*
Цахилгаан II хичээлээр утасны кабел, кабелийн телевизийн кабел, BICSI/RBT системийн зэсэд суурилсан Сүлжээний кабел, Шилэн кабелийг багтааж худалдааны барилга, харилцаа холбооны кабелийг тавих хичээлийг заана. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн (OSHA) захиргааны ажлыг мөн санал болгоно. Төгсөх ангийн сурагчид цахилгаан түгээлтийн салбарт ажиллаж сурах хөтөлбөрт оролцох эрхтэй байж магадгүй. Үндэсний цахилгааны хуулийн стандартын дагуу худалдааны кабел тавихыг заана. Сүлжээний кабел тавихыг BICSI/RBT системийн стандартын дагуу заах ба TIA/EIA 568A стандартыг хангана. Сурагчид харилцаа холбооны кабелийн стандарт, кабел тавих арга, техник, сүлжээ ба кабелийн түүх, нэр томьёог сурна. Сүлжээний кабелийн хичээлийг бүгдийг нь дүүргэсэн, муж улс, нутаг, багшийн шаардлагыг хангасан сурагчид BICSI/RBT гэрчилгээний шалгалт өгөх боломжтой болох ба энэ нь улс даяар хүлээн зөвшөөрөгдсөн харилцаа холбооны гэрчилгээ юм.

- ***Гэрчилгээ:*** *OSHA-10 Барилгын аюулгүй байдлын карт; BICSI/RBT Системийн зэст суурилсан сүлжээний кабел ба шилэн кабелийн системийн гэрчилгээ (зөвхөн англи хэлэнд өгнө).*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Цахилгаан III (28537)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Цахилгаан I болон II*
Оюутнууд практик туршлагаараа цахилгаан системийг суурилуулах, ашиглах, засвар үйлчилгээ хийх, үйлдвэрлэлийн чиглэлээр ашиглах ур чадварыг үргэлжлүүлэн хөгжүүлдэг. Тэд мөн гэрэлтүүлэгч, хэт гүйдлийн хамгаалалт, үйлчилгээний тоног төхөөрөмж, моторын удирдлага, трансформатор, газардуулга, Үндэсний цахилгааны код (NEC) зэргийг судалдаг. Нөхцөл байдлын зааварчилгаа, оюутнуудын хамтарсан ажил мэргэжлийн болон техникийн оюутны байгууллагын (CTSO) үйл ажиллагаанд оролцох нь манлайлал, хүмүүстэй харилцах, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болно. Өндөр чанартай ажил дээр суурилсан сургалт (HQWBL) нь оюутнуудын карьерын зорилго ба/эсвэл сонирхолтой холбоотой, сургалттай уялдуулан, орон нутгийн бизнес, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх туршлага судлах боломжийг олгоно.

*Тайлбар: Ангийн дээд хэмжээ 20 сурагч байна.*

- ***Гэрчилгээ:*** *Оюутны сонгосон баталгаажсан кредитийг тухайн хичээлтэй холбоотой салбарын гэрчилгээ, NCCER-ийн цахилгааны нэгдүгээр түвшний элсэлтийн түвшний үнэлгээ эсвэл бусад курсийн улсын батлагдсан гэрчилгээг давснаар авах боломжтой.*

**Эмнэлгийн анхны тусламжийн техникч I (28334) (98334W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Эмнэлгийн анхны тусламжийн техникч II (28335) (983359)-той хамт. Биологи (24310) ба сурагчид Виржиниагийн Эрүүл мэндийн газар, Эмнэлгийн анхны тусламжийн үйлчилгээний хэсгийн EMT хөтөлбөрт оролцох эрхийн шаардлага, үүний дотор хичээлийг эхлэхэд 16 нас хүрсэн байх; 18 наснаас доош настай бол эцэг эхийн зөвшөөрөл; Арлингтоны Улсын Сургуулиас тодорхойлсны дагуу англи хэлээр унших, бичих, ярих, ойлгох өндөр түвшинд хүрсэн байх ёстой.*

Энэ нь Үндэсний хурдын замын тээврийн аюулгүй байдлын агентлаг/АНУ-ын Тээврийн газар 1994 Эмнэлгийн яаралтай тусламжийн техникчийн үндэсний суурь стандартын хичээлийн хөтөлбөрийн дагуу заах (EMT-B) коллежийн түвшний хөтөлбөр юм. Энэ хичээл нь эрүүл мэндийн салбар эсхүл Анхны тусламжийн гэрчилгээ шаардлагатай аль нэг салбарт сонирхолтой сурагчид хамгийн сайн тохирсон. Сурагчид анатоми, физиологи сурч, анхны тусламжийн үйлчилгээ, амьсгалуулах тусламж, өвчтөнд үнэлгээ хийх, эмнэлгийн яаралтай тусламж, эх барих/эмэгтэйчүүдийн яаралтай тусламж, шокт орсон өвчтөнд туслах, хүүхдийн түргэн тусламж, түргэн тусламжийн машин дотор хагалгааны талаар сурна. Сурагчид мөн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч, анхны тусламж үзүүлэгчийн Америкийн Зүрхний холбооны анхан шатны тусламжийн хичээлийг дүүргэнэ. Сурагчид мөн эмнэлгийн түргэн тусламжийн тасаг эсхүл түргэн тусламжийн машин дотор тусалж, ажиглах боломж олгоно.

- ***Ахлах сургуулийн нэмэлт кредит:*** *Энэ хичээлээр авсан кредит нь стандарт дипломын гуравдугаар байгалийн шинжлэлийн лабораторийн кредит буюу ахисан түвшний дипломын дөрөвдүгээр лабораторийн кредитийн шаардлагыг хангана. Сурагчид лабораторийн байгалийн ухаанд нэг кредит, нарийн/практик хичээлд хоёр дахь кредитийг авна.*

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу. Энэ нь сурагчид George Washington University-ийн анагаахын бакалаврын хөтөлбөрт хямдруулсан зардалтайгаар автоматаар элсэх EMS-ийн AAS төгсөлтийн замыг олгоно.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Эмнэлгийн анхны тусламжийн техникч II (28335) (98335W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Эмнэлгийн анхны тусламжийн техникч I-тэй зэрэг*

Энэ хичээлийн даалгаврууд нь Үндэсний болон Виржиниагийн эмнэлгийн анхны тусламжийн үйлчилгээний (EMS) боловсролын стандартын дагуу байна. Сурагчид EMS-ийн үйл ажиллагаа, эмнэлгийн түргэн тусламж, онцгой өвчтөнүүдийн бүлгийн зохицуулалт гэсэн зүйлд анхаарч түргэн тусламжийн мэдлэг, чадвараа дээшлүүлнэ. Хичээлээс гадуурх цагаар хамгийн багадаа 10 өвчтөнтэй харилцах дадлагад сурагчид оролцох шаардлагатай. Энэ хичээлийг дараалаар нь дүүргэсэн бол CTE-ийн төгсөгчийн статус авна. Хичээлийн бүх шаардлагуудыг амжилттай хангаж, багшаас зөвлөмж авсан бол Виржиниа мужийн физиомотор шалгалт, Түргэн тусламжийн техникчийн үндэсний бүртгэлийн онолын шалгалтад (NREMT) орох эрхтэй болж болно. Сурагчид Анхны тусламж үзүүлэгчийн “Functional Position Description” шаардлагыг хангах ёстой (Виржиниагийн хууль, EMS.TR.14B, 12VAC5-31-1501-г үзнэ үү.). Виржиниагийн хуулийн, 12VAC5-31-1501-ийн дагуу сурагчид хамгийн багадаа 85 хувийн онол, лабораторийн хичээлийг дүүргэх ёстой.

ТАЙЛБАР: Сурагчид EMT-ийн анхны хичээлд суухаас өмнө 16 нас хүрсэн байх ёстой. Бүх сурагчид хурууны хээ болон мансууруулах бодисын шинжилгээгээр эрүүгийн гэмт хэрэгт холбогдох шалгалтад орсон байх ёстой.

- ***Ахлах сургуулийн нэмэлт кредит:*** **А** *Энэ хичээлээр авсан кредит нь стандарт дипломын гуравдугаар байгалийн шинжлэлийн лабораторийн кредит буюу ахисан түвшний дипломын дөрөвдүгээр лабораторийн кредитийн шаардлагыг хангана. Сурагчид лабораторийн байгалийн ухаанд нэг кредит, нарийн/практик хичээлд хоёр дахь кредитийг авна.*

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу. Энэ нь сурагчид George Washington University-ийн анагаахын бакалаврын хөтөлбөрт хямдруулсан зардалтайгаар автоматаар элсэх EMS-ийн AAS төгсөлтийн замыг олгоно.*
- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Эмнэлгийн анхны тусламжийн техникч III (28336) (98335W)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Эмнэлгийн анхны тусламжийн техникч II*

Энэ хичээлийг Эмнэлгийн анхны тусламжийн (EMT) I, II хичээлийг дүүргэсэн бөгөөд Виржиниагийн Эмнэлгийн анхны тусламжийн газрын (OEMS) EMT-ийн гэрчилгээ авах сурагчдад зориулсан. Сурагчид ахисан түвшний анхны тусламж үзүүлдэг болохын хувьд анхан шатны хичээлд сурсан чадвараа бэхжүүлж, анхны тусламжийн эмнэлгийн үйлчилгээний (EMS) боловсролын суурийг тавьж, гэрчилгээ авах ба дахин гэрчилгээ авах боловсролын шаардлагыг хангана. Сурагчид мөн бусад гал, хууль цагдаа, түргэн тусламжийн удирдлагын бүх нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үйлчилгээтэй харилцаж сурна. Хичээл нь ментортой болон хичээлийн журмаар орно. Сурагчид хамгийн багадаа 85 хувийн онол, лабораторийн хичээлийг дүүргэх ёстой.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Эрчим хүч (26448)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*

Энэ хичээлээр сурагчид эрчим хүчний эх үүсвэрийн талаар судалж, цахилгаан үүсгэгч, дамжуулагч, түгээгчийн талаар Эрчим хүчний ажилчдын боловсролын төвийн Эрчим хүчний салбарын үндэс гэсэн хичээлийг ашиглаж сурна. Энэ хичээл нь амьдралд ойр дадлагаар математик, шинжлэх ухаан, техникийн бичгийн боловсролыг өгнө. Сурагчид эрчим хүчний үйлдвэрлэлийн суурь гэрчилгээг авах шалгалтыг өгөх боломжтой болно.

## Төсөлд суурилсан манлайллын зам [Project Lead the Way ] (PLTW)

*"Project Lead the Way" нь инженерчлэлд холбогдох чиг баримжаа авах хүлээн зөвшөөрөгдсөн хичээлийн цуврал бөгөөд сурагчдыг коллежийн инженерийн хөтөлбөрт амжилттай суралцахад бэлтгэнэ. Энэ хөтөлбөрт орж ирж байгаа сурагчид математикийн ба байгалийн шинжлэлийн коллежид бэлтгэх цуврал хичээлд бүртгүүлсэн байх ёстой.*

**Инженерчлэл I: Инженерчлэлийн дизайны удиртгал (28491)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*

Инженерчлэл I-ээр инженерийн загварт анхаарна. Сурагчид төслийн шийдлүүдийг хийж, эдгээрт дүн шинжилгээ, үнэлгээ хийх компьютерын программ хангамж ашиглана. Тэд хэлбэр, зориулалтын дизайн концепцийг сурч, хамгийн сүүлийн үеийн технологийн дизайны концепцийг үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болгож хэрэгжүүлэхэд ашиглана. Энэ хичээлээр сурагчдад дизайн хийх үйл явцыг ойлгож, хэрэглэх, загвар хөгжүүлэхдээ өөрчлөгдөх дизайны концепцийг хэрэглэх, хатуу загвар гаргах компьютерын дизайны программ хангамжийг ашиглаж бүтээгдэхүүний загварыг хөгжүүлж, бүтээж, дүн шинжилгээ хийх замаар дизайны шийдэл гаргахыг заана.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Инженерчлэл II: Инженерчлэлийн зарчмууд (28492)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Инженерчлэл I*

Энэ хичээл инженерийн технологийн талаар тойм өгнө. Сурагчид бодит амьдралын инженерчлэлийн асуудлыг шийдвэрлэж, асуудал шийдэх чадвар эзэмшинэ. Онол сурч, практик туршлага олсноор сурагчид технологийн өөрчлөлтөөс гарч ирэх нийгэм, улс төрийн үр дагавруудыг авч үзнэ. Судлах зарим зүйлд инженерчлэлийн өнцгөөс харах, дизайны үйл явц, харилцаа ба баримтжуулалт, инженерчлэлийн системүүд, статик, материал ба материалыг шалгах, термодинамик багтана.

- ***Гэрчилгээ: Сурагчийн сонгосон*** *баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Дижитал электроник (26671)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Инженерчлэл: Удиртгал I-ээс Инженерчлэл (28491), Инженерчлэл II: Инженерчлэлийн зарчмууд (28492)*

Энэ инженерчлэлийн өмнөх хичээл нь үндэсний инженерчлэлийн хөтөлбөрийн (Инженерчлэлийн зарчмууд, Инженерийн дизайн) хоёр үндсэн хичээлээс бүрдэнэ. Сурагчид дизайн гаргаж, шалгаж, дамжуулагч, төхөөрөмжийг бүтээхдээ электрониксын логикийн сурахад компьютерын

загвар ашиглана. Тэд хяналтын системийн програмчлалыг хэрэглэж, хэлхээний дараалллын логик, цахим хэлхээний үндсийг сурна. Компьютерын хэлхээний тухай танилцуулна_

| |
|---|
| Инженерчлэл II шат: 28493, 28494. Хоёр хичээлд зэрэг бүртгүүлсэн байх ёстой. |

**Компьютерыг багтаасан үйлдвэрлэлийн инженерчлэл (28493)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Инженерчлэл II (28492)*
Энэ мэргэшсэн хичээлээр сурагчид компьютерын загварчлалын программ хангамжаар 3-D дизайн бүтээж, өөрсдийн дизайны компьютерын хяналттай загварын боловсруулах замаар роботын ба автомат үйлдвэрлэлийн концепцийг заалгах болно.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Инженерчлэлийн оргил: Дизайн, хөгжүүлэлт (28494)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Инженерчлэл II (28492), II (28492)*
Энэхүү төгсөх хичээлээр нутгийн менторуудын зааварчилгааг авах сурагчдын багууд судалгаа хийх, дизайн гаргах, инженерчлэлийн асуудлуудын шийдлүүдийг гаргах болно. Сурагчид инженерчлэлийн амьдралын жишээгээр мэдлэг, чадвар, чадамжуудаа хэрэглэнэ. Сурагчид бие даасан судалгааны төсөл болон багт чиглэсэн төслийг хөгжүүлж, албан ёсоор танилцуулах шаардлагатай ба эдгээрийг зөвлөл үнэлнэ.

**Биотехнологи хэрэглэх шинжилгээний технологи (28325)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Биологи (24310)*
Нэн ялангуяа биотехнологийг хамруулсан задлан шинжилгээний салбарт ажил мэргэжил хийх зорилттой сурагчдад Биотехнологийг хэрэглэх шинжилгээний технологийн хичээл зориулагдсан. Коллежийн түвшний материалтай тул их хүнд хичээл. Сурагчид эрүүгийн гэмт хэрэг гарсан газарт хэрхэн ажиллах, ДНХ-ийн шинжилгээг хэрхэн хийх, шилэнд буй сорьцод шинжилгээ хийх, цус цацагдсан байдалд шинжилгээ хийх, хэргийн талаар ярилцах семинарт оролцох талаар сурна. Сурагчдаас лабораторийн стандарт ажиллагааг мөрдөх, бүх шинжилгээнд шинжлэх ухааныг аргачлал хэрэглэхийг шаардана. Сурагчид энтомологи, остеологи, антропологи, задлан шинжилгээний ургамал судлал, хордолтын шинжилгээ, ДНХ шинжилгээ гэсэн янз бүрийн техникийн сурна. Энэ хичээлийг байгалийн шинжлэлд сайн сурагчдад зөвлөж байна.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Эрүүл мэндийн шинжлэх ухаан (28303)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээлээр сурагчдад эрүүл мэндийн салбарт ажил мэргэжил эзэмшихтэй холбоотой танилцуулга өгч, бүх эрүүл мэнд, анагаахын шинжлэх ухаанд шаардлагатай суур чадварыг хөгжүүлнэ. Энэ нь АНУ-ын эрүүл мэндийн системийг ойлгоход тусалж, биеийн эрүүл мэнд, анатоми, физиологи, патологи, шинжлэл ба эмнэлгийн үйл явц, эмчилгээ, сэтгэлийн цочрол ба эрүүл мэндийн яаралтай тусламжийн сууръ нэр томьёог сурагчдад заахад зориулагдсан. Хичээлийн явцад эрүүл мэндийн үйлчилгээний аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйжүүлэлт, мэргэжлийн байдал, хариуцлага, үр бүтээмжтэй байх талаар анхаарч заана. Сурагчид эрүүл мэнд, анагаахын салбарт ажил хайх чадваруудыг суралцаж эхэлнэ. Үүний дээр анагаахын лабораторийн үйл явц, эмзүйн суурь, биотехнологийн концепц, чанартай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай харилцааны чадварыг хичээлд багтаана.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Эмнэлгийн технологи (28383) (98383W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
Урьдчилсан шаардлага: *Байхгүй*
Анагаахын нэр томьёо хичээл нь сурагчдад эрүүл мэндийн үйлчилгээний хэлийг сургахад зориулагдсан. Сэдвүүд нь логик дараалалтай ба хүний биеийн анатоми, физиологиос эхэлж, патологи, шинжилгээ хийх үйл явц, эмчилгээ, эцэст нь эмзүйн шинжлэх ухаанаар үргэлжилж, дуусна. Сурагчид сэдэл тус бүрд концепц, нэр томьёо, товчлолыг сурна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө*

*биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Материал, процессын технологи (28433)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид хэрэглэж болох бүтээгдэхүүн үйлдвэрлэж, туршилт хийх явцдаа материал, процесст анхаарлаа хандуулна. Сургалтад ажил мэргэжлийн талаар дүгнэж шинжлэх болон металл, хуванцар, мод, шавар, нийлмэл материалын шинжилгээ, туршилт, ажиллагаанд холбогдох багаж хэрэгсэл, төхөөрөмжийг хэрэглэж сурна. Нэг цагийн лабораторийн хичээлийг техникийн салбар ажил мэргэжил эзэмших хүсэлтэй болон өөрсдийн хэрэгдэгчийн мэдлэг, технологийн суурь мэдлэгээ сайжруулах гэж байгаа сурагчдад зөвлөж байна.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Эмийн сангийн техникч (28305)**
**Нэг жил, хоёр кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэхүү гэрчилгээтэй хөтөлбөрийг эмийн сангийн техникчээр ажиллаж эхлэх суурь чадвар, мэдлэгтэй сурагчдад зориулсан. Хичээлийн ажил нь Эмийн сангийн зөвлөлийн шаардлагыг хангах ба сурагчдыг нэг бол улсын шалгалт эсхүл Эмийн сангийн техникчийн гэрчилгээний зөвлөлөөс удирддаг үндэсний шалгалтад бэлтгэнэ. Зохих чадвар, мэдлэгтэй дадлагажиж, туршлагажсан эмийн сангийн техникчид дунд сургуулиа төгсөөд эмийн салбарт олон янзын сонирхолтой, хүндэтгэл хүлээсэн мэргэжлийн сонголтуудтай байх болно.

- ***Гэрчилгээ:*** *Эмийн сангийн техникчийн гэрчилгээний эмийн сангийн шалгалт (ExCPT)*

| |
|---|
| Гэрэл зураг, дүрс бичлэгийн технологийн хичээлийн дараалал: 28625, 28626. Хоёр хичээлд зэрэг бүртгүүлсэн байх ёстой. |

**Гэрэл зураг, дүрс бичлэгийн технологи I (28625)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Гэрэл зураг, дүрс бичлэгийн технологи II (28626) хичээлд давхар бүртгүүлэх*
Гэрэл зургийн технологийн хичээлээр сурагчдад гэрэл зургийн суурь зарчмуудыг танилцуулахын зэрэгцээ дижитал зурагт илүү анхаарах болно. Сурагчид гэрэл зургийг харилцааны хэрэгсэл болохынх нь хувьд суралцаж, дижитал салбар дахь аажим өөрчлөлтийн талаар мэдэж авна. Сурагчид зураг боловсруулах программ хангамжийг дижитал зургийг өөрчлөхөд хэрэглэж сурна.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Гэрэл зураг, дүрс бичлэгийн технологи II (28626)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Гэрэл зураг, дүрс бичлэгийн технологи I (28625) хичээлд давхар бүртгүүлэх*
Энэ хичээлээр сурагчдад дүрс бичлэг ба медиа продакшныг бүхий л талаас нь амьдралд ойр суралцах боломжийг сурагчдад олгоно. Сурагчид продакшны дараах бүх үйл явцад концепц гаргаж, төлөвлөж, хувь нэмрээ оруулна: продакшнд бэлтгэх, продакшн, продакшны дараах ажил. Үүний дээр мэдээлэл цуглуулах, бичлэг хийх янз бүрийн аргуудаар дадлагажиж, янз бүрийн дүрс бичлэг, медиа продакшн хийхийн тулд шинэ агуулга бүтээж, студи ажиллагааны программ хангамж, видео ба аудио тоног төхөөрөмжийг ажиллуулна.

**Физик/Хөдөлмөрийн эмчилгээ I (28340) (98340W)**
**Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ курс нь физик, хөдөлмөрийн эмчилгээний мэргэжлүүдийн талаарх танилцуулга юм. Оюутнууд эрүүл мэндийн салбарын эмч нарын зарчим, практикийг судалж, лицензтэй физик ба/эсвэл мэргэжлийн эмчийн шууд удирдлага дор эмнэлзүйн ажиглалтад оролцдог. Физик эмчилгээ, хөдөлмөрийн эмчилгээний чиглэлээр эмнэлзүйн ур чадвар нь оюутнуудад нөхөн сэргээх эмчилгээний талаар ойлголттой болох боломжийг олгодог бөгөөд энэ нь тусламж үйлчилгээний тасралтгүй болон хувь хүний амьдралын туршид хийгддэг. Энэхүү сургалтыг амжилттай дүүргэсний дараа оюутнууд физик эмчилгээ, хөдөлмөрийн эмчилгээ, ярианы эмчилгээ, спортын анагаах ухаан, биеийн тамирын дасгал, хиропрактикийн анагаах ухаан, биологи, дасгалын шинжлэх ухаан гэх мэт төрөл бүрийн чиглэлээр тодорхой зэрэг / лиценз авахаар дээд боловсрол эзэмших боломжтой. Нөхцөл байдлын зааварчилгаа, оюутнуудын хамтарсан ажил мэргэжлийн болон техникийн оюутны байгууллагын (CTSO) үйл ажиллагаанд оролцох нь манлайлал, хүмүүстэй харилцах, ажил мэргэжлийн

ур чадварыг хөгжүүлэх болно. Өндөр чанартай ажил дээр суурилсан сургалт (HQWBL) нь оюутнуудын ажил мэргэжлийн зорилго ба/эсвэл сонирхолд нийцсэн туршлага судлах боломжийг олгож, зааварчилгаатай нэгтгэж, орон нутгийн бизнес, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Физик/Хөдөлмөрийн эмчилгээ II (28341) (98341)**
**Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Физик/хөдөлмөрийн эмчилгээ I*
Энэхүү сургалт нь кинезиологи, анатомийн талаарх үндсэн ойлголтыг эмнэлзүйн үүднээс авч үзэх, физик/хөдөлмөрийн эмч нарын үздэг нийтлэг эмгэгийн анатомийн үндэслэлийг багтаах зорилготой юм. Сургалтыг практик үйл ажиллагааны лаборатори, практик туршлагаар бэхжүүлдэг. Оюутнууд P/OT I ангид сурсан эмчилгээний эмч нарын зарчим, практикийг үргэлжлүүлэн судалж, лицензтэй физик ба/эсвэл мэргэжлийн эмчийн шууд удирдлага дор эмнэлзүйн ажиглалтад оролцдог. Физик эмчилгээ, хөдөлмөрийн эмчилгээний чиглэлээр эмнэлзүйн ур чадвар нь оюутнуудад нөхөн сэргээх эмчилгээний талаар ойлголттой болох боломжийг олгодог бөгөөд энэ нь тусламж үйлчилгээний тасралтгүй болон хувь хүний амьдралын туршид хийгддэг. Энэхүү сургалтыг амжилттай дүүргэсний дараа оюутнууд физик эмчилгээ, хөдөлмөрийн эмчилгээ, ярианы эмчилгээ, спортын анагаах ухаан, биеийн тамирын дасгал, хиропрактикийн анагаах ухаан, биологи, дасгалын шинжлэх ухаан гэх мэт төрөл бүрийн чиглэлээр тодорхой зэрэг / лиценз авахаар дээд боловсрол эзэмших боломжтой. Нөхцөл байдлын зааварчилгаа, оюутнуудын хамтарсан ажил мэргэжлийн болон техникийн оюутны байгууллагын (CTSO) үйл ажиллагаанд оролцох нь манлайлал, хүмүүстэй харилцах, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болно. Өндөр чанартай ажил дээр суурилсан сургалт (HQWBL) нь оюутнуудын ажил мэргэжлийн зорилго ба/эсвэл сонирхолд нийцсэн туршлага судлах боломжийг олгож, зааварчилгаатай нэгтгэж, орон нутгийн бизнес, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Роботын дизайн (28421)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Сурагчид компьютер, бичил процессор болон тэдгээрийг үйлдвэрлэл, тээвэрлэлт болон харилцаа холбооны системд хэрэглэх хэрэглээний талаар судална. Хамрах сэдвүүдэд компьютер төхөөрөмж болон үйлдлийн систем, робот, програмчлал, удирдлагын систем болон тэдгээр технологиудын нийгэм/ соёлд үзүүлэх нөлөөлөл хамаарна. Асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанууд сурагчдад дизайн гаргах, програмчлах болон интерфейс төхөөрөмжүүдийг компьютер системүүдтэй холбогдох сорилт болно. Сургалтын үйл ажиллагаанд робот, компьютерын тусламжтай үйлдвэрлэл болон дизайн, цахилгаан механик төхөөрөмжүүдийг удирдах зэрэг нь багтана. Сурагчид Роботын ба автомат технологийн шалгалт, Ажлын байранд бэлэн болсонд холбогдох шалгалт хоёрыг өгөх замаар гэрчилгээ авах эрхтэй болно.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Спортын анагаах ухаан/Хөнгөн атлетикийн сургалт (28350)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Спортын анагаах ухаан/Атлетик бэлтгэл II ангид нэгэн зэрэг элссэн.*
Энэ курст оюутнууд Анхны тусламж/CPR/AED-ийн гэрчилгээ авдаг. Уг хичээлээр хүний анатоми ба физиологи, хоол тэжээл, биомеханик, эмнэлгийн нэр томьёо, осол гэмтэл, өвчин эмгэг, спортын анагаах ухааны эрх зүй, ёс зүйн асуудал зэрэг сэдвүүдээр оюутнуудыг танилцуулна. Оюутнууд спортын анагаах ухааны чиглэлээр ирээдүйн карьераа шалгадаг. Энэхүү сургалтыг амжилттай дүүргэсний дараа оюутнууд Спортын Анагаах Ухааны II-д хамрагдаж, хувийн дасгалжуулагчийн гэрчилгээ авах эрхтэй. Нөхцөл байдлын зааварчилгаа, оюутнуудын хамтарсан ажил мэргэжлийн болон техникийн оюутны байгууллагын (CTSO) үйл ажиллагаанд оролцох нь манлайлал, хүмүүстэй харилцах, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болно. Өндөр чанартай ажил дээр суурилсан сургалт (HQWBL) нь оюутнуудын ажил мэргэжлийн зорилго ба/эсвэл

сонирхолд нийцсэн туршлага судлах боломжийг олгож, зааварчилгаатай нэгтгэж, орон нутгийн бизнес, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Спортын анагаах ухаан/Хөнгөн атлетикийн сургалт. II (28351)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Спортын анагаах ухаан/Тамирчны бэлтгэл I ангид нэгэн зэрэг элссэн.*
Энэхүү сургалтыг амжилттай дүүргэсний дараа оюутнууд Үндэсний Спортын Анагаах Ухааны Академийн Мэргэшсэн Хувийн Дасгалжуулагчийн (NASM-CPT) шалгалт өгөх эрхтэй болно. Энэхүү сургалт нь биеийн тамирын дасгалын физиологи, биомеханик, дасгалын хөтөлбөрийн загвар, гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх, үнэлэх, эмчлэх, удирдах зэрэг сэдвээр Спортын анагаах ухаан I-ийн үндсэн мэдлэг дээр суурилдаг. Оюутнууд дадлага хийх зэрэг спортын анагаах ухааны чиглэлээр мэргэжлээр бэлтгэдэг. Нөхцөл байдлын зааварчилгаа, оюутнуудын хамтарсан ажил мэргэжлийн болон техникийн оюутны байгууллагын (CTSO) үйл ажиллагаанд оролцох нь манлайлал, хүмүүстэй харилцах, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх болно. Өндөр чанартай ажил дээр суурилсан сургалт (HQWBL) нь оюутнуудын ажил мэргэжлийн зорилго ба/эсвэл сонирхолд нийцсэн туршлага судлах боломжийг олгож, зааварчилгаатай нэгтгэж, орон нутгийн бизнес, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

| |
|---|
| Жижиг амьтны асаргаа хичээлийн дараалал: 28062, 28063. Хоёр хичээлд зэрэг бүртгүүлсэн байх ёстой. |

**Жижиг амьтныг арчлах I (28062)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Биологи (24310) ба Жижиг амьтныг асрах II (28063)*
Жижиг амьтныг асрах I хичээл нь малын эмч зэргийг багтааж амьтантай холбоотой ажил мэргэжилд амжилт гаргах практик чадваруудыг сурагчдыг дунд сургуулийн дараах боловсролд бэлтгэх онолын сургалтуудтай хослуулна. Сурагчид жижиг ахуйн амьтадад анхаарна. Тэдгээртэй харьцах, тэжээл өгөх, арчлах, самнах нь өдөр тутмын ажил байна. Сурагчид янз бүрийн лабораторийн амьтдын харьцаа, дасгалжуулалтын тухай сурна. Сурагчид Америкийн Улаан Загалмайн шугамаар муур, нохойд анхны тусламж өгөх гэрчилгээ авна. Сурагчид нохой, муур, туулай, хулгана, харх, үлийн цагаан оготныг багтааж амьтны шинжилгээний газарт буй олон янзын жижиг амьтадтай харилцана. Энэхүү хөтөлбөрт холбогдсон нутгийн амьтны бизнесүүдийн хүчтэй холбоогоор дамжуулж сурагчид дадлага хийх боломжтой болно.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Жижиг амьтныг арчлах II (28063)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Биологи I- Жижиг амьтныг асрах I (28062) хичээлд зэрэг бүртгүүлэх*
Сурагчид харьцуулсан анатоми, өвчнөөс урьдчилан сэргийлэх, паразит судлал, ген судлал, үржил гэснийг багтааж амьтны шинжлэх ухаан, амьтан асрах мэдлэгээ дээшлүүлнэ. Сурагчид урт сүүлтэй тоть, какаду тоть, могой, гүрвэл, яст мэлхий, мэлхий, загас, үет хөлтөн зэрэг жижиг, сонин амьтадтай харьцахад анхаарлаа төвлөрүүлнэ. Малын эмчийн туслахын техникийн ур чадварыг мөн зааж өгч, дадлагажуулна. Сурагчид Амьтны менежментийн дадлага 2, “State University New York” - “Jefferson Community College”-ийн Зоо паркийн технологийн Хэрэглээний шинжлэх ухааны төгсөлтөд чиглэсэн ZOO 276-ийн 3 кредитийг авч болно.

- ***Ахлах сургуулийн нэмэлт кредит:*** ***A*** *Энэ хичээлээр авсан кредит нь стандарт дипломын гуравдугаар байгалийн шинжлэлийн лабораторийн кредит буюу ахисан түвшиний дипломын дөрөвдүгээр лабораторийн кредитийн шаардлагыг хангана. Байгалийн шинжлэлийн кредитээс гадна сурагчид нарийн/практик сургалтын хоёр кредит авна. Энэ хичээл нь стандарт дипломын хичээлийн дараалалд багтана.*
- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

| |
|---|
| Мал эмнэлгийн шинжлэх ухааны хичээлийн дараалал: 28064, 628061. Хоёр хичээлд зэрэг бүртгүүлсэн байх ёстой. |

**Мал эмнэлгийн шинжлэх ухаан I (28064)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Биологи (24310), Мал эмнэлгийн шинжлэх ухаан II (28061) хичээлд давхар бүртгүүлэх*
Сурагчид амьтны эрүүл мэнд, хоол тэжээл, менежмент, нөхөн үржихүй, үнэлгээ гэсэн сэдвүүдэд анхаарч, жижиг амьтныг хэрхэн арчлах, менежмент хийх талаар сурна. Хичээлийн агуулгад жижиг амьтныг асрахад ашиглах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрны талаар хичээл болон манлайллыг хөгжүүлэх үйл ажиллагаа багтана.

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Мал эмнэлгийн шинжлэх ухаан II (28061)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Биологи (24310), Мал эмнэлгийн шинжлэх ухаан I (28064) хичээлд давхар бүртгүүлэх*
Мал эмнэлгийн шинжлэх ухаан хичээлээр дунд сургуулийн дараах боловсролд амжилт гаргах болон Мал эмнэлгийн салбар болон холбоотой мэргэжлээр ажил мэргэжилтэй болоход сурагчдад туслах техникийн мэдлэг, чадварыг олгоно. Сурагчид Амьтан шинжлэлийн төвд байгаа олон янзын гэрийн тэжээвэр болон содон амьтадтай ажиллах болно. Хичээлийн агуулгад академик мэдлэг, ажил мэргэжлийн чадварыг хөгжүүлэх болон бизнесийн менежмент, мал эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, байр хэрэгслийг хэрэглэх зэрэг тусгайлсан мэдлэг, чадварыг заах багтана. Хөтөлбөр нь амьтантай холбоотой бизнесүүдтэй хүчтэй холбогдсон тул манлайллын чадвараа нэмэгдүүлэх, дадлагад оролцох боломжийг олгоно. Энэ хичээлд бүртгүүлсэн сурагчид математик, байгалийн шинжлэлд сайн байх ёстой ба жижиг амьтадтай харьцаж мэддэг байх ёстой. Сурагчид Амьтны менежментийн дадлага 2, “State University New York” - “Jefferson Community College”-ийн Зоо паркийн технологийн Хэрэглээний шинжлэх ухааны төгсөлтөд чиглэсэн ZOO 276-ийн 3 кредитийг авч болно.

- ***Ахлах сургуулийн нэмэлт кредит:*** *Энэ хичээлээр авсан кредит нь стандарт дипломын гуравдугаар байгалийн шинжлэлийн лабораторийн кредит буюу ахисан түвшний дипломын дөрөвдүгээр лабораторийн кредитийн шаардлагыг хангана. Байгалийн шинжлэлийн кредитээс гадна сурагчид нарийн/практик сургалтын хоёр кредит авна. Энэ хичээл нь тохируулсан стандарт дипломын хичээлийн дараалалд багтана.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Телевизийн продакшн I (28689) (98689W**
**Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Телевизийн продакшн I хичээл нь дижитал медиа продакшны онол, дадлагыг хамарна. Сурагчид Виржиниад байдаг хамгийн сайн төвийн нэг болох Карьерын төвийн Дижитал медиа продакшн дээрх практик төслүүдээр ур чадвараа хөгжүүлнэ. Продакшны ажлууд нь телевиз, радио, интернэт гэсэн салбаруудад байх ба бүх нийтэд үйлчлэх зарлал (PSAs), хөгжмийн видео, жижиг алтернатив кинонууд, радиогийн нэвтрүүлгүүд, веб хуудаснууд, анимац багтана. Телевизийн продакшны сурагчид уралдааны шалгаруулалтын янз бүрийн боломжууд болон энэ хичээлээр хийсэн ажлаар нутгийн, муж улсын төдийгүй үндэсний шагналуудыг авах нь нийтлэг байдаг. Сурагчид оригинал бүтээл хийхэд бие даан, бүлгээр ажиллах ба бүтээлээ хичээлийн төгсгөлд мэргэжлийн дижитал портфолио болгож авч үлдэнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Телевиз, мультимедиа продакшн II (28690) (98690W) DE)**
**Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Телевиз I эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*
Телевиз, мультимедиа продакшн II бол сурагчдыг мэргэжлийн медиа бүтээгчийн мэргэжилд бэлтгэх эрчимтэй, практик хичээл юм. Хичээл нь продакшн компанийн загвараар явагдаж, сурагчдад Карьерын төвийн гайхалтай Дижитал медиа продакшн студи дээр уран бүтээл хийх олон боломжийг өгнө. Төслүүдийг уралдаан тэмцээн, үйлчлүүлэгч, олон нийтэд зориулж хийнэ. Сурагчид богино кино, баримтат кино зэрэг бие даасан төслүүдийг

хэрэгжүүлэх боломжтой байна. Эдгээр төслүүд нь сурагчдад медиа продакшн бизнесийн тухай заагаад зогсохгүй бусад үеийн нөхдөөсөө ялгарах мэргэжлийн портфолиотой болоход нь тусална. Шагнал, дадлага, тэтгэлэг, амжилттай дээд боловсролын болон мэргэжлийн зам гэсэн давуу талуудад хүргэнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

**Телевиз, мультимедиа продакшн III (28691) (98691)**
**Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Телевиз, мультимедиа продакшн II*
Сурагчид медиа продакшны өндөр мэддэг, чадварыг харуулна. Тэд медиа продюсер шиг ажиллаж, зорилтод үзэгчдэд зориулсан хөтөлбөрийг боловсруулж, сурталчлахын зэрэгцээ оригинал бүтээл хийнэ. Сурагчид дунд сургуулийн дараах болон ажил мэргэжлийн зорилтоо ахиулах дижитал мэргэжлийн портфолиог бий болгоно. Тэд хөгжил хөдөлгөөнтэй медиа продакшн салбарын тухай судалж, (дадлага, ажил, дагалдагч зэрэг) жинхэнэ амьдралын боломжуудын тухай олж мэднэ. Сурагчид дунд сургуулийн дараах боломжуудыг судалж, коллеж болон ажил мэргэжлийн амжилтын стратегиа боловсруулна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу*

- ***Гэрчилгээ:*** *Сурагчийн сонгосон баталгаажсан кредитийг хичээлд холбогдох үйлдвэрлэлийн дадлагын гэрчилгээг авснаар хангаж болно.*

## НЭМЭЛТ "СТЕ" БУС ХИЧЭЭЛҮҮД АРЛИНГТОНЫ КАРЬЕРЫН ТӨВД

**Анатоми/Физиологи I, хосолсон төгсөлт (28085) (98085W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги:10-12**
*Урьдчилсан шаардлага): Биологи (24310)*
Энэ хичээл нь хүний биеийн бүтцийг танилцуулах хичээл бөгөөд эрүүл мэнд, анагаахын мэргэжилд сонирхолтой сурагчдад зориулагдсан. Хичээлээр биеийн бүтэц, эсийн ажиллагаа, эрхтэн, эрхтний системийн түвшнийг үзэх ба хичээлийн туршид ердийн биеийн анатоми, физиологид анхаарна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Дээд тооны удиртгал, хос төгсөлт (93162W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: VPT-д шалгарах оноо (бүх 9 бүлэгт тэнцэх, Алгебр II хүртэлх агуулга)*
NOVA MTH 161-аар коллежийн алгебр, матриц болон алгебрын, илтгэгчийн, логарифмын функцүүдийг танилцуулна. NOVA MTH 162-аар тригонометр, аналитик геометр, эрэмбэ ба бүлгийг танилцуулна. Хичээлээр сурагчийг MTH 263/264 Дээд тоо I/II-т бэлтгэнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Дээд тооны удиртгал, хос төгсөлт (93176W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 11-12**
*Урьдчилсан шаардлага: MTH 163 эсхүл MTH 164 эсхүл Алгебрын хоёр бүлэг, Геометрийн нэг бүлэг бөгөөд Тригонометр ба Дээд тооны удиртгал тус бүрд нэг хагас бүлэг*
Хязгаар, уламжлал, дифференциалыг багтааж алгебрын болон хийсвэр функцүүдийн аналитик геометрийг болон интеграцийг хэрэглээнийх нь хамт танилцуулна. Математик, физик, инженерийн шинжлэх ухааны хөтөлбөрт зориулсан.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Дээд тоо, хос төгсөлт I/II (93179W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Дээд тооны удиртгал, хос төгсөлт (93162W) эсхүл Дээд тооны удиртгал/Тригонометр (23162) эсхүл Дээд тооны удиртгал, эрчимжүүлсэн (23164) – C буюу дээш дүн*
Хязгаар, уламжлал, янз бүрийн төрлийн функцийн дифференциал, дифференциалын дүрмийг хэрэглэх, дифференциалыг хэрэглэх, антидифференциал коэффициент, интеграл, интеграцийн хэрэглээг танилцуулна. Үүний дээр сурагчид гурвалжин, туйл, параметрийн график, хязгааргүй ба хязгаартай интеграл, интеграцийн аргачлал, векторын үүрэг, эзлэхүүн, дараалал, хүчний цуваа ба хэрэглэгдэхүүн зэргийг багтааж алгебрын тооцоолол, хийсвэр функцүүдийг сурах болно. Үндсэн теоремын нотолгоонд мөн анхаарна. Математик, физик, инженерийн шинжлэх ухааны хөтөлбөрийн хичээлийг танилцуулна.

***Коллежийн кредит:** Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Аналитик геометртэй хамт дээд тоо, хос төгсөлт (93173W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Precalculus дээр "C" эсвэл илүү, Intensified эсвэл "C" эсвэл NOVA MTH 161/162 дээр "B" эсвэл Precalculus дээр илүү сайн.*
Энэ хичээлээр хязгаар, уламжлал, дифференциалыг багтааж алгебрын болон хийсвэр функцүүдийн аналитик геометр болон тооцоолол, мөн интеграцийг хэрэглээнийх нь хамт танилцуулна. Математик, физик, инженерийн шинжлэх ухааны хөтөлбөрт зориулсан.

- ***Коллежийн кредит:** Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Эдийн засаг, хосолсон төгсөлт (92801W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид NOVA-д элсэх шаардлагыг хангах ёстой*
Хичээлээр коллежийн кредит өгөх ба коллежийн нэгдүгээр курсийн эдийн засгийн удиртгал хичээлтэй дүйцнэ. Энэ хичээлд бүртгүүлсэн сурагчид эдийн засгийн системд хэрэглэдэг эдийн засгийн зарчмуудыг сайтар ойлгоход анхаарсан Макро эдийн засгийн хичээлийг нэг улиралд авна. Үүний дээр сурагчид Микро эдийн засгийн хичээлийг нэг улирал авах ба үүгээр эдийн засгийн системд хэрэглэгч, үйлдвэрлэгч хоёул тодорхой шийдвэр гаргахад холбогдох эдийн засгийн зарчмуудад анхаарна. *Энэ хичээлийг амжилттай дүүргэснээр сурагчдын Эдийн засаг, хувийн санхүүгийн төгсөлтийн шаардлагыг хангана.*

- ***Коллежийн кредит:** Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Ерөнхий биологи, хосолсон төгсөлт (94310W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Биологи, Хими*
Энэ хичээлээр эсийн бүтэц, метаболизм, ген, амьдралын олон талт байдал, организмын анатоми ба физиологи, экосистемийн зохион байгуулалт, эволюцын үйл явцын контекстийг багтааж биологийн концепцуудын гүнзгийрүүлж заана. Хичээлээр тоон дата цуглуулах, шинжлэх ажил бүхий лабораторийн ажлыг онцолж үзнэ.

- ***Коллежийн кредит:** Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Коллежийн ерөнхий физик I, хосолсон төгсөлт (94501W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Дээд тооны удиртгал, DE (93162W) & ENG 111-д хангалттай оноо авсан байх*
Физикийн үндсийг заана. Термодинамик, долгионы үзэгдэл, цахилгаан, оптик, татах хүч, орчин үеийн физикийн сонгосон сэдвүүдийг багтаана. II-ийн Хэсэг I.

- ***Коллежийн кредит:** Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Коллежийн ерөнхий физик II, хосолсон төгсөлт (94502W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Коллежийн ерөнхий физик I, хосолсон төгсөлт (94501W)*
Физикийн үндсийг заана. Термодинамик, долгионы үзэгдэл, цахилгаан, оптик, татах хүч, орчин үеийн физикийн сонгосон сэдвүүдийг багтаана. II-ийн Хэсэг II.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Байгал орчны ерөнхий шинжлэх ухаан, хосолсон төгсөлт (94270W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Биологи, Хими*
Удиртгал хичээлээр дэлхийн байгаль орчны тогтолцоог бүрдүүлэх суурь бүрдэл зүйлс ба харилцаанд голчлон анхаарна. Хичээлээр байгаль орчны асуудлыг ойлгох, тодорхойлоход зайлшгүй шаардлагатай биологи, хими, дэлхий судлалын суур шинжлэх ухааны концепцуудыг багтаана.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Дунд шатны Испани хэл I/II, хосолсон төгсөлт (95501W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Испани хэл IV-ийг амжилттай дүүргэсэн эсхүл багшийн тодорхойлсноор үүнтэй ижил түвшинтэй ба коллежийн түвшний хурдтай хичээлд бүртгүүлэхэд бэлэн*
Сурагчид одоо болж буй үйл явдлуудын талаар хэлэлцэж, уран зохиолын бүтээлийг сурч, шинжилж эх материалыг ойлгоно. Тэд холбогдох хэлний соёл, түүх, уран зохиолын сонгосон сэдвүүдийг илүү нарийвчилж уншиж, бичиж, ярилцах ба үгчилж ойлгохоос илүүгээр ойлгох чадвараа өргөжүүлнэ. Хичээлээр Испани хэлний ертөнцийн бүтээл, дадлыг бий болгогч харах өнцгийг шинжилж соёлын талаас нь багтаана. Энэ хичээл нь ACTFL (American Council on the Teaching of Foreign Languages [Америкийн Гадаад хэлний сургалтын зөвлөл])-ийн хэлний түвшний журамд заасан дунд төвшнөөс дээш түвшинд хүрч Испани хэлээ сайжруулахад зориулагдсан.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлнэ. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Латин V давхар элсэлт (95350W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Латин IV хэлээр B ба түүнээс дээш зэрэгтэй, багшийн зөвлөмж.*
Оюутнууд Ромын зохиолчдын жинхэнэ эшлэлүүдийг уншиж, хэлний бүтэц, үгсийн санг контекстээр нь авч үздэг. Үгийн сонголт, синтакс, зүйрлэлээр дамжуулан ойлгох, стилистикийн арга барилд дүн шинжилгээ хийх, зохиогчийн санаа зорилгыг тайлбарлахад анхаарлаа хандуулдаг. Латин шүлгийг тоолуураар чангаар уншиж, тухайн хэсгийн сэтгэлийн байдалд тоолуурын нөлөөг судлах болно. Оюутнууд эшлэл судлал болон томоохон сэдвүүдийн хоорондох холболтыг бий болгодог, үүнд: эртний түүх, газарзүй; Ромын өдөр тутмын амьдрал, соёл; болон латин хэлнээс гаралтай орчин үеийн үгс.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Статистик I/II, хосолсон төгсөлт (93163W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Холбогдох түвшин тогтоох шалгалт буюу MTH152 эсхүл MTH163 эсхүл MTH182-д хангалттай оноо авсан*
Тодорхойлох статистик, энгийн магадлал, магадлалын хуваарилалт, таамаг, гипотезийг шалгахын багтаана. Таамаглал, гипотезыг шалгахыг үргэлжлүүлэх ба харилцан хамаарал, уналт, хувилбарын анализад илүү анхаарна. “Chi-square” тест, параметрийн бус аргачлалууд.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Маргаашийн багш нар II, хосолсон төгсөлт (29063) (99063W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Маргаашийн багш нар I (99062W)*
Сурагчид Боловсрол, сургалтын салбарын мэргэжлүүдтэй танилцахаа үргэлжлүүлнэ. Сурагчид дунд сургуулийн дараа юу хийх талаар судлах явцдаа боловсролын салбарт ажил мэргэжил эзэмшихэд бэлтгэх боломжийг хичээлээр тэдэнд олгож, Виржиниад багшийн гэрчилгээ авах үйл явцыг зааж, дадлага хийх боломж олгоно.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Виржиниа, АНУ-ын түүх, хосолсон төгсөлт (92360W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид NOVA-д элсэх шаардлагыг хангах ёстой*
Энэ хичээлээр Виржиниагийн болон АНУ-ын эртний үеэс эхлээд өнөөг хүртэлх түүхийг ерөнхийд нь үзэх ба сурагчдад Нэгдсэн Улсын түүхийг ерөнхий шинж байдлаар ойлгох боломжийг олгоно. Сурагчид Виржиниа болон Нэгдсэн улсын хөгжлийг эрт дээр үеэс тодорхойлж ирсэн улс төр, эдийн засаг, нийгэм, оюуны, соёлын, шашны чухал өөрчлөлтүүдийн тухай сурна. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

## ДАДЛАГЫН ХӨТӨЛБӨР

**PRIME (Мэргэжилтэй холбоотой дадлага, менторын туршлага [Professional Related Intern-Mentorship Experience]) (29060)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид 16 нас хүрсэн байх ёстой ба өөрөө зорчиж очих боломжтой байх ёстой.*
PRIME бол авьяастны үйлчилгээнд хамрагдсан ба/эсхүл дараагийн шатанд үргэлжлүүлэн сурна гэсэн хүлээлттэйгээр ядаж нэг CTE ангийг дүүргэсэн сурагчдад зориулсан дадлагын хөтөлбөр юм. Энэ нь сурагчдын сонирхолд тохирох чиглэлээр мэргэжлийн дадлага хийх боломжийг бий болгох зорилготой. Сурагчид зуны цагт 140 цагийг зааж өгсөн ментортой хамт ажиллаж, кредит авна. Илүү мэдээлэл ба маягтыг авах бол Карьерын төвтэй холбогдоно уу.

**Сургуулиас ажлын талбар дахь шилжилт/Дадлага (29828)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: 16 нас хүрсэн байх; Карьерын төвийн CTE хөтөлбөрийг (бүтэн хөтөлбөр) "C" буюу дээш дүнтэй дүүргэх; үүний дээр, CTE чадварын багшийн бичгээр өгсөн зөвлөмж*
Энэ хичээл нь Карьер, техникийн боловсролын (CTE) хөтөлбөрийн шатуудыг дүүргэсэн, өөрийн мэргэжлийн сонголттой холбоотой ажил хийж өөрийн боловсрол, чадварыг дээшлүүлэхийг хүсэж байгаа эсхүл өөрсдийн сонгосон салбарт илүү өндөр мэргэшил эзэмшихээр дадлага сургалтаа үргэлжлүүлэх гэж байгаа сурагчдад зориулагдсан. Сурагчдад дадлагад холбогдож CTE багш ба дадлагын зохицуулагчид туслалцаа үзүүлнэ. Сурагчид хоёр кредит авахын тулд дадлагын газарт 280 цаг байх ёстой. Сурагчид дадлагын зааварлагчаар улирал тутамд хоёр удаа үнэлүүлж, улирлын дүнгээ авна.

## АКАДЕМИК ХӨТӨЛБӨР

***Арлингтоны карьерын төвийн Арлингтон тех***
**9-12-р анги**
"Arlington Tech" нь төсөлд суурилсан эрчимжүүлэх сургалтын хөтөлбөр ба сурагчдыг коллеж, ажлын байранд бусадтай хамтран ажиллахад бэлтгэдэг. Сурагчид өөрсдийн хичээл сурлагын мэдлэгийг Карьер, техникийн боловсролоор [Career Technical Education (CTE)] хөгжүүлэх чадвартай хослуулж, бодит амьдралын асуудлыг шийдэж, нутаг усандаа үйлчилгээ үзүүлэх талаар суралцана.

*Тайлбар: Алгебр I /Геометр, хавсарсан блок – Энэ блокийг Arlington Tech-д санал болгоно. Хичээл орох үед Алгебр I-ийг дүүргээгүй байсан сурагчид Алгебр I /Геометр, хавсарсан блокт бүртгүүлэх боломжтой байна. Энэ блок нь Алгебр I ба Геометрийг нэг жилийн хичээлээр хослуулах ба баталгаажсан төгсөлтийн кредит авахаар Алгебр*

*I-ийг авч байгаа сурагчид тохирох ба төгсөлтийн 2 стандарт кредиттэй.*

Arlington Tech нь сурагчдад олон төрлийн CTE хөтөлбөрт гэрчилгээ авах, Northern Virginia Community College-ийн давхар кредиттэй сургалтад хамрагдаж Коллежийн эхэн үеийн кредит авч коллежийг товчлох боломжийг олгоно. Төсөлд суурилсан цогц сургалт болохын хувьд Arlington Tech-ийн сурагчид нэг жилийн турш үргэлжлэх төгсөх ангийн сурагчийн ажил хийх ба үүний хүрээнд тэд дадлагажигч, зөвлөх, хараат бус судлаачаар ажиллана. Arlington Tech-д суралцана гэдэг нь идэвхтэй (судалж, асууж), бодитой (тодорхой төслүүдээр), сурагчийн өөрийн сонирхлыг дагасан байна гэсэн үг юм.

**Arlington Tech Оргил туршлага (28955)**
**Бүтэн жил, танхимын хичээлээр 1 кредит ба ажлын дадлагаар олж авах янз бүрийн нэмэлт кредитүүд***
**Ангиуд: 12.**
*Урьдчилсан шаардлага: Сурагчийн өөрийн сонирхож буй мэргэжлийн карьер, техникийн (CTE) өмнөх сургалт, ажлын байранд шилжихэд бэлэн болсныг батлах чадварууд Сурагч нь 12-р ангид бүртгүүлсэн байх ёстой*
**Кредит: Хичээлийн жилд ажлын дадлагын 1-3 кредит, ажлын цагийн баримтад тулгуурлана (1 кредит=280 цаг, 2 кредит=560 цаг, 3 кредит=840 цаг) Зуны цагт авсан аливаа цагийг ирэх намрын хичээлийн жилд оруулж тооцно.*

“Arlington Tech Capstone Experience” бол “Arlington Tech”-ийн сурагчдын олон салбарыг нэгтгэсэн төсөлд суурилсан сурах ба ажил мэргэжлийн хөгжлийн нэгтгэл, оргил юм. “Capstone Experience” нь сурагчдад Карьер, техникийн боловсролын (CTE) хичээлүүдээр сурсан өөрсдийн техникийн мэдлэг, судалгааны чадвараа бизнес ба үйлдвэрлэлийн жинхэнэ ертөнцөд хэрэглэж, ахиулах гарц замыг олгодог. Сурагчид “Capstone Experience”-ийг нэг буюу гурван замаар дүүргэж болно.

1. Сурагчийн мэргэжлийн замд нь ач холбогдолтой цалинтай ба цалингүй ажлын байрны (ажил олгогчийн ажлын газарт) дадлагын хэлбэрээр (ажилласан цагаас хамаарч 1-3 кредит)

2. Бүтээгдэхүүн гаргах буюу асуудал шийдэх замаар үйлчилгээ үзүүлэх төслийн менежер/зөвлөх (ажлын байр дээр эсхүл сургууль дээр ажиллах) хэлбэрээр

3. Их сургууль, засгийн газар, ашгийн төлөө бус байгууллагад судалгааны туслах (ажлын байр дээр эсхүл сургууль дээр ажиллах) хэлбэрээр

“Capstone Experience” нь сонгосон мэргэжлийн чиглэлээрээ, эсхүл сонирхсон салбартаа үргэлжлүүлэн судалгаа хийх сурагчийн мэдлэг, чадварыг үргэлжлүүлэн хөгжүүлнэ. Сурагчид “Capstone”-ий зохицуулагчийн тусламжтайгаар 11-р ангидаа “Capstone”-д оролцохоо баталгаажуулах хариуцлагыг үүрнэ. Ажилд суурилсан сургалтын төлөвлөгөөг сурагч, Capstone-ий зохицуулагч, ажлын байрны ментор нар боловсруулах ба энэ нь сурагчийн ажилд суурилсан дадлагын хөтөч болж, үр дүн, ажлыг үнэлэхэд тусална. Capstone-ий зохицуулагч ба сурагчийн ментор нь сурагчийн ажилд суурилсан дадлагад дэмжлэг үзүүлж, 12-р ангийн жилд сурагчийн дадлагын үр дүн, ажлыг үнэлнэ. Сурагч Capstone Experience хичээлд бүртгүүлбэл эцэг эх, асран хамгаалагч, ажлын байрны ментор, сурагч, APS-ийн ажилтнууд харилцан ойлголцлын баримт бичигт гарын үсэг зурж, сурагч Capstone Experience-ий бүх ажиллагаанд оролцох эрхтэй гэсэн хуульзүйн зөвшөөрлийг өгнө. Capstone Experience-ий ажлын байранд орохын тулд сурагч хичээлийн жилийн төгсгөлд нэг эсхүл хоёр ажлын чөлөөний цагтай байхыг зөвлөж байна. Энэ нь Arlington Tech-ийн сурагчдын хувьд заавал биелүүлэх шаардлага байна.

**Академик Академи**
**Анги: 9-12**
*Урьдчилсан шаардлага: Академик Академид орох зөвшөөрлийг Академик Академийн зохицуулагч өгнө.*
Академик Академи нь сурагч төвтэй тусгайлсан дэмжлэгийг өгөхийн тулд цогц ахлах сургуулиас ялгаатай хөтөлбөр юм. 9-р ангиас эхлээд 12-р ангийн сурагчдад үйлчилгээ үзүүлнэ.

Хөтөлбөрийг цөөн тооны сурагчтай анги, багш/сурагчийн тооны харьцаа бага, багш тусгайлан дааж авч чиглүүлэх, бүтцийг тодорхойлсон хичээл хэлбэрээр гаргасан. Сургалтын хөтөлбөр нь англи хэл, математик, нийгэм судлал, байгалийн шинжлэл байна. Академик хичээлээс гадна сурагчид Карьерын төв дээрх Карьер, техникийн боловсролын (CTE) олон тооны сонгох хичээлээс сонгож бүртгүүлж болно. Академи нь хөтөлбөрт тэсвэртэй байх чадвар, нийгмийн харилцаа сэтгэл санааны өсөлтөд анхаарсан цогц зөвлөгөө багтсан. Сурагчид Академид таван цагийн хугацаанд сууж болох ба цогц ахлах сургуульдаа нэмэлт хоёр хичээл авахаар

буцаж очиж эсхүл хичээлийн бүх цагаа Карьерын төв дээр өнгөрүүлэхээр шийдэж болно.
Академик Академи нь Арлингтоны Карьерын төвд байрлана. Хаяг: 816 South Walter Reed Drive, Arlington, Virginia. Хөтөлбөрийн зохицуулагчтай 703-228-5790 утсаар холбогдож болно.

**Англи хэл суралцагчдын нийгэмлэг**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Англи хэл суралцагсдын нийгэмлэг [the English Learner Community (ELC)]-т Хөтөлбөрийн зохицуулагч зөвшөөрч оруулна.*
ELC нь ахлах насны (16-21 насны) англи хэл суралцагчдад (EL) зориулсан бөгөөд тэд жижиг бүлгийн, тохируулсан академик орчинд суралцах давуу талыг олж авах ба энэ нь карьер ба техникийн боловсролтой холбоотой. ELC-д сонгогдсон сурагчид унших, бичих, дүрмийн хоёр цагийн хэлний хичээлд бүртгүүлнэ. Тэд мөн математик, байгалийн шинжлэл, нийгмийн ухааны нэмэлт гурван кредитийг авна. Эцэст нь сурагчид Карьерын төв дээр Карьер, техникийн боловсролын (CTE) хоёр цаг сонгох хичээлд бүртгүүлнэ. Хөтөлбөрт оролцогч сурагчид өөрийн сонгосон мэргэжлийн салбарт гэрчилгээ буюу лиценз авах ба/эсхүл өөрийн техникийн хичээлдээ коллежийн кредит авахын зэрэгцээ ахлах сургуулийн дипломын авахын тулд суралцах давуу талыг эдэлнэ.

**Манлайллын оргил (28956)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Аль CTE-ийн хичээлтэй зэрэг бүртгүүлж болно.*
Ажилд суурилсан сургалтын хөтөлбөр [Work Based Learning Capstone (WBLC)] нь сурагчийн өөрийн сонирхсон мэргэжлийнхээ салбарт авах хичээл юм. Энэ хичээлээр сурагчид Карьер, техникийн боловсролын (CTE) сонгох хичээлүүдээр сурсан өөрсдийн мэдлэг, техникийн чадвар, манлайлал, ажлын байранд бэлтгэгдсэн байх чадвараа бизнес ба үйлдвэрлэлийн жинхэнэ ертөнцөд хэрэглэнэ. Сурагчид өөрийн сонирхож, сонгосон мэргэжлийн салбарт хичээлийн хөтөлбөрт заасан хамгийн багадаа хоёр карьер, техникийн боловсролын (CTE) хичээл авсан байх шаардлагатай.

“WBL Capstone” нь сонгосон мэргэжлийн чиглэлээр, эсхүл үргэлжлүүлэн сурах сонирхолтой салбарт сурагчийн мэдлэг, чадварыг үргэлжлүүлэн хөгжүүлнэ. Ажилд суурилсан сургалтын төлөвлөгөөг сурагч, багш, ажлын байрны ментор нар боловсруулах ба энэ нь сурагчийн ажилд суурилсан дадлагын хөтөч болж, үр дүн, ажлыг үнэлэхэд тусална. Ажилд суурилсан сургалтын (WBL) хэд хэдэн загварууд бий: кредит олгох нэгдэл хоршоо “co-op” (“ангийн хичээл давхар авах ба ажлын байран дээр хийх дадлага”), ба кредит авахгүй үйлчилгээнд суурилсан сургалт, дадлага, ба сургууль дээрх компани (бизнесийн хөтөлбөр). Сурагч өөрт тохирох WBL-ийг тодорхойлохын тулд WBL-ийн зохицуулагч багштай харилцана. Сурагчид эцэг эх буюу асран хамгаалагчийн зөвшөөрөл шаардлагатай. WBL-ийн ажлын байранд орохын тулд сурагч хичээлийн жилийн төгсгөлд нэг эсхүл хоёр WBL-ийн чөлөөний цагтай байхыг зөвлөж байна.

## АЖИЛ ЭРХЛЭЛТЭД БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР (PEP)

**Бүтэн жил, бүтэн өдрийн хөтөлбөр; 6-8 кредит**
**Анги: 12 ба төгссөний дараа**
*Урьдчилсан шаардлага:* **Хөтөлбөрт оролцох үйл явц ахлах сургуулийн шилжилтийн зохицуулагчтай холбогдож эхэлнэ.** Хувь хүнд тохируулсан боловсролын хөтөлбөр [Individual Education Program (IEP)]-т одоо байхаас гадна PEP сурагчид нь гэрээр сургуулийн боловсрол авахаа дуусгах дөхөж байх ёстой; өөрийгөө бие даан авч явах буюу ажилтнаас зарим нэг л тусламж авч өөрийгөө авч явах чадвартай байх; нийтийн унаагаар бие даан эсвэл бага зэрэг дасгал хийсний дараа бага зэрэг тусламжтайгаар зорчих чадвартай; ажлын дадлагын орчинд бие даан эсхүл зарим нэг тусламжтайгаар ажиллах боломжтой байх ёстой. Сурагчид Карьерын төвийн ангийн хичээлд бие даан эсхүл бага зэрэг тусламжтайгаар суух чадвартай бол CTE-ийн хичээлүүдэд бүртгүүлж болно. PEP хөтөлбөр нь оффисын технологи, цалинтай ба цалингүй дадлага болон мэргэжлийн боловсролын мэдлэгийг өгөх ба хувийн санхүү болон Карьерын төв, нийгэмд бусадтай харилцах чадварыг санал болгоно. Сурагч бүрийн хэрэгцээнд тулгуурлаж зарим академик хичээлүүдийг санал болгоно. Сурагчид долоо хоногт гурваас дөрвөн цаг дадлагын газар дээр байх багтах ба SOL-той холбогдолгүй академик хичээлүүд багтаж болно. Сурагчид дадлага хийх замаар тодорхой хэмжээнд бие дааж ажиллах чадвартай болох тул зарим сурагчдыг дадлагын газарт тусгайлан харж хандаж болно.

PEP нь сурагчид академик хичээлтэй хослуулан орон нутаг даяарх дадлагын газарт цалинтай ба цалингүй дадлага хийж ажил мэргэжлийн талаар мэдэж авах боломж олгоно. Сурагчийн ажлын хуваарь нь ерөнхийдөө Карьерын төв дээрх хоёр өдрийн хичээл, өдөрт гурав дөрвөн цагийн

дадлагаас бүрдэнэ. Ихэнх сурагчид жилийн хугацаан хоёр буюу гурван ажлыг турших үзнэ. PEP-ийн сурагчид нь ахлах сургуулийн диплом эсхүл гэрчилгээнд шаардлагатай академик кредит болон сонгох хичээлийн кредитийг авна.

**Мэргэжлийн боловсрол (20998)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 12 ба төгссөний дараа**
*Урьдчилсан шаардлага: PEP-д бүртгүүлэх*
PEP-ийн сурагчид өөрийг хариуцсан ажилтантай долоо хоногт хоёр өдөр уулзаж ажил мэргэжилтэй холбоотой хичээлийн заавар авна. Сурагчдад өөрийн ажлын байр болон өөрийн гаргаж буй ахицын талаар дүгнэлт хийхийг зөвлөж байна. Тэд тодорхой төрлийн ажлын байранд тавих шаардлага, авах сэтгэл ханамж сурагчийн чадвар, хэрэгцээнд хэрхэн тохирч байгаа талаар бодож үзнэ. Сурагч бүр шилжилтийн тэмдэглэл хөтөлнө. Энэ хичээлийг нэгээс олон удаа авч болно.

**Мэргэжилтэй танилцах (20999)**
**Нэг жил, хоёр кредит**
**Анги: 12 ба төгссөний дараа**
*Урьдчилсан шаардлага: PEP-д бүртгүүлэх*
PEP-ийн сурагчид долоо хоногт гурван өдөр, нийтдээ ойролцоогоор 12 цаг нутгийн янз бүрийн газар дадлага хийнэ. Сурагчийг дадлагад хуваарилахаас өмнө PEP-ийн ажилчид боломжит газрыг тогтоож, дүн шинжилгээ хийнэ. Дадлагын газрыг сурагчийн сонирхол, чадвар болон байгаа газрын хэрэгцээнд тулгуурлаж хуваарилна. Бие даасан дадлагын газруудад байнгын ажилчид нь ментороор ажиллах ба сурагчийн гаргаж буй ахицыг хянана. Ажилд холбогдох гүйцэтгэл, чадвар, зан харилцааны талаар бичгээр өгсөн үнэлгээг сурагчид авна. Бүлгээр (ерөнхийдөө 3-5 сурагч нэг дадлагын дасгалжуулагчтай) дадлага хийх газарт PEP-ийн ажилтан цуг ажиллаж, сурагчийн ахицыг үнэлнэ. Бүх PEP-ийн сурагчид өөрсдийн PEP дээрх хугацаандаа мэргэжлийн портфолио бэлтгэх ба үүнд тэмдэглэл, дэмжих тодорхойлолт захидал, намтар, ажлын жишээ, дадлагын газар авхуулсан зураг, “Миний тухай” танилцуулга болон бусад зүйлс багтана.

## ARLINGTON COMMUNITY АХЛАХ СУРГУУЛЬ

Arlington Community ахлах сургууль нь ахлах сургуулиа төгсөх гэж байгаа 16 ба түүнээс дээш насны сурагчдад зориулсан каунти даяар сонгох сургууль юм. Магадлан итгэмжлэгдсэн ахлах сургууль болохын хувьд дипломыг Арлингтоны нийгэмлэгийн сургуулийн нэрээр өгнө. Энэ нь ахлах сургуулийн диплом авахад шаардлагатай хичээлүүдийг улирлаар (жилд 8 хүртэл кредиттэйгээр - өдрийн ангиуд) болон жилийн турш (жилд 2 хүртэл сонгох ба 2 үндсэн хичээлээр - оройн ангиуд) санал болгодгоор онцлог юм. Хичээлийг өдөр болон оройн цагаар 8:00 цагаас 21:10 цаг болтол явуулдаг. Хичээлийг сурагчдад бие даан суралцах боломж олгож, чадварт суурилсан загвараар явуулна.

Arlington Community-ийн олон талт сурагчид нь ахлах сургуулийн диплом авахыг зориод зогсохгүй коллеж, ажил, ирээдүйд өөрийгөө бэлтгэдэг. Диплом авахад шаардлагатай хичээлүүдийг санал болгоод зогсохгүй өдрийн болон оройн цагаар Карьер, техникийн хичээл, мөн Northern Virginia Community College-ийн давхар төгсөлтийн коллежийн кредитийн боломжууд бий. Arlington Community ахлах сургуульд элсэхийг хүсэж байгаа сурагчид сургуультай шууд холбоо барьж, эсхүл элсэх мэдээллийн талаар одоогийн сургуулийнхаа зөвлөхтэй уулзана уу.

## ARLINGTON COMMUNITY АХЛАХ СУРГУУЛЬ ДЭЭР САНАЛ БОЛГОЖ БУЙ НЭМЭЛТ “AT” БУС ХИЧЭЭЛҮҮД

**Ажил мэргэжлийн судалгаа (22010)**
**Бүтэн жил, нэг кредит**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл нь янз бүрийн судлах шинжлэх ажлаар ажил мэргэжлүүдийн талаар нарийн судлахаас бүрдэнэ. Сурагчид ажилчдад тавих шаардлагууд, ажилтны мэргэшил, зохион байгуулалтын бүтэц, чанарын хяналтын арга хэмжээ, сонгосон бодлогууд ба зохицуулалтууд, ёс зүйн асуудлууд, ажлын урамшууллын талаар ажиглаж, шинжилж, тайлагнана. Сурагчийн карьерын үнэлгээний дүнгүүд, янз бүрийн боловсролын сонголтуудыг харьцуулж, өөрсдийн академик болон карьертай холбоотой зорилтуудаа гаргаж, авч үзнэ.

**Англи хэл 11 Стратегиуд (21151)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл нь Англи хэл 11-ийн кредитийг авах гэж байгаа сурагчдын анхлан элсэх хичээл юм. Англи хэл 11 хичээлийг хувь хүнд болон чадварт тохируулсан, сурах болон мэдлэг дээшлүүлэхэд дэмжлэг болохоор агуулгыг нэмж баяжуулсан байдлаар явуулдаг. Сурагчид Англи хэл 11-ийн 80% ба түүнээс дээш агуулгыг сурсан бол Англи хэл 11-ийн бүрэн хичээл, кредитэд шилжинэ.

**ELD Дүрмийн хичээл (20891)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Англи хэл суралцагчийн (EL) үйлчилгээнд бүртгүүлсэн байх.*
Энэхүү сонгох хичээлээр Англи хэл суралцагчид (EL) өөрсдийн хэрэгцээнд тохирсон дүрмийн хэсэгт тусгайлсан хичээлийг авах боломжтой байдаг.

**Биологийн удиртгал (24301)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
Энэ хичээл нь Биологийн кредитийг авах гэж байгаа сурагчдын анхлан элсэх хичээл юм. Биологийн хичээлийг хувь хүнд болон чадварт тохируулсан, сурах болон мэдлэг дээшлүүлэхэд дэмжлэг болохоор агуулгыг нэмж баяжуулсан байдлаар явуулдаг. Сурагчид Биологийн хичээлийн 80% ба түүнээс дээш агуулгыг сурсан бол Биологийн бүрэн хичээл, кредитэд шилжинэ.

**Дэлхий/Байгал шинжлэлийн удиртгал (24201)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
Энэ хичээл нь Дэлхий шинжлэлийн кредитийг авах гэж байгаа сурагчдын анхлан элсэх хичээл юм. Дэлхий шинжлэл хичээлийг хувь хүнд болон чадварт тохируулсан, сурах болон мэдлэг дээшлүүлэхэд дэмжлэг болохоор агуулгыг нэмж баяжуулсан байдлаар явуулдаг. Сурагчид Дэлхий шинжлэл хичээлийн 80% ба түүнээс дээш агуулгыг сурсан бол Дэлхий шинжлэлийн бүрэн хичээл, кредитэд шилжинэ.

**Виржиниа ба Америкийн Нэгдсэн Улсын түүхийн удиртгал (22202)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
Энэ хичээл нь Америкийн Нэгдсэн Улс, Виржиниагийн түүхийн кредитийг авах гэж байгаа сурагчдын анхлан элсэх хичээл юм. ВИ/АНУ түүхийн хичээлийг хувь хүнд болон чадварт тохируулсан, сурах болон мэдлэг дээшлүүлэхэд дэмжлэг болохоор агуулгыг нэмж баяжуулсан байдлаар явуулдаг. Сурагчид ВИ/АНУ түүхийн хичээлийн 80% ба түүнээс дээш агуулгыг сурсан бол ВИ/АНУ түүхийн бүрэн хичээл, кредитэд шилжинэ.

**Дэлхийн газар зүйн удиртгал (22201)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
Энэ хичээл нь Дэлхийн газар зүйн кредитийг авах гэж байгаа сурагчдын анхлан элсэх хичээл юм. Дэлхийн газар зүй хичээлийг хувь хүнд болон чадварт тохируулсан, сурах болон мэдлэг дээшлүүлэхэд дэмжлэг болохоор агуулгыг нэмж баяжуулсан байдлаар явуулдаг. Сурагчид Дэлхийн газар зүй хичээлийн 80% ба түүнээс дээш агуулгыг сурсан бол Дэлхийн газар зүй бүрэн хичээл, кредитэд шилжинэ.

**Дэлхийн түүх, газар зүйн удиртгал (22203)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
Энэ хичээл нь Дэлхийн түүх, газар зүйн кредитийг авах гэж байгаа сурагчдын анхлан элсэх хичээл юм. Дэлхийн түүх, газар зүй хичээлийг хувь хүнд болон чадварт тохируулсан, сурах болон мэдлэг дээшлүүлэхэд дэмжлэг болохоор агуулгыг нэмж баяжуулсан байдлаар явуулдаг. Сурагчид Дэлхийн түүх, газар зүй хичээлийн 80% ба түүнээс дээш агуулгыг сурсан бол Дэлхийн газар зүй бүрэн хичээл, кредитэд шилжинэ.

# WAKEFIELD АХЛАХ ДУНД СУРГУУЛЬ

## Бүх сурагчдад зориулсан тусгай хөтөлбөрүүд

## 2022 - 23

**АКАДЕМИК АМЖИЛТЫН СУУРЬ ХӨТӨЛБӨР**
**(9-р анги)**

**ТӨГСӨХ АНГИЙН ТӨСӨЛД ТАВИХ ШААРДЛАГА**
**(12-р анги)**

**АТ ТӨГСӨЛТИЙН ДИПЛОМ**

**WAKEFIELD ДАХЬ НЭМЭЛТ ХИЧЭЭЛ**

**ГҮНЗГИЙРҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР**

**АХИСАН ШАТНЫХНЫ СҮЛЖЭЭ**

**W**

**Wakefield**

**Арлингтон, ВА**

## АКАДЕМИК АМЖИЛТЫН СУУРЬ ХӨТӨЛБӨР

## 9-р АНГИ

9-р ангийн сурагчид шилжилтийн наснаас насанд хүрэгч болох чухал өөрчлөлтүүд буюу ахлах сургуулийн дараах дээд боловсролын ертөнцөд орох, ажил мэргэжил сонгох, нийгмийн хүрээнд насанд хүрэхэд бэлэн байдлаар ахлах сургуульд орж ирдэг. Есдүгээр ангийнханд зориулсан манай хөтөлбөр сурагчдыг оюун санаа, нийгэм, бие бялдрын хувьд насанд хүрэхэд бэлтгэхэд зориулагдсан.

Манай Академик амжилтын суурь хөтөлбөр нь дунд сургуулийг саяхан дүүргэсэн шилжилтийн насныхныг ахлах сургуулийн бүх салбарт амжилт олох оюун санааны бөгөөд академик сургалтын суурь арга зам, арга хэрэгслээр хангах болно. Тэд ахисан түвшний эрчимтэй хичээлийг хийх чадвар, мэдлэг, оюуны чадварыг олж авна.

Академик амжилтын суурь хөтөлбөр нь сурагчдад математик, англи хэл, байгалийн шинжлэл, нийгмийн ухааны эрчимтэй хичээлийг санал болгох ба хичээлийн хөтөлбөрт бүх сурагчдад илүү их, бат найдвартай мэдлэгийг олгохын тул технологи ашиглана. Хөтөлбөрөөр англи хэл 9, дэлхийн түүх, биологи, математикийн ахисан түвшин, эрчимжүүлсэн, жирийн түвшний хичээлүүдийг заана. Мөн тусгай боловсролын сурагчдын тусгай хэрэгцээг хангах зорилгоор гол хичээлүүдийг хамтран заахыг санал болгоно.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ШИНЖҮҮД

**Хувь хүнд тохируулсан хичээлүүд**

Сурагчдыг хичээлийн өдрийн зарим хэсэгт нь академик баг эсхүл “*Houses*” гэж бүлэглэнэ. Тэдэнд сурагч бүртэй танилцах багш нарын баг хичээл заана. Сурагчид хичээлийг тохируулж заах ба баяжуулж, давтаж, шаардлагатай бол хурдасгана.

**Салбар дундын холбоо**

“House” байдлаар зохион байгуулагдсан тул багш нарын багууд салбар тус бүрийн хичээлийг хамтдаа төлөвлөж, боловсруулна. Энэ нь сурагчдад агуулгын хоорондох холбоог олж харж, мэдлэг болон сурсан зүйлээ жинхэнэ амьдрал хэрэгжүүлнэ. Бүх салбар суралцахад дэмжлэг үзүүлэх утгаар технологийн хичээлийг заадаг.

**Сурахад сурагчийн өөрийн хариуцлага**

Сурагч өөрийн суралцах үйл явцдаа хариуцлага үүрэх чадвар, оюуны арга барилыг эзэмшиж, өөрийн чадварыг үнэлж, хувийн зорилт тавьж, энэ зорилтоо биелүүлэх цаг, ажлаа зохицуулна. Тэд мөн ахлах сургуулийн дараах болон ажил мэргэжлийн урт хугацааны зорилгоо тодорхойлж эхэлнэ.

## СУРАГЧИЙГ ҮНЭЛЭХ

APS-ийн сургалтын хөтөлбөр, Виржиниагийн сургалтын стандартад суурилж, хичээл бүрийн хувьд тодорхойлсон сургалтын зорилгод зааснаар бүх сурагчид (англи хэл, математик, байгалийн шинжлэл, нийгмийн ухаан) дөрвөн гол салбарыг сайн эзэмшсэн байх ёстой. Үнэлгээг уламжлалт шалгалт, өдөр бүрийн даалгавар, танилцуулга, бүлгийн болон бие даасан төслүүд, олон салбарыг нэгтгэсэн мультимедиа танилцуулгууд үнэлгээний хэлбэрт багтана.

Сурагчийн ахицыг “house” дахь багш бүр тогтмол хянаж, сурагч өөрөө мөн хянаж үзнэ. Дүн гарах хоёр дахь цагийн дундуур сурагч бүрд холбогдож эцэг эх -сурагч-багшийн хурлыг Суурь хөтөлбөрийн хурлын өдрөөр хийнэ. Энэ нь эхний улирлын үеэр хүрсэн амжилтууд, хоёр дахь улирлын зорилтын талаар эцэг эх, сурагчид тойм өгч, аравдугаар ангийн хичээлийн сонголтын талаар асуултуудад хариулна. Хичээлийн жилийн хугацаанд шаардлагатай бол нэмэлт хурлуудыг хийнэ.

## Заавар

**Сургалтын хөтөлбөр**

Каунтигаар зөвшөөрсөн хичээлийн хөтөлбөрийг байгалийн шинжлэл, (Биологи, Эрчимжүүлсэн биологи, эсхүл Гүнзгийрүүлсэн биологи), Англи хэл (Англи хэл 9 эсхүл Англи хэл 9, эрчимжүүлсэн), ба нийгэм судлалд (1500 он хүртэлх Дэлхийн түүх эсхүл 1500 оноос өнөөг хүртэлх эрчимжүүлсэн Дэлхийн түүх) баримтална. 9-р ангид орж ирэхдээ АТ дэлхийн түүх хичээлийг авахад бэлэн сурагчид "House"-ийн хичээлүүдийг авч болно. Манай 9-р ангийн математикийн хичээлийг "House"-ууд дундаа хариуцдаг тул математикийн хичээлд нэгээс илүү "House"-ын сурагчид байна.

Сурагчид хичээлийн жилийн эхэнд MacBook Air авах ба үг, хүснэгт, дата сан боловсруулах, нийтлэх, график гаргах, веб хуудас хийх, чимэглэж янзлах суурь программууд гээд янз бүрийн компьютерын программ, аппликейшнийг хэрэглэнэ., Сурагчид мөн аудио, зурагт, дүрс бичлэгийн технологийг танилцуулгын дизайн гаргахад хэрхэн хэрэглэхийг сурна.

**Авьяастан**

Бүх эрчимжүүлсэн, дээд шатны хичээлүүдээр бүтээлчээр сэтгэх, шүүмжтэй бодох, асуудал шийдэх, семинарын хэлэлцүүлэг, судалгааны аргачлалыг шууд ба дам багтаахыг хичээлийн хөтөлбөрт зааж өгсөн. Хичээлийн хурд, тавих шаардлага нь авьяастан сурагчийн оюуны хэрэгцээг хангах зорилготой.

**Хурдасгах/Давтах**

"House" бүр уян хатан, янз бүрийн байдлаар ажиллах ба энэ нь тохирсон сургалт хийх боломжийг бий болгоно. Хэрэгцээ, хүсэл зориг байгаа бол сурагчдад ахисан түвшний сургалтыг өгнө. "House" доторх бүлгүүдийг сурагчид эрчимжүүлсэн хөтөлбөрт бэлэн болсноо харуулах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд байгуулдаг. "House" тогтолцоо нь сурагчдад давтлага, бэхжүүлэх гээд ялгамжтай боломжуудыг олгодог.

**Тусгай боловсролын сурагчид**
Суурь хөтөлбөрт Тусгай боловсролын сургуулийн сурагчдыг багтаасан боломжуудыг тусгасан байдаг.

## ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХУВААРЬ

- "House" бүр үндсэн багш, зөвлөхүүдтэй бөгөөд тэд ижил бүлгийн сурагчдыг хамтдаа хариуцна.

- "House" бүрд авьяастны үйлчилгээнд хамрагдах сурагчид, тусгай боловсролын үйлчилгээг авах сурагчид, англи хэл суралцагч сурагчдыг багтаана.

- Сурагчид "House"-аас гадуур өөрийн математик ба сонгох хичээлээ авна. Эдгээр сонгох хичээлд Эрүүл мэнд, Биеийн тамир I, Дэлхийн хэлний хичээлүүд, Урлаг ба тайзны урлаг багтана.

## ТӨГСӨХ АНГИЙН ТӨСӨЛД ТАВИХ ШААРДЛАГА

**12-р анги**

**Төгсөх ангийн төслийн семинар**
**Бүтэн жил, нэг кредит (20190)**
**Нэг улирал, нэг хагас кредит (20195)**
**12-р анги**

**Төгсөх ангийн төслийн бие даалт (20191)**
**Бүтэн жил, нэг кредит**
**12-р анги**

Төгсөх ангийн төсөл нь 12-р ангийн сурагч бүр өөрийн сонгосон сэдвээр хийх бие даасан судалгаа, бүтээгдэхүүн юм. Төгсөх ангийн төсөл нь нэг чухал ажлыг сонгож, судалж, бичих чадвараа харуулах боломж бөгөөд ажлыг факультетын гишүүн, хамтран суралцагчид, эксперт зөвлөх болон бусад насанд хүрэгчдийг багтаасан зөвлөлийн өмнө танилцуулдаг. Төгсөх ангийн төсөлд санал, явцын тэмдэглэл, танилцуулах эсээ, танилцуулгатай илтгэлийг багтаана. Төгсөх ангийн сурагч бүр факультетын зөвлөхийн зааврын доор төслийн танилцуулгыг бэлтгэж ажиллана. Төгсөх ангийн төсөл нь ирээдүйн ажил олгогч төдийгүй коллеж болон их сургуулийн ажилчдад үзүүлэх ажил болж болох ба ахлах сургуулийн дараа үргэлжлүүлэх судлах зүйл болж болно. Энэ нь манай Wakefield сурагчдын хамгийн онцгой ажил бөгөөд тэд 9, 10, 11-р ангидаа энэ сорилтод бэлтгэсэн тул Төгсөх ангийн төсөл нь төгсөлтийн нэг шаардлага юм. Сурагчид Төгсөх ангийн төслийг хангалттай хэмжээнд гүйцэтгэсэн бол нэг кредит авна. Сурагчид Төгсөх ангийн төслийг бие даалт хэлбэрээр (20191) хийж болно. Эсхүл Төгсөх ангийн төслийн семинарт (20190) бүртгүүлэх замаар бүтэн жилээр эсхүл төгсөх жилийнхээ хоёрдугаар улиралд (21095) 5 кредиттэйгээр хийж болно.

## АТ ТӨГСӨЛТИЙН ДИПЛОМ

AT Capstone™ нь коллежид орохоор ихээхэн хэрэг болох бие даасан судалгаа, багаар ажиллах, харилцааны чадварт сурагчийг сургах Коллежийн зөвлөлийн хөтөлбөр юм. Энэ нь сониуч, хараат бус, бусадтай ажиллах чадвартай судлаачийг өсгөж, тэднийг логиктой, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад бэлтгэнэ.

AT Capstone нь — AT семинар ба AT судалгаа — гэсэн хоёр AT хичээлээс бүрддэг ба бусад AT хичээлүүдийн тухайн салбарын сургалт дээр нэмэлт болох, өргөжүүлэхэд зориулагдсан. Оролцогч сургуулиуд одоогийн AT сурагчдад судалгааны онцгой боломжуудыг олгоход эсхүл AT Capstone хөтөлбөрөөр хөгжүүлж буй аргументад суурилсан бичгийн чадваруудыг эзэмшихэд сурагчдыг оролцуулах замаар AT-г нэвтрэхийг өргөжүүлэхэд AT Capstone хөтөлбөрийг ашиглаж болно.

Энэ хичээлүүдийг авсан сурагчид AT Capstone-д багтах ба энэ нь улс даяарх коллеж, их сургуулиуд хүлээн зөвшөөрөх онцгой амжилт юм. Хоёр хичээлийг амжилттай дүүргэснээр сурагчид AT Capstone гэрчилгээ авна. Capstone-д багтсан, аль нэг салбарт бусад дөрвөн AT шалгалтыг давсан сурагчид AT Capstone диплом авна.

**Семинар, AT (22110) (32110)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
AT семинар нь илүү цогц эсхүл академик бөгөөд амьдралын сэдвүүд, асуудлуудын талаар янз бүрийн өнцгөөс үнэлэн судлахад сурагчдыг хэлэлцүүлэгт оруулах суурь хичээл юм. Асуулт тавих аргачлалаар сурагчид нийтлэл, судалгаа, суурь сурах бичиг, философийн бичиглэлийг уншиж, шинжилнэ; илтгэл, нэвтрүүлэг, хувийн танилцуулгыг сонсож, үзнэ; урлагийн бүтээл, тоглолтыг үзнэ. Сурагчид олон эх үүсвэрийн мэдээллийг нэгтгэж, судалгаанд суурилсан бичгийн ажлын өөрийн дадлыг хөгжүүлж, бие даан болон бүлгээр илтгэл болон үзүүлэн бэлтгэж, үзүүлнэ. Хичээлээр мэдээллийг оновчтой, зөв шинжилж, үнэлэх чадварыг сурагчдад өгч, нотолгоонд суурилсан аргументийг эзэмшиж, илэрхийлэх чадварыг олгох зорилготой.
*Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй (22110).*

**Судалгаа, AT (22112) (32112)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Семинар, AT-г амжилттай дүүргэсэн байх*
AT Судалгаа хичээлээр сурагчид өөрсдийн сонирхсон сэдвээр академик сэдэв, асуудлыг гүнзгийрүүлэн сонирхох боломжийг олгоно. Энэхүү судалгаагаар, сурагчид судалгааны асуултад хариулж, жилийн хугацаанд судалгааг төлөвлөж, гүйцэтгэнэ. AT Судалгаа хичээлээр сурагчид AT Семинар хичээлээр олж авсан чадвараа цааш хөгжүүлж, судалгааны аргачлалыг ойлгож; ёсзүйтэй судалгаа хийж; судалгааны асуулт дээр ажиллах явцдаа мэдээллийг тодорхойлж, шинжилж, өөрийнхөөрөө илэрхийлнэ. Сурагчид өөрсдийн чадварыг хөгжүүлж, өөрийн ахицыг баримтжуулж, өөрсдийн судалгааны ажлын явцыг портфолиод оруулах болно. Хичээлээр 4000-5000 үгтэй (хэрэв тохирох бол илтгэл, тоглолт эсхүл хийсэн

зүйлийнхээ үзэсгэлэнг хамт гаргаж) судалгааны өгүүлэл бичих ба бичсэнээ илтгэлээр хамгаална. *Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй (22112).*

## WAKEFIELD-Д САНАЛ БОЛГОЖ БУЙ НЭМЭЛТ АХИСАН ТҮВШНИЙ ХИЧЭЭЛҮҮД

**Байгал орчны шинжлэх ухаан, AT (34270)**
**Бүтэн жил, нэг кредит + Хоёр кредитийг авч, AT шалгалт, давхар цаг, (34271) давхар хичээлээр 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Хоёр лабораторийн шинжлэх ухааныг амжилттай дүүргэх (нэг нь амьдралын, нөгөөх нь физикийн); гэхдээ, сурагчид хоёр лабораторийн шинжлэх ухааныг амжилттай дүүргэсэн (нэг нь амьдралын, нөгөөх нь физикийн) Хими IF-д давхар бүртгүүлж болно; Алгебр II эсхүл дүйцэх хичээлийг хангалттай дүнтэй төгсссөн эсхүл зэрэг бүртгүүлсэн, Байгал орчны шинжлэх ухааны сонгосон сэдвүүд хичээлд зэрэг бүртгүүлэх ба багшийн заавар*
Ахисан түвшний Байгал орчны шинжлэх ухаан нь байгалийн харилцан холбоог ойлгох, байгалиас болон хүнээс шалтгаалсан байгаль орчны асуудлуудыг тодорхойлж, шинжлэх, эдгээр асуудлуудтай холбоотой харьцангуй эрсдэлүүдийг үнэлэх, эдгээрийг шийдэх ба/эсхүл урьдчилан сэргийлэхэд шаардлагатай шинжлэх ухааны зарчмууд, концепцууд, аргачлалыг сурагчдад зааж өгнө.
*Сурагчид хоёр шаардлагатай хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй. (24365) (24271).*

**Байгал орчны шинжлэх ухааны сонгосон сэдвүүд, AT (34271)**
**Бүтэн жил, нэг кредит, давхар цаг**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: AT-ийн Байгал орчны шинжлэх ухаан хичээлд давхар бүртгүүлэх*
Эдгээр сэдвүүд нь сурагчдад нэлээд хэдэн байгаль орчны шинжлэх ухааны салбарт өргөн хүрээний лабораторийн шинжилгээ хийх боломжийг олгоно. Лабораторийн судалгааг судалгааны газар дээрх туршлагатай холбосноор сурагчид байгаль орчны асуудлыг анхан шатны түвшинд ажиглаж сурна. Дэлхийн системүүдийн харилцан хамаарал, хүн амын динамик, сэргээгдэх/сэргээгдэх бус эх үүсвэрийг эхний улирлын хичээлээр багтаана. Байгал орчны чанар, глобал өөрчлөлт, байгаль орчин, нийгмийг хоёрдугаар улиралд үзнэ.
*Энэ хичээлийн ерөнхий сонгох хичээлд тооцно. Үүний дээр бие даасан болон бүлгийн судалгааны төслийг гаргаж, гүйцэтгэх шаардлага тавина.*

## WAKEFIELD ДЭЭР НЭМЭЛТ AT-БУС ХИЧЭЭЛҮҮДИЙГ САНАЛ БОЛГОНО

**Америкийн соёл иргэншил: Англи хэл (21176), нийгэм судлал, эрчимжүүлсэн (22376)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит (Англи хэл дээр нэг, Виржиниа, АНУ-ын түүх дээр нэг кредит)**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ хичээл нь уран зохиол, хэл, найруулга зүйн арван нэгдүгээр ангийн англи хэлтэй зэрэг явагдах зориулалттай. Хэрэглээний ба дүрслэх урлаг болон Америкийн Нэгдсэн Улсын нийгэм, оюуны хөгжлийн түүхэд илүү анхаарал тавина. АНУ-ын уран зохиолын ба түүхэн үе шатуудыг хооронд нь холбож үзнэ. *Хичээлийн төгсгөлд Сургалтын стандартын гурван үнэлгээ бий: унших, бичих, Виржиниа ба АНУ-ын түүх SOL шалгалтад тэнцэх, хичээлээр хоёр баталгаажсан кредит өгнө.*

**Анатоми/Физиологи I/II, хосолсон төгсөлт (94320W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Биологи ба лабораторийн нэмэлт байгалийн шинжлэлийн хичээл*
Энэ хичээл нь хүний биеийн бүтцийг танилцуулах хичээл бөгөөд эрүүл мэнд, анагаахын мэргэжилд сонирхолтой сурагчдад зориулагдсан. Хичээлээр биеийн бүтэц, эсийн ажиллагаа, эрхтэн, эрхтний системийн түвшнийг үзэх ба хичээлийн туршид ердийн биеийн анатоми, физиологид анхаарна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Дэлхий судлал, Хэсэг I (20045)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Тухайн сурагчид Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай*
Энэ хичээлээр геологи, далай судлал, цаг уур судлал, одон орон судлалын багтааж Дэлхий судлалын нийтлэг концепцуудыг сурах юм. Энэ нь хоёр хэсэгтэй цуврал хичээлийн эхнийх бөгөөд агуулгад холбогдож өөрийн унших чадвараа дээшлүүлэх, мөн янз бүрийн мэдээллийг сурах, эмхлэх, тайлбарлах чадварт холбогдож сурагчдад туслах арга барилуудыг багтаана. Тохируулсан стандарт диплом авах гэж байгаа сурагчдад энэ хичээлд байгалийн шинжлэлийн кредит өгнө. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. Энэ хичээл мөн Стандарт дипломын лабораторийн кредитэд тооцогдож, кредит авч болно. Үүний тулд Дэлхий судлал, Хэсэг II-т сууж, Дэлхий судлал SOL шалгалтыг өгөх ёстой.

**Дэлхий судлал, Хэсэг II (20046)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Сурагчид тусгай боловсролын үйлчилгээг авах хэрэгцээтэй гэсэн тодорхойлолттой байх ёстой ба Дэлхий судлал, Хэсэг I хичээлийг дүүргэсэн байх ёстой*
Энэ хичээлээр геологи, далай судлал, цаг уур судлал, одон орон судлалыг илүү нарийн судлахыг багтааж Дэлхий судлалын нийтлэг концепцуудыг үргэлжлүүлэн сурах юм. Энэ нь хоёр хэсэгтэй хичээлийн хоёр дахь хэсэг бөгөөд агуулгад холбогдож өөрийн унших чадвараа үргэлжлүүлэн дээшлүүлэх, мөн янз бүрийн мэдээллийг сурах, эмхлэх, тайлбарлах чадварт холбогдож сурагчдад туслах арга барилуудыг багтаана. Хичээлийн төгсгөлд SOL шалгалт бий. Энэ хичээлийг дүүргэж, Дэлхий судлалын SOL шалгалтыг давсан сурагчид нэг баталгаажсан байгалийн шинжлэлийн кредит авна.

**Дэлхий судлал II: Далай судлал (24220)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Дэлхий судлал ба лабораторийн шинжилгээний нэг нэмэлт*
Энэ хичээлээр далай судлалын гол сэдвүүдийг сурагчдад танилцуулна. Хичээлээр далай дэлхийд үзүүлэх нөлөө, яагаад бидэнд чухал болох, далай хүн төрөлхтний түүхэнд ямар нөлөөтэй байсан талаар заана. Далай судлал нь газар зүй, далайн биологид холбогдох ба далайн ёроолын геологи, газар зүй, далайн усны физикийн шинж, далайн химийн бүтэц, далайн биологи, далайн давсжих хөдөлгөөн, давлагаа, таталт, далай судлалын хэрэгслүүд, аргачлал гэсэн сэдвүүдийг багтаана. Хичээл нь далай судлалын концепцүүдийг гүнзгийрүүлэн үзэхэд зориулагдсан.

**Кино судлал II (21447)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Кино судлал I-ийг дүүргэх буюу зааварлагчийн зөвшөөрлөөр*
Кино судлал II нь Кино судлал I-ээр үзсэн концепцуудыг үргэлжлүүлэн гүнзгийрүүлнэ. Сурагчид кино үзэх талаар ойлголтынхоо хүрээнд кино хийх жанр, жишээг илүү ихээр жишээ авна. Ярианы болон бичгийн чадваруудаа дадлагажуулахаас гадна Кино судлал II-оор киноны эрхлэгч, жүжигчдийн талаар судалж, үндэстний кино, кино зохиол, кино хийх дадлага, нууцлаг зүйлс, хар цагаан киноны талаар суралцана.

**Дунд шатны оркестр (29243)**
**Бүтэн жил, нэг кредит**
**9-12-р анги***
*Урьдчилсан шаардлага: Өмнөх оркестрын туршлага эсхүл зааварлагчийн зөвшөөрөл*
Дунд шатны оркестр нь сурагчдыг Цөөхүүл оркестрт бэлтгэнэ. Дунд шатны хөгжмийн техникийн сургалт, ансамбль, хараагаар унших сургалтыг давтлагад багтаах ба мөн агуулгыг тодруулах түүх, онолыг мэдээллийг өгнө. Олон тооны сургуулиудын тоглолт болон аялан тоглолтод оролцох шаардлага тавина.

**Ахисан шатны Театрын урлагийн судлал (21432)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 12**
*Урьдчилсан шаардлага: Ахисан шатны Театр IV*
Ахисан шатны жүжгийн урлагийн сургалтаар сурагчид Ахисан шатны Театр IV-ийн ажлаа үргэлжлүүлэх ба хэд хэдэн тоглолтыг хийх үйл явцыг бүхэлд нь ойлгож, байлцах болно. Тоглолт, шоуг удирдаж, бүтээж, зохицуулах замаар сурагчид өмнө сурсан бүх техникийн элементүүд, жүжиглэлт, удирдах техникүүд, бүлгийн динамик чадваруудыг нэгтгэж, хэрэглэнэ. Хичээлээр бие даасан төслүүдэд илүү анхаарал тавина. Төгсөлтөд ангиас гадуур давтах багтаж магадгүй.

**Дэлхийн Уран зохиол (21518)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 12**
*Урьдчилсан шаардлага: Багшийн зөвлөснөөр*
Дэлхийн уран зохиол нь хэл болон бичгийн талаар Англи хэл 12-той параллель байна. Сургалтад Европ, Африк, Ази, Өмнөд болон Төв Америкийн харьцуулсан уран зохиолыг маш ихээр уншиж, орчин үеийн сэтгэлгээнд анхаарна. Сурагчид ангид танилцуулга хийхээр бие даасан төслүүд санаачилж, салбар хэлэлцүүлэгт оролцож, олон жижиг өгүүлэмжүүдийг бичнэ. Өндөр зэргээр санаачилгатай, сахилгатай сурагчдад зориулсан.

# WAKEFIELD-ИЙН ГҮНЗГИЙРҮҮЛСЭН ХИЧЭЭЛҮҮД

Wakefield дахь гүнзгийрүүлсэн хөтөлбөр нь дунд сургуульд эхлүүлсэн Испани хэл, соёлын сургалтыг үргэлжлүүлж, дэлгэрүүлнэ. Сурагчдад зорилтот хэлээр ахисан шатны ангийн ажил өгөх ба сурагчид сэдвийн хэсгүүдээр хичээл заалгах боломжтой. Гүнзгийрүүлсэн сургалтын сурагчид Төгсөлтийн төслөө бүгдийг нь эсхүл заримыг нь испани хэлээр хийж болно.

**Испани хэл Гүнзгийрүүлсэн 9 (25511)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 9**
*Урьдчилсан шаардлага: Gunston дээр 8-р ангийн гүнзгийрүүлсэн сургалтыг амжилттай дүүргэсэн байх ёстой.*
Сурагчид дадлага туршлага хийх боломжтой орчинд Испани хэлээ үргэлжлүүлэн хөгжүүлнэ. Унших, бичих чадварт анхаарснаар сурагчид AT Хэл, соёл болон AT Испани уран зохиол зэрэг дээд шатны хичээлүүдэд сурагчдыг бэлтгэнэ. Сурагчид Испани хэлний сургалтын туршлагаа хичээлийн бусад салбартай холбож үзнэ. Тэд Испани хэлний ертөнцийн тухай соёлын мэдлэгээ цааш хөгжүүлж, мэдлэгээ хичээлээс гадуур ашиглана.

**Испани хэл Гүнзгийрүүлсэн 10 (25521)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Испани хэл, гүнзгийрүүлсэн 9-ийг амжилттай дүүргэх (25511).*
Сурагчид уран зохиол болон сэдэвчилсэн бүлгүүдэд холбогдож унших, дүрэм, бичих, сонсох, ярихад үргэлжлүүлэн анхаарч, Испани хэл болон Испани хэлтэй ертөнцийн соёлын тухай сургалтаа үргэлжлүүлнэ. Энэ нь Гүнзгийрүүлсэн 9 хичээлийн үргэлжлэл бөгөөд AT Испани хэл, AT Испани хэлний уран зохиол хичээлүүдэд бүртгүүлэх замаар цаашид суралцах хүсэлтэй сурагчдад зориулсан.

**Биологийн лабораторийн хичээл, эрчимжүүлсэн, гүнзгийрүүлсэн (24319)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 9**
*Урьдчилсан шаардлага: Гүнзгийрүүлсэн хөтөлбөрт элсэх*
Хичээлийг эрчимтэй бөгөөд өргөн хүрээний байгалийн шинжлэлийн мэдлэг олж авах чадвар, хүсэл эрмэлзэлтэй сурагчдад зориулсан. Молекулын биологи, цитологи, ген, эсийн физиологи, экологи, биологийн төрөл зүйлийн судалгаа сэдэвт багтана. Лабораторийн ажиллагаа, туршилт, шинжилгээг илүү хэрэглэхэд илүү анхаарна. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Эрчимжүүлсэн Хими- Гүнзгийрүүлсэн (24416)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II-ийг төгсгөсөн эсхүл үүнийг давхар авах эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*
Энэ хичээлээр сурагчдыг коллежийн түвшний химид бэлтгэнэ. Хичээлээр атом, молекулын бүтэц, байдал, химийн үйлчлэлийн зарчмуудыг сайтар ойлгох ойлголтыг өгнө. Тоон дата анализад онцгой анхаарч, лабораторийн ажлыг түлхүү хийнэ. Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.

**Эдийн засаг, хувийн санхүү, гүнзгийрүүлсэн (22211)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 10-12**
*Урьдчилсан шаардлага: Гүнзгийрүүлсэн хөтөлбөрт элсэх*
Хичээлийн агуулга/зааврыг Испани хэлээр өгнө. Энэ хичээлээр эдийн засаг, хувь хүний санхүүгийн талаар ерөнхийд нь үзнэ. Америкийн бизнесийн тогтолцоо, эдийн засгийн зарчмууд, нийлүүлэлт/эрэлтийн эдийн засаг, хөдөлмөр ба үйлдвэрлэл, Холбооны улсын нөөцийн тогтолцоо, засгийн газрын мөнгөний бодлого, голлох улсуудын эдийн засгийн системийн харьцуулалт, эдийн засгийн философитой глобал худалдааны нөлөөний талаар хичээлээр үзнэ. Сурагчид санхүү, хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээл, хураамж, хөрөнгө оруулалтаас авах зүйл, тэтгэвэрт гарах, өмчийн төлөвлөлт, хэрэглэгчийн зээл, мөнгөний менежмент, төсөвлөх, санхүүгийн тайлан, даатгал ба эрсдэлийн менежмент, орон байрны өмчлөл, коллежийн боловсролын төлөвлөлт, цалингийн татвар, хэрэглэгчийг хамгаалах хууль ба санхүүгийн хариуцлагын талаар суралцана. ***Энэ хичээлийн зарим хэсгийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.*** *WISE Санхүүгийн мэдлэгийн шалгалтыг сурагчид Карьер, техникийн төгсөлтийн кредит авахын тулд өгөх шаардлагатай байж болно. Энэ хичээлээр бүх эдийн засаг, санхүүгийн төгсөлтийн шаардлагыг багтаана. Энэ хичээл болон CTE хичээлийг амжилттай дүүргэсэн сурагчид “биелүүлсэн” статус авч болно. Энэ хичээлийг*

*нийгэм судлал, гэр бүл ба хэрэглэгчийн шинжлэх ухаан эсхүл бизнесийн хичээлийн төгсөлтийг кредит авахад авч болно. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

# Ахисан түвшний сургалтын (AT®) сүлжээ

***Оюутаныхаа ирээдүйд хүрэх гүүрийг бий болгох***

Вэйкфилд ахлах сургууль, Арлингтон, VA - 703.228.6700 - www.apsva.us/wakefield

***<u>Ахисан түвшин гэж юу вэ (AT®)?</u>***

Коллежийн Зөвлөлөөс (жишээ нь: “SAT”) тэтгэдэг **Ахисан түвшний хөтөлбөр** (AT®) нь ахлах сургуулийн сурагчдад **ахлах сургуульд байхдаа коллежийн кредит авах, ахисан түвшинд орох эсхүл коллежид элсэхдээ хоёуланг нь авах боломжийг санал болгодог.**. Одоогоор, AT® шалгалтыг 36 хичээлд санал болгож байна. Ахисан түвшний хөтөлбөр (AT®) 1955 онд эхлэх үед 1229 сурагчид AT® шалгалтыг өгч байсан. 2015 онд 2,5 сая гаруй сурагчид 4,5 сая гаруй шалгалтыг өгсөн ба дэлхий даяар 2000 гаруй их сургууль тодорхой нэг байдлаар AT® Хөтөлбөрийг хэрэглэж байна.

***<u>Wakefield ахлах сургуулийн ахисан түвшний сургалтын (AT®) сүлжээ гэж юу вэ?</u>***

***Wakefield сургуулийн зүгээс AT® хөтөлбөр нь зөвхөн “авьяастанд” бус харин бэлтгэгдсэн сурагчдад зориулагдсан гэсэн үзлийн үүднээс* Wakefield AT® сүлжээ** 2004 оны хавраас Арлингтоны каунтигийн сургуулийн зөвлөлөөс баталсан жишиг төслийг эхлүүлсэн. Wakefield ахисан түвшний сүлжээ нь каунти даяарх хөтөлбөр бөгөөд Арлингтонд амьдардаг, гэхдээ Wakefield-д хамрагдах тойргоос гадуур амьдардаг сурагчид хөтөлбөрт оролцохоор шилжих хүсэлт гаргаж болно.

Wakefield-д элсэн орсноор сурагчид AT Сүлжээнд есдүгээр ангиасаа эхлэн оролцож болно. Ахлах сургуулийн нэгдүгээр ангийн сурагчид AT Дэлхийн түүх эсхүл 9-р ангийн Суурь олгох хөтөлбөрийн хүрээнд AT-ийн өмнөх эрчимжүүлсэн хичээлүүдэд бүртгүүлж болно. Ахлах сургуулийн нэгдүгээр ангийн сурагч болохын хувьд сурагчид дөрвөн жилийн төлөвлөгөөгөө сургуулийн зөвлөхтэй ажиллаж гаргана. Энэ төлөвлөгөө нь сурагчийн давуу тал, сонирхолд зориулагдсан. Бүх сурагчид ирээдүйд хамгийн сайн бэлтгэгдэхийн тулд эрчимтэй хичээл авах хэрэгтэй байдаг.

AT хичээл маягаар нэлээдгүй сорилттой, хэцүү хичээлүүдийг заадаг ба Wakefield нь Коллежийн зөвлөлөөс баталсан 37 AT хичээлийн 30-ыг нь санал болгодог. Бүх сурагчдад AT хичээлд бүртгүүлэх боломжийг нээлттэй болгосон Нэгдсэн Улсын анхны ахлах сургуулиудын нэг болохын хувьд Wakefield сургуулиас эдгээр хичээлүүдийн академик ба хувь хүнд өгөх сорилтыг ойлгож, сурагчдад дэмжлэг хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. AT Сүлжээг энэхүү дэмжлэгийг үзүүлэхийн тулд байгуулсан бөгөөд дараахыг багтааж, янз бүрийн хичээлийн болон зөвлөгөөний санаачилгаар үүнийгээ хэрэгжүүлж байна:

- **Wakefield AT Summer Bridge Program** – нь AT сурагчдын 3 өдрийн семинар, хичээл бөгөөд сурагчид ирэх хичээлийн жилд авах AT хичээлүүддээ илүү сайн бэлтгэхийн тулд наймдугаар сард үүнд оролцдог.
- **AT Consult** – нь сурагчдад хичээлийн ажлаа гүйцэтгэж дуусах цаг өгөх, бие дааж сурах, мөн боломжтой бол AT хичээлийн багш нартайгаа уулзах боломжийг олгодог.
- **AT Capstone** – нь AT сонгох хичээлүүд —AT семинар, AT судалгаа — бөгөөд эдгээр нь AT Capstone гэрчилгээ буюу AT Capstone дипломд хүргэнэ.
- **Wakefield’s Cohort for Minority Males** болон **United Minority Girls programs** -тай хамтарч цагаан арьстан ба цагаан арьстан бус сурагчдын хоорондын амжилтын ялгааг авч үзнэ.
- AT хөндлөн багийн сургалтад факультетаар оролцох, Коллежийн зөвлөлөөс тэтгэсэн үйл ажиллагаа дээр AT хичээлд бэлтгэх.
- Эрчимжүүлсэн AT түвшний хичээлд амжилт гаргах 8-аас 12-р ангийн сурагчдыг факультетаас шалгаруулж, авах.
- Эрчимжүүлсэн болон AT хичээлүүдийн давуу талуудыг тайлбарласан факультетаас хийх семинар, оройн танилцуулгын арга хэмжээнүүд.

# Washington-Liberty ахлах сургуулийн Олон Улсын Бакалаврын Хөтөлбөр

Олон улсын бакалаврын (ОУБ)-ын хөтөлбөр [The International Baccalaureate (IB)] гэж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрийг Washington-Liberty ахлах сургуулиас өндөр идэвхтэй 11, 12-р ангийн сурагчдад санал болгодог. Энэ нь авьяастай, хүсэл эрмэлзэлтэй сурагчдыг дайчлах академик хичээлийн бүтэцтэй, эрчимтэй хөтөлбөр юм. ОУБ хөтөлбөр нь сурагчийн оюуны, философийн, нийгмийн харилцааны хөгжлийг хангах цогц боловсролын үзэл санаанаас бүрддэг.

ОУБ хөтөлбөр нь олон янзын хичээлийг багтаасан хоёр жилийн хөтөлбөр юм. Хөтөлбөрт дараах багтана:

- *Янз бүрийн салбарт зургаан академик хичээлийг амжилттай дүүргэх*
- *Салбар хичээл бүрд сургуулиас гадуурх байгууллагаас авах шалгалтыг өгөх*
- *CAS ([Бүтээлч, Идэвхтэй, Үйлчлэх] Creativity, Activity, and Service)-д оролцох*
- *Мэдлэгийн онол хичээлд бүртгүүлэх*
- *Сурагч өөрийн сонирхсон сэдвээр өргөн хүрээний эсээ бичиж өгөх*

Швейцар Улсын Женев хотын Олон Улсын Бакалаврын байгууллагаас дээрх зүйлсийг бүгдийг нь дүүргэж, гаднаас авах зургаан шалгалтыг амжилттай өгсөн сурагчид ОУБ-ын диплом өгдөг. Ихэнх тохиолдолд диплом нь дэлхий даяар их сургуульд орох эрхийн бичиг болж үйлчилдэг. АНУ-ын олон коллеж, их сургуулийн дипломыг албан ёсоор зөвшөөрдөг ба/эсхүл авсан хичээлийн гэрчилгээг хэсэгчлэн тооцдог. (Ийнхүү хүлээн зөвшөөрөхтэй холбоотой бүрэн хэмжээний жагсаалтыг Зөвлөгөөний алба, ОУБ-ын зохицуулагч эсхүл интернэтээр www.ibo.org/ хаягаар авч болно.) Сурагчид ОУБ-ын дипломыг бүрэн хэмжээгээр авахгүйгээр зарим нэг ОУБ-ын хичээлүүдийг авч болно. Ахисан түвшний сургалтын дипломд тавигдах шаардлагыг 6-р хуудаснаас үзнэ үү. Эдгээр хичээлүүдэд тавих шаардлагыг Сургалтын хөтөлбөрт зааж өгсөн.

## ОУБ-ЫН ДИПЛОМЫН ХӨТӨЛБӨРИЙН БҮРДЭЛ ЗҮЙЛС

Хичээлийн салбарыг дараах байдлаар бүлэглэсэн:

Бүлэг 1: Хэл, уран зохиолын хичээлүүд –
- Англи хэл A Уран зохиол
- Англи хэл A, Уран зохиол
- Испани хэл A, Уран зохиол

Бүлэг 2: Хэл сурах –
- Араб хэл AB/B
- Хятад мандарин AB/B
- Франц AB/B
- Латин хэл
- Испани хэл AB/B

Бүлэг 3: Хувь хүн ба нийгэм –
- Бизнес, менежмент
- Эдийн засаг
- Газар зүй

- Америкчуудын түүх (1 дэх жил) /Хорьдугаар зууны дэлхийн түүх (2 дахь жил)
- Философи
- Сэтгэл судлал
- Нийгмийн антропологи

Бүлэг 4: Туршилтын шинжлэх ухаан –

- Биологи
- Хими
- Мэдээлэл зүй
- Дизайны технологи
- Байгал орчны системүүд ба нийгэм
- Физик
- Спорт, Дасгал ба Эрүүл мэндийн шинжлэх ухаан

Бүлэг 5: Математик –

- Математик: Хэрэглээ ба тайлбар
- Математик: Анализ, аргачлал

Бүлэг 6: Урлаг

- Кино
- Дуу хөгжим
- Театрын урлаг
- Дүрслэх урлаг

Үндсэн: Мэдлэгийн онол, эсээ, CAS (Бүтээлч, идэвхтэй, үйлчлэх [Creativity, Activity, and Service])

**ОУБ-ын сурагчийн профиль**

ОУБ-ын [The International Baccalaureate (IB)] хөтөлбөрийн зорилго нь хүн төрөлхтний нийтлэг зүйлс бөгөөд илүү сайн, энх тайван дэлхийг бүтээх харилцан хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн олон улсын сэтгэлгээтэй хүмүүсийг хөгжүүлэх юм.

ОУБ-ын сурагчид нь дараахыг эрмэлзэнэ:

| | |
|---|---|
| **Сониуч байх** | Тэд байгалиас сониуч байхыг эрмэлзэнэ. Судалгаа хийхэд шаардлагатай чадварыг эзэмшиж, бие даан сурах чадвараа харуулна. Сурахад дурлаж, энэхүү сурахад дурлах байдал амьдралын туршид үргэлжилнэ. |
| **Мэдлэгтэй байх** | Улс нутагт болон дэлхий даяар ач холбогдолтой концепц, санаа, асуудлыг суралцана. Энэ явцдаа мэдлэгээ гүнзгийрүүлж, янз бүрийн салбарыг хамарсан өргөн, тэнцвэртэй ойлголтыг хөгжүүлнэ. |
| **Бодож тунгаах** | Асуудлыг цогцоор нь ойлгох, шалтгааныг гаргах, ёс зүйтэй шийдвэр гаргахын тулд шүүмжтэй, бүтээлчээр бодож сэтгэх чадварыг ашиглах санаачилга гаргана. |
| **Харилцаа** | Нэгээс олон тооны хэлээр болон харилцааны янз бүрийн байдлаар санаа, мэдээллийг сайтар ойлгож, бүтээлчээр харилцах чадвартай байна. Бусадтай бүтээмжтэй, хүсэл эрмэлзэлтэйгээр хамтарч ажиллана. |
| **Зарчим** | Ёс зүйтэй, шударга байж, шударга байдал, шударга ёсны талаар хүчтэй мэдрэмжтэй, хувь хүн, бүлэг, хүмүүсийн нийгэмлэгийн нэр төрийг хүндэтгэнэ. Өөрсдийн үйлдэлд хариуцлага хүлээж, үр дагаврыг хариуцна. |
| **Нээлттэй байх** | Өөрийн соёл, хувь хүний түүхээ ойлгож, хүндлэхийн зэрэгцээ бусад хүмүүс, нийгэмлэгүүдийн харах өнцөг, үнэт зүйл, уламжлалд нээлттэй хандана. Янз бүрийн харах өнцгийг олж мэдэж, үнэлж дүгнэхэд нээлттэй байх ба өөрийн туршлагадаа үндэслэж өсөж дэвжих хүсэлтэй байна. |
| **Санаа тавих** | Бусдын мэдрэмж, сэтгэл санааг ойлгож, хүндэлж үзэхээ харуулна. Бусад хүмүүсийн амьдрал, байгаль орчинд эерэг өөрчлөлтийг авчрахад хувь хүний хувьд үйлчлэх хүсэлтэй байна. |
| **Эрсдэл гаргагч** | Таньж мэдэхгүй нөхцөл байдалд зоригтой, эрэлхийлэгчээр хандах ба шинэ үүрэг хариуцлага, санаа, стратегийн талаар таньж мэдэх хүсэл зоригтой байна. Зоригтой байж, өөрийн итгэл үнэмшлээ хамгаалж илэрхийлнэ. |
| **Тэнцвэртэй байдал** | Тайван, сэтгэл хангалуун байх нь өөрт болон бусдад тустайг ойлгож оюун санаа, бие бялдар, сэтгэл хөдлөлийн тэнцвэртэй байдлын чухлыг ойлгоно. |
| **Тунгааж үзэх** | Өөрийн сурч байгаа байдал, туршлагын талаар дүгнэж, тунгааж үзнэ. Өөрийн сурах үйл явц, хувийн хөгжлөө дэмжихийн тулд өөрийн давуу тал, хязгаарыг үнэлж, ойлгоно. |

© International Baccalaureate Organization 2006

| **Washington-Liberty ахлах сургууль**<br>**Олон улсын бакалаврын хөтөлбөр** | | | | |
|---|---|---|---|---|
| **ОУБ-ын бүлэг** | **9-р анги** | **10-р анги** | **11-р анги** | **12-р анги** |
| **Бүлэг 1**<br>**Хэлний А** | Англи хэл (10035) | Англи хэл (10035)<br><br>Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан АТ Испани хэл | ОУБ Англи хэл, уран зохиол, HL хэсэг 1<br>ОУБ Англи хэл, уран зохиол, SL хэсэг 1<br>ОУБ Испани хэл, уран зохиол, HL<br>(Чөлөөтэй ярьдаг хүмүүс - хос хэлтний диплом) хэсэг 1 | ОУБ Англи хэл, уран зохиол, HL хэсэг 2<br>ОУБ Англи хэл, уран зохиол, SL хэсэг 2<br>ОУБ Испани хэл, уран зохиол, HL<br>(Чөлөөтэй ярьдаг хүмүүс - хос хэлтний диплом) хэсэг 2 |
| **Бүлэг 2**<br>**Хэл сурах** | Испани хэл III<br>эсхүл FS II<br>Франц хэл III<br>Хятад хэл III<br>Латин хэл III | Испани хэл IV<br>эсхүл FS III<br>Франц хэл IV<br>Хятад хэл IV<br>Латин хэл IV | ОУБ Испани хэл B SL/HL хэсэг 1<br>ОУБ Франц хэл SL/HL хэсэг 1<br>ОУБ Мандарин/Хятад хэл SL/HL хэсэг 1<br>ОУБ Латин хэл SL/HL хэсэг 1<br>ОУБ Араб хэл SL хэсэг 1 | ОУБ Испани хэл B SL/HL хэсэг 2<br>ОУБ Франц хэл SL/HL хэсэг 2<br>ОУБ Мандарин/Хятад хэл SL/HL хэсэг 2<br>ОУБ Латин хэл SL/HL хэсэг 2<br>ОУБ Араб хэл SL хэсэг 2 |
| **Бүлэг 3**<br>**Хувь хүн ба нийгэм** | Дэлхий түүх: | АТ Засгийн газар хоёрдугаар ангийнханд | ОУБ Америкийн түүх HL Хэсэг 1<br>ОУБ Бизнес, менежмент SL (нэг жил)<br>ОУБ Эдийн засаг SL (нэг жил)<br>ОУБ Газар зүй SL (нэг жил)<br>ОУБ ITGS SL (нэг жил)<br>ОУБ Философи SL (нэг жил)<br>ОУБ Философи SL (нэг жил) эсхүл HL хэсэг 1<br>ОУБ Нийгмийн антропологи SL (нэг жил) эсхүл HL хэсэг 1 | 20-р зууны Дэлхийн түүх HL хэсэг 2 ОУБ-ын сэдвүүд<br>ОУБ Бизнес, менежмент SL (нэг жил)<br>ОУБ Эдийн засаг SL (нэг жил)<br>ОУБ Газар зүй SL (нэг жил)<br>ОУБ ITGS SL (нэг жил)<br>ОУБ Философи SL (нэг жил)<br>ОУБ Философи SL (нэг жил) эсхүл HL хэсэг 2<br>ОУБ Нийгмийн антропологи SL (нэг жил) эсхүл HL хэсэг 2 |
| **Бүлэг 4**<br>**Туршилтын Шинжлэх ухаан** | Биологи* | Хими* | ОУБ Биологи SL (нэг жил) эсхүл HL хэсэг 1<br>ОУБ Хими (HL) Хэсэг 1<br>ОУБ Мэдээлэл зүй SL хэсэг 1 or HL хэсэг 1<br>ОУБ Дизайны технологи (SL) хэсэг 1<br>ОУБ Байгал орчны системүүд SL (нэг жил, давхар блок)<br>ОУБ Физик SL хэсэг 1<br>ОУБ Спорт, дасгал, эрүүл мэндийн шинжлэх ухаан SL хэсэг 1 | ОУБ Биологи SL (нэг жил) эсхүл HL хэсэг 2<br>ОУБ Хими HL Хэсэг 2<br>ОУБ Мэдээлэл зүй SL хэсэг 1 or HL хэсэг 2<br>ОУБ Дизайны технологи SL хэсэг 2<br>ОУБ Байгал орчны сис. SL (нэг жил, давхар блок)<br>ОУБ Физик SL хэсэг 2<br>ОУБ Спорт, дасгал, эрүүл мэндийн шинжлэх ухаан SL хэсэг 2 |
| **Бүлэг 5**<br>**Математик** | Геометр* эсхүл Алгебр II* | Алгебр II* эсхүл ОУБ Математик SL хэсэг 1 (эрчимжүүлсэн) | Алгебр III<br>ОУБ Математик: Анализ, аргачлал SL хэсэг 1 (Дээд тооны удиртгал)<br>ОУБ Математик: Анализ, аргачлал SL хэсэг 2 / HL хэсэг 1 (BC Калк) | ОУБ Математик Хэрэглээ ба тайлбар SL (нэг жил)<br>ОУБ Математик: Анализ, аргачлал SL хэсэг 2 / HL хэсэг 2 (AB эсхүл BC Калк)<br>ОУБ Математик: Анализ, Аргачлал HL хэсэг 2 |
| **Бүлэг 6 ба Сонгох** | Сонгох | Сонгох | ОУБ Кино SL хэсэг 1 эсхүл HL хэсэг 1<br>ОУБ Хөгжим SL (нэг жил)<br>ОУБ Театр SL (нэг жил) эсхүл Театр HL хэсэг 1<br>ОУБ Визуал урлаг (HL) хэсэг | ОУБ Кино SL хэсэг 2 эсхүл HL хэсэг 2<br>ОУБ Хөгжим SL (нэг жил)<br>ОУБ Театр SL (нэг жил) эсхүл Театр HL хэсэг 2<br>ОУБ Визуал урлаг (нэг жил) эсхүл ОУБ Визуал (HL) хэсэг 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бусад** | Эрүүл мэнд/Биеийн тамир I | Эрүүл мэнд/Биеийн тамир I | Сонгох/Ерөнхий цаг/ TOK | Сонгох/Ерөнхий цаг/ TOK |

Тайлбар: *Эрчимжүүлсний зөвлөж байна. **Эрчимжүүлсэн эсхүл AT зөвлөж байна. HL гэдэг илүү өндөр түвшин гэсэн үг бөгөөд хамгийн багадаа 240 цагийн хичээл шаардана. Бүх HL хичээлийг хоёр жилийн хугацаанд заана. SL гэдэг илүү стандарт түвшин гэсэн үг бөгөөд хамгийн багадаа 150 цагийн хичээл шаардана. ОУБ-ыг бүрэн хэмжээгээр авсан сурагчид бүлэг бүрээс нэг хичээл авах ёстой. Сурагчид бүлэг 1-ийн хоёр хичээлийг авснаар хос хэлтний диплом авна. Сурагчид ахлах сургуулийн эхний жилийн эцэст хоёр SL шалгалт өгч болно. 11 болон 12-р ангийн тусгайлсан хичээлийн хуваариар сурагч бүрд өөрийн гэсэн хувилбар бий болгоно.

## БҮТЭЭЛЧ, ИДЭВХТЭЙ, ҮЙЛЧИЛГЭЭ

Сурагчид бүтээлч, идэвхтэй, үйлчилгээ гэсний бүрдэл бүрд өөрийн сонирхлыг тусгаж өөрийн төлөвлөгөөг тодорхойлно. Ихэнхийг хичээлийн болон хичээлээс гадуурх хөтөлбөрийн хүрээнд гаргаж болно. Сурагч бүр ахлах сургуулийн сүүлийн хоёр жилд (зуныг багтааж) хоёр CAS үйл ажиллагаанд оролцох ёстой. Үүний нэг хэсэг нь үйлчилгээнд чиглэх ёстой. Үйлчилгээг бие даан эсхүл бүлгээр үзүүлж болно. Үйлчилгээтэй холбоотой боломжуудын талаар мэдээллийг CAS зохицуулагчаас эсхүл W-L дэх ОУБ-ын газраас авч болно. Сурагчид эдгээр чухал ажлуудыг хийхээсээ өмнө өөрийн саналаа эхэлж CAS-ын зохицуулагчид танилцуулж, зөвшөөрөл авах ёстой.

## МЭДЛЭГИЙН ОНОЛ

Мэдлэгийн тухай олон салбарыг нэгтгэсэн онолын хичээл (TOK) нь салбар бүрийн мэдлэгийн мөн чанарын талаар мэдэж авч, тэдгээрийн харах өнцгийг үнэлж хүндэтгэхэд чиглэсэн.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ЭСЭЭ

Дэлгэрэнгүй эсээг ОУБ-ын хөтөлбөрийн зургаан бүлэг хичээлийн нэгээс, заасан сэдвүүдээр гүнзгийрүүлсэн судалгаа хийх гэж тодорхойлно. Энэ нь сурагчид бие даан судалгаа хийх боломж олгох зорилготой. Сурагчид өөрийн сонирхсон салбарыг авах нь зүйтэй юм. Ахлах сургуулийн эхний жилийн явцад сурагч сэдвээ сонгож, факультетын зөвлөхөд сурагчийг ногдуулна. Сурагчид ахлах сургуулийн эхний жилдээ төслөө эхлүүлэх хэрэгтэй бөгөөд зөвлөхийн зааврын дагуу удаах зунд ажлаа үргэлжлүүлнэ. Дэлгэрэнгүй эссэнд холбогдож хугацаа заасан байдаг ба зөвлөх болон сурагчид хамтарч эсээг гүйцэтгэж дуусах цагийн хуваарийг хамтарч гаргаж болно. Үүнд төгсөх ангийн сурагчийн нэмэгдэж байгаа хичээлийн ачаалал, коллежид элсэх хүсэлт гаргах үйл явц, цагийн асуудлыг харгалзаж үзнэ. Дэлгэрэнгүй эсээг төгсөх жилийн эхний улиралд хийж өгнө.

## ОЛОН УЛСЫН БАКАЛАВРЫН ХИЧЭЭЛИЙН САНАЛУУД

### <u>Бүлэг 1</u>

### *Хэлний А*

| | | |
|---|---|---|
| **ОУБ Англи хэл, уран зохиол, HL)** | **Хэсэг I (31197)** | **Хоёр жил, хоёр кредит** |
| | **Хэсэг II (31198)** | **(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Англи хэл 10 эрчимжүүлсэн эсхүл зааварлагчийн зөвлөснөөр*
The ОУБ Англи хэл, уран зохиол HL нь хоёр жилийн сургалт бөгөөд ОУБ-ын шаардлага болон Виржиниа муж улс, Арлингтоны Улсын сургуулиудын шаардлагуудыг хангана. ОУБ Англи хэл, уран зохиол HL хичээлийн хүрээнд сурагчид ОУБ-ын холбогдох журмын дагуу уран зохиолд анхаарлаа төвлөрүүлнэ. Үүний зэрэгцээ өөрсийн бүтээлч, шүүмжит сэтгэлгээний чадвараа дээшлүүлж, дэлхийн иргэн бөгөөд урт хугацааны суралцагч болоход шаардлагатай чадвар, мэдлэгээ дээшлүүлнэ. *Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Англи хэлний өндөр түвшиний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (21197) (21198).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм. Энэ хичээл болон Хэл А-ийн хичээлийг амжилттай дүүргэсэн сурагчид ОУБ-ын хос хэлтний дипломыг авах эрхтэй болно. *SOL шалгалтыг Хэсэг 1-ийн төгсгөлд авна 1. SOL шалгалтад тэнцэх, мөн хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл (HL)**

| | | |
|---|---|---|
| **ОУБ-ын англи хэл уран зохиол (SL)** | **Хэсэг I (31190)<br>Хэсэг II (31191)** | **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Англи хэл 10 эрчимжүүлсэн эсхүл зааварлагчийн зөвлөснөөр*
The ОУБ Англи хэл, уран зохиол SL нь хоёр жилийн сургалт бөгөөд ОУБ-ын шаардлага болон Виржиниа муж улс, Арлингтоны Улсын сургуулиудын шаардлагуудыг хангана. ОУБ Англи хэл, уран зохиол SL хичээлийн хүрээнд сурагчид ОУБ-ын холбогдох журмын дагуу хэл, уран зохиолд анхаарлаа төвлөрүүлнэ. Сурагчид уншиж буй зүйлдээ дүн шинжилгээ хийх болон уран зохиолын ба уран зохиолын уншлагыг унших дадлага болгох чадварыг хөгжүүлж, хэл ба унших зүйлийн утгыг ухаж ойлгох асуулт асуух хэрэгтэй байна. Үүний зэрэгцээ өөрсийн бүтээлч, шүүмжит сэтгэлгээний чадвараа дээшлүүлж, дэлхийн иргэн бөгөөд урт хугацааны суралцагч болоход шаардлагатай чадвар, мэдлэгээ дээшлүүлнэ. *Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Англи хэлний стандарт түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (21190) (21191).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм. Энэ хичээл болон Хэл А-ийн хичээлийг амжилттай дүүргэсэн сурагчид ОУБ-ын хос хэлтний дипломыг авах эрхтэй болно. *SOL шалгалтыг Хэсэг 1-ийн төгсгөлд авна. SOL шалгалтад тэнцэх, мөн хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

| | | |
|---|---|---|
| **ОУБ Испани хэл уран зохиол (HL)** | **Хэсэг I (35577)<br>Хэсэг II (35587)** | **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Чөлөөтэй яригсдын Испани хэл III эсхүл AT Испани хэл ба багшийн зөвлөгөө*
ОУБ-ын хэл, уран зохиол HL хичээл нь хоёр жилийн хичээл бөгөөд ОУБ-ын шаардлагыг хангана. ОУБ Испани хэл, уран зохиол HL хичээлийн хүрээнд сурагчид ОУБ-ын холбогдох журмын дагуу хэл, уран зохиолд анхаарлаа төвлөрүүлнэ. Үүний зэрэгцээ өөрсийн бүтээлч, шүүмжит сэтгэлгээний чадвараа дээшлүүлж, дэлхийн иргэн бөгөөд урт хугацааны суралцагч болоход тэдэнд шаардлагатай чадвар, мэдлэгээ дээшлүүлнэ. *Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Испани хэлний өндөр түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (25577) (25587).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм. Энэ хичээл болон Хэл А-ийн хичээлийг амжилттай дүүргэсэн сурагчид ОУБ-ын хос хэлтний дипломыг авах эрхтэй болно.

## **Бүлэг 2**

***L Хэлний***

| | | |
|---|---|---|
| **ОУБ Араб хэл (SL)** | **Хэсэг I (35841))**<br>**Хэсэг II (35845)** | **Хоёр жил, хоёр кредит**<br>**(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Араб хэл түвшин IV ба багшийн зөвлөснөөр*
ОУБ-ын Араб хэлний хичээл нь хоёр жилийн хичээл бөгөөд ОУБ-ын шаардлагыг хангана. Энэ хичээлээр хэл сурах, хэлний чадваруудыг хөгжүүлэхэд анхаарна. Эдгээр хэлний чадваруудыг сурч, янз бүрийн бичгийн болон ярианы материалуудыг хэрэглэж хөгжүүлнэ. Ийм материал нь өдөр тутмын ярианаас уран зохиол унших хүртэл байна. Сэдвүүдэд харилцаа ба медиа, дэлхий нийтийн асуудлууд, нийгмийн харилцаа, соёлын ялгаатай байдал, уламжлал, заншил, эрүүл мэнд, чөлөөт цаг, шинжлэх ухаан болон уран зохиол судлах багтана. *Энэ хичээлээр сурагчдыг ОУБ-ын стандарт түвшний Араб хэлний шалгалтад бэлтгэх ба шалгалтыг хэл сурсан 6 дахь жилийн эцэст авна. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (25841) (25845).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

| | | |
|---|---|---|
| **ОУБ Мандарин Хятад хэл ab initio (SL)** | **Хэсэг I (35815)**<br>**Хэсэг II (35825)** | **Хоёр жил, хоёр кредит**<br>**(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Хятад хэл түвшин IV ба багшийн зөвлөснөөр*
ОУБ-ын Хятад хэлний хичээл нь хоёр жилийн хэл сурах хичээл бөгөөд ОУБ-ын шаардлагыг хангана. Энэ нь өмнө нь хязгаартай хэмжээнд Мандарин сурсан сурагчдад зориулагдсан. Сурагчид Мандаринаас харилцаж сурах явцдаа хүлээж авах, бүтээмжтэй, харилцах чадварыг эзэмшинэ. Таван сэдэвт анхаарна: хувь чанар, туршлага, хүний ухаан, нийгмийн зохион байгуулалт, ертөнцөд хамтдаа амьдрах. Энэ хичээлээр сурагчдыг ОУБ-ын стандарт түвшний Мандарин Хятад хэлний шалгалтад бэлтгэх ба шалгалтыг хэл сурсан 6 дахь жилийн эцэст авна. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (25815) (25825). Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

| | | |
|---|---|---|
| **ОУБ Мандарин Хятад B (SL)** | **Хэсэг I (35817)**<br>**Хэсэг II (35827)** | **Хоёр жил, хоёр кредит**<br>**(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Хятад хэл түвшин IV ба багшийн зөвлөснөөр*
ОУБ-ын Хятад хэлний хичээл нь хоёр жилийн хэл сурах хичээл бөгөөд ОУБ-ын шаардлагыг хангана. Энэ нь өмнө нь хязгаартай хэмжээнд зорилтот хэлийг сурсан сурагчдад зориулагдсан. Энэ хичээлээр хэл сурах, хэлний чадваруудыг хөгжүүлэхэд анхаарна. Сурагчид хэл, сэдэв, уншлагын зүйлийг сурч харилцах замаар өөрийн чадвараа хөгжүүлнэ. Сурагчид танил болон танил бус зүйлийн талаар харилцаж сурна. Энэ хичээлийг авсан сурагчид тухайн сэдвээр гүнзгийрүүлэн сурах тул өөрсдийн

чадвараа ab initio сурагчдаас илүү өндөр түвшинд хүргэнэ. Энэ хичээлээр сурагчдыг ОУБ-ын стандарт түвшний Мандарин Хятад SL хэлний шалгалтад бэлтгэх ба шалгалтыг хэл сурсан 6 дахь жилийн эцэст авна. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (25817) (25827). Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

| | | |
|---|---|---|
| **ОУБ Мандарин Хятад (HL)** | **Хэсэг I (35816)**<br>**Хэсэг II (35826)** | **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Хятад хэл түвшин IV ба багшийн зөвлөснөөр*
ОУБ-ын Хятад хэлний хичээл нь хоёр жилийн хичээл бөгөөд ОУБ-ын шаардлагыг хангана. Энэ хичээлээр хэл сурах, хэлний чадваруудыг хөгжүүлэхэд анхаарна. Эдгээр хэлний чадваруудыг сурч, янз бүрийн бичгийн болон ярианы материалуудыг хэрэглэж хөгжүүлнэ. Ийм материал нь өдөр тутмын ярианаас уран зохиол унших хүртэл байна. Сэдвүүдэд харилцаа ба медиа, дэлхий нийтийн асуудлууд, нийгмийн харилцаа, соёлын ялгаатай байдал, уламжлал, заншил, эрүүл мэнд, чөлөөт цаг, шинжлэх ухаан болон уран зохиол судлах багтана. Мандарин/Хятад B SL ба HL-ийн сурагчид танил болон танил бус сэдвүүдээр зорилтот хэлээр харилцаж сурна. Хэл B SL ба HL-ийн ялгаа нь ойлгох, бүтээмжтэй байх, харилцах чадварт холбогдох сурагчийн чадварын түвшнээр тодорхойлогдоно. HL-ээр зорилтот хэл дээр бичигдсэн хоёр уран зохиолын бүтээлийг сурахыг шаардах ба сурагчид харилцахдаа хэрэглэж байгаа хэлээ илүү олон янзаар, илүү ахисан түвшинд хэрэглэхийг сурагчдаас шаардана. *Энэ хичээлээр сурагчдыг ОУБ-ын стандарт түвшний Мандарин Хятад SL хэлний шалгалтад бэлтгэх ба шалгалтыг хэл сурсан 6 дахь жилийн эцэст авна. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (25816) (25826).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

| | | |
|---|---|---|
| **ОУВ Франц хэл (SL)** | **Хэсэг I (35157)**<br>**Хэсэг II (35167)** | **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Франц хэл түвшин IV ба багшийн зөвлөснөөр*
Сурагчид ярих, сонсох, унших, бичих чадвараа бүгдийг нь илүү нарийн болгож хөгжүүлнэ. Дүрмийн бүтцийг үзэж, илүү нарийвчлах ба үгсийн санг хөгжүүлэх, баяжуулахад илүү анхаарна. Сурагчид өөрсдийн хэлний ба соёлын мэдлэгээ сонин, сэтгүүл, радио телевизийн хөтөлбөрийн бичлэг, уран зохиол (зөгнөлт, баримтат зохиол) зэрэг янз бүрийн эх сурвалжаас олж авах ба эдгээр нь бүгд өөрчлөлт, бүлэг, зугаа цэнгэл гэсэн гурван сэдэвт тулгуурлана. Энэ хичээлээр сурагчдыг ОУБ-ын стандарт түвшний Франц хэлний шалгалтад бэлтгэх ба шалгалтыг хэл сурсан 6 дахь жилийн эцэст авна. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг сурагчид авахгүй (25157) (25167). Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Франц B (HL)** **Хэсэг I (35158)** **Хэсэг II (35168)** **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)**

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Франц хэл түвшин IV ба багшийн зөвлөснөөр*
Хэлний B хичээлийн төгсгөлд Өндөр түвшний сурагчид ойлгомжтой, хурдтайгаар олон янзын нөхцөл байдалд харилцах чадвартай болсон байх ёстой; хэлний бүх чухал аман болон бичгийн хэлбэрийг янз бүрийн хэлбэр, нөхцөл байдалд оновчтой хэрэглэж, ойлгохоо харуулах; өргөн хүрээний үгсийн санг ойлгож, ихээхэн хэсгийг нь хэрэглэх; тухайн тохиолдолд ерөнхийдөө тохирох илэрхийлэл, хэлбэрийг сонгох, санаагаа ерөнхийдөө ойлгомжтой бөгөөд чөлөөтэй илэрхийлэх; аргументийг ойлгомжтой, логиктой, итгүүлж тавих; нэлээдгүй хүнд ярианы болон бичгийн материалыг ойлгож, шинжлэх; хэлний дам санааг ойлгох; сурч байгаа хэлтэй холбоотой соёлын талаар мэдлэгээ харуулах шаардлагатай. *Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Франц хэлний өндөр түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг сурагчид авахгүй (25158) (25168).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Латин хэл (SL)** **Хэсэг I (35357)** **Хэсэг II (35367)** **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)**

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Латин хэл IV ба багшийн зөвлөснөөр*
Энэхүү хоёр жилийн сургалт нь сурагчид өмнөх жилүүдэд Латин хэлний хичээлээр сурсан хэлний чадвар дээр суурилж, сонгодог зохиолчид оригинал хэл дээр бичсэн зүйлс дээр анхаарлаа төвлөрүүлнэ. Сурагчид сонгодог уран зохиолыг (илтгэл болохын хувьд, үгсийн сан, соёлын контекст зэргээр) өргөн утгаар нь ойлгох ба үүнд өөрийн хувийн дүгнэлтээ хийх чадвартай болно. Үүний дээр сурагчид оригинал Латин хэлний текстийг унших дээрээ нэмж олон төрлийн орчуулгыг болон судалгааны бичгийг унших ба холбогдох мэдээллийг цуглуулж, шинжлэх чадвараа баяжуулж, сонгодог соёлыг ойлгох ойлголтоо өөрийн соёлтой ижил эсхүл ялгаатай байдлын талаар мэдэж баяжуулна. Хоёр жилийн курс (2022 оны хавар хүртэл идэвхтэй хичээлийн хөтөлбөр) нь Овидийн хувиргалт болон дараах зохиогч, сэдвүүдийг хамарна. Villains - Vergil, *Aeneid*, номын хэсэг 10, Livy, *Ab Urbe Condita* ба Lucretia-д холбогдох хэсэг; Sallust, *Bellum Catilinae*-ийн хэсэг; Түүх - Caesar, *De Bello Gallico*, VII номын хэсэг. *Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Латин хэлний стандарт түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (25357) (25367).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

| | | |
|---|---|---|
| **ОУБ Латин хэл (HL)** | **Хэсэг I (35362)**<br>**Хэсэг II (35372)** | **Хоёр жил, хоёр кредит**<br>**(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Латин хэл IV ба багшийн зөвлөснөөр*
ОУБ-ын Латин хэлний хичээл нь хоёр жилийн хичээл бөгөөд Бүлэг Хоёрын шаардлагыг хангана. Энэхүү хоёр жилийн сургалт нь сурагчид өмнөх жилүүдэд Латин хэлний хичээлээр сурсан хэлний чадвар дээр суурилж, сонгодог зохиолчид оригинал хэл дээр бичсэн зүйлс дээр анхаарлаа төвлөрүүлнэ. Сурагчид сонгодог уран зохиолыг (илтгэл болохын хувьд, үгсийн сан, соёлын контекст зэргээр) өргөн утгаар нь ойлгох ба үүнд өөрийн хувийн дүгнэлтээ хийх чадвартай болно. Үүний дээр сурагчид оригинал Латин хэлний текстийг унших дээрээ нэмж олон төрлийн орчуулгыг болон судалгааны бичгийг унших ба холбогдох мэдээллийг цуглуулж, шинжлэх чадвараа баяжуулж, сонгодог соёлыг ойлгох ойлголтоо өөрийн соёлтой ижил эсхүл ялгаатай байдлын талаар мэдэж баяжуулна. Хоёр жилийн хичээл (хөтөлбөр 2022 хавар идэвхтэй байна) нь Ovid-ийн метаморфоз болон дараах зохиолчид, сэдвийг хамарна**: Villains** - Vergil, *Aeneid,* номын хэсэг 10, *Livy, Ab Urbe Condita,* Lucretia ба Verginia-д холбогдох хэсэг; Sallust, Bellum Catilinae-ийн хэсэг; Түүх - Caesar, De Bello Gallico, VII номын хэсэг, Livy, Ab Urbe Condita, Trasimine нуурын тулалдаанд холбогдох хэсэг. Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Латин хэлний өндөр түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. HL Латин хэлний шалгалт SL шалгалтаас ойролцоогоор ⅓-ээр илүү материал хамрах ба Англиар бичсэн жижиг эсээ багтаах ба хөтөлбөрийн дагуух унших зүйл, хичээлээс гадуурх уншлага, судалгааны бичгийг багтаана. *Сурагчид сонгодог ертөнцөд холбогдох өөрийн сонирхлын сэдвээр англи хэлээр судалгааны ажлын хэлбэрээр ажил бичиж, дотоод үнэлгээ авна (10-12 эх бичиг, 1200-үгийн хязгаартай). Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (25362) (25372).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

| | | |
|---|---|---|
| **ОУБ Испани хэл B (SL)** | **Хэсэг I (35575)**<br>**Хэсэг II (35585)** | **Хоёр жил, хоёр кредит**<br>**(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Испани хэл IV эсхүл чөлөөтэй яригсдын Испани хэл III ба багшийн зөвлөгөө*
Харилцах ярианы хэлэнд анхаарахын зэрэгцээ сонсох, унших, бичих чадварт анхаарна. Медиа, театр, нутгийн онцгой Испани мэргэжилтнүүд зэрэг янз бүрийн эх үүсвэрийг сурагчийн хэлийг баяжуулахад ашиглана. Гурван гол сэдвүүд: өөрчлөлт, бүлэг, чөлөөт цаг нь хичээлийн хөтөлбөрийн гол анхаарах зүйл юм. *Энэ хичээлээр сурагчдыг ОУБ-ын стандарт түвшний Испани хэлний шалгалтад бэлтгэх ба шалгалтыг хэл сурсан 6 дахь жилийн эцэст авна. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (25575) (25585).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Испани хэл B (HL)** **Хэсэг I (35578)** **Хэсэг II (35588)** **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)**

**Ангиуд: 11-12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Испани хэл түвшин IV ба багшийн зөвлөснөөр*
Хэлний B хичээлийн төгсгөлд Өндөр түвшний сурагчид ойлгомжтой, хурдтайгаар олон янзын нөхцөл байдалд харилцах чадвартай болсон байх ёстой; хэлний бүх чухал аман болон бичгийн хэлбэрийг янз бүрийн хэлбэр, нөхцөл байдалд оновчтой хэрэглэж, ойлгохоо харуулах; өргөн хүрээний үгсийн санг ойлгож, ихээхэн хэсгийг нь хэрэглэх; тухайн тохиолдолд ерөнхийдөө тохирох илэрхийлэл, хэлбэрийг сонгох, санаагаа ерөнхийдөө ойлгомжтой бөгөөд чөлөөтэй илэрхийлэх; аргументийг ойлгомжтой, логиктой, итгүүлж тавих; нэлээдгүй хүнд ярианы болон бичгийн материалыг ойлгож, шинжлэх; хэлний дам санааг ойлгох; сурч байгаа хэлтэй холбоотой соёлын талаар мэдлэгээ харуулах шаардлагатай. *Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Испани хэлний өндөр түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (25578) (25588).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

## Бүлэг 3

***Хувь хүн ба нийгэм***

**ОУБ Бизнес, менежмент (SL)** **(36114)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**
**Анги: 10 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх математик ба байгалийн шинжлэлийн хичээлд B дундаж дүнтэй*
Энэ хичээл нь динамик бизнесийн орчинд хувь хүн, бүлгүүд хэрхэн харилцдаг талаар эрчимтэй ба шүүмжтэй сурах зорилготой хичээл юм. Энэ нь бизнесийн шийдвэрийг хэрхэн гаргадаг, эдгээр шийдвэрүүд нь дотоод ба гадаад орчинд хэрхэн нөлөөлдөг ба эдгээр шийдвэрүүд нь хэрхэн олон улсын хамтын ажиллагаа ба хариуцлагатай иргэнийг бүрдүүлдэг талаар үзнэ. Бизнесийн боловсролын аргыг хичээлээр хэрэглэнэ. Сурагчид танхимын хичээлийг хичээлийн жилийн туршид байнга зааварчилгаа авч зөвшөөрөгдсөн ажлын байранд хийх дадлагатай хослуулж болно. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Бизнес, менежментийн ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (26114).* Энэ хичээл нь Карьер техник/Урлагийн кредиттэй.

**IB Цахим Нийгэм (SL)** **(36617/26617)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**

**Анги: 11 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
IB Дипломын Хөтөлбөрийн Дижитал Нийгэм курс нь хувь хүн болон нийгмийн сэдвийн бүлгүүдийн хүрээнд явагддаг салбар хоорондын сургалт юм. Энэхүү сургалт нь орчин үеийн ертөнцөд дижитал систем, технологийн үр нөлөө, ач холбогдлыг судлах сонирхолтой залуучуудад зориулагдсан болно. Уг курс нь ухагдахуун, агуулга, контекстийг лавлагаагаар нэгтгэдэг. Суралцахдаа бодит жишээн дээр төвлөрч, дижитал нийгэмтэй холбоотой төрөл бүрийн эх сурвалжуудыг судалж, дижитал системийн хүмүүс болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг судалж, шинээр гарч ирж буй чиг хандлага, ирээдүйн хөгжлийн талаар тусгана. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд ITGS-ийн ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (26617).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Эдийн засаг (SL)** **(32802)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**

**Анги: 10 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх нийгэм судлалын хичээлийн багшийн бичгээр өгсөн зөвлөмж эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*
Эдийн засаг нь эх үүсвэрүүдийг хэрхэн, яагаад хуваарилдаг талаар үзэх динамик нийгмийн ухаан юм. Энэ нь хувь хүн, байгууллага, үндэстнүүд хэрхэн эдийн засгийн зорилтын төлөө зохион байгуулалтад ордог талаар сонирхолтой, бидэнд хамааралтай хичээлд түүх, газар зүй, сэтгэл судлал, социологи, улс төр, математик, шинжлэх ухааныг нэгтгэнэ. Энэ хичээлээр бодит амьдралын асуудалд онолын үүднээс харахад анхаарна. Гол сэдвүүдэд микро эдийн засаг, макро эдийн засаг, олон улсын худалдаа, эдийн засгийн хөгжил багтана. Нэлээд хэдэн зүйлийг анхаарч үзнэ: Татварыг нэмэх ёстой юу эсхүл багасгах ёстой юу? Худалдааны дефицит чухал уу? үгүй юу? Ажилгүйдлийг багасгах боломжтой юу? Ирээдүйн засгийн газар нийгмийн халамжийг төлж чадах уу? байгаль орчныг үнэлэх ёстой юу? Хөгжиж буй орнуудын өрийг чөлөөлөхийн төлөөх ямар аргументүүд байх вэ? АНУ нь NAFTA-ийн гишүүн байсан хэвээр байх ёстой юу? *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Эдийн засгийн ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Энэ хичээлийг амжилттай дүүргэснээр сурагчдын Эдийн засаг, хувийн санхүүгийн төгсөлтийн шаардлагыг хангана. Энэ хичээлийн зарим хэсгийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй. (22802).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Газар зүй (SL)** **(32210)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**

**Анги: 10 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Нийгэм судлал багш эсхүл ОУБ-ын зохицуулагчийн зөвлөмж*
Энэ хичээл нь зохион байгуулалтын хувьд сэдвээр, анхаарах зүйл нь хүн, агуулга нь өргөн байна. Хүн ам, эх үүсвэр, эдийн засгийн ба амьдралын чанарын зарчмуудыг багтааж хөгжлийн тухай хоорондоо холбоотой сэдвүүд нь гол асуудал нь байна. Үндсэн агуулгыг дагалдуулж физик газарзүйн цувралууд байх ба тус бүр нь хүний менежмент, хариу үйлдэл байна. Чадварт суурилсан, газар зүйчдийн зураглал гаргах ба төсөөтэй аргачлалуудыг хэрэглэхийг онцгойлж, байршлын зураг, газрын зураг, зургуудаар хүний ба биеийн зүйлсийг нэгтгэхийг тодруулж үзнэ. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Газарзүйн ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (22210).*Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Америкийн түүх (HL)** **Хэсэг I (32385)** **Бүтэн жил, нэг кредит (хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр +1.0 чанарын оноо ба HL ОУБ шалгалт)**

**Анги: 11.**

**Шаардлага хангасан бүх 11 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Дэлхийн түүх (Эрчимжүүлсэн зөвлөсөн) ба АТ ВИ/АНУ-ын Засгийн газрыг дүүргэх*

Америкчуудын түүх хичээлээр сурагчдад Америкийн талаар сэдэвчилж гүнзгийрүүлэн үзнэ. Хичээлээр түүхийг шинжлэх ухааны салбар болохын хувьд танилцуулж, сурагчдад түүхийг шинжлэх үйл явцыг ойлгоход тусална. Америкийн түүх бол Америк үндэстний түүхийг Нэгдсэн Улсын түүхэд илүү анхаарч, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын түүхийг нарийвчлан үзэх хичээл юм. Сурагчдад түүхийг нотолгоонд суурилах талаасаа шинжлэх ухаан, мэдэж авснаа бичих, түгээх талаасаа урлаг гэдгийг танилцуулна. Түүх бол янз бүрийн эх сурвалжаас авсан нотолгоо судлалаар өнгөрснийг бичиж авч, эргэн тогтоох мэргэжлийн түүхчдийн оролдлого юм. Энэ нь хүн, нийгмийг хамгийн өргөн утгаар нь авч үздэг: улс төр, нийгэм, эдийн засаг, соёл. Сурагчид түүхийн мөн чанарыг ойлгож, түүхэн бичлэгийг тайлбарлах, ойлгоход эх сурвалжуудыг ашиглах чадвартай болно. *Энэ хичээл нь Хорьдугаар зууны дэлхийн түүхийн сэдвүүдтэй хамт Америкийн түүхийн хичээлийн Виржиниа муж улсын шаардлагыг хангах ба төгсөх жил авах түүхийн хичээлийн өндөр түвшиний ОУБ-ын шалгалтад сурагчдыг бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (22385).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

Хорьдугаар зууны дэлхийн түүх сэдвээр цааш суралцахгүй бөгөөд Америкийн түүх хичээлийг дүүргэсэн бол ВИ/АНУ SOL шалгалтаар сурагчид ВИ/АНУ-ын түүх хичээлийн кредит авна; гэхдээ тэд чанарын оноо авахгүй ба тэдний тэмдэглэлийг АНУ ба Виржиниагийн түүх гэж өөрчилнө.

**ОУБ-ын сэдвүүд Хорьдугаар зууны дэлхийн Түүх (HL)** **Хэсэг II (32386)** **Бүтэн жил, нэг кредит (хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр +1.0 чанарын оноо ба HL ОУБ шалгалт)**

**Анги: 12**

**Шаардлага хангасан бүх 12 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: ОУБ Америкийн түүх HL Хэсэг 1*

Энэ хичээлээр Америкийн түүхийг бүс нутгийн хувьд төвлөрч судлах явцдаа Хорьдугаар зууны Дэлхийн түүхийн сонгосон сэдвүүдийг сурах боломжийг сурагчдад өгнө. Хорьдугаар зууны голлох үйл явдлууд хэрхэн болсон, Америкт хэрхэн нөлөөлсөн талаар холбогдох тохиолдлын түүхээр судлах болно. *Энэ хичээл нь Америкийн түүхтэй хамт Америкийн түүхийн хичээлийн Виржиниа муж улсын шаардлагыг хангах ба төгсөх жил авах түүхийн хичээлийн өндөр түвшиний ОУБ-ын шалгалтад сурагчдыг бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (22386).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Философи (SL)** **(32600)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**

**Анги: 10 эсхүл 12**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Өмнөх нийгэм судлалын хичээлийн багшийн бичгээр өгсөн зөвлөмж эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*

ОУБ-ын Араб хэлний хичээл нь хоёр жилийн хичээл бөгөөд ОУБ-ын шаардлагыг хангана. Сурагчид хүний оршихуйн суурь асуултуудыг судлах болно: Би хэн бэ? Би юуны тулд энд байна вэ? Аз жаргал гэж юу вэ? Амьдралын утга юу вэ? Амьдрал утга учиртай юу? Хүн болохын хувьд байгаль орчны төлөө хариуцлага хүлээх үү? Бид муу хууль гэж бодож байсан ч гэсэн хуулийг дагаж мөрдөх ёстой юу? Аргументэд суурилсан арга ажиллагаа, философийн олон талт тайлбарын мөн чанарт хүрэхийн тулд, мөн товч, тохирох, логиктой хэлийг утгыг нь тодорхой гаргах байдлаар хэрэглэхийн тулд сурагчдаас философийн үзэл санаа, агуулгыг ойлгож байгаагаа харуулахыг шаардана. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Философийн ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг сурагчид авахгүй (22600).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Сэтгэл судлал (SL)** **(32901)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**

**Анги: 10 эсхүл 12**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Өмнөх нийгэм судлалын хичээлийн багшийн бичгээр өгсөн зөвлөмж эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*

ОУБ-ын Сэтгэлд судлалын хичээл нь хоёр жилийн хичээл бөгөөд ОУБ-ын шаардлагыг хангана. ОУБ-ын Сэтгэл судлалыг стандарт түвшинд сурсны дараа сурагчид сэтгэл судлалын дараах гурван чухал харах өнцгийн үндсэн санааг тайлбарлаж, харьцуулж, ялгаж салгаж, үнэлэх чадвартай байна: биологийн, сэтгэн бодох, суралцах. Сурагчид 2000 -3000 үгтэй шинжлэх ухааны дүгнэлт бичих нэг шинжлэх ухааны туршилт хийх шаардлагатай. Сурагчид хувь нэмрээ оруулах дэлхийн иргэн, амьдралын туршид суралцагчид шаардлагатай шүүмжит сэтгэлгээний чадварыг эзэмшиж, мэдлэг олж авна. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Сэтгэл судлалын ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг сурагчид авахгүй (22901).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Сэтгэл судлал (HL)** **Хэсэг I (32385)** **Хэсэг II (32386)** **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)**

**Анги: 10 эсхүл 12**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Өмнөх нийгэм судлалын хичээлийн багшийн бичгээр өгсөн зөвлөмж эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*

ОУБ-ын Сэтгэл судлал хичээл нь хоёр жилийн хичээл бөгөөд ОУБ-ын шаардлагыг хангана. Сурагчид сэтгэл судлалын бүх дөрвөн чиглэлийг сурна: Биологи, тархи, хүмүүнлэгийн ба сурах чиг. Сурагчид мөн хоёр сонголтын сэдвийг сурч, гурван судалгаа хийнэ: туршилт, асуулга, ажиглалт. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Сэтгэл судлалын ОУБ-ын өндөр түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (22903) (22904).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог хоёр жилийн хичээлийг дүүргэж авах юм. Энэ хичээлээр 2 нийгэм судлалын кредит авна.

**ОУБ Нийгмийн антропологи (SL)** **(32372)** **Бүтэн жил, нэг кредит**

**(+1.0 чанарын оноо)**

**Анги: 10 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх нийгэм судлалын хичээлийн багшийн бичгээр өгсөн зөвлөмж эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*
ОУБ-ын нийгмийн антропологи нь ОУБ-ын шаардлагыг хангах нэг жилийн хичээл бөгөөд жирийн хүмүүст анхаарч соёл, нийгмийг харьцуулж судлах юм. Сурагчид нийгмийн ба соёлын амьдралын ерөнхий зарчмуудтай танилцаж, эдгээрийг тодорхой нийгэм, соёлуудад хэрэглэнэ. Хичээлээр нутгийн болон глобал өнцгөөс харахыг хэрэглэх ба хотын болон хөдөөгийн нийгмийн тухай авч үзнэ. Судлах зүйлст цусан холбоо, бэлэг тэмдэг, хэл, яс үндэс, хүйс, эрх мэдэл хамаарна. Нийгмийн антропологи нь дайн, зөрчил, байгаль орчин, ядуурал, тэгш бус байдал, хүний эрх зэрэг орчин үеийн чухал асуудлуудыг ойлгоход дэмжлэг болно. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Нийгмийн антропологийн ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (22372).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Нийгмийн антропологи (HL)** **Хэсэг I (32375)** **Хоёр жил, хоёр кредит**

**Хэсэг II (32377)** **(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)**

**Анги: 11, 12**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх нийгэм судлалын хичээлийн багшийн бичгээр өгсөн зөвлөмж эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*
ОУБ-ын дээгүүр түвшний нийгмийн антропологи нь хоёр жилийн хичээл бөгөөд ОУБ-ын хөтөлбөрийн шаардлагыг хангана. Нийгмийн ба соёлын антропологи нь соёл ба хүний нийгмийн харьцуулсан судлал юм. Сурагчид нийгмийн ба соёлын амьдралын ерөнхий зарчмуудтай танилцаж, эдгээрийг тодорхой нийгэм, соёлуудад хэрэглэнэ. Антропологийн сэдвүүдэд нийгмийн өөрчлөлт, цусан холбоо, бэлэг тэмдэг, солилцоо, итгэлийн тогтолцоо, яс үндэс, эрх мэдлийг харьцааг багтаана. Нийгмийн болон соёлын антропологиор хотын ба хөдөөгийн нийгэм болон орчин үеийн үндэстэн улсуудын тухай үзнэ. Нийгмийн антропологи нь дайн, зөрчил, байгаль орчин, ядуурал, тэгш бус байдал, хүний ба соёлын эрх зэрэг орчин үеийн чухал асуудлуудыг ойлгоход дэмжлэг болно. Ахисан түвшний сурагчид антропологийн онол нэмэлт хичээлийг авах болно. Сурагчид өөрсдийн онолын мэдлэгийг хуудас 1 (2 ба 3-р асуултууд), хуудас 2 ба хуудас 3 асуултад оруулж өгөх ёстой. Ахисан түвшний сурагчид судалгаа хийж, тайлагнах бол, SL сурагчид ажиглалт хийж, мэдээлж, шүүмж хийнэ. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Нийгмийн антропологийн Дээгүүр түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (22374) (22377).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог хоёр жилийн хичээлийг дүүргэж авах юм.

## Бүлэг 4

### *Туршилтын шинжлэх ухаан*

**ОУБ Биологи (SL)** **34378** **Бүтэн жил, нэг кредит** **(+1.0 чанарын оноо)**

**Анги: 10 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Биологи, Хими*
Энэ хичээл нь эс, молекулын биологи, ген, экологи, эволюц, биологийн олон зүйл, хүний физиологийг багтаана. Үүний дээр SL сурагчдын долоон сэдвээс хоёр сэдвийг сонгох сургалт. Шүүмжит сэтгэлгээ,

шинжлэх ухааны онолыг ойлгох, туршилтад илүү анхаарах болно. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Биологийн ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (24378).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

| | | |
|---|---|---|
| **ОУБ Биологи (HL)** | **Хэсэг I (32376)** | **Хоёр жил, хоёр кредит** |
| **Лабораторийн анги** | **Хэсэг II (34377)** | **(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |
| **Ангиуд: 11-12** | | |

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Биологи 1, Химиi*
ОУБ-ын Биологи HL бол бичгийн харилцаанд голчилж, амьдралыг янз бүрийн түвшинд судлах судалгаанд суурилсан шинжлэх ухаан юм. Амьд системүүдийг молекул төвшнөөс ерөнхий түвшинд, нэн ялангуяа амьдралын биохимийн үйл явц, эсийн бүтэц ба ажиллагаа, гомеостаз, ген ба гений инженерчлэл, эволюц, таксоном, харьцуулсан анатоми, нөхөн үржих ба хөгжил, байгаль орчин ба экосистем, бүлгийн судалгаа, хүний системийн бүтэц ба ажиллагаатай танилцана. Энэ хичээлийн хүрээнд лабораторийн болон бие даасан ажиллагааг шаардана. Эхний жилээр суурь хичээл орох ба хоёр дахь жилд Хэсэг I-ээр танилцуулсан зарчмуудыг илүү их гүнзгийрүүлж үзнэ. Амьд системүүд молекул төвшнөөс ерөнхий түвшин хүртэл үргэлжлүүлж үзнэ. Хоёр жилийн хичээлийн хоёр дахь жилийн судалгаа нь амьдралын биохимийн үйл явц, гомеостаз, ургамлын биологи, эволюц, таксоном, харьцуулсан анатоми, нөхөн үржихүй ба хөгжил, хүний системийн бүтэц, ажиллагаа байна. Статистикийн анализ, бие даасан судалгааг багтаахын тулд энэ хичээлээр лабораторийн тайланг шаардана. *Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Биологийн өндөр түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (24376) (24377).* Энэ ОУБ-ын хичээлээр нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог хичээлийг дүүргэж, шалгалт өгснөөр авах юм.

| | | |
|---|---|---|
| **ОУБ Хими (HL)** | **Хэсэг I (34476)** | **Хоёр жил, хоёр кредит** |
| **Лабораторийн анги** | **Хэсэг II (34477))** | **(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)** |
| **Ангиуд: 11-12** | | |

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Жирийн эсхүл эрчимжүүлсэн Хими хичээл дээр B эсхүл дээш дүн; Алгебр II хичээлд B эсхүл дээш дүн ба/эсхүл багийн зөвшөөрлөөр. Хэсэг I эхлэх үед зуны даалгаврыг гүйцэтгэж өгнө.*
Хими нь гол шинжлэх ухаан бөгөөд практик ба туршилтын чадваруудыг хослуулсан академик хичээл болон туршилтын шинжлэх ухаан юм. Энэ хичээл нь хоёр жилийн хичээл бөгөөд ОУБ-ын шаардлагыг хангана. Энэ хичээл нь өндөр сахилга баттай, сониуч сурагчдад туршилтын чадвар, шинжлэх ухааны мэдээллийг үнэлэх чадварыг хөгжүүлэх боломжийг олгох юм. Хичээлийн сэдэвт атомын онол, мөчлөг, холбоо, энерги, кинетик, тэнцвэр, хүчил ба суурь, электрохими, органик хими, тоон хими, дата боловсруулах багтана. Энэ хичээлээр Эм ба эмийн зүйл, Химийн анализ, Байгал орчны хими, Үйлдвэрлэлийн хими, Хүний биохими, Хүнсний хими, мөн Органик химийн нэмэлт сэдвүүдийг багтаана. Сурагчид олон салбарын нэгтгэсэн Бүлэг 4 төслийг хэрэгжүүлж, бие даасан судалгааны төсөл хийх шаардлагатай. ОУБ-ын Хими (HL)-ийн Хэсэг 2-ийн үед химийн сэдэв бүр дээр нэмэлт өндөр түвшний хичээл хийх ба Олон улсын бакалаврын байгууллагын шаардлагыг биелүүлнэ. *Энэ хичээлийн хоёр хэсгээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Химийн өндөр түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (24476) (24477).* Энэ ОУБ-ын хичээлээр нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог ОУБ хими хичээлийг дүүргэж, шалгалт өгснөөр авах юм. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй.

**ОУБ Мэдээлэл зүй (SL)** **Хэсэг I (36540)** **Хоёр жил, хоёр кредит**
**Хэсэг II (36550)** **(+1.0 чанарын оноог жил бүр,**
**Ангиуд: 11-12** **хоёр жилийг хоёуланг нь**
**дүүргэснээр)**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II-ийг ахлах сургуулийн нэгдүгээр ангиас өмнө B эсхүл дээш дүнтэй төгсссөн байх*
ОУБ-ийн компьютерын шинжлэх ухааны хичээл нь коллежийн түвшний эхний хичээлүүдийг (CSI ба CS2) багтаах хоёр жилийн хөтөлбөр юм. Сурагчид компьютерын бодомжийн эх суурь концепцуудыг ойлгох ойлголтоо болон компьютер болон бусад дижитал төхөөрөмжүүд хэрхэн ажилладаг талаар мэдлэгээ хөгжүүлнэ. *Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Компьютерын шинжлэх ухааны стандарт түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (26540) (26550).* Хоёр жилийн хичээлийг дүүргэснээр төгсөлтийн дүнд холбогдож нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авахыг ОУБ-ын хичээлээр олгоно. Энэ хичээл нь Карьер техник/Урлагийн кредиттэй. *Энэ хичээлийн зарим хэсгийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.*

**ОУБ Мэдээлэл зүй (HL)** **Хэсэг I (36560)** **Хоёр жил, хоёр кредит**
**Хэсэг II (36570)** **(+1.0 чанарын оноог жил бүр,**
**Ангиуд: 11-12** **хоёр жилийг хоёуланг нь**
**дүүргэснээр)**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II-ийг ахлах сургуулийн нэгдүгээр ангиас өмнө B эсхүл дээш дүнтэй төгсссөн байх*
ОУБ-ийн компьютерын шинжлэх ухааны хичээл нь Компьютерын машины холбоо (ACM) болон Америкийн мэдээлэл боловсруулах нийгэмлэгүүдийн (AFIPS) бусад холбоонуудаас зөвлөсөн коллежийн түвшний эхний хичээлүүдийг (CSI ба CS2) багтаах хоёр жилийн хөтөлбөр юм. Хичээлд холбогдож компьютерын Java хэлийг үзнэ. *Энэ хичээлээр сурагчийг төгсөлтийн жилийн эцэст авах Компьютерын шинжлэх ухааны өндөр түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (26560) (26570).* Хоёр жилийн хичээлийг дүүргэснээр төгсөлтийн дүнд холбогдож нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авахыг ОУБ-ын хичээлээр олгоно. Энэ хичээл нь Карьер техник/Урлагийн кредиттэй. *Энэ хичээлийн зарим хэсгийн онлайнаар заах ба ингэснээр цахим хичээлийн төгсөлтийн шаардлагыг хангана.*

**ОУБ Дизайны технологи (SL)** **Хэсэг I (38496)** **Хоёр жил, хоёр кредит**
**Хэсэг II (38497)** **(+1.0 чанарын оноог жил бүр,**
**Ангиуд: 11-12** **хоёр жилийг хоёуланг нь**
**дүүргэснээр)**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Дизайныг "ямар нэг зүйлийг санаандаа төсөөлөх" гэж тодорхойлж болно. Дизайн нь бидний хүрээлэн буй орчны мэдээллийг цуглуулж, мэдээллийг боловсруулж, байгаа зүйлийг өөрчлөх эсхүл цоо шинийг бүтээх төлөвлөгөөг боловсруулах юм. Дизайнер нь материалын орчны талаар мэдлэгтэй байх ёстой ба улс төр, эдийн засгийн үр дагавар, юу хүмүүсийн тэргүүн зэрэгт авч үзэх зүйлд хамаарч байгаа талаар ойлголттой байх ёстой. Дизайны технологи нь нутгийн бөгөөд одоо байгаа эх үүсвэрийг аль болох илүү ашиглахыг эрмэлзэхийн зэрэгцээ, асуудал шийдэх орчинд мэдлэг, чадвар, дизайны зарчмуудыг нэгтгэсэн суралцах загварт суурилдаг. Дизайны технологи эсхүл дизайны өмнөх туршлагатай байх шаардлагагүй. Дизайны үйл явц нь хичээлийн гол хэсэг бөгөөд сурагчдыг энэ үйл явцыг практик ажил дээр төдийгүй онолын хувьд ашиглахыг шаардана. Сурагчдыг дизайны төсөл болон практик ажил хийхийг шаардана. Тэд тэмдэглэл хөтлөх шаардлагатай. *Энэ хичээлээр сурагчдыг Дизайны технологийн стандарт түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (28496) (28497).* Хоёр жилийн хичээлийг дүүргэснээр төгсөлтийн дүнд холбогдож нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авахыг ОУБ-ын хичээлээр олгоно.

**ОУБ-ын орчны системүүд, нийгэм (SL)** **(34275)** **Бүтэн жил, хоёр мөчлөг, хоёр кредит + 1.0 чанарын оноо**
**Лабораторийн хичээл**
**Анги: 10 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Өмнөх байгалийн шинжлэлийн хичээлүүдэд В дундаж дүнтэй, багшийн зөвлөмжтэй эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*
Орчны системүүд ба нийгэм хичээл нь салбар хоорондын (бүлэг 3 ба 4) стандарт түвшний хичээл юм. Энэ хичээлийн зорилго нь сурагчдад байгаль орчны системүүд ба нийгмийн хоорондын харилцааны талаар оновчтой ойлголтыг сурагчдад өгөх явдал юм. Хичээлийн сэдэвт систем, загвар, экосистем, хүн ам, боломжийн хязгаар ба эх үүсвэрийг ашиглах, биологийн олон зүйлийг хадгалах, хүн амын менежмент, дэлхийн дулаарал, байгаль орчныг үнэлэх системүүд багтана. Хичээлээр байгаль орчны үйл явцыг нутгаас дэлхийн түвшин хүртэлх янз бүрийн хүрээнд ойлгуулахыг эрмэлзэнэ. Байгал орчны асуудалд нутгийн болон дэлхий даяарх түвшинд дүн шинжилгээ хийх мэдлэг, аргачлал, чадварыг олгож, сурагчдад сурсан мэдлэг, аргачлал, чадвараа хэрэглэх чадварыг суулгана. Хичээл нь салбар хоорондынх тул сурагчид "зургаан өнцөгт бүлэг" 3 ба 4-ийн шаардлагыг хангах боломжтой байхын зэрэгцээ сурагчдад "зургаан өнцөгт бүлэг" дотроо аль ч хичээлийг, үүний дотор бүлэг 3 ба 4-ийн аль ч хичээлийг сонгох боломжийг үлдээнэ. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Орчны системүүд ба нийгэм хичээлийн ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (24275).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Физик (SL)** **Хэсэг I (34576)** **Хоёр жил, хоёр кредит**
**Лабораторийн анги** **Хэсэг II (34577)** **(+1.0 чанарын оноог жил бүр,**
**Ангиуд: 11-12** **хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Алгебр II-ийг В эсхүл дээш дүнтэй, эсхүл Эрчимжүүлсэн Algebra II-ийг С эсхүл дээш дүнтэй*
Бусад бүх шинжлэх ухааны суурь болсон физикийн шинжлэх ухааны хичээл нь сурагчид өөрсдийн орчин тойрны бодит ертөнцийн математикийн илэрхийллийг таньж сурахад зориулагдсан. Физик бол ертөнцийн математик илэрхийлэл юм. Энэ хичээл нь хоёр жилийн хичээл бөгөөд ОУБ-ын хөтөлбөрийн хангах зорилготой. Сургуулийн туршид үзсэн бүх математикийн мэдлэгийг ашиглаж, сурагчид сонгодог механик, дулааны физик, цахилгаан ба соронзон, долгион ба энгийн жигд хөдөлгөөн (дуу, гэрлийг багтааж), атомын ба цөмийн физик, харьцангуй зэрэг гол цөм сэдвүүдийг шинжилж үзнэ. Хичээлээр долгионы үзэгдэл, астрофизик гэсэн хоёр сонголтын сэдвээр дуусах ба энэ нь үндсэн сэдвүүд дээр ихээхэн суурилна. Физикийн системүүдийн математик загваруудыг хөгжүүлэхийн тулд ОУБ Физик нь лабораторийн туршилт хийх, мэдээлэл цуглуулж, тайлбарлах болон эдгээрийн танилцуулахад анхаарна. Сурагчид W-L дахь бусад ОУБ-ын шинжлэх ухааны хичээлүүдтэй хамт олон салбарыг нэгтгэсэн Бүлэг 4 төслийг гүйцэтгэх ёстой. ОУБ-ын Физикийн хичээлийн сурагчид Жил 1-ийн эцэст үзсэн гол сэдвүүдээр өргөн хүрээний шалгалт өгнө. *Жил 2-ийн 5-р сард сурагчид ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг Физикийн хичээлээр дэлхий даяарх бусад сурагчдын адил өгнө. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг сурагчид авахгүй (24576) (24577)* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ-ын Спорт, дасгал, эрүүл мэнд шинжлэх ухаан** **Хэсэг I (38055)** **Хоёр жил, хоёр кредит**
**Ангиуд: 11-12** **Хэсэг II (38057)** **(+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Өмнөх байгалийн шинжлэлийн хичээлүүдэд B дундаж дүнтэй ба/эсхүл багшийн зөвлөмж*

ОУБ Спорт, Дасгал, Эрүүл мэндийн шинжлэх ухаан SL нь анатоми, физиологи, биомеханик, сэтгэл судлал, хоол хүнсний шинжлэх ухааныг нэгтгэх ба эдгээрийг биеийн тамир, эрүүл мэнд талаас нь сурна. Сурагчид янз бүрийн үндсэн болон сонголтыг сэдвийг үзэж амьдралын (турших үзэх) туршилтыг лабораторид болон амьдрал дээр хийнэ. Энэ нь шинжлэх ухааны зарчмуудыг хэрэглэх, хүний биеийн чадварт анализ хийхэд шаардлагатай мэдлэг, ойлголтыг авах боломжийг олгоно. Хичээлээр хувь хүн болон дэлхийн өнцгөөс спорт, дасгал, эрүүл мэндийн асуудлыг авч үзэх олон улсын ба ёсзүйн асуудлыг холбогдох тохиолдолд авч үзнэ. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд Спорт, дасгал, эрүүл мэнд хичээлийн ОУБ-ын стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (28055) (28057).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

## Бүлэг 5

### *Математик*

**ОУБ Математик: Хэрэглээ ба тайлбар (SL) нийгэм (SL)** **(33170)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**
**Анги: 10 эсхүл 12**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Алгебр III ба багшийн зөвлөмж ба өмнөх математикийн хичээлүүд дээр B эсхүл илүү дундаж дүнтэй байх*

ОУБ Математик Хэрэглээ, тайлбар хичээл нь математикийн контекстийн учир утгыг тодруулах хичээл юм. Энэ хичээл нь манай ертөнцийг тодорхойлох, практик асуудлуудыг шийдвэрлэхэд холбогдох математик мэдлэгээ хөгжүүлэх сонирхолтой сурагчдад зориулагдсан. Сурагчид дараах сэдвүүдийг сурч, судална: тооны онол ба алгебр, геометр ба тригоном, статистик ба магадлал, функц ба индуктив дифференциалын тооцоолол. Гол концепцуудаар сэдвүүд хоорондоо холбоотой байна. ОУБ-аар шаардсаны дагуу сурагч бүр хувийн судалгаанаас бүрдэх дотоод үнэлгээг хийнэ. *Энэ хичээл нь сурагчдыг Хэрэглээ, тайлбар хичээлийн стандарт түвшний ОУБ-ын шалгалтад бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (23170).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм.

**ОУБ Математик: Шинжилгээ аргачлал (SL)** **Хэсэг I (33171)** **Хэсэг II (33172)** **Бүтэн жил, нэг кредит (хоёр жилийг дүүргэснээр +1.0 чанарын оноо)**
**Анги: 10 эсхүл 12**

**Шаардлага хангасан бүх 10 ба 11-р ангийн W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Эрчимжүүлсэн Алгебр II эсхүл багшийн зөвлөмж ба өмнөх математикийн хичээлүүд дээр B эсхүл илүү дундаж дүнтэй байх*

ОУБ Математик: Шинжилгээ, аргачлал (SL) нь сурагчдад дараах математикийн сэдвүүдийг сурах, судлах боломжийг олгох зорилготой: тооны онол ба холбогдох сэдвүүд, алгебр, геометр ба тригонометрийн сэдвүүд, вектор, матриц, магадлал, статистик ба функц. Жил 2-ийн хичээлийн агуулгад нэг хувьсагчийн тооцооллын концепцийг судлах ба AT дээд тооны зорилтуудыг болон ОУБ-ын

математикийг давтахыг багтаана. Анализ, аргачлал шалгалт Сурагчид ОУБ-ын математикийг дүүргэх ёстой: Шинжилгээ, аргачлал Хэсэг I-ийг C эсхүл дээш дүнтэй төгсөж Хэсэг II-т орно. ОУБ-ын хөтөлбөрөөр шаардсанаар Жил 2-д сурагч бүрийн хувьд дотоод үнэлгээ хийнэ. Дотоод үнэлгээ нь хувь сурагчийн математикийн үнэлгээ юм. *Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (23171 (23172).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд 1.0 чанарын нэмэлт үнэлгээ оноог авах юм.

**ОУБ Математик: Шинжилгээ аргачлал (HL)** | **Хэсэг I (33181)** | **Хоёр жил, хоёр кредит**
**Анги: 11, 12** | **Хэсэг II (33182)** | **(хоёр жилийг дүүргэснээр +1.0 чанарын оноо)**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Эрчимжүүлсэн Дээд тооны удиртгал/ОУБ-ын математикийг дүүргэх: Шинжилгээ, аргачлал Стандарт түвшин Хэсэг 1-ийг B эсхүл сайн; эсхүл багшийн зөвлөмж; өмнөх математикийн хичээлүүдэд B эсхүл дундаж дүнтэй.*

ОУБ Математик: Шинжилгээ, аргачлал HL нь хоёр жилийн, эрчимтэй сургалт юм. Эхний жилийн хичээл дээд тооны сэдвийг багтаах ба үүнд функцүүд, график хязгаар ба үргэлжлэл, дифференциалыг дээд тоо, дифференциалын хэрэглээ, интеграл дээд тоо, интегралын хэрэглээ, дараалал ба цуваа багтана. Хичээлд алгебр, аксиом геометр, тригоном, аналитик геометрийн суурь мэдлэг шаардлагатай. ОУБ-ын математикийн хоёр дахь жил: Шинжилгээ, аргачлал HL хичээл нь Вектор, Шилжүүлэг, Комплекс тоо, Магадлал ба статистик, Функц ба тэнцэтгэл, Тойрог функц, Тригонометр, Вектор геометр. ОУБ Математик: Шинжилгээ, аргачлал HL нь коллежийн түвшинд ажиллаж, сурах дадлыг шаардана. ОУБ-ын таван цагийн гадны байгууллагаас авах шалгалтыг төгсөх жилийн эцэст өгөх ба энэ нь төгсөлтийн дүнгийн наян хувь болно. ОУБ-ын хөтөлбөрөөр шаардсанаар хэсэг 2-д сурагч бүрийн хувьд дотоод үнэлгээ хийнэ. Энэ дотоод үнэлгээ нь хувь хүний математикийн мэдлэг бөгөөд ОУБ-ын шалгалтын дүнгийн хорин хувь байна. *Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (23181) (23182).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд 1.0 чанарын нэмэлт үнэлгээ оноог авах юм.

## Бүлэг 6

### *Урлаг*

**ОУБ Кино (SL)** **Хэсэг I (33144)** **Хэсэг II (31145)** **Хоёр жил, хоёр кредит (хоёр жилийг дүүргэснээр +1.0 чанарын оноо)**

**Анги: 11, 12**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Өмнөх Англи хэлний хичээлийн багшийн бичгээр өгсөн зөвлөмж эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*

ОУБ-ын Кино хичээл нь хоёр жилийн хөтөлбөр бөгөөд ОУБ-ын хөтөлбөрийн шаардлагыг хангана. Энэ хичээлээр сурагчийн ойлголт, шүүмжит сэтгэлгээ, бодож үзэж шинжлэх, бүтээмжтэй оролцох, төсөөлөн бодож сэтгэх чадваруудыг хөгжүүлэх зорилготой бөгөөд энэ зорилгыг кино урлаг, киноны ажилд амьдралд ойр байдлаар хандах байдлыг хангаж хүрнэ. Киноны үгийг сурч, шинжилж, кино хийх дасгал хийх замаар, энэ хичээл сурагчдад киноны түүхийн талаар мэдэж авах боломж олгох ба Мэдлэгийн түүхийн гол зарчмуудыг хичээлийн хөтөлбөртэй холбож, мөн янз бүрийн кино хийх аргачлал, техникийг хөгжүүлж, бүтээлчээр хэрэглэнэ. ОУБ-ын киноны хичээлийн сурагчид хичээлийн туршид киноны хэлийг тайлбарлах, бусдад танилцуулах үйл явцыг ойлгож, оролцохын зэрэгцээ киног хувь хүний, онолын, соёлын үүднээс танин мэдэж, эдгээр нь кино хийх аргачлал, киног хүлээж авахад хэрхэн нөлөөлж байгаа талаар өөрсдийн ойлголтыг гүнзгийрүүлнэ. Сурагчдыг гаднаас ОУБ-ын байгууллагаас үнэлэх ба дотоодоос зааварлагч үнэлнэ. Энэ нь тус бүр ОУБ-ын шалгалтын нийт онооны тавин хувийг эзэлнэ. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд стандарт түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (21144) (21145).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм. Энэ хичээл нь Карьер техник/Урлагийн кредиттэй.

**ОУБ Кино (HL)** **Хэсэг I (33147)** **Хэсэг II (31149)** **Хоёр жил, хоёр кредит (хоёр жилийг дүүргэснээр +1.0 чанарын оноо)**

**Анги: 11, 12**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**

*Урьдчилсан шаардлага: Өмнөх Англи хэлний хичээлийн багшийн бичгээр өгсөн зөвлөмж эсхүл зааварлагчийн зөвшөөрлөөр*

ОУБ-ын Кино хичээл нь хоёр жилийн хөтөлбөр бөгөөд ОУБ-ын хөтөлбөрийн шаардлагыг хангана. IV Кино хичээл нь киноны үгийг тайлбарлаж, хийхэд сурагчид өндөр чадвартай болох чадварыг хөгжүүлэх зорилготой. Киноны үгийг сурч, шинжилж, кино хийх дасгалуудаар энэ хичээл киноны түүх, онол ба нийгэм эдийн засгийн суурьтай танилцуулна. Киноны хичээлийн бүх сурагчид Бие даасан ажлын судалгаа хийж, бичих ёстой. Мөн Практик төсөл хийж, ОУБ-ын байгууллагаас зааж өгсөн киноны таван минут хэсгийг нарийн шинжилж амаар танилцуулга хийнэ. Хичээлийн хоёрдугаар хэсэг сурагчдад бүтээлч чадвар, онолын ойлголт, үгийн шинжилгээний чадвараа илүү бүрэн хөгжүүлэх боломжийг олгоно. Хоёрдугаар хэсэг нь портфолио кино хөгжүүлэхийг багтаана. Сурагчдыг гаднаас ОУБ-ын байгууллагаас үнэлэх ба дотоодоос зааварлагч үнэлнэ. Энэ нь тус бүр ОУБ-ын шалгалтын нийт онооны тавин хувийг эзэлнэ. *Энэ хичээл нь сурагчийг сургалтын төгсгөлд илүү өндөр түвшний шалгалтыг өгөхөд бэлтгэнэ. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (21147) (21149).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм. Энэ хичээл нь Карьер техник/Урлагийн кредиттэй.

**ОУБ Хөгжим (SL)** **(39227)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**

**Анги: 10 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Ахлах сургуулийн аль нэг хөгжмийн хичээлийг нэг жил үзсэн ба/эсвэл зааварлагчийн зөвшөөрлөөр*
Сурагчид хөгжмийн үндсийн талаар сайн ойлголттой байх ёстой ба хичээлд бүртгүүлэхийн тулд ядаж нэг түлхүүрээр хөгжим унших чадвартай байх ёстой. Тэд хөгжмийн бүтэц, нийгэмтэй холбогдох байдлыг бүрэн ойлгохын тулд янз бүрийн соёл ба цаг үеийн хөгжмийг судална. Сурагчид хөгжим зохиож ба/эсвэл тоглолт хийнэ. Нэмэлт хувийн хичээлийг зөвлөж байгаа ч ийм шаардлага тавихгүй. Сурагчид хөгжим зохиох чадвараа M.I.D.I. компьютерын хэрэгслийг хэрэглэж хөгжүүлнэ. *Хөгжмийн шалгалт дээр нэмж сурагчийн зохиосон хөгжмийн дээд зэргийн тоглолт буюу танилцуулгыг шаардана. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (24227).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт оноог авах юм. Энэ хичээлд Урлагийн нэг кредит өгнө.

**ОУБ Театрын урлаг (SL)** **(39141)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**

**Анги: 10 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Жүжгийн аль нэг хичээлийг (тех театр хичээл байж болно) C эсхүл дээш дүнтэй; ба/эсхүл зааварлагчийн зөвлөмжөөр*
Театрын урлагийн хөтөлбөрийн зорилго нь сурагчид театрын мөн чанарыг ойлгох, үүнийг хийх болон сурах замаар ойлгох, үүнийг зөвхөн ойлголтоор бус өөрийн бие, сэтгэл хөдлөлөөр ойлгох, өөрийн соёлоос бусад соёлуудад энэ ямар хэлбэрээр байдгийг ойлгох, энэ ойлголтууд дээрээ тулгуурлаж өөрийгөө, нийгмээ, дэлхийг ойлгоход сурагчдад тусална. Стандарт түвшний сургалт нь дөрвөн заавал үзэх хэсгээс бүрдэнэ: Тоглолт хийх чадвар, Дэлхийн театр судлал, Тоглолтын практик судалгаа ба Театрын продакшн. Хичээл нь сурагчийг хичээлийн төгсгөлд авах Стандарт түвшний ОУБ-ын үнэлгээнд бэлтгэх ба 1750 үгтэй судалгааны бичиглэл ба илтгэл (хамгийн ихдээ 15-20 минут), сурагчийн сурсан зүйл, хөгжлийг харуулах ойролцоогоор 3000 үгтэй портфолиогоос бүрдэнэ.
Театрын урлаг. *Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (29141).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт үнэлгээг авах юм. Энэ хичээлд Урлагийн нэг кредит өгнө.

**ОУБ Театрын урлаг (HL)** **Хэсэг I (31942)** **Хэсэг II (39143)** **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)**

**Анги: 11, 12**

**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Жүжгийн аль нэг хичээлийг (тех театр хичээл байж болно) C эсхүл дээш дүнтэй; ба/эсхүл зааварлагчийн зөвлөмжөөр*
Театрын урлагийн хөтөлбөрийн зорилго нь сурагчид театрын мөн чанарыг ойлгох, үүнийг хийх болон сурах замаар ойлгох, үүнийг зөвхөн ойлголтоор бус өөрийн бие, сэтгэл хөдлөлөөр ойлгох, өөрийн соёлоос бусад соёлуудад энэ ямар хэлбэрээр байдгийг ойлгох, энэ ойлголтууд дээрээ тулгуурлаж өөрийгөө, нийгмээ, дэлхийг ойлгоход сурагчдад тусална. Өндөр түвшний сургалт нь дөрвөн заавал үзэх хэсгээс бүрдэнэ: Тоглолт хийх чадвар, Дэлхийн театр судлал, Тоглолтын практик анализ, Театрын продакшн ба Хувийн төсөл. Хичээл нь сурагчийг хоёр жилийн сургалтын төгсгөлд авах Өндөр түвшний ОУБ-ын үнэлгээнд бэлтгэх ба 2500 үгтэй судалгааны бичиглэл ба тайзны тоглолтын тухай практик шинжилгээ хийх илтгэл (хамгийн ихдээ 15-20 минут), сурагчийн театрт сурсан зүйл, хөгжлийг харуулах ойролцоогоор 4500 үгтэй портфолио болон хувийн төслөөс бүрдэнэ. *Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (29142) (29143)* Энэ ОУБ-ын

хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт үнэлгээг авах юм. Энэ хичээлд Урлагийн 2 кредит өгнө.

**ОУБ Визуал урлаг (SL)** **(39144)** **Бүтэн жил, нэг кредит (+1.0 чанарын оноо)**

**Анги: 10 эсхүл 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Урлаг II хичээлийн амжилттай дүүргэх мөн зааварлагчийн зөвшөөрлөөр*
Сурагчид урлагийн бүтээл хийх үйл явц, гоо зүйн асуудлууд, урлагийн шүүмж, урлагийн түүх ба соёлын ахисан шатны судалгаанд оролцоно. Тэд судалгааны явцдаа сонгосон сэдвүүдийг хэрхэн ойлгосон талаараа үгээр, бичгээр, зургаар үзүүлнэ. Багш, сурагчийн хооронд тохиролцсон салбарт чухал судалгааг хийснийг нотлох судалгааны ажлын дэвтэр шаардлагатай. *Дотоод үнэлгээ бий; үүний дээр сурагч нь гаднаас авах үнэлгээ шалгалтад үзүүлэн бэлтгэх ёстой. Дотоод үнэлгээг бүрэн хийхгүйгээр ба/эсхүл шалгалт өгөхгүйгээр нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (29144).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт үнэлгээг авах юм. Энэ хичээлд Урлагийн кредит авна.

**ОУБ Визуал урлаг (HL)** **Хэсэг I (31946)** **Хэсэг II (31148)** **Хоёр жил, хоёр кредит (+1.0 чанарын оноог жил бүр, хоёр жилийг хоёуланг нь дүүргэснээр)**

**Анги: 11, 12**
**Шаардлага хангасан бүх 11 ба 12 W-L сурагчдад нээлттэй.**
*Урьдчилсан шаардлага: Үнэлгээний үндсэн дээрх зааварлагчийн зөвшөөрөл ба ОУБ-ын шаардлагыг хангах чадварыг харуулах ажлыг шалгах*
Энэ нь 240 цагийн (хоёр жил эсхүл дүйцэх) сургалт бөгөөд багш ба сурагчийн хооронд тохирсон нэг салбарт чухал судалгааг хийснийг нотлох судалгааны тэмдэглэлийг хичээлийн нэг хагасын шаардлагыг хангана. Хичээлийн өөр нэг хагас нь студид нэг ажил янз бүрийн хэрэгсэл, техникийг ашиглаж хийх юм. Энэ 240 цагийн хичээлийн үр дүнд нэг танилцуулга, үзэсгэлэн гаргах шаардлагатай. Урлангийн ОУБ-ын хөтөлбөрөө үргэлжлүүлэхийг хүсэж байгаа сурагчид энэ нь хоёр жилийн хөтөлбөр гэдгийг ойлгох ёстой. Энэ хичээлд зургийн ном/сэтгүүл, студи бүтээл холбогдоно. *Дотоод үнэлгээ шалгалт байх ба үзэсгэлэнгийн ажлыг гаднаас үнэлэх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй (29146) (29148).* Энэ ОУБ-ын хичээлийг дүүргэснээр төгсөх дүнд нэмж олгох 1.0 чанарын нэмэлт үнэлгээг авах юм. Энэ хичээлд Урлагийн кредит өгнө.

## ОУБ-ЫН НЭМЭЛТ ШААРДЛАГУУД

**ОУБ-ын үндэс/Мэдлэгийн түүх** Хэсэг 1 (22604) Хэсэг 2 (32604) **Хоёр жил, хоёр кредит (хоёр жилийг дүүргэснээр +1.0 чанарын оноо хэсэг 2-т)**

**Анги: 11, 12**
**11 ба 12-р ангийн W-L-ийн бүрэн ОУБ-ын диплом авах эрмэлзэлтэй сурагчдад нээлттэй.**
ОУБ-ын үндсэн/TOK хичээл нь хоёр жилийн хичээл юм. Сурагчид 11-р ангидаа хэсэг 1-ийг, 12-р ангидаа хэсэг 2-ийг дүүргэнэ. Энэ хичээлийн зорилго нь сурагчид ОУБ-ын дипломын хөтөлбөртөө шилжих явцад нь тэдэнд туслах, ОУБ-ын үндсэн шаардлагуудын (CAS, EE, ба TOK) талаар цаг гаргаж, зүг чиг өгөх явдал юм. Хичээлийн хөтөлбөрөөр амар хялбар биш ОУБ-ын хичээлүүдийг амжилттай дүүргэхэд шаардлагатай чадваруудыг хөгжүүлэхэд сурагчдад туслахын зэрэгцээ үндсэн бүрдэл хэсгүүдээр сурагчдад туслах зорилготой. Сурах чадварт холбогдох ОУБ-ын (ATL) аргачлалд анхаарлаа хандуулна. Мэдлэгийн онол [Theory of Knowledge (TOK)] хичээлд 11-р ангид нэг улирал, 12-р ангид нэг улирлыг зориулна. TOK нь ОУБ-ын сургалтын үзэл санааны нэг гол элемент юм. Үүний зорилго нь мэдлэг, ангид болон ангиас гадуур олж авсан туршлагад шүүмжтэй хандах, мэдлэг ба туршлагын

суурийг үнэлэх, нотолгоо ба аргументийг шүүмжтэй авч үзсэний үндсэн дээрх хувийн бодол санааны хэлбэрийг хөгжүүлэх юм. Мэдлэгийн онолын албан ёсны ОУБ-ын үнэлгээнд нэг үзэсгэлэн гаргах (дотоод үнэлгээ) ба заасан сэдвээр нэг эсээ бичих (гадаад үнэлгээ) багтана. Хичээлийн дүнг сурагч тодорхойлох ба янз бүрийн үнэлгээнээс бүрдэнэ. Дотоод үнэлгээ ба/эсхүл Гадаад үнэлгээг хийхгүйгээр хоёр дахь жилд нэмэлт чанарын оноонуудыг авахгүй (22606).

## WASHINGTON-LIBERTY ДЭЭР САНАЛ БОЛГОЖ БУЙ НЭМЭЛТ АТ-БУС ХИЧЭЭЛҮҮД

**Америкийн африкчуудын уран зохиол (21064)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
Америкийн Африкчуудын Уран зохиол хичээлээр шүлэг, уран зохиол, жүжиг, өөрийн намтрыг багтааж янз бүрийн жанраар Америкийн Африк зохиолчдын хамгийн нэр хүндтэй зарим зохиолыг танилцуулна. Энэ хичээлээр Америкийн Африкчуудын уран зохиолын өнөөдрийн нийгмийн ач холбогдолд голчлон анхаарна.

**Зүг чиг, байршил тодорхойлох багаж хэрэгсэл, техник (98423W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Анги: 11, 12**
*Урьдчилсан нөхцөл: байхгүй*
Энэ хичээл нь James Madison University-ийн Зүг чиг, байршил тодорхойлох хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд сурагчдад байршлын технологийг хэрэглэх талаар заана. Үүнд газар зүйн мэдээллийн систем (GIS), глобал байршлын систем (GPS), сонирхсон сэдвээр зайнаас тандах зэрэг багтана. Энэ хичээлээр сурагчдад өргөн хүрээний судалгааны төслийн загвар гаргаж, гүйцэтгэх боломж олгоно. Сурагчийн өөрийн сонирхсон асуудлыг тодорхойлж, энэ асуудлын оролцогчдыг тодорхойлж, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай дата ба байршлын хэрэгслийг үнэлж, дата анализ хийж, оролцогчдод боломжит шийдлүүдийг санал болгож, танилцуулна.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг James Madison University (JMU)-д давхар тооцох ба энэ хичээлийг амжилттай дүүргэснээр нийт JMU-ийн 6 кредитийг Geog 161 болохын хувьд Энэ хичээлийн агуулга нь коллежийн түвшинд байна.. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

**Дэлхий судлал II: Далай судлал (24220)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Анги: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Дэлхий судлал ба лабораторийн шинжилгээний нэг нэмэлт*
Энэ хичээлээр далай судлалын гол сэдвүүдийг сурагчдад танилцуулна. Хичээлээр далай дэлхийд үзүүлэх нөлөө, яагаад бидэнд чухал болох, далай хүн төрөлхтний түүхэнд ямар нөлөөтэй байсан талаар заана. Далай судлал нь газар зүй, далайн биологид холбогдох ба далайн ёроолын геологи, газар зүй, далайн усны физикийн шинж, далайн химийн бүтэц, далайн биологи, далайн давсжих хөдөлгөөн, давлагаа, таталт, далай судлалын хэрэгслүүд, аргачлал гэсэн сэдвүүдийг багтаана. Хичээл нь далай судлалын концепцүүдийг гүнзгийрүүлэн үзэхэд зориулагдсан.

**Дээд тооны удиртгал, хос төгсөлт (93162W)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**9-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: VPT-д шалгарах оноо (бүх 9 бүлэгт тэнцэх, Алгебр II хүртэлх агуулга)*
NOVA MTH 161-аар коллежийн алгебр, матриц болон алгебрын, илтгэгчийн, логарифмын функцүүдийг танилцуулна. NOVA MTH 162-аар тригонометр, аналитик геометр, эрэмбэ ба бүлгийг танилцуулна. Хичээлээр сурагчийг MTH 263/264 Дээд тоо I/II-т бэлтгэнэ.

- ***Коллежийн кредит:*** *Энэ хичээлийг Northern Virginia Community College-д давхар бүртгүүлж болно. NOVA-ийн элсэлтийн шаардлагыг бүртгүүлэхээс өмнө биелүүлсэн байх ёстой. Илүү мэдээллийг өөрийн сургуулийн зөвлөхөөс авна уу.*

# LogoDescription нь дунд зэргийн итгэлтэйгээр автоматаар үүсгэгддэг

## Нарийвчилсан байршуулах Capstone хөтөлбөр

Коллежийн Удирдах зөвлөлөөс санал болгодог Yorktown Advanced Placement (AP®) Capstone™ хөтөлбөр нь хамтын судалгаа, багаар ажиллах, шүүмжлэлтэй сэтгэлгээ, харилцаа холбоогоор дамжуулан эрэл хайгуул, оюутан төвтэй суралцах боломжийг сайжруулдаг. Энэхүү хөтөлбөр нь оюутны сонирхол, эрдэм шинжилгээний тэнцвэрийг онцолж, бүх оюутнуудад хүртээмжтэй АТ курсуудыг олгодог. Йорктаун ахлах сургууль олон агуулгын чиглэлээр 32 АТ курс санал болгодог бөгөөд АТ Capstone курсууд нь ур чадварт суурилсан сургалтууд бөгөөд оюутнуудад төвлөрсөн лавлагаанд төвлөрдөг.

АТ Capstone нь — АТ семинар ба АТ судалгаа — гэсэн хоёр АТ хичээлээс бүрддэг ба бусад АТ хичээлүүдийн тухайн салбарын сургалт дээр нэмэлт болох, өргөжүүлэхэд зориулагдсан. Оролцогч сургуулиуд одоогийн АТ сурагчдад судалгааны онцгой боломжуудыг олгоход эсхүл АТ Capstone хөтөлбөрөөр хөгжүүлж буй аргументад суурилсан бичгийн чадваруудыг эзэмшихэд сурагчдыг оролцуулах замаар АТ-г нэвтрэхийг өргөжүүлэхэд АТ Capstone хөтөлбөрийг ашиглаж болно. Энэ хичээлүүдийг авсан сурагчид АТ Capstone-д багтах ба энэ нь улс даяарх коллеж, их сургуулиуд хүлээн зөвшөөрөх онцгой амжилт юм.

Оюутнууд хоёр хичээлийг амжилттай дүүргэсний дараа АТ семинар, судалгааны гэрчилгээ авдаг (зураг харна уу). Capstone-д багтсан, аль нэг салбарт бусад дөрвөн АТ шалгалтыг давсан сурагчид АТ Capstone диплом авна. Оюутнууд мөн анхны АТ курс эсвэл 2 ба түүнээс дээш АТ курст элссэн оюутнуудад зориулсан туслах анги болох АТ Consult-д хандах боломжтой.




**AT CAPSTONE TIMELINE**

10-12-р ангийн сурагчид 2023-24 оны хичээлийн жилд АТ семинарт хамрагдах боломжтой. АТ Consult нь 2023-24 оны хооронд гарах болно. АТ Research-ийг 2024-25 оны хичээлийн жилд 11-12-р ангийн сурагчдад зориулсан дараалсан хичээл болгон санал болгоно.

AT CAPSTONE COURSE, 2023-24 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

**Семинар, АТ (22110) (32110)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
АТ семинар нь илүү цогц эсхүл академик бөгөөд амьдралын сэдвүүд, асуудлуудын талаар янз бүрийн өнцгөөс үнэлэн судлахад сурагчдыг хэлэлцүүлэгт оруулах суурь хичээл юм. Асуулт тавих аргачлалаар сурагчид нийтлэл, судалгаа, суурь сурах бичиг, философийн бичиглэлийг уншиж, шинжилнэ; илтгэл, нэвтрүүлэг, хувийн танилцуулгыг сонсож, үзнэ; урлагийн бүтээл, тоглолтыг үзнэ. Сурагчид олон эх үүсвэрийн мэдээллийг нэгтгэж, судалгаанд суурилсан бичгийн ажлын өөрийн дадлыг хөгжүүлж, бие

даан болон бүлгээр илтгэл болон үзүүлэн бэлтгэж, үзүүлнэ. Хичээлээр мэдээллийг оновчтой, зөв шинжилж, үнэлэх чадварыг сурагчдад өгч, нотолгоонд суурилсан аргументийг эзэмшиж, илэрхийлэх чадварыг олгох зорилготой. Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй (22110).

**AT оюутнуудад зориулсан зөвлөгөө (20184)**
**Бүтэн жил, нэг мөчлөг, нэг кредит 11-12**
*Урьдчилсан шаардлага: Эхний AT хичээлдээ бүртгүүлсэн эсхүл 2 ба түүнээс дээш AT хичээлд бүртгүүлсэн бөгөөд ахисан түвшний диплом авахаар сурч байгаа сурагчид*

- Унших, чимээгүй орчинд суралцах
- AT-ийн хичээлийн сэдвээр хичээл/ганцаарчилсан
- AT курсийн ажилд дэмжлэг үзүүлэх
- Суралцах бүлгэм байгуулах
- AT шалгалтад дүгнэлт хийх уулзалтууд
- PSAT/SAT семинар
- AT хувийн зохион байгуулалтын семинар (жишээ нь: цагийн менежмент, зохион байгуулах чадвар, стрессээ хянах)
- Коллежид бэлтгэж төлөвлөх семинар

## YORKTOWN-Д САНАЛ БОЛГОЖ БУЙ НЭМЭЛТ АХИСАН ТҮВШНИЙ ХИЧЭЭЛҮҮД

**Байгал орчны шинжлэх ухаан, AT (34270)**
**Бүтэн жил, нэг кредит + Хоёр кредитийг авч, AT шалгалт, давхар цаг, (34571) давхар хичээлээр 1.0 чанарын оноо**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Хоёр лабораторийн шинжлэх ухааныг амжилттай дүүргэх (нэг нь амьдралын, нөгөөх нь физикийн); гэхдээ, сурагчид хоёр лабораторийн шинжлэх ухааныг амжилттай дүүргэсэн (нэг нь амьдралын, нөгөөх нь физикийн) Хими IF-д давхар бүртгүүлж болно; Алгебр II эсхүл дүйцэх хичээлийг хангалттай дүнтэй төгссөн эсхүл зэрэг бүртгүүлсэн, Байгал орчны шинжлэх ухааны сонгосон сэдвүүд хичээлд зэрэг бүртгүүлэх ба багшийн заавар*
Ахисан түвшний Байгал орчны шинжлэх ухаан нь байгалийн харилцан холбоог ойлгох, байгалиас болон хүнээс шалтгаалсан байгаль орчны асуудлуудыг тодорхойлж, шинжлэх, эдгээр асуудлуудтай холбоотой харьцангуй эрсдэлүүдийг үнэлэх, эдгээрийг шийдэх ба/эсхүл урьдчилан сэргийлэхэд шаардлагатай шинжлэх ухааны зарчмууд, концепцууд, аргачлалыг сурагчдад зааж өгнө.
*Сурагчид хоёр шаардлагатай хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид хичээлүүдийн аль алинд нь чанарын нэмэлт оноо авахгүй. (24365) (24271).*

**Байгал орчны шинжлэх ухааны сонгосон сэдвүүд (34271)**
**Бүтэн жил, нэг кредит, давхар цаг**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: AT-ийн Байгал орчны шинжлэх ухаан хичээлд давхар бүртгүүлэх*
Эдгээр сэдвүүд нь сурагчдад нэлээд хэдэн байгаль орчны шинжлэх ухааны салбарт өргөн хүрээний лабораторийн шинжилгээ хийх боломжийг олгоно. Лабораторийн судалгааг судалгааны газар дээрх туршлагатай холбосноор сурагчид байгаль орчны асуудлыг анхан шатны түвшинд ажиглаж сурна. Дэлхийн системүүдийн харилцан хамаарал, хүн амын динамик, сэргээгдэх/сэргээгдэх бус эх үүсвэрийг эхний улирлын хичээлээр багтаана. Байгал орчны чанар, глобал өөрчлөлт, байгаль орчин, нийгмийг хоёрдугаар улиралд үзнэ. *Энэ хичээлийн ерөнхий сонгох хичээлд тооцно. Үүний дээр бие даасан болон бүлгийн судалгааны төслийг гаргаж, гүйцэтгэх шаардлага тавина.*

**Харьцуулсан Засгийн газар, AT (32442)**
**Бүтэн жил, нэг кредит + 1.0 чанарын оноо**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Энэ нь харьцуулсан засгийн газар ба улс төрийн коллежийн түвшний удиртгал хичээл юм. Хичээлээр улс төрийн тогтолцоо, бодлого ба сонгосон зургаан улсын улс төр, эдийн засаг, нийгмийн сорилтуудыг шинжилж үзнэ: Хятад, Иран, Мексик, Нигер, Орос, Их Британи. Сурагчид эрх мэдэл, эрх бүхий байгууллага, эрхтэй байдал, тогтвортой байдал, ардчилал, дотоод ба гадаад хүчин зүйлс, улс төрийн шинжилгээний аргачлал зэрэг сэдвүүдийг үзэх явцдаа, дата анализ хийх болон унших зүйл дээр суурилж өөрсдийн харьцуулсан засгийн газар, улс төрийн ойлголтоо олж авна.
*Сурагчид энэ хичээлтэй холбоотой AT-ын шалгалтыг өгөх шаардлагатай. Шалгалт өгөөгүй сурагчид чанарын нэмэлт оноо авахгүй.*

## <u>YORKTOWN ДЭЭР НЭМЭЛТ AT-БУС ХИЧЭЭЛҮҮДИЙГ САНАЛ БОЛГОНО</u>

**Биологи II: Генетик (24325)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Биологийн хичээлийг амжилттай дүүргэх*
Энэхүү сургалт нь ДНХ-ийн бүтэц, үйл ажиллагаа нь гений олон тал, удамшил, шинжлэх ухааны хөгжил, генетикийн хэрэглээг ойлгох үндэс суурь болох биологийн үзэл баримтлалд тулгуурлах зорилготой юм. Сэдвүүд нь молекул генетик, хромосомын генетик, генетик ба хүний эрүүл мэнд, синтетик биологи, популяцийн генетик зэрэг орно.

**Хими, Лабораторийн хичээлийн (24400) зарчмууд**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Үндсэн зорилго нь өдөр тутмын амьдралд холбогдох химийг сурагчдад танилцуулахад оршино. Ангийн ажил, лабораторийн туршилтад онцгой анхаарна. *Хичээлийн төгсгөлийн SOL-ийн шалгалттай. SOL шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит өгнө.*

**Англи хэл 9 (21130), Дэлхийн түүх, Газар зүй: МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл (22216)**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
Хичээлээр сурагчдад Англи хэл 9, Дэлхийн түүх, Газар зүйг идэвхтэй, эрчимтэйгээр сурах боломжийг санал болгоно. МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл. Сурагчид хоёр сэдвээр хоёулангаар нь ярилцаж, семинар, загвар, судалгаа хийж оролцоно. Хичээлээр сурагчийг хамтаар суралцах орчинд хамт суралцагчид, багштай хамтарч ярилцах оролцох боломжоор хангана. *Дэлхийн түүх II-ийн сургалтын стандартын шалгалтад тэнцэх, хичээлээр баталгаажсан кредит авна.*

**Англи хэл 9 (21132), эрчимжүүлсэн ба Дэлхийн түүх (22343), эрчимжүүлсэн**
**Бүтэн жил, хоёр цаг, хоёр кредит (Англи хэл дээр нэг, Дэлхийн түүх дээр нэг кредит)**
*Урьдчилсан шаардлага: Англи хэл болон нийгэм судлалд аль алинд нь өндөр амжилт гаргасан. Багш болон/эсхүл зөвлөхийн санал болгосноор.*
Энэ хичээлийг авьяастай, ахисан шатны сурагчдад зориулсан. Их уншиж, бичиж, дүрэм болон үгсийн санг эрчимтэй гүнзгийрүүлж, баримтат зохиол, уран зохиол, жүжиг, шүлгийг эрчимжүүлэн сурч, Англи хэл уран зохиолын хичээлийн бүх салбараар Англи 9-ийн төвшнөөс илүү өндөр хэмжээнд үр дүн гаргахыг шаардана. Салбар хоорондын аргачлалыг хэрэглэж, Англи хэл болон Дэлхийн түүхийг хамтад нь заана. Уран зохиол, баримтат зохиолын янз бүрийн жанрыг сурах замаар сурагчид хувь чанар, соёл, зөрчил гэсэн Дэлхийн түүхийн сэдвүүдтэй танилцана. Энэ хичээлийг авьяастны үйлчилгээтэй хамт хийнэ. *Энэ хичээлийн төгсгөлд Дэлхийн түүх SOL шалгалтыг өгнө.*

**Кино судлал II (21447)**
**Нэг улирал, нэг хагас кредит**
**Ангиуд: 11-12**
*Урьдчилсан шаардлага: Кино судлал I-ийг дүүргэх буюу багшийн зөвшөөрлөөр*
Кино судлал II нь Кино судлал I-ээр үзсэн концепцуудыг үргэлжлүүлэн гүнзгийрүүлнэ. Сурагчид кино үзэх талаар ойлголтынхоо хүрээнд кино хийх жанр, жишээг илүү ихээр жишээ авна. Ярианы болон бичгийн чадваруудаа дадлагажуулахаас гадна Кино судлал II-оор киноны эрхлэгч, жүжигчдийн талаар судалж, үндэстний кино, кино зохиол, кино хийх дадлага, нууцлаг зүйлс, хар цагаан киноны талаар суралцана.

**SOAR ([Амжилт, Боломж, Үр дүн]) (20152)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 9**
*Урьдчилсан шаардлага: Өнгөрсөн хичээлийн амжилт ба/эсхүл дунд сургуульд авдаг янз бүрийн шалгалтуудын оноо нь 80% эсхүл дээш, дунд сургуулийн зөвлөмж*
SOAR нь үндэсний цөөнхийн 9-р ангийн сурагчдад зориулсан онцгой хөтөлбөр юм. SOAR-ийн хичээл нь хүч өгөх, амжилт гаргах, бие даалгах, оролцож, хүндлэх үндсийг тавьсан дэмжих орчин юм. SOAR-ийн хөтөлбөр нь сурах чадвар, зохион байгуулалтын стратеги, шүүмжит сэтгэлгээ, манлайллын чадварыг хэрэгжүүлнэ.

**SOAR ([Амжилт, Боломж, Үр дүн]) (20151)**
**Бүтэн жил, нэг кредит**
**10-12-р анги**
*Урьдчилсан шаардлага: Байхгүй*
SOAR нь ахисан түвшний тэтгэлэг авах, манлайлах, дунд сургуулийн дараах боловсролд холбогдож нэмэлт дэмжлэг авахыг хүсэж байгаа өнгөт арьстай сурагчдын хувьд боломж юм. Сурагчид цагийн менежмент, академик чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлж, өөрсдийн манлайллын чадвараа дээшлүүлэх явцдаа нийгмийн тэгш байдлын асуудалд оролцож, коллежид хүсэлт гаргах, санхүүгийн тусламж авахад бэлтгэнэ.

**Дэлхийн Уран зохиол (21518)**
**Бүтэн жил, нэг кредит**
**Ангиуд: 12**
*Урьдчилсан шаардлага: Багшийн зөвлөснөөр*
Дэлхийн уран зохиол нь хэл болон бичгийн талаар Англи хэл 12-той параллель байна. Сургалтад Европ, Африк, Ази, Өмнөд болон Төв Америкийн харьцуулсан уран зохиолыг маш ихээр уншиж, орчин үеийн сэтгэлгээнд анхаарна. Сурагчид ангид танилцуулга хийхээр бие даасан төслүүд санаачилж, салбар хэлэлцүүлэгт оролцож, олон жижиг өгүүлэмжүүдийг бичнэ. *Өндөр зэргээр санаачилгатай, сахилгатай сурагчдад зориулсан.*

## ХОСОЛСОН ТӨГСӨЛТ

Хосолсон төгсөлт нь ахлах сургуульд байхдаа Northern Virginia Community College (NOVA)-ийн шугамаар авсан хичээлүүддээ коллежийн кредит авах боломжийг ахлах сургуулийн сурагчдад олгодог гүнзгийрүүлсэн, эрчимтэй боломж юм. Хосолсон төгсөлтийн сурагчид ахлах сургууль болон NOVA-д бүртгэлтэй байна.

**Хос төгсөлтийн хичээлийг хэн авч болох вэ?**
Хос төгсөлтийн хичээлүүдийг ахлах сургуулийн эхний бөгөөд төгсөх ангийн сурагчид эсхүл дүйцэх гэрээр суралцагсад авч болно. Эдгээр хичээлүүдийг авахын тулд унших, бичих, математикийн чадвараа харуулах ёстой. VCCS бодлогоор коллежийн түвшний хичээл авахад бэлэн онцгой сайн ахлах сургуулийн нэг, хоёрдугаар ангийн сурагчдыг харгалзаж үзэхийг коллежуудад зөвшөөрдөг. Хоёрдугаар ангийн сурагчдыг тухайн тохиолдол бүрд авч үзнэ.

**Хос төгсөлтийн ач холбогдол**
Хос төгсөлтөөр сурагчдад коллежийн хичээлд түрүүлж элсэх замаар өөрийн боловсролоо ахиулах боломжийг олгодог. Энэ нь сурагчдад ахлах сургууль төгстлөө хүлээлгүйгээр дараагийн академик зорилтоо хэрэгжүүлж эхлэхийг зөвшөөрдөг. Ахлах сургуульд байхдаа коллежийн кредит авч байгаа сурагчид ахлах сургуулиа төгсөөд боловсролын замаа цаашид үргэлжлүүлэх магадлал өндрийг судалгаагаар харуулдаг.

Үүний дээр хос төгсөлт нь:

- Сурагчдад ахлах сургуулийн бөгөөд коллежийн кредит зэрэг авах боломж өгдөг.
- Ахлах сургуульд авсан хичээлийг коллежид авч давхардуулах шаардлагагүй болдог.
- Сурагчид коллеж орохоосоо өмнө кредит цуглуулж, коллежийг эрт буюу цагт нь төгсөх боломжтой болдог.
- Ихэнх коллежид шаарддаг ерөнхий боловсролын хичээлүүдийг дүүргэх боломжийг өргөн хүрээний хичээлүүдээр сурагчдад олгож, голлох хичээл гэж хэлэхээсээ өмнө янз бүрийн салбаруудтай танилцах боломж олгодог.
- Ахлах сургуулиас коллежид шилжихийг хөнгөвчилдөг.
- Дунд сургуулийн дараах боловсролын төлбөрийг багасгадаг.

**Хос төгсөлтийн баримтууд**

- Хос төгсөлтийн сурагчийн хувиар цуглуулсан кредитийг дөрвөн жилийн коллежид шилжүүлж болно.
- Хос төгсөлтийн сурагчийн хувиар NOVA-ийн хичээлийг авснаар сурагчид цаг, мөнгө хэмнэнэ.
- NOVA-аас багшийн хүрэлцээнээс шалтгаалж олон ахлах сургууль дээр хос төгсөлтийн хичээлүүдийг санал болгодог.
- Хос төгсөлтийн сурагчид гэрчилгээ авах эсхүл холбоотой төгсөлтийн диплом авахаар сурна.
- Хос төгсөлтийн сурагчид шилжүүлж болох Ерөнхий боловсролын гэрчилгээ авахаар сурна.

**Хос төгсөлтийн хичээлийг авах**

- Бүх сурагчид хос төгсөлтийн хичээлүүдийг авахын тулд коллежид ороход бэлэн болсноо харуулна. PSAT, SAT, ACT, AT эсхүл SOL-ийн дүн сурагч хичээлийг авах эрхтэй эсэхийг тодорхойлно. Хос төгсөлтийн хичээлийг авахын тулд сурагч онлайнаар NOVA-д https://apply.vccs.edu/ хаягаар хүсэлт гаргах ёстой.
- Хос төгсөлтийн хичээлд бүртгүүлэхийн тулд сурагчид https://nvcc.dualenroll.com/ хаягаар бүртгүүлэх ёстой.

- 1973 оны Ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хуулийн 504-р хэсэг болон Хөгжлийн бэрхшээлтэй америкчуудын тухай (ADA) хуулийн дагуу сургуульд одоо бүртгэлтэй бөгөөд амьдралын нэг ба хэд хэдэн зүйлд ихээхэн хязгаарлалтай тул хөгжлийн бэрхшээлтэй гэсэн баримт бичигтэй бөгөөд академик сургалтын шаардлагыг хангасан сурагчдад үйлчилгээг үзүүлнэ. NOVA-н байр, хүртээмжийн үйлчилгээний вэбсайт дээрх мэдээллийг анхааралтай уншина уу: https://www.nvcc.edu/accommodations/index.html
- Хос төгсөлтийн сурагчид насанд хүрэгчдийн түвшний агуулга, ярилцлагыг коллежийн түвшний хичээлд хийх шаардлагатай болно.
- Хос төгсөлтийн сургалт нь NOVA-ийн хичээлийн нэг хэсэг бөгөөд сурагчийн байгаа аль ч коллеж/их сургуульд явуулах ёстой.
- Сурагч оролцохгүй байх/хичээлд суухгүй бол энэ нь хос төгсөлтийн хичээлд үлдэх эсэхэд сөргөөр нөлөөлнө. Сурагч 2 улиралтай (бүтэн жилийн) хичээлийн жилд эхний улирлыг нь төгсгөөгүй бол сурагчийг хоёр дахь улирлын хос төгсөлтийн ангиас автоматаар гаргана.
- NOVA-ий хичээлүүд хичээлийн бүтэн жилийн турш явагдана. Жилийн хугацааны хос төгсөлтийн [Dual Enrollment (DE)] хичээлүүдийг авч байгаа сурагчид хавар, намрын улиралд хоёр дараалсан NOVA-ийн хичээлд бүртгүүлж болно. Коллежийн хичээлийн хоёрдугаар улиралд үргэлжлүүлэн суухын тулд математикийн хичээлд C болон дээш дүн авсан байх ёстойг анхаарна уу (жишээ нь MTH 161, MTH 162). Бусад хичээлүүдийн хувьд эхний улиралд тэнцсэн дүн авах нь хоёрдугаар улиралд үргэлжлүүлэх урьдчилсан нөхцөл болно (жишээ нь DE Англи хэл 12 нь ENG 111 ба ENG 112). Төгсөлтийн шаардлагыг хангах эсхүл өөр коллеж эсхүл их сургуульд шилжихийн тулд сурагч C болон дээш дүн авсан байх ёстой.
- Хос төгсөлтийн хичээлүүд нь коллежийн семестрийн хуваарьт суурилсан ба энэ нь дунд сургуулийн хуваариас ялгаатай. Хичээлүүд нь өөрийн гэсэн эхлэх, гарах, төгсөх өдрүүдтэй бөгөөд үүнийг хичээлийн хөтөлбөрт зааж өгдөг. Энэ өдрүүдэд анхаарлаа хандуулна уу. Учир нь орхих, гарах нь таны албан ёсны коллежийн тэмдэглэлд нөлөөлнө.
- Хос төгсөлтийн сурагчид нь NOVA-ийн сурагчдын адил давуу тал, эрх эдлэх эрхтэй. Энэ нь үнэ төлбөргүй сургалт, NOVA-ийн номын сангийн систем, кампус дээрх үйл ажиллагаа, сурагчийн үйлчилгээ болон бусад олон зүйлийг багтаана. Бүртгүүлмэгцээ сурагч нь NOVA-ийн сурагчийн үнэмлэхийг авах хүсэлт гаргаж болох ба энэ нь эдгээр давуу тал, эрхийг эдлэх боломжийг өгнө.

Илүү их мэдээллийг Хос төгсөлтийн гарын авлагаас авна уу.
https://www.nvcc.edu/dual-enrollment/manual.html

## Санал болгож буй хос төгсөлтийн хичээлүүд

| Ахлах сургуулийн хичээлийн нэр | NOVA Хичээл | NOVA-ийн хичээлийн нэр | NOVA-ийн кредит |
|---|---|---|---|
| Автомашины технологи I (98509W) | AUT 100 | Автомашины дэлгүүрийн ажлын удиртгал | 2 |
| Автомашины технологи II (98507W) | AUT 265 | Автомашины тоормосны систем | 4 |
| Автомашины технологи III (98508W) | AUT 265 | Автомашины тэнхлэг, дугуй, жолоо | 4 |
| Анатоми/Физиологи I (98085W) | BIO 141 | Хүний анатоми, Физиологи | 4 |
| Анатоми/Физиологи I/II (94320W) | BIO 141/142 | Хүний анатоми, Физиологи I, II | 8. |
| Дээд тоо (93176W) * | MTH 263 | Дээд тоо I | 4 |
| Дээд тоо I/II (93179W) * | MTH 263/264 | Дээд тоо I /II | 8. |
| Дээд тоо w/Аналитик геометр (93173W) * | MTH 263 | Дээд тоо II | 4 |
| Компьютерын туслалцаатай техникийн зураг (98439W) | CAD 140 | Техникийн зураг | 3. |
| Компьютерын архитекторын зураг (98408W) | ARC 123/124 | Архитекторын график I/II | 6. |
| Компьютерын мэдээллийн системүүд (96614W) | ITN 100<br>ITE 170 | Харилцаа холбооны удиртгал<br>Мультимедиа программ хангамж | 6. |
| Компьютерын мэдээллийн системүүд, ахисан түвшин (96649W) | ITE 115 | Компьютерын аппликейшн, концепцууд | 3. |
| Компьютерын програмчлал (96638W) | CSC 221 | Бодлого бодох, програмчлалын удиртгал | 3. |

| Ахлах сургуулийн хичээлийн нэр | NOVA Хичээл | NOVA-ийн хичээлийн нэр | NOVA-ийн кредит |
|---|---|---|---|
| Компьютерын програмчлал, эрчимжүүлсэн, DE (96644W) | CSC 222<br>CSC 208 | Объектыг баримталсан програмчлал<br>Дискрит бүтцийн удиртгал | 7/ |
| Компьютерын програмчлал, ахисан түвшин (96643W) | CSC 223<br>CSC 205 | Дата бүтэц, алгоритмын шинжилгээ<br>Компьютерын зохион байгуулалт | 7/ |
| Кибер: Cisco Академи Түвшин 1, Хэсэг I (96542W) ба Түвшин 1, Хэсэг II (96543W) | ITN 106<br>ITN 107 | Микрокомпьютерын үйлдлийн систем<br>Хувийн компьютерын програм хангамж, эвдрэлийг засах | 6. |
| Кибер аюулгүй байдал I: Кибер аюулгүй байдлын үндэс (96659W) | ITN 106 | Микрокомпьютерын үйлдлийн систем | 3. |
| Кибер аюулгүй байдлын системүүд (96667W) * | ITN 107 | Хувийн компьютерын програм хангамж, эвдрэлийг засах | 3. |
| Кибер аюулгүй байдал II: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа (96657W) * | ITN 101 | Сүлжээний концепцийн удиртгал | 3. |
| Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын программ хангамжийн ажиллагаа (96662W) * | INT 171 | Unix I | 3. |
| Кибер аюулгүй байдал III: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа, Ахисан түвшин (96658W) * | ITN 200 | Удирдлагын сүлжээний эх үүсвэр | 3. |
| Кибер аюулгүй байдал III: Кибер аюулгүй байдлын программ хангамжийн ажиллагаа, ахисан түвшин (96663W) * | ITN 260 | Сүлжээний аюулгүй байдлын суурь мэдлэг | 3. |
| Дата сангийн дизайн, менежмент (96660W) | ITD 256<br>ITE 140 | Ахисан түвшний дата сангийн удирдлага<br>Хүснэгтийн программ хангамж | 6. |
| Дифференциалын тэгшитгэл (93180W) | MTH 267 | Дифференциалын тэгшитгэл (93180W) | 3. |
| Дижитал гэрэл зураг III (98610W) | PHT 101 | Гэрэл зураг I | 3. |
| Бага насны хүүхдийн боловсрол I (98235W) | CHD 120<br>CHD 145 | Бага насны хүүхдийн тухай удиртгал<br>Хүүхдэд урлаг, хөгжим, хөдөлгөөн заах | 6. |
| Бага насны хүүхдийн боловсрол II (98236W) | CHD 165 | Бага насны хүүхдийн ажиглалт, оролцоо | 3. |
| Эдийн засаг DE (92801W) * | ECO 201<br>ECO 202 | Макро/Микро эдийн засгийн зарчмууд | 6. |
| Эмнэлгийн түргэн тусламжийн техникч I (98334W) Эмнэлгийн түргэн тусламжийн техникч II (98335W) | EMS 111<br>EMS 120 | Эмнэлгийн анхны тусламжийн техникч-суурь<br>Эмнэлгийн анхны тусламжийн техникч-суурь эмнэлгийн | 8. |
| Англи хэл 11 (Коллеж, Найруулга зүй), DE (91150W)<br>Англи хэл 12 (Коллеж, Найруулга зүй), DE (91160W) | ENG 111<br>ENG 112 | Коллежийн Найруулга зүй I, II | 6. |
| Англи хэл 12 (Их Британийн ба Дэлхийн уран зохиол), DE (91161W) | ENG 251<br>ENG 243 | Дэлхийн англи хэлний уран зохиолын судалгаа I/II | 6. |
| Бизнес эрхлэлт I (99094W) | BUS 116 | Бизнес эрхлэлт | 3. |
| Бизнес эрхлэлт, ахисан түвшин (99095), DE | BUS 165 | Жижиг бизнесийн менежмент | 3. |
| Ерөнхий биологи DE (94310W) | BIO 101<br>BIO 102 | Ерөнхий биологи I/II | 8. |
| Байгал орчны ерөнхий шинжлэх ухаан (94270W) * | ENV 121<br>ENV 122 | Байгал орчны ерөнхий шинжлэх ухаан I/II | 8. |
| Коллежийн ерөнхий физик DE I (94501W) * | PHY 201 | Коллежийн ерөнхий физик I | 4 |
| Коллежийн ерөнхий физик DE II) * | PHY 202 | Коллежийн ерөнхий физик II | 4 |
| Шугаман алгебр (93165W) | MTH 266 | Шугаман алгебр | 3. |
| Эмнэлгийн технологи (98383W) | HIM 111 | Эмнэлгийн нэр томьёо I | 3. |
| Олон хувилбартай Дээд тоо (93178W) | MTH 265 | Дээд тоо III | 4 |

| | | | |
|---|---|---|---|
| Мэдээллийн технологийн удиртгал (96116W) | ITE 115<br>ITE 100 | Компьютерын аппликейшн, концепцуудын удиртгал<br>Мэдээллийн технологийн системийн удиртгал | 6. |
| Дээд тооны удиртгал DE (93162W) * | MTH 161<br>MTH 162 | Дээд тооны удиртгал I/II | 6. |
| Тоон дүн шинжилгээ (93167W) | MTH 154 | Тоон үндэслэгээ | 3. |
| Дунд шатны Испани хэл I/II DE (95501W) * | SPA 201<br>SPA 202 | Дунд шатны Испани хэл I/II | 6. |
| Статистик I/II DE (93163W) ***** | MTH 245 | Статистик I | 3. |
| Маргаашийн багш нар I (99062W) | EDU 200 | Багшлах мэргэжлийн тухай удиртгал | 3. |
| Маргаашийн багш нар II (99063W) * | EDU 207 | Хүний өсөлт, хөгжил | 3. |
| ТВ, мультимедиа продакшн 1 (98689W) | PHT 130 | Видео I | 3. |
| ТВ, мультимедиа продакшн II (98690W) | PHT 131 | Видео II | 3. |
| ТВ, мультимедиа продакшн III (98691W) | PHT 274 | Дижитал кино засах, постпродакшн | 3. |
| ВИ, АНУ-ын түүх DE (92360W) ***** | HIS 121<br>HIS 122 | АНУ-ын түүх I/II | 6. |
| ВИ, АНУ-ын Засгийн газар DE (92240W) | PLS 135 | АНУ-ын Засгийн газар I | 3. |
| Векторын тооцоолол (93175W) | MTH 265 | Дээд тоо III | 4 |
| Вэб хуудасны дизайн, мультимедиа (96646W) | ITD 110<br>ITD 210 | Вэб хуудасны дизайн I, II | 6. |
| Вэб хуудасны дизайн, мультимедиа, ахисан шат<br>(96631W) | ITN 225 | Вэб скриптийн хэл | 3. |
| ***Арлингтоны Карьерын төвд бүтэн сурч байгаа сурагчдын хувьд л боломжтой.** | | | |

***Багшийн хүрэлцээнээс шалтгаалж APS-ийн янз бүрийн байршлуудад зөвшөөрөгдсөн хос төгсөлтийн хичээлүүдийг санал болгож болно.***

***Нэмэлт мэдээлэл авахын тулд сургуулийн зөвлөхтэй ярилцана уу***

Бидний жиргээгээр дагаарай: @APSNOVA_Partners

# NOVA-ийн Ерөнхий сургалтын гэрчилгээ
# Arlington Public Schools

Дараахаар Арлингтоны Улсын сургуулийн шаардлага хангасан сурагчид NOVA Community College-ийн Ерөнхий сургалтын гэрчилгээ авах хичээлийн хуваарь, замыг гаргасан болно. Энэ гэрчилгээг авахын тулд кредитийн хамгийн багадаа хорин таван хувь (25%), эсхүл есийг (9) хос төгсөлтийн хичээлээр авсан байх ёстой.*Коллежийн хичээлийг сонгохдоо өөрийн орохыг хүсэж байгаа коллежид кредитийг шилжүүлж болох эсэхийг шалгаж үзвэл зүйтэй юм.*

| **NOVA-ийн хичээл** | **Ахлах сургуулийн боломжит хичээлүүд** | | | |
|---|---|---|---|---|
| | ***АТ-ийн хичээлүүд*** | | ***Энсийн дүнгээс шалтгаалж ОУБ-ын кредитийг 1 эсхүл 2 хичээлд авна.*** | ***С эсхүл дээш дүнтэй бол хосолсон төгсөлт*** |
| **ENG 111/ 112 Коллежийн Найруулга зүй I ба II**<br>Коллежийн кредит: 6.<br>Ахлах сургуулийн кредит: 1<br>Ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлага: Англи хэл 12 | *АТ-ийн хичээлийг 3-тай эсхүл дараах шалгалт дээр сайн:*<br>АТ-ийн Хэл, найруулга зүй = ENG 111<br>АТ-ийн Хэл, найруулга зүй = ENG 112 | | ОУБ-ын Англи хэл HL = ENG 111 эсхүл ENG 111/112 | ENG 111/ 112 Коллежийн Найруулга зүй I ба II<br>DE ENG 251/243 Дэлхийн англи хэлний судалгаа. I ба II |
| **МТН 154**<br>**Тоон үндэслэгээ**<br>**ЭСХҮЛ дээгүүр шатны математикийн хичээл**<br>Коллежийн кредит: хичээлээс шалтгаалж 3-10.<br>Ахлах сургуулийн кредит: 1<br>Ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлага: Ахисан түвшний математик | *АТ-ийн хичээлийг 3-тай эсхүл дараах шалгалт дээр сайн:*<br>АТ Дээд тоо AB = MTH 263<br>АТ Статистик = MTH 245 | *АТ-ийн хичээлийг 4-тэй эсхүл дараах шалгалт дээр сайн:*<br>АТ Дээд тоо AB = MTH 263/264 | ОУБ Математик HL = MTH 263 or MTH 263/264 | DE MTH 154 – Тоон үндэслэгээ<br>DE MTH 161/162- Дээд тооны удиртгал I, II<br>DE MTH 263- Дээд тоо I<br>DE MTH 263/264- Дээд тооны удиртгал I, II<br>DE MTH 265- Дээд тоо III<br>DE MTH 266- Шугаман Алгебр |
| **Физикийн эсхүл Амьд организмын шинжлэх ухаан**<br>**Лаборатори I, II-ийн хамт**<br>Коллежийн кредит: 8.<br>Ахлах сургуулийн кредит: 6/2<br>Ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлага: Байгалийн шинжлэлийн кредит | *АТ-ийн хичээлийг 3-тай эсхүл дараах шалгалт дээр сайн:*<br>АТ Биологи = BIO 101<br>АТ Хими = CHM 101<br>АТ Физик 1 = PHY 101<br>АТ Физик 2 – PHY 201<br>АТ Физик С Цахилгаан, соронз = PHY 202<br>АТ Физик Механик – PHY 201 | *АТ-ийн хичээлийг 4-тэй эсхүл дараах шалгалт дээр сайн:*<br>АТ Биологи = BIO 101/102<br>АТ Хими = CHM 111<br>АТ Физик 1 = PHY 201<br>АТ Физик 2 = PHY 202<br>АТ Физик С Цахилгаан, соронз = PHY 232<br>АТ Физик Механик – PHY 231<br>АТ Байгал орчны Шинжлэх ухаан = ENV 121/122 | ОУБ Биологи HL = BIO 101 эсхүл BIO 101/102<br>ОУБ Хими HL = CHM 111 эсхүл CHM 111/112 | DE Биологи 101/102 – Ерөнхий Биологи I, II<br>DE PHY 201/202- Коллежийн ерөнхий физик I, II |
| **Дүүргээс баталсан 3 нийгэм судлалын хичээлүүд.**<br>Коллежийн кредит: 9.<br>Ахлах сургуулийн кредит: 1.5-2 (сурагчдад хамгийн багадаа 2 хичээл хэрэгтэй)<br>Ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлага: Түүх, нийгэм судлалын кредитүүд | *АТ-ийн хичээлийг 3-тай эсхүл дараах шалгалт дээр сайн:*<br>АТ Европын түүх = HIS 101<br>АТ Виржиниа, АНУ-ын түүх = HIS 121<br>АТ Дэлхийн түүх = HIS 111<br>АТ Харьцуулсан Засгийн газар ба Улс төр = PLS 140<br>АТ Засгийн газар, АНУ-ын улс төр = PLS 135<br>АТ Эдийн засаг, Макро = ECO 201<br>АТ Эдийн засаг, Микро = ECO 202<br>АТ Сэтгэл зүй = PSY 200<br>АТ Хүний амын газар зүй= GEO 210 | *АТ-ийн хичээлийг 4-тэй эсхүл дараах шалгалт дээр сайн*<br>АТ Европын түүх = HIS 101/102<br>АТ ВИ, АНУ-ын түүх = HIS 121/122<br>АТ Дэлхийн түүх = HIS 111/112 | Дэлхийн түүхийн ОУБ-ын сэдвүүд HL = HIS 101 or HIS 101-112<br>ОУБ Америкчуудын түүх HL = HIS Elective<br>ОУБ Физиологи HL = PSY 201 or PSY 201-202<br>IB Нийгмийн антропологи HL = SOC 211 or SOC 211-212 | DE PLS 135/136- АНУ-ын Засгийн газар I, II<br>DE JIS 121/122 – АНУ, ВИ түүх I, II |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Дүүргээс баталсан 2 хүмүүнлэгийн хичээл.**<br>Коллежийн кредит: 6.<br>Ахлах сургуулийн кредит: 1<br>Ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлага: Сонгох, Дэлхийн уран зохиол эсхүл Англи хэл 12 (авсан хичээлээс кредитийн тоо хамаарна) | *AT-ийн хичээлийг 3-тай эсхүл дараах шалгалт дээр сайн:*<br>AT Урлагийн түүх = ART 101<br>*AT-ийн хичээлийг 4-тэй эсхүл дараах шалгалт дээр сайн*<br>AT Хятад хэл = CHI 201<br>AT Франц хэл V = FRE 201<br>AT Герман хэл V = GER 201 | *AT-ийн хичээлийг 4-тэй эсхүл дараах шалгалт дээр сайн*<br>AT Испани хэл V = SPA 201<br>AT Урлагийн түүх = ART 101-102<br>*AT-ийн хичээлийг 5-тай эсхүл дараах шалгалт дээр сайн:*<br>AT Урлагийн түүх = ART 101/102 | ОУБ Философи = PHI 101 эсхүл PHI 101-102<br>IB Франц HL = FRE 201-202 оноо нь 6 эсхүл 7<br>IB Испани хэл HL = SPA 201-202 оноо нь 6 эсхүл 7 | DE SPA 201 / 202 Дунд шатны Испани хэл I, II |
| SDV 100 Коллежийн амжилтын чадварууд<br>Коллежийн кредит: 1<br>Ахлах сургуулийн кредит: Холбогдолгүй<br>Ахлах сургууль төгсөхөд тавигдах шаардлага: Холбогдолгүй | | | | DE SDV 100 Коллежийн амжилтын чадварууд *(ACC)* |

*Дээр жагсаасан бүх ОУБ-ын хичээлүүд зөвхөн дээгүүр түвшний [Higher Level (HL)] 5 буюу дээш шалгалтын оноог багтаана. Стандарт түвшний [Standard Level (SL)] ОУБ-ын шалгалтад кредит өгөхгүй. Энэ хичээлүүдийг зөвхөн Washington-Liberty дээр санал болгодог. Эцсийн дүнгээс шалтгаалж ОУБ-ын кредитийг нэг эсхүл хоёр NOVA-ийн хичээлд авна. 5 оноог ерөнхийдөө NOVA-ийн нэг хичээл, 6 эсхүл 7 оноо нь ерөнхийдөө NOVA-ийн хоёр хичээлд тооцогдоно.*

# 2022-23 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД САНАЛ БОЛГОЖ БАЙГАА ХИЧЭЭЛҮҮДИЙН ИНДЕКС

| УРЛАГИЙН БОЛОВСРОЛ (Хуудас 19-24) | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| Ахисан шатны хамтлаг | 29234 |
| Ахисан түвшний хоор | 29289 |
| Ахисан шатны Театр IV | 21430 |
| Ахисан шатны театр судлал (WKHS ба YHS) | 21432 |
| Урлагийн түүх, AT | 39151 |
| Урлаг I | 29120 |
| Урлаг II | 29130 |
| Урлаг III | 29140 |
| Бассо хоор | 29266 |
| Төгөлдөр хуур | 29200 |
| Ажил мэргэжлийн судалгаа | 22010 |
| Керамик I | 29167 |
| Керамик I | 29168 |
| Керамик III | 29169 |
| Бэсрэг хоор | 29252 |
| Цөөхүүл оркестр | 29242 |
| Компьютерын график | 29152 |
| Компьютерын график II | 29153 |
| Компьютерын график III | 29154 |
| Концертын хор | 29260 |
| Гар урлал | 29162 |
| Дижитал гэрэл зураг I | 29193 |
| Дижитал гэрэл зураг II | 29194 |
| Дижитал гэрэл зураг III | 29195 |
| Дижитал фото зураг III, хосолсон төгсөлт | 98610W |
| Чуулга | *29250 |
| Урлагийн дадлагын хөтөлбөр I | 29290 |
| Урлагийн дадлагын хөтөлбөр II | 29291 |
| Урлагийн дадлагын хөтөлбөр III | 29292 |
| Гитар I | 29245 |
| Ахисан түвшний гитар | 29247 |
| Дунд шатны хамтлаг | 29233 |
| Барималтай танилцах нь | *29165 |
| Гар урлалтай танилцах нь | *29160 |
| Жааз хөгжим/Чуулга | 29251 |
| Жааз/Поп дууны лаборатори/чуулга | 29280 |
| Хөгжимт жагсаалын хамтлаг | *29254 |
| Хөгжмийн дадлага: Түүхэн хөгжим, жанр, соёл | 29222 |
| Хөгжмийн онол, AT | 39226 |
| Уран зураг, зураг | *29163 |
| Баримал | 29166 |
| Хөгжим бичих, цахим аудио, хөгжмийн түүх | 29225 |
| Чавхдаст хөгжмийн чуулга | 29244 |
| Урлаг, дизайн, AT | 39149 |
| Театрын техник | 21435 |
| Театрын урлаг I | 21400 |
| Театрын урлаг II | 21415 |
| Театрын урлаг III | 21425 |
| Трэбл хоор | 29263 |

| КАРЬЕР, ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ (Хуудас 26-32 ба 77-101) | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| QuickBooks-ээр нягтлан бодох | 26320 |
| Жижиг амьтныг арчлах I | 28062 |
| Жижиг амьтныг арчлах II | 28063 |
| Ахисан шатны зураг, дизайн | 28440 |
| Агаарын хөлгийн инженерчлэл | 28498 |
| Залуу агаарын цэрэг ROTC I | 29911 |
| Залуу агаарын цэрэг ROTC II | 29912 |
| Залуу агаарын цэрэг ROTC III | 29913 |
| Залуу агаарын цэрэг ROTC IV | 29914 |
| Автомашины эвдрэл засвар I | 28677 |
| Автомашины эвдрэл засвар II | 28678 |
| Автомашины эвдрэл засвар III | 28680 |
| Автомашины засвар, гэрлийн засвар | 28675 |
| Автомашины технологи I | 28509 |
| Автомашины технологи II | 28507 |
| Автомашины технологи III | 28508 |
| Агаарын хөдөлгүүрийн технологи I | 28731 |
| Агаарын хөдөлгүүрийн технологи II | 28732 |
| Үсчин I | 28531 |
| Үсчин II | 28532 |
| Үсчин III | 28526 |
| Эрүүл мэнд, анагаахын биотехнологи | 28326 |
| Хүүхдийн хүмүүжил, эцэг эхийн хичээл | 28232 |
| Хүүхдийн хүмүүжил, эцэг эхийн хичээл | *28230 |
| Компьютерын туслалцаатай архитекторын зураг | 28408 |
| Компьютерын туслалцаатай инженерчлэлийн зураг | 28438 |
| Компьютерын тусламжтай техникийн зураг | 28439 |
| Компьютерын мэдээллийн системүүд | 26614 |
| Компьютерын мэдээллийн системүүд, хосолсон төгсөлт | 96614W |
| Компьютерын мэдээллийн системүүд, ахисан түвшин | 26649 |
| Компьютерын мэдээллийн системүүд, ахисан түвшин, хосолсон төгсөлт | 96649W |
| Компьютер оролцуулсан үйлдвэрлэлийн инженерчлэл | 28493 |
| Компьютерын програмчлал | 26638 |
| Компьютерын програмчлал, хосолсон төгсөлт | 96638W |
| Компьютерын програмчлал, ахисан түвшин | 26643 |
| Компьютерын програмчлал, ахисан түвшний, хосолсон төгсөлт | 96643W |
| Компьютерын програмчлал, эрчимжүүлсэн | 26637 |
| Компьютерын програмчлал, эрчимжүүлсэн, хосолсон төгсөлт | 96644W |
| Мэдээлэл зүйн зарчмууд, AT | 33186 |
| Мэдээлэл зүй, AT | 33185 |

| КАРЬЕР, ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ (үргэлжлэл) (Хуудас 26-32 ба 77-101) | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| Барилгын технологи | 28512 |
| “Соор” нэгдлийн мэргэжлийн дадлага | 28951 |
| Гоо сайхан I | 28528 |
| Гоо сайхан II | 28529 |
| Гоо сайхан III | 28530 |
| Эрүүгийн шүүх I | 28702 |
| Эрүүгийн шүүх II | 28703 |
| Хоолны урлаг, шинжлэх ухаан I | 28522 |
| Хоолны урлаг, шинжлэх ухаан II | 28523 |
| Хоолны урлаг III: Талх, жигнэмэг | 28524 |
| Хоолны урлаг III: Хүлээн авалтын үйлчилгээ | 28525 |
| Кибер аюулгүй байдал I: Кибер аюулгүй байдлын үндэс | 26659 |
| Кибер аюулгүй байдал I: Кибер аюулгүй байдлын үндсэн мэдлэг, хосолсон төгсөлт | 96659W |
| Кибер аюулгүй байдлын системүүд | 26667 |
| Кибер аюулгүй байдлын системүүд Хосолсон төгсөлт | 96667W |
| Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын ажиллагаа | 26662 |
| Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын программ хангамжийн ажиллагаа, хосолсон төгсөлт | 96662W |
| Кибер аюулгүй байдал II: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа | 26657 |
| Кибер аюулгүй байдал II: Компьютерын программ хангамжийн сүлжээг ажиллуулах, хосолсон төгсөлт | 96657W |
| Кибер аюулгүй байдал III: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа, Ахисан түвшин | 26658 |
| Кибер аюулгүй байдал III: Компьютерын программ хангамжийн сүлжээг ажиллуулах, ахисан түвшин, хосолсон төгсөлт | 96658W |
| Кибер аюулгүй байдал III: Кибер аюулгүй байдлын программ хангамжийн ажиллагаа, ахисан түвшин | 26663 |
| Кибер аюулгүй байдал III: Кибер аюулгүй байдлын программ хангамжийн ажиллагаа, ахисан түвшин, хосолсон төгсөлт | 96663W |
| Кибер: Cisco академи, Түвшин 1, Хэсэг I | 26542 |
| Кибер: Cisco академи, Түвшин 1, Хэсэг I Хос төгсөлт | 96542W |
| Кибер: Cisco академи, Түвшин 1, Хэсэг II | 26543 |
| Кибер: Cisco академи, Түвшин 1, Хэсэг II Хосолсон төгсөлт | 96543W |
| Дата сангийн дизайн, менежмент | 26664 |
| Дата сангийн дизайн, удирдлага, хосолсон төгсөлт | 96660W |
| Дижитал анимац | 28457 |
| Дижитал электроник | 26671 |
| Динамик харилцаа | *21517 |
| Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсрол I | 28235 |
| Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсрол I, Хосолсон төгсөлт | 98235W |
| Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсрол II | 28236 |
| Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсрол II, хосолсон төгсөлт | 98236W |
| Ажил эрхлэлттэй холбоотой боловсрол, Жил 1 | 29087 |
| Ажил эрхлэлттэй холбоотой боловсрол, Жил 2 | 29089 |
| Ажил эрхлэлтэд бэлтгэх боловсрол, Жил 1 | 29083 |
| Ажил эрхлэлтэд бэлтгэх боловсрол, Жил 2 | 29088 |
| Цахилгаан I | 28534 |
| Цахилгаан II | 28535 |
| Эмнэлгийн анхны тусламжийн техникч I | 28334 |
| Эмнэлгийн түргэн тусламжийн техникч I, хосолсон төгсөлт | 98334W |
| Эмнэлгийн анхны тусламжийн техникч II | 28335 |
| Эмнэлгийн анхны тусламжийн техникч II | 28336 |
| Эмнэлгийн түргэн тусламжийн техникч II, хосолсон төгсөлт | 98335W |
| Эрчим хүч | 26448 |
| Инженерчлэл I: Инженерчлэлийн дизайны удиртгал | 28491 |
| Инженерчлэл II: Инженерчлэлийн зарчмууд | 28492 |
| Инженерчлэлийн оргил: Дизайн, хөгжүүлэлт | 28494 |
| Бизнес эрхлэлт | 29094 |
| Бизнес эрхлэлт, хосолсон төгсөлт | 99094W |
| Бизнес эрхлэлт, ахисан түвшин | 29095 |
| Бизнес эрхлэлт, ахисан, хосолсон төгсөлт | 99095W |
| Шинжилгээний технологи/хэрэглээ: Биотехнологи | 28325 |
| Дээд зэргийн амттан: Хоол хүнс, эрүүл мэнд | 28274 |
| Дээд зэргийн амттан: Хүнс, эрүүл мэнд - Улирал | *28272 |
| Дээд зэргийн амттан: Хоолны урлагийн удиртгал | 28250 |
| График харилцааны систем | 28458 |
| Эрүүл мэндийн шинжлэх ухаан | 28303 |
| Бизнес, маркетингийн удиртгал | 26112 |
| Загварын салбарын мэргэжлийн удиртгал | 28147 |
| Тоглоомын дизайны удиртгал | 28461 |
| Мэдээллийн технологийн удиртгал | 26116 |
| Мэдээллийн технологийн үндэс, хосолсон төгсөлт | 96116W |
| Барилгын дотоод заслын удиртгал | 28289 |
| Манлайллын оргил | 28956 |
| Маркетинг | 28120 |
| Материал, процессын технологи | 28305 |
| Эмнэлгийн технологи | 28383 |
| Эмнэлзүйн нэр томьёо, хосолсон төгсөлт | 98383W |
| Эмийн сангийн техникч | 28305 |
| Гэрэл зураг, дүрс бичлэгийн технологи I | 28625 |
| Гэрэл зураг, дүрс бичлэгийн технологи II | 28626 |
| PRIME (Мэргэжилтэй холбоотой дадлага, менторын туршлага ¨[Professional Related Intern-Mentorship Experience]) | 29060 |
| Роботын дизайн | 28421 |
| Сургуулиас ажлын байранд шилжих шилжилтийн дадлага | 29828 |
| Спорт, энтертайнмент, амралт чөлөөт цаг | 28123 |

| | |
|---|---|
| Тогтвортой, шинэчлэгдэх технологи | 28460 |
| Маргаашийн багш нар I | 29062 |
| Маргаашийн багш нар I, хосолсон төгсөлт | 99062W |
| Маргаашийн багш нар II | 29063 |
| Маргаашийн багш нар II, хосолсон төгсөлт | 99063W |
| Робот зохион бүтээх технологи (18421) | 28421 |
| Мал эмнэлгийн шинжлэх ухаан I | 28064 |
| Мал эмнэлгийн шинжлэх ухаан II | 28061 |
| Телевизийн продакшн I | 28689 |
| Телевизийн продакшн, хосолсон төгсөлт | 98689W |
| ТВ, мультимедиа продакшн II | 28690 |
| ТВ, мультимедиа продакшн II, Хосолсон төгсөлт | 98690W |
| ТВ, мультимедиа продакшн III | 28691 |
| Телевиз, мультимедиа продакшн III, хосолсон төгсөлт | 98691W |
| Вэб хуудасны дизайн, мультимедиа | 26646 |
| Вэб хуудасны дизайн, мультимедиа, хосолсон төгсөлт | 96646W |
| Вэб хуудасны дизайн, мультимедиа, Ахисан шат | 26631 |
| Вэб хуудасны дизайн, мультимедиа, ахисан түвшний хосолсон төгсөлт | 96631W |

| АНГЛИ ХЭЛ, УРАН ЗОХИОЛ (Хуудас 45-64) | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| Америкийн африкчуудын уран зохиол | 21064 |
| Америкийн соёл иргэншил: Англи хэл, нийгэм судлал, эрчимжүүлсэн | 21176/ 22376 |
| Уншлагын элементүүд ба стратеги | 21180 |
| Англи хэл 9 | 21130 |
| Англи хэл 9, Дэлхийн түүх, Газар зүй: МЭ 1500-аас өнөөг хүртэл (зөвхөн YHS) | 21130/ 22216 |
| Англи хэл 9 ба Дэлхийн түүх, эрчимжүүлсэн (зөвхөн YHS) | 21132/ 22343 |
| Англи хэл 10 | 21140 |
| Англи 10 Эрчимжүүлсэн | 21142 |
| Англи хэл 11 | 21150 |
| Англи хэл 11, (Коллежийн Найруулга зүй) хосолсон төгсөлт | 91150W |
| ELD Англи хэл 11 Үргэлжлэл | 21185 |
| Англи хэл 11 Стратеги (зөвхөн ACHS) | 21151 |
| Англи хэл 12 | 21160 |
| Англи хэл 12, (Коллежийн Найруулга зүй) хосолсон төгсөлт | 91160W |
| Англи хэл 12, (Их Британийн ба Дэлхийн уран зохиол) Хосолсон төгсөлт | 91161W |
| Англи хэл, найруулга зүй, AT 11-р анги | 31196 |
| Англи хэлний уран зохиол, найруулга зүй, 12-р анги | 31195 |
| Кино судлал | *21446 |
| Кино студи II (зөвхөн WKHS ба YHS) | *21447 |

| | |
|---|---|
| Сэтгүүл зүй: Нэвтрүүлэг | 21218 |
| Сэтгүүл зүй: Уран зохиолын сэтгүүл | 21207 |
| Сэтгүүл зүй: Сонин | 21205 |
| Сэтгүүл зүй: Жилийн ном | 21209 |
| Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага | *20202 |
| Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага | *20201 |
| Дэлхийн Уран зохиол | 21518 |

| ЭРҮҮЛ МЭНД, БИЕ БЯЛДРЫН БОЛОВСРОЛ (Хуудас 20-25) | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| Биеийн тамирын тусгай боловсрол - 9-р анги | 27670 |
| Биеийн тамирын тусгай боловсрол - 10-р анги | 27680 |
| Биеийн тамирын тусгай боловсрол - 11-р анги | 27690 |
| Биеийн тамирын тусгай боловсрол - 12-р анги | 27700 |
| Жолоочийн боловсрол, аюулгүй байдал | *27010 |
| Жолоочийн боловсрол, аюулгүй байдал | *27011 |
| Эрүүл мэнд, Бие бялдрын боловсрол ELD | 27330 |
| Эрүүл мэнд, Бие бялдрын боловсрол I | 27300 |
| Эрүүл мэнд, Бие бялдрын боловсрол II | 27400 |
| Эрүүл мэнд I | *27320 |
| Эрүүл мэнд, бие бялдар ба жолоочийн боловсрол II (зөвхөн WKHS) | 27410 |
| Биеийн тамир III (Улирал 1) | *27510 |
| Биеийн тамир III (Улирал 2) | *27515 |
| Биеийн тамир IV (Улирал 1) | *27610 |
| Биеийн тамир IV (Улирал 2) | *27615 |

| АНГЛИ ХЭЛ СУРАЛЦАГСДЫН ҮЙЛЧИЛГЭЭ (Хуудас 45- 42) *Англи хэлний сургалтын кодыг Англи хэлний сургалт хэсгээс харна уу | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| ELD 1/SLIFE Унших чадварын хөгжил | 20775 |
| ELD SLIFE Математикийн үндэс | 23111 |
| ELD SLIFE Алгебрын өмнөх | 23113 |
| ELD 1/SLIFE Унших | 20776 |
| ELD 1 Уншлага | 20787 |
| ELD 1 Байгалийн ухаан | 20780 |
| ELD 1 Нийгэм судлал | 20789 |
| ELD 1 Ярих/Бичих | 20788 |
| ELD 2 Уншлага | 20791 |
| ELD 2 Байгалийн ухаан | 20781 |
| ELD 2 Нийгэм судлал | 20793 |
| ELD Байгал орчны шинжлэх ухаан | 24362 |
| ELD Физикийн зарчмууд | 24501 |
| ELD Виржиниа ба АНУ-ыг Засгийн газар | 22446 |
| ELD Дүрмийн хичээл (зөвхөн ACHS) | 20891 |
| ELD Биологи Лабораторийн хичээл | 24317 |
| ELD 4 Уншлага | 20797 |

| | |
|---|---|
| ELD 3 Уншлага | 20794 |
| ELD 3-4 Дэлхийн түүх, Газар зүй, МЭ-ий 1500 он хүртэл | 22345 |

| МАТЕМАТИК (Хуудас 46-50) | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| Алгебр I | 23130 |
| Алгебр I, Хэсэг I | 23131 |
| Алгебр I, Хэсэг II | 23132 |
| Алгебр II | 23135 |
| Алгебр II/Тригонометр, Эрчимжүүлсэн | 23136 |
| Алгебр III | 23155 |
| Алгебр, функц, дата шинжилгээ | 23145 |
| Дээд тоо AB, AP | 33177 |
| Дээд тоо BC, AT | 33179 |
| Аналитик геометртэй хамт дээд тоо, хос төгсөлт | 93173W |
| Дээд тооны удиртгал, хос төгсөлт | 93176W |
| Дээд тоо I/II, хос төгсөлт | 93179W |
| Өгөгдлийн шинжлэх ухаан | 23195 |
| Дифференциалын тэгшитгэл (93180W) | 93180W |
| Геометр | 23143 |
| Геометр, Эрчимжүүлсэн | 23141 |
| Геометр, зарчмууд | 23142 |
| Ахлах сургуулийн ерөнхий математик | 23120 |
| Шугаман алгебр | 93165W |
| Олон хувилбартай Дээд тоо | 93178W |
| Тооцооллын өмнөх, AT | 33164 |
| Дээд тооны удиртгал, хос төгсөлт | 93162W |
| Дээд тооны удиртгал/Тригонометр | 23162 |
| Магадлал, статистик | 23190 |
| Тоон анализ, хосолсон төгсөлт | 93167W |
| Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага-Алгебр | 20203 |
| Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага | 20204 |
| Статистик I/II, хосолмол төгсөлт | 93163W |
| AT Статистик | 33192 |
| Стратеги, Алгебр I | 23124 |
| Стратеги, Алгебр II | 23126 |
| Стратеги, геометр | 23128 |
| Векторын тооцоолол | 93175W |

| БАЙГАЛИЙН УХААН (Хуудас 40-41) | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| Анатоми/Физиологи I, хосолсон төгсөлт | 98085W |
| Анатоми/Физиологи I/II, хосолсон төгсөлт | 94320W |
| Arlington Tech Оргил туршлага | 28955 |
| Одон орон | 24700 |
| Биологи | 24310 |
| Биологи II-Генетик (Зөвхөн YHS) | 24325 |
| Биологи II/Хүний биологи | 28085 |
| Биологийн лабораторийн хичээл, эрчимжүүлсэн, гүнзгийрүүлсэн | 24319 |
| Биологи, AT | 34370 |
| Хими | 24410 |
| Хими, AT | 34470 |
| Дэлхий судлал | 24210 |
| Дэлхий судлал II: Далай судлал | 24220 |
| Байгал орчны шинжлэх ухаан | 24361 |
| Экологи | 24365 |
| Байгал орчны шинжлэх ухаан, AT (зөвхөн WKHS & YHS) | 34270 |
| Ерөнхий биологи, хосолсон төгсөлт | 94310W |
| Коллежийн ерөнхий физик I, хосолсон төгсөлт | 94501W |
| Коллежийн ерөнхий физик II, хосолсон төгсөлт | 94502W |
| Байгал орчны ерөнхий шинжлэл, хосолсон төгсөлт | 94270W |
| Зүг чиг, байршил тодорхойлох багаж хэрэгсэл, техник (зөвхөн WL) | 98423W |
| Эрчимжүүлсэн биологи | 24315 |
| Эрчимжүүлсэн хими | 24415 |
| Эрчимжүүлсэн дэлхий судлал | 24215 |
| Эрчимжүүлсэн физик | 24515 |
| Биологийн удиртгал (зөвхөн ACHS) | 24301 |
| Дэлхий/Агаар мандал судлалын удиртгал (зөвхөн ACHS) | 24201 |
| Физик | 24510 |
| Физик C: Механик, Эрчим хүч, Татах хүч, AT | 34570 |
| Физик I, AT | 34578 |
| Физик II, AT | 34579 |
| Физикийн зарчмууд (20049) | 24500 |
| Химийн зарчмууд (зөвхөн YHS) | 24400 |
| Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага-Биологи | *20205 |
| Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага-Дэлхий судлал | *20206 |
| Биологийн сонгосон сэдвүүд | 34371 |
| Химийн сонгосон сэдвүүд | 34471 |
| Байгал орчны шинжлэх ухааны сонгосон сэдвүүд, AT | 34271 |
| Физик C-ийн сонгосон сэдвүүд | 34571 |
| Физик I-ийн сонгосон сэдвүүд | 34568 |
| Физик II-ийн сонгосон сэдвүүд | 34569 |

| НИЙГЭМ СУДЛАЛ (Хуудас 60-65) | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| Америкийн Африкчуудын судлал | 22371 |
| Америкийн соёл иргэншил: Англи хэл, нийгэм судлал, эрчимжүүлсэн (зөвхөн WKHS) | 21176/ 22376 |
| Харьцуулсан Засгийн газар, AT | 32442 |
| Эдийн засаг, хувийн санхүү | 22212 |
| Эдийн засаг, хувийн санхүү, гүнзгийрүүлсэн | 22211 |
| Эдийн засаг, AT | 32806 |

| | |
|---|---|
| Эдийн засаг, хосолсон төгсөлт | 92801W |
| Англи хэл 9, Дэлхийн түүх, Газар зүй: МЭ 1500-аас өнөөг хүртэл (зөвхөн YHS) | 21130/ 22216 |
| Европын түүх, AT | 32399 |
| Антропологи, AT | 32212 |
| Хуульзүйн удиртгал | *22218 |
| ВИ/АНУ-ын түүхийн удиртгал (зөвхөн ACHS) | 22202 |
| Дэлхийн газар зүйн удиртгал (зөвхөн ACHS) | 22201 |
| Дэлхийн түүх, газар зүйн удиртгал (ACHS) | 22203 |
| Латин Америкийн судлал | 22373 |
| Олон талын оролцоог хангах талаар дасгалжуулагчдын манлайллын чадвар | 22700 |
| Сэтгэл судлал | 22900 |
| Сэтгэл судлал, AT | 32902 |
| Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага-ВИ/АНУ-ын Засгийн газар | *20209 |
| Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага-Дэлхийн газар зүй | *20208 |
| Өөрийн хурдад тохируулсан бие даасан давтлага-Дэлхийн түүх II | *20207 |
| Социологи | 22500 |
| Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд | 22440. |
| Виржиниа, АНУ-ын Засгийн газар, хосолсон төгсөлт | 92240W |
| Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд, AT | 32445 |
| Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх | 22360 |
| **НИЙГМИЙН СУДАЛГААНЫ үргэлжлэл (Хуудас 60-65)** | |
| АНУ-ын түүх I/II | 32319 |
| Виржиниа, АНУ-ын түүх, хосолсон төгсөлт | 92360W |
| Эдийн засаг, хувийн санхүү | 22212V |
| Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд | 22440V |
| Виржиниа, Америкийн Нэгдсэн Улсын түүх | 22360V |
| Дэлхийн нийгэм, улс төр | *22388 |
| Дэлхийн газар зүй | 22210 |
| Дэлхийн түүх, Англи хэл 9, эрчимжүүлсэн (зөвхөн YHS) | 22343/ 21132 |
| Дэлхийн түүх, Газар зүй, МЭ-ий 1500 оноос өнөөг хүртэл | 22216 |
| Дэлхийн түүх, Газар зүй: Эртнээс МЭ-ий 1500 он хүртэл | 22215 |
| Дэлхийн түүх, Газар зүй: Эртнээс МЭ-ий 1500 он хүртэл, эрчимжүүлсэн | 22219 |
| Дэлхий түүх: Орчин үе, AT | 32400 |

| **ТУСГАЙ БОЛОВСРОЛ (Хуудас 69-72)** | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| Алгебр I, Хэсэг I | 20008 |
| Дэлхий, агаар мандал судлалын хэрэглээ | 24211 |
| Биологи, Хэсэг I | 20020 |
| Биологи, Хэсэг II | 20021 |
| Дэлхий судлал, Хэсэг I (зөвхөн WKHS) | 20045 |
| Дэлхий судлал, Хэсэг II | 20046 |
| Англи хэл | 20035 |
| Англи хэл 9 | 20001 |
| Англи хэл 10 | 20002 |
| Англи хэл 12 | 20004 |
| Заах арга зүй судлал | 20028 |
| Англи хэл 11 | 20003 |
| Амьдралын чадварууд | 20026 |
| Математик | 20036 |
| Мэргэжлийн боловсрол | 20998 |
| Мэргэжлийн боловсролын сургалт/Ажилд орох боловсрол | 20976 |
| Мэргэжилтэй танилцах | 20999 |
| Хувийн амьдрал, санхүү | 20055 |
| Физикийн зарчмууд | 20049 |
| Унших | 20014 |
| Унших | 20015 |
| Унших | *20006 |
| Байгалийн ухаан | 20038 |
| Геометрийн сонгосон сэдвүүд | 20054 |
| Нийгэмших чадвар | 20023 |
| Нийгмийн ухаан | 20039 |
| АНУ-ын түүхийн хэрэглээ | 20053 |
| Виржиниа, АНУ-ын Засгийн газар | 20018 |
| Виржиниа, АНУ-ын түүх | 20017 |
| Виржиниа, АНУ-ын түүх, Хэсэг I | 20016 |
| Виржиниа, АНУ-ын түүх, Хэсэг II | 20019 |
| Дэлхийн газар зүй | 20040 |
| Дэлхийн түүх, Газар зүй, Хэсэг I | 20051 |
| Дэлхийн түүх, газар зүй өнөөг хүртэл, Хэсэг II | 20052 |
| Бичих | *20005 |

| **ДЭЛХИЙН ХЭЛНҮҮД (Хуудас 74-83)** | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| Ахисан түвшний Франц хэл | 25160 |
| Ахисан түвшний Латин хэл | 25360 |
| Ахисан түвшний Испани хэл | 25560 |
| Америкийн дохионы хэл I | 25990 |
| Америкийн дохионы хэл II | 25995 |
| Америкийн дохионы хэл III | 25997 |
| Америкийн дохионы хэл IV | 25992 |
| Араб хэл I | 25800 |
| Араб хэл II | 25822 |
| Араб хэл III | 25830 |
| Араб хэл IV | 25840 |
| Араб хэл I | 25841 |
| Хятад хэл I | 25615 |

| | |
|---|---|
| Хятад хэл II | 25625 |
| Хятад хэл III | 25630 |
| Хятад хэл IV | 25640 |
| Хятад хэл ба соёл, AT | 35860 |
| Франц хэл I | 25110 |
| Франц хэл II | 25120 |
| Франц хэл III | 25130 |
| Франц хэл IV | 25140 |
| Франц хэл V | 25150 |
| Франц хэл ба соёл, AT | 35165 |
| Герман хэл I | 25210 |
| Герман хэл II | 25220 |
| Герман хэл III | 25230 |
| Япон хэл I | 25910 |
| Япон хэл II | 25920 |
| Япон хэл III | 25930 |
| Латин хэл I | 25310 |
| Латин хэл II | 25320 |
| Латин хэл III | 25330 |
| Латин хэл IV | 25340 |
| Латин хэл V | 25350 |
| Латин хэл, AT | 35350 |
| Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл I | 25517 |
| Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл II | 25527 |
| Чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан Испани хэл III | 25537 |
| Испани хэл I | 25510 |
| Испани хэл II | 25520 |
| Испани хэл III | 25530 |
| Испани хэл Гүнзгийрүүлсэн 9 | 25511 |
| **ДЭЛХИЙН ХЭЛ (үргэлжлэл) (Хуудас 127-128)** | |
| Испани хэл Гүнзгийрүүлсэн 10 | 25521 |
| Испани хэл IV | 25540 |
| Испани хэл V | 25550 |
| Испани хэл ба соёл, AT | 35565 |
| Испани уран зохиол, AT | 35580 |

| **WASHINGTON-LIBERTY ДЭХ ОУБ-ЫН ХИЧЭЭЛҮҮД (Хуудас 136-154)** | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| ОУБ Араб хэл (SL) Хэсэг I | 35841 |
| ОУБ Араб хэл (SL) Хэсэг II | 35845 |
| ОУБ Биологи (HL) Хэсэг I | 34376 |
| ОУБ Биологи (HL) Хэсэг II | 34377 |
| ОУБ Биологи (SL) | 34378 |
| ОУБ Бизнес, менежмент (SL) | 36114 |
| ОУБ Хими (HL) Хэсэг I | 34476 |
| ОУБ Хими (HL) Хэсэг II | 34477 |
| ОУБ Мэдээлэл зүй (SL) Хэсэг I | 36540 |
| ОУБ Мэдээлэл зүй (SL) Хэсэг II | 36550 |
| ОУБ Мэдээлэл зүй (HL) Хэсэг I | 36560 |
| ОУБ Мэдээлэл зүй (HL) Хэсэг II | 36570 |
| ОУБ Дизайны технологи (SL) Хэсэг I | 38496 |
| ОУБ Дизайны технологи (SL) Хэсэг II | 38496 |
| ОУБ Эдийн засаг (SL) | 32802 |
| ОУБ Англи хэл (HL) Хэсэг I | 31197 |
| ОУБ Англи хэл (HL) Хэсэг II | 31198 |
| ОУБ Англи хэл, уран зохиол, (SL) Хэсэг I | 31190 |
| ОУБ Англи хэл, уран зохиол, (SL) Хэсэг II | 31191 |
| ОУБ Байгал орчны сис. Нийгэм (SL) | 34275 |
| ОУБ Кино (HL) Хэсэг I | 31147 |
| ОУБ Кино (HL) Хэсэг II | 31149 |
| ОУБ Кино (SL) Хэсэг I | 31144 |
| ОУБ Кино (SL) Хэсэг II | 31145 |
| ОУБ Франц хэл B (HL) Хэсэг I | 35158 |
| ОУБ Франц хэл B (HL) Хэсэг II | 35168 |
| ОУБ Франц хэл B (SL) Хэсэг I | 35157 |
| ОУБ Франц хэл B (SL) Хэсэг II | 35167 |
| ОУБ Газар зүй (SL) | 32210 |
| ОУБ Америкийн түүх (HL) Хэсэг 1 | 32385 |
| ОУБ Латин хэл (HL) Хэсэг I | 35362 |
| ОУБ Латин хэл (HL) Хэсэг II | 35372 |
| ОУБ Латин хэл (SL) Хэсэг I | 35357 |
| ОУБ Латин хэл (SL) Хэсэг II | 35367 |
| ОУБ Мандарин Хятад хэл ab initio (SL) Хэсэг I | 35815 |
| ОУБ Мандарин Хятад хэл ab initio (SL) Хэсэг II | 35825 |
| ОУБ Мандарин Хятад хэл (SL) Хэсэг I | 35817 |
| ОУБ Мандарин Хятад хэл (SL) Хэсэг II | 35827 |
| ОУБ Мандарин Хятад хэл (HL) Хэсэг I | 35816 |
| ОУБ Мандарин Хятад хэл (HL) Хэсэг II | 35826 |
| ОУБ Математик: Анализ, Аргачлал (SL) Хэсэг I | 33171 |
| ОУБ Математик: Анализ, Аргачлал (SL) Хэсэг II | 33172 |
| ОУБ Математик: Хэрэглээ ба тайлбар (SL) | 33170 |
| ОУБ Математик: Анализ, Аргачлал (HL) Хэсэг I | 33181 |
| ОУБ Математик: Анализ, Аргачлал (HL) Хэсэг II | 33182 |
| ОУБ Хөгжим (SL) | 39227 |
| ОУБ Философи (SL) | 32600 |
| ОУБ Физик (SL) Хэсэг I | 34576 |
| ОУБ Физик (SL) Хэсэг II | 34577 |
| ОУБ Физиологи (HL) Хэсэг I | 32903 |
| ОУБ Физиологи (HL) Хэсэг II | 32904 |
| ОУБ Физиологи (SL) | 32901 |
| ОУБ Нийгмийн антропологи (HL) Хэсэг I | 32375 |
| ОУБ Нийгмийн антропологи (HL) Хэсэг II | 32377 |
| ОУБ Нийгмийн антропологи (SL) | 32372 |
| ОУБ Испани хэл B (HL) Хэсэг I | 35578 |
| ОУБ Испани хэл B (HL) Хэсэг II | 35588 |
| ОУБ Испани хэл B (SL) Хэсэг I | 35575 |
| ОУБ Испани хэл B (SL) Хэсэг II | 35585 |
| ОУБ Испани хэл, уран зохиол, (HL) Хэсэг I | 35577 |
| ОУБ Испани хэл, уран зохиол, (HL) Хэсэг II | 35587 |

| | |
|---|---|
| ОУБ Спорт, дасгал, эрүүл мэндийн шинжлэх ухаан (SL) Хэсэг I | 38055 |
| ОУБ Спорт, дасгал, эрүүл мэндийн шинжлэх ухаан (SL) Хэсэг II | 38057 |
| ОУБ Театрын урлаг (HL) Хэсэг I | 39142 |
| ОУБ Театрын урлаг (HL) Хэсэг II | 39143 |
| ОУБ Театрын урлаг (SL) | 39141 |
| 20-р зууны Дэлхийн түүх (HL) Хэсэг II | 32386 |
| ОУБ Визуал урлаг (HL) Хэсэг I | 39146 |
| ОУБ Визуал урлаг (HL) Хэсэг II | 39148 |
| ОУБ Визуал урлаг (SL) | 39144 |

***Улирлын хичээл***

| НЭМЭЛТ ХИЧЭЭЛҮҮД | |
|---|---|
| **ХИЧЭЭЛИЙН НЭР** | **КОД** |
| АТ оюутнуудад хандана уу | 20184 |
| Заах арга зүй судлал | *20030 |
| Судалгаа, АТ (зөвхөн WKHS) | 32112 |
| Семинар, АТ (зөвхөн WKHS ба YHS) | 32110 |
| Төгсөлтийн төсөл (*21095 улирлын сонголт) (зөвхөн WKHS) | 20190 |
| Төгсөх ангийн төслийн бие даалт (зөвхөн WKHS) | 20191 |
| SOAR (зөвхөн YHS) | 20152 |
| SOAR семинар (зөвхөн YHS) | 20151 |
| Сайн дурын үйлчилгээ (*20156 улирлын сонголт) | 20155 |

## ХАВСРАЛТ А
## Arlington Public Schools
## Санал болгож буй урлагийн хичээлүүд

Дараах хичээлүүд нь одоогийн урлаг гэсэн тодорхойлолтод нийцнэ. Нэг нэгж кредитийг хоёр эсхүл илүү тоогоор дуусгасан бол улирлын хичээлүүдийг авч болно.

**Дүрслэх урлаг**
Урлаг I (29120)
Урлаг II (29130)
Урлаг III (29140)
Урлаг, дизайн, AT (39149)
Урлагийн түүх, AT (39151)
ОУБ Визуал урлаг (HL) Хэсэг I (39146) Хэсэг II (39148)
ОУБ Визуал урлаг (SL) (39144)
Керамик I (29167)
Керамик II (29168)
Керамик III (29169)
Гар урлалтай танилцах нь (29160)
Гар урлал (29162)
Уран зураг, зураг (S) (29163)
Компьютерын график (29152)
Компьютерын график II (29153)
Компьютерын график III (29154)
Дижитал гэрэл зураг I (29193)
Дижитал гэрэл зураг II (29194)
Дижитал гэрэл зураг III (29195)
Баримлын урлагийн удиртгал (S) (29165)
Баримал (29166)
Телевизийн продакшн I (28689)
Телевиз, мультимедиа продакшн II (28690)
Телевиз, мультимедиа продакшн III (28691)

**Дуу хөгжим**
Бэсрэг хоор (29252)
Концертын хор (29260)
Трэбл хоор (29263)
Бассо хоор (29266)
Ахисан түвшний хоор (29289)
Дунд шатны хамтлаг (29233)
Ахисан шатны хамтлаг (29234)
Хөгжимт жагсаалын хамтлаг (S) (29254)
Чуулга (S) (29250)
Төгөлдөр хуур (29200)
Чавхдаст хөгжмийн чуулга (29244)
Цөөхүүл оркестр (29242)
Гитар I (29245)
Ахисан түвшний гитар (29247)
Хөгжим бичих, цахим аудио, хөгжмийн түүх (29225)
Хөгжимд дурлах: Хөгжмийн түүх: Жанр, соёл (29222)
Хөгжмийн онол, AT (39226)
ОУБ Хөгжим SL (39227)
Жааз хөгжим/Чуулга (29251)
Жааз/Поп дууны лаборатори/чуулга (29280)

**Театрын урлаг**
Театрын урлаг I (21400)
Театрын урлаг II (21415)
Театрын урлаг III (21425)
Ахисан түвшний Театрын урлаг IV (21430)
Театрын техник (21435)
ОУБ Театрын урлаг SL (39141)
ОУБ Театрын урлаг HL Хэсэг I (39142) Хэсэг II (39143)
ОУБ Кино SL Хэсэг I (31144) Хэсэг II (31145)
ОУБ Кино HL Хэсэг I (31147) Хэсэг II (31149)

**Урлагийн дадлагын хөтөлбөр I**
Урлагийн дадлагын хөтөлбөр I (29290)
Урлагийн дадлагын хөтөлбөр II (29291)
Урлагийн дадлагын хөтөлбөр III (29292

# <u>ХАВСРАЛТ B</u>

## Arlington Public Schools

## Хавсралт B – Карьер, техникийн боловсролын (CTE) хичээлийн тойм

| **<u>2022-23</u> Санал болгож буй хичээлүүд** | **Карьерын төв** | **Wakefield** | **W-L** | **Yorktown** |
|---|---|---|---|---|
| Бизнес, мэдээллийн технологи | | | | |
| QuickBooks-ээр нягтлан бодох (26320) | X | X | X | X |
| Компьютерын мэдээллийн системүүд (26614) | X | X | X | X |
| Компьютерын програмчлал (26638) | X | | | |
| Компьютерын програмчлал, эрчимжүүлсэн, (26637) | X | | | |
| Компьютерын програмчлал, ахисан түвшин (26643) | X | X | X | X |
| Кибер: Cisco академи, Түвшин 1, Хэсэг I (26542) | X | X | X | X |
| Кибер: Cisco академи, Түвшин 1, Хэсэг II (26543) | X | X | X | X |
| Кибер аюулгүй байдал I: Кибер аюулгүй байдлын үндэс (26659) | X | | | |
| Кибер аюулгүй байдал II: Компьютерын программ хангамжийн сүлжээний ажиллагаа (26657) | X | | | |
| Кибер аюулгүй байдал II: Кибер аюулгүй байдлын ажиллагаа (26662) | X | | | |
| Кибер аюулгүй байдал III: Компьютерын программ хангамжийн сүлжээ (26658) | X | | | |
| Кибер аюулгүй байдал III: Кибер аюулгүй байдлын программ хангамж (26663) | X | | | |
| Нэгдэл “Coop” Ажлын дадлага I, II, III, CTE хичээлд давхар бүртгүүлэхийг шаардана, (28951, 28953, 28954) | X | X | X | X |
| Эрүүгийн шүүх I, II (28702) (28703) | X | | | |
| Вэб хуудасны дизайн, мультимедиа (26646) | X | X | X | X |
| Вэб хуудасны дизайн, мультимедиа, ахисан шат (26631) | X | X | X | X |
| Бизнес эрхлэлт (29094) | X | X | X | X |
| Бизнес эрхлэлт, ахисан түвшин (99095) | X | X | X | X |
| Бизнес, маркетингийн удиртгал (26112) | | X | X | X |
| Мэдээллийн технологийн удиртгал (26116) | X | X | X | X |
| ОУБ Бизнес, менежмент (SL) (36114) | | | X | |
| **Мэдээлэл зүй** | | | | |
| Мэдээлэл зүй, AT (33185) | | X | X | X |
| Мэдээлэл зүйн зарчмууд, AT (33186) | X | X | X | X |
| ОУБ Мэдээлэл зүй, SL Хэсэг I (36540), Хэсэг II (36550) | | | X | |
| ОУБ Мэдээлэл зүй, HL Хэсэг I (36560), Хэсэг II (36570) | | | X | |
| **Маркетинг** | | | | |
| Бизнес, маркетингийн удиртгал (26112) | | X | X | X |
| Спорт, энтертайнмент, амралт чөлөөт цаг (28123) | | X | X | X |
| [illegible] | | | | |
| Хүүхдийн хөгжил, эцэг эхийн хичээл - Жил (28232) Улирал (28230) | | X | X | X |
| Бага насны хүүхдийн боловсрол I (28235), II (28236) | X | | | |
| Дээд зэргийн амттан: Хүнс, эрүүл мэнд - Жил (28274) Улирал (28272) | | X | X | X |
| Дээд зэргийн амттан: Хоолны урлагийн удиртгал | | X | X | X |
| Загварын салбарын мэргэжлийн удиртгал | | X | X | X |
| Барилгын дотоод заслын удиртгал (28289) | | X | X | X |
| Маргаашийн багш нар I (29062), II (29063) | X | X | X | X |
| **Техникийн боловсрол/Худалдаа, үйлдвэрлэлийн хөтөлбөр** | | | | |
| Ахисан шатны зураг, дизайн (28440) | X | X | X | X |
| Агаарын хөлгийн инженерчлэл (28498) | X | | | |
| Автомашины эвдрэл засвар I (28677), II (28678), III (28680) | X | | | |
| Автомашины засвар, гэрлийн засвар (28675) | X | | | |
| Автомашины технологи I (28509) | X | | | |
| Автомашины технологи II (28507) | X | | | |

| 2022-23 Санал болгож буй хичээлүүд | Карьерын төв | Wakefield | W-L | Yorktown |
|---|---|---|---|---|
| Автомашины технологи III (28508) | X | | | |
| **Техникийн боловсрол/Худалдаа, үйлдвэрлэлийн хөтөлбөр** | | | | |
| Агаарын хөдөлгүүрийн технологи | X | | | |
| Агаарын хөдөлгүүрийн технологи II (28732) | X | | | |
| Үсчин I (28531) | X | | | |
| Үсчин II (28532) | X | | | |
| Үсчин III (28526) | X | | | |
| Эрүүл мэнд, анагаахын биотехнологи (28326) | X | | | |
| Мужааны I (28519) ба II (28520) ба III (28540) | X | | | |
| Компьютерын туслалцаатай архитекторын зураг (28408) | X | X | X | X |
| Компьютерын туслалцаатай инженерчлэлийн зураг (28438) | X | X | X | X |
| Компьютерын тусламжтай техникийн зураг (28439) | X | X | X | X |
| Компьютер оролцуулсан үйлдвэрлэлийн инженерчлэл (28493) | X | | | |
| Барилгын технологи (28512) | X | | | |
| Гоо сайхан I (28528) | X | | | |
| Гоо сайхан II (28529) | X | | | |
| Гоо сайхан III (28530) | X | | | |
| Эрүүгийн шүүх I, II (28702) (28703) | X | | | |
| Хоолны урлаг, шинжлэх ухаан I (28522), II (28523) | X | | | |
| Хоолны урлаг III: Талх, жигнэмэг (28524) | X | | | |
| Хоолны урлаг III: Хүлээн авалтын үйлчилгээ (28525). | X | | | |
| Дижитал анимац (28457) | X | | | |
| Дижитал электроник (26671) | X | | | |
| Цахилгаан I (28534). II (28535) | X | | | |
| Эмнэлгийн анхны тусламжийн техникч I (28334) (98334W) | X | | | |
| Эмнэлгийн анхны тусламжийн техникч III (28335) | X | | | |
| Эрчим хүч (26448) | X | | | |
| Инженерчлэл I: Инженерчлэлийн дизайны удиртгал (28491) | X | X | X | X |
| Инженерчлэл II: Инженерчлэлийн зарчмууд (28492) | X | X | X | X |
| Инженерчлэлийн оргил: Дизайн, хөгжүүлэлт (28494) | X | X | X | X |
| Биотехнологид хэрэглэх шинжилгээний технологи (28325) | X | | | |
| График харилцааны систем (28458) | X | | | |
| Эрүүл мэндийн шинжлэх ухаан (28303) | X | | | |
| ОУБ Дизайны технологи Хэсэг I (38496), Хэсэг II (38497) | | | X | |
| Материал ба процесс | X | | | |
| Эмнэлгийн технологи (28383) | X | | | |
| Эмийн сангийн техникч (28305) | X | | | |
| Гэрэл зураг, дүрс бичлэг I (28625) | X | | | |
| Гэрэл зураг, дүрс бичлэг II (28626) | X | | | |
| Физик/Хөдөлмөрийн эмчилгээ I (28340/98340W) & II (28341/98341W) | X | | | |
| Роботын дизайн (28421) | X | | | |
| Сургуулиас ажлын байранд шилжих шилжилтийн дадлага (29828) | X | | | |
| Жижиг амьтныг арчлах I/ (28062), II (28063) | X | | | |
| Залуу агаарын цэрэг ROTC I (29911), II (29912) | X | | | |
| Залуу агаарын цэрэг ROTC III (29913), IV (29914) | X | | | |
| Тогтвортой, сэргээгдэх технологи (28460) | X | | | |
| Амьтны техникийн шинжлэх ухаан I/Мал эмнэлийн шинжлэх ухаан I (28064) & II (28061) | X | | | |
| Телевизийн продакшн I (28689) | X | | | |
| Телевиз, мультимедиа продакшн II (28690) | X | | | |
| Телевиз, мультимедиа продакшн III (28691) | X | | | |

*Тайлбар: Эдгээрийн аль ч хичээлд элсэн орсноор үйлдвэрлэлийн гэрчилгээ авч эсхүл улсын лицензийн шалгалт өгөх багтах ба нь Стандарт дипломын төгсөлтийн шаардлагыг хангах юм.*

## ХАВСРАЛТ C
**Arlington Public Schools**
Цахим хичээлийн саналууд

**Урлагийн боловсрол**
- Урлагийн түүх, AT
- Хөгжмийн онол, AT

**Карьер ба техник, насанд хүрэгчдийн боловсрол (CTE)**
- Мэдээлэл зүй A, AT
- Компьютерын шинжлэх ухааны зарчмууд, AT

**Англи хэл, уран зохиол (ELA)**
- Англи хэл 9
- Англи хэл 10
- Англи хэл 11
- Англи хэл 12
- Англи хэлний уран зохиол, найруулга зүй, AT
- Англи хэлний уран зохиол, найруулга зүй, AT

**Эрүүл мэнд, биеийн тамир**
- Эрүүл мэнд I (0.5 кредит)

**Математик**
- Алгебр I
- Геометр
- Алгебр II
- Алгебр, функц, дата шинжилгээ (AFDA)
- Дээд тооны удиртгал/Математикийн анализ
- Дээд тоо AB, AP
- Дээд тоо BC, AT
- Статистик, AT

**Шинжлэх ухаан**
- Биологи
- Биологи II Анатоми/Физик
- Биологи II Экологи
- Биологи, AT
- Хими I
- Хими II
- Дэлхий, агаар мандал судлал
- Дэлхий судлал II: Одон орон
- Дэлхий судлал II: Далай судлал
- Байгал орчны шинжлэх ухаан, AT
- Физик
- Физик I, AT
- Физик II, AT

**Нийгэм судлал**
- Америкийн африкчуудын түүх
- Харьцуулсан төр засаг, улс төр, AT
- Эдийн засаг, хувийн санхүү
- Эдийн засаг, AT (AT Макро ба AT Микрог хослуулна)
- Европын түүх, AT
- Антропологи, AT
- Сэтгэл судлал
- Сэтгэл судлал, AT
- Виржиниа, АНУ-ын түүх
- Виржиниа, АНУ-ын Засгийн газар
- Дэлхийн газар зүй
- 1500 он хүртэлх дэлхийн түүх, газар зүй
- Дэлхийн түүх, газар зүй: 1500 оноос өнөөг хүртэл
- Дэлхий түүх: Орчин үе, AT

**Дэлхийн хэл**
- Америкийн дохионы хэл I*
- Америкийн дохионы хэл II*
- Америкийн дохионы хэл III*
- Араб хэл I *
- Араб хэл II*
- Араб хэл III*
- Хятад хэл I*
- Хятад хэл II*
- Хятад хэл III
- Хятад хэл IV
- Хятад хэл ба соёл, AT
- Франц хэл I*
- Франц хэл II*
- Франц хэл III
- Франц хэл IV
- Франц хэл ба соёл, AT
- Латин хэл I*
- Латин хэл II*
- Латин хэл III
- Латин хэл IV
- Латин хэл, AT
- Испани хэл I*
- Испани хэл I*
- Испани хэл III
- Испани хэл IV
- Испани хэл, соёл, AT
- Испани уран зохиол, соёл, AT

**Хичээлийг 7-12 ангиудад санал болгоно*